

УСТГА КРИПТОНИТЫГ

ХҮЧИЙГ ЧИНЬ СОРОГЧ
ЗҮЙЛИЙГ УСТГА

ЖОН
БИВЭР



“КРИПТОНИТЫГ УСТГА”
СУРГАЛТЫН DVD-Г ХАВСАРГАВ

Хүндэт найз минь,

Энэ ном бол хуудсан дээрх үгсээрээ таны амьдралыг мөнхөд өөрчлөхийн төлөө залбирлаар төрсөн, танд зориулсан бэлэг шүү.

Өнөөдөр бид өдөр бүр Христэд итгэх итгэлийн маань хамаг хүчийг ховх сорох санаатай криптонит хэмээгч, бодит сүнслэг зүйлийн эзэрхийллийн эрин үе болох эцсийн цаг үед аж төрж байгаа гэдэгт би итгэдэг.

Христэд итгэдэг олон хүн өөрсдийг нь чангаагч зүйлсийг тасар татаад, эрх чөлөөнд гарах гэж оролдох тусам, улам бүр урам алдаж, тамирдмаар нөхцөлд орох нь их бий. Гэтэл Бурхан ийм байлгахыг хүсдэггүй. Бурхан таныг амьдралынхаа тал бүр дээр ялагч байгаасай гэж хүсдэг. Үүгээр барахгүй Бурхан танд тантай сөргөлдөх алив атаатныг нухчин дарах хүчийг өгдөг.

Би танд энэ номоороо амьдралыг маань хуу эргүүлсэн хувийнхаа адал явдлыг ч, амьдралыг маань мөнхөд өөрчилсөн Библийн үнэнийг ч хүргэнэ. Та ч бас Бурхантай дотносож чадна. Та ч бас эргэн тойрноо орвонгоор нь эргүүлэх хүчтэй, амьд итгэлтэй байж чадна. Гэхдээ эхлээд өөрийнхөө сүнслэг криптониттай тулалдах ёстой.

Та CloudLibrary.org цахим хаягаар нэвтэрч, энэ болоод бусад бүх материалыг таньдаг, мэддэг бүх хүндээ чөлөөтэй дамжуулж хүргээрэй.

Христ дотор барилдсан



Жон Бивэр ах чинь.
JohnBevere@gmail.com



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

УСТА

КРИПТОНИТЫ

Манай Жон Бивэр биднийг хүчирхэгжүүлдэг нигүүлслээр нүглийг яаж бяц дарахыг яруу тодоор харуулж яваа, манай үеийнхэний үг дуугүй хүлээн зөвшөөрбөл зохилтой, практик эш үзүүлэгч билээ. “Криптонитыг устга” номдоо Жон хүн бүрийн амьдралд оршиж байдаг криптонитыг Бурханы хайраар устгаж болдгийг илчилжээ. Бурхан минь, энэ илчлэлээ Жоноор дамжуулж бидэнд хэлсэнд баярлалаа!

РОБЕРТ МОРРИС

Техасын Даллас/Форт Ворт Гэйтвэй Чуулганы үндэслэн байгуулагч пастор, *The Blessed Life, The God I Never Knew, Truly Free, Frequency* зэрэг шилдэг борлуулалттай номын зохиолч

Энэ бол Бурханы хувиас багыг хүлээж авахгүй байхыг Христийн биед уриалсан үг ажээ. Итгэгч хүмүүст Бурханы төлөө амьдарсан шиг амьдрахад нь туслах гэсэн Жоны Библийн ухаарал, сэдэл нь зүрхэндээ хүлээн авч, хэрэгжүүлдэг хүнд ёстой л эрдэнэ юм.

Жойс Мэйер

Шилдэг борлуулалттай номын зохиолч, Библийн багш

“Криптонитыг устга” номоороо Жон Бивэр Христийн доторх хүчин чадлаа ашиглахад маань хориг болдог хүчит цайзуудыг маш тодорхой хэлж өгчээ. Энэ ном нь хүмүүсийн амьдралд байдаг криптонитыг элдэв маяггүй, эрс тэс илчлээд, эдгээртэй нүүрэлдүүлжээ.

ЖЕНТСЕН ФРАНКЛИН

Фрии Чапел чуулганы тэргүүн пастор,
Нью Йорк Таймсын шилдэг борлуулалттай номын зохиолч

Жон Бивэр Библийн зарчим, сургаалын илчлэл, хүмүүсийг гэх хайраараа хүмүүсийг ч, Бурханы хаанчлалыг ч байгуулсаар хэдэн арван жил болжээ. Түүний номууд дэлхийн өнцөг булан бүрт хүрч, хүмүүсийн амьдралд хэмжээлэшгүй нөлөө үзүүлсээр

байна. Би түүний үнэнч нөхөрлөл, итгэмжтэй үйлчлэл, үзэг цаас нийлүүлэх дуулгавартай занд нь гүнээ талархаж явдаг.

БРАЙН ХЬЮСТОН

Хиллсон чуулганы тэргүүн пастор

Сүнсээр дүүрэн. Сэнхрүүлсэн. Хүчирхэг. “Криптонитыг устга” ном нь бидний сайн танил гэм нүглийн аажмаар чангардаг боомилгоч атгыг нигүүлсэл, үнэнээр ноцоож байгаад машид хичээнгүй суллажээ. Энэ ном нь үнэнийг харьцангуй гэж үздэг, үгэнд орохыг мэдэхгүй, бидэнд хамгийн сайн сайхныг буюу Өөрт нь захирагдаж, эрх чөлөөтэй амьдралыг хүсдэг Эзэнд дурлахыг мэдэхгүй үеийнхэнийг удирдахад туслана гэдэгт итгэж байна.

ЛУИ ГИГЛО

Пэйшн Сити чуулганы пастор, Пэйшн Конференцийг үндэслэн байгуулагч, *Goliath Must Fall* номын зохиолч

Жон Бивэрийн бичсэн ном угийн л ярих юмгүй, аугаа байдаг ч, давхар давхар гэнэтийн бэлэгээрээ энэ ном үнэхээр манлайлжээ. Жон энэ удаа амьдралын амин чухал асуудлыг олж хөндсөнгүй гэж хэлэх гэсэнгүй. Харин ч эсрэгээрээ Жон Бурханы нигүүлслээр бичвэрээ улам л торгон ирээр сийлж, улам л шижир болгожээ. Гэхдээ Жоно чухам бидний хамар дор байсаар байдаг ч, огт хардаггүй зүйлийг олж харуулах чадварыг үнэнхүү бишрэх юм. Чухал ном гэвэл дэндүү багадсан явдал болно. Энэ бол их бага гэлтгүй, манай үеийн итгэгч хүн бүрийн заавал унших ном ажээ.

БИЛЛ ЖОНСОН

Калифорни мужийн Реддинг хотын Бетел чуулганы пастор,
God is Good номын зохиолч

УСТГА КРИПТОНИТЫГ

ХҮЧИЙГ ЧИНЬ СОРОГЧ
ЗҮЙЛИЙГ УСТГА

ЖОН
БИВЭР

Killing Kryptonite Mongolian by John P. Bevere

© 2019 Messenger International

MessengerInternational.org

Originally published in English as Killing Kryptonite

ISBN 978-1-937558-13-0 (International edition)

ISBN: 978-1-937558-11-6 (Hardcover edition)

ISBN 978-1-937558-12-3 (Electronic edition)

Additional resources in Mongolian by John and Lisa Bevere are available for free download at: CloudLibrary.org

To contact the author : JohnBevere@ymail.com

This book is a gift from Messenger International and is NOT FOR SALE

Mongolian Killing Kryptonite Printing 1,

10,000 copies Printed in Mongolia

“Криптонитыг устга” зохиолч Жон Бивэр

© 2019 Мессенжер Интернэйшнэл

MessengerInternational.org

Анхлан Англи хэлээр Killing Kryptonite нэрээр хэвлэгдсэн.

ISBN 978-1-937558-13-0 (Олон улсын хувилбар)

ISBN: 978-1-937558-11-6 (Цаасаар хэвлэгдсэн хувилбар)

ISBN 978-1-937558-12-3 (Цахим хувилбар)

Жон, Лиза Бивэрийн Монгол болоод олон улсын хэл дээрх материалыг дараах цахим хуудаснаас татаж авах боломжтой: CloudLibrary.org

Зохиогчтой холбогдох хаяг: JohnBevere@ymail.com

Монгол хэл дээрх энэхүү номыг Мессенжер Интернэйшнэл байгууллагаас

бэлэглэж байгаа бөгөөд ХУДАЛДАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.

“Криптонитыг устга” номын эхний хэвлэл

Монгол улсад 10,000 хувь хэвлэв

Энэхүү номоо Мессенжер Интернэйшнэл
байгууллагынхаа хамтран зүтгэгч нарт зориулав.

Бурханы нигүүлслээр бид хамтдаа Есүс Христийн Сайн мэдээг сая, сая хүнд хүргэсээр явна. Та нарын маань итгэл, талант, бусдыг гэх сэтгэл, хөдөлмөр зүтгэлгүйгээр энэ бүхэн хэрхэвч биелэхгүй байсан. Та бүхэнтэй мөр зэрэгцэн хөдөлмөрлөх нь Лиза, бид хоёрын хувьд нэр төрийн хэрэг бөгөөд Есүс та нарын итгэмжтэй үйлчлэлийг шагнах тэр Өдрийг тэсэн ядан хүлээж байна.

*Учир нь Эзэн Есүсийг ирэхэд Түүний өмнө
хэн бидний найдвар эсвэл баяр баясгалан эсвэл
өргөмжлөлийн титэм бэ? Энэ нь та нар бус уу? Та нар
бидний алдар бөгөөд баяр баясгалан билээ.*

— 1Тесалоник 2:19-20

2019 оны Мессенжерийнхээ багт баярлалаа!

АГУУЛГА

Номын заавар	13
Танилцуулга	15

ХЭСЭГ 1: Ганц хүний хүч

1. Зугтдаг асуулт	21
2. Криптониттай танилц	31
3. Нэг	41
4. Халдварт Криптонит	49
5. Өөрөө өөрчлөлт нь бай	59
6. Хөдөлгүүр	69
7. Ганц хүний хүч	75

ХЭСЭГ 2: Криптонитыг олж тогтоох нь

8. Гэрлэлтийн гэрээ	87
9. Бурханы өмнө завхайрах	95
10. Завхайрлын цаана юу байна?	103
11. Итгэгч хүмүүсийн шүтээн мөргөл	113
12. Дарамтаа хөнгөлөх	123
13. Криптонит!	131
14. Нүгэл	139

ХЭСЭГ 3: Криптонитын үр нөлөө

15. Нүглийн хүч (1–р хэсэг)	149
16. Нүглийн хүч (2–р хэсэг)	159
17. Төөрөлдсөн	169
18. Хулхи Есүс	177
19. Эхлэх цэг	187
20. Гэмшил	199
21. Гурван төрлийн хаан	209

ХЭСЭГ 4: Криптонитыг устгах

22. Багийг хуулах нь	221
23. Хүлцэнгүй байдал	231
24. Хайр ба үнэн	241
25. Криптонитыг устгах нь	251
26. Нүгэл биш нүгэл	261
27. Найрын үүд	271
28. Бос	281
Хэлэлцэх асуулт	291
Бүгдэд нээлттэй аврал	301
Номын танилцуулга	304
CloudLibrary гэж юу вэ?	316
“Криптонитыг устга” цогц сургалтын материалын агуулга	317

НОМЫН ЗААВАР

“Криптонитыг устга” номыг бусад номын л адил уншина. Би номынхоо бүлэг бүрийг зориуд богино бичсэн учраас, нэг бүлгийг 10-15 минутад л уншаад дуусгачихна. Бүлэг бүрийн ард “Хэрэгжүүлэлт” гэсэн хэсэг бий. Бүлэг бүрээс сурсан үнэнээ амьдралдаа хэрэгжүүлэхэд чинь энэ хэсэг туслана. Энэ нь номоосоо дутахгүй чухал хэсэг учраас, битгий алгасаарай. Ер нь бол, би танд өдөрт ганц л бүлэг уншихыг зөвлөнө. Ингэсэн тохиолдолд та дараагийн бүлэгтээ орохоосоо өмнө шаардлагатай бүх алхмаа гүйцэтгэж дуусгасан байна.

“Криптонитыг устга” номыг бүлгээрээ судлах хүсэлтэй хүмүүст зориулж, номын арын хуудсанд “Хэлэлцэх асуултыг” орууллаа. Түүнээс гадна номын маань агуулгатай хослох мульти-медиа сургалтыг гаргасан нь энэ сэдвийг илүү гүн гүнзгий судлах хүсэлтэй хүнд нэн тустай байх болно. (Энэ талаар номын арын хуудсанд дэлгэрэнгүй танилцуулсан болно)

Хэрэв та номоо “Криптонитыг устга” цогц сургалтын хөтөлбөрөөр нь судлаж байгаа бол, DVD дотор юмуу эсвэл CloudLibrary.org цахим хаяг дээр буй долоо хоног тутмын видео хичээлээ үзэж сонсоод, дараа нь тухайн хэсгийн хэлэлцэх асуултын дагуу хоорондоо ярилцаарай. Номынхоо тохирох хэсгийг уулзалтаасаа урьдчилж уншсан байх ёстой шүү.

За амжилт!



Жон

ТАНИЛЦУУЛГА

Надад энэ ном шиг хэдэнтээ бичихээ болиод, хаячихмаар санагдаж байсан ном байхгүй гэхээр та гайхах байх. Одоо тайлбарлая. Гэхдээ эхлээд “Криптонитыг устга” ном маань Христэд итгэдэг хүмүүст ямар хамаатай болохыг гялс тайлбарлая.

Ихэнх маань “Криптонит” гэдэг үг Супермэний зөгнөлт түүх дээр гардгийг мэдэх байх. Америк домог болох шахсан энэ түүхийг анх Жерри Сиегел, Жо Шустер гэдэг ахлах сургуулийн хоёр найз - жаал зохиосон бөгөөд 1938 оны 6-аар сард анх комик хэлбэрээр гарчээ. Супер хүчтэй, сайхан сэтгэлтэй баатрын энэ түүх нь Нацистийн дарангуйллын цагт төгс хор тайлагч болжээ. Супермэн гэрлийн хурдаар алдаршиж, яваандаа хэвлэлээр төдийгүй, радио, зурагт, блокбастер кинонд мөнхрөв.

Гэтэл хэсэг хугацааны дараа Супермэний хэт төгс байдлаас хүмүүс уйдаж эхэлжээ. Үүнээс болж 1940 онд зохиолчид нь хожим криптонит нэрээрээ алдаршсан бодисыг зохион бүтээсэн юм. Энэ нь Супермэний төрөлх гаригаас гаралтай, түүний хүчийг үхүүлэх увидастай бодис ажээ. Супермэн криптонитын нөлөөнд автахдаа, жирийн хүнээс ч дорой нэгэн болж хувирна.

Тэгвэл Христэд итгэдэг бидэнд ч Бурханаас өгсөн хүч, зан чанарыг маань үхүүлдэг “криптонит” байдаг. Тэр нь юу вэ? Түүнийг яаж таних вэ? Тэр зүйл бидний хувь, хувьсгалд хэрхэн нөлөөлдөг вэ? Бидний үр нөлөө, хүмүүсийг авралд хүргэх чадварыг хэрхэн боогдуулдаг вэ? Бид үүний эрхшээлд орохдоо, юугаа алддаг вэ? Тэр зүйл яагаад тийм амархан зүсээ хувиргадаг вэ? Энэ мэт асуултад хариулах гэж л энэ ном төрсөн юм.

Энэ бол миний Ариун Сүнсний удирдамжаар бичсэн хорь дахь ном. Номоо бичиж байхдаа би тав зургаан удаа бууж

өгмөөр болж байснаа түрүүн хэлсэн. Нэгэн шалтгаан нь: миний өөрийн амьдралд байгаа, үгүйсгэхийн аргагүй асуудлыг энэ ном илчлээд байв. Тэгээд би өөрөөсөө: *“Би Бурханы хүссэнээс дорой амьдралыг хүсээд байна уу? Даяар чуулган нийгмээ өөрчлөх хэмжээнд Бурханы оршихуй, хүчээр дүүрч чадаж байна уу?”* гэж асуув. Үнэндээ би хэд хэдэн удаа харанхуй шөнөөр сэрээд: “Аааа, би энэ номыг үнэхээр бичмээргүй байна, больмоор байна” гэж хэлсэн юм.

Гэвч тухай бүр Ариун Сүнсний: “Болохгүй!” гэдэг үг намайг дэлсдэг байлаа. Тэгээд энэ үгийн соён гэгээрлийн үрээр дэлхий даяар эрүүл саруул итгэгч хүмүүс, чуулганууд бий болно гэдгийг хамгийн сүүлд Ариун Сүнс надад аминчлан батлав. Энэ үгээр хотууд өөрчлөгдөх ажээ.

Эл амлалтыг хүлээн авсныхаа дараа би номоо итгэлээр үргэлжлүүлэн бичив. Тэгээд номынхоо адаг хэсгийг буюу сүүлийн долоон бүлгийг бичихдээ л ач холбогдлыг нь тайлж ойлгосон юм. Би энэ үгийн цэц ухааныг төдийгүй, хэрэгцээг ухаарав. Харин өнөөдөр би энэ номоо миний нэрээр гаргасан Бурханы амин чухал үг гэж үздэг.

Номын маань ашиг тус сүүл хэсэгтээ байгаа гэхээр, шууд сүүл хэсгийг нь уншчихмаар санагдаж байна уу? Тэгж болохгүй шүү. Номынхоо эхний гурван хэсгийг алгасчихбал, дөрөвдүгээр хэсгийн үр нөлөө нь огцом буурна. Жишээлбэл, та киног эхнээс нь дуустал цэгцтэй үзэлгүй, шууд сүүлийн хорин минутын оргил хэсгийг нь үзбэл, шур хийгээд өнгөрөх хэсэгхэн үйл явдал танд утга төгөлдөр санагдахгүй. Та киногоо бүрэн үзсэн хүмүүс шиг уйлж, дуулж, баясалгүй, юу болоод өнгөрөв гэсээр л хоцорно.

Ном маань тус бүр долоон бүлэг бүхий дөрвөн хэсэгтэй буюу нийт хорин найман бүлэгтэй. Завгүй уншигч нартаа дөхөм болгох үүднээс зориуд богино бүлгээр бичлээ. Та дөрвөн долоо хоногийн турш өдөр бүр нэг бүлэг уншиж болно. Үүнд чинь 10-15 минут л зарцуулагдана. Эсвэл долоо хоногт нэг бүлэг унших маягаар зургаан сарын хугацаанд уншиж дуусгаж болно. Эсвэл зүгээр л ном уншдаг шиг угсруулж уншиж болно. Ямартаа ч бид номоо таны хуваарьт нийцүүлэх гэж ихэд мэрийлээ.

Эцэст нь нэг зүйлийг захья. Энэ номын үг таны ертөнцийг эрхшээх гэсэн үзэл бодол, криптонитаас хамгаалах арга зам болно

шүү. Уншиж эхлэхээсээ өмнө мэлмий тань тунгалаг байхын төлөө мөн та газар дээрх хувь тавилангаа биелүүлэх хүчтэй байхын төлөө тэнгэрийн цэц ухааныг Ариун Сүнснээс гуйя.

Аав аа, амьдралд минь хандсан хүслийг тань харах, сонсох, хүлээн авах нүд, чих, сэтгэлийг минь нээгээч. Ариун Сүнс минь, энэ үгээр дамжуулж Эзэн Есүс Христийн замыг гүн бөгөөд нарийн ойлгуулаач. Та бол миний Багш. Энэ номын үг бүрээр надтай ярьж, амьдралыг маань мөнхөд өөрчлөөч. Есүсийн нэрээр. Амень.

「ЭНЦ ХҮНИЙ ХҮЧ

「ХЭСЭГ 1」

ЗУГТДАГ АСУУЛТ

Санамж:

Танилцуулга хэсгийг уншиж амжаагүй хүн байгаа бол, заавал уншихыг зөвлөе. Тэгж байж л та гараанаасаа зөв гарна. За амжилт!

“Криптонитыг утсгах” ий? Энэ чинь тэгээд Супермэний тухай ном уу? Үгүй л дээ. Гэхдээ бидний итгэлийн түүх Супермэний түүхтэй гайхмаар хослодог. Юугаараа хослодгийг үзье.

Супермэн энэ дэлхийнх биш бол, Бурханы хүүхдүүд бид ч энэ дэлхийнх биш юм.

Супермэнд жирийн хүнд байдаггүй, ер бусын хүч байдаг бол, бид ч энэ дэлхийн бус хүчээр зэвсэглэсэн.

Супермэн муу муухайтай тэмцдэг бол, бид ч ёрын муутай тэмцдэг.

Супермэн хорон санаатны дарлалд орсон хүмүүсийг чөлөөлж хамгаалдаг бол, бид ч боолуудыг чөлөөлж, сул доройг хамгаалдаг.

Супермэн нарнаас хүчээ авдаг бол, бид Хүүгээс хүчээ авдаг.

Супермэнийг түүний төрөлх гаригаас гаралтай криптонит хэмээх радио идэвхит зохиомол бодис л дийлдэг бол, Бурханы

хүүхдүүдийг ч дарж авдаг, бидний төрөлх гаригаас гаралтай “криптонит” гэж бий. Тийм ээ, энэ дэлхийгээс үүсэлгүй, харин бидний бий болсон тэр газраас үүсэлтэй эд. Криптонит нь Супермэний хүмүүн бус чадварыг үхүүлэхээр барахгүй, эгэл хүнээс ч дорой буурай болгож чаддаг бол, манай криптонит ч биднийг тийм болгож авдаг.

Тэгвэл бидний тэр криптонит нь юу вэ? Үүнийг олж мэдэхээсээ өмнө эхлээд түүхэн тайзыг засах хэрэгтэй. Аугаа хүчирхэг Супермэнийг эрхшээлдээ оруулж дөнгөдөг криптонитын давуу чанар юу вэ? Юу гэхээр, криптонитыг танихын аргагүй ажээ. Тиймээс Супермэн маань криптонитын эрхшээлд орсон хойноо л энэ нь криптонит байсныг мэддэг байна. Яг үүн шиг итгэдэг хүмүүсийг ч, Христийн биеийг ч доройтуулагч тэр криптонитыг манайхан өнөө хэр танихгүй явсаар л байна. Тэгвэл криптонитыг таниад зогсохгүй, хувь хүнд болоод нийгэмд учруулах хор уршигтай нь хамт сөнөөх чадварыг танд суулгах нь номын маань үндсэн зорилго билээ. Тэгэхээр нэг асуулт тавья.

Хамгийн том хүсэл

Бидний хамгийн том хүсэл юу вэ? “Бидний” гэж хэлсэн маань учиртай. Яагаад гэвэл үнэнийг хэлэхэд хүмүүс ерөнхийдөө адилхан байдаг. Бид бүгдээрээ л амжилттай болох, талбартаа тэргүүлэх, алдартай болох, сайхан гэр бүлтэй болох, сайн найз нөхөдтэй байх, эрч хүчтэй, хүчирхэг нийгэмд амьдрах, эрүүл саруул байх юмуу хүссэн бүхнээ хийх хангалттай мөнгөтэй байхыг хүснэ.

Эдгээр нь бүгдээрээ сайн сайхан бөгөөд тэр бүү хэл дийлэнх нь зайлшгүй хэрэгтэй зүйл боловч, үнэндээ бидний хамгийн том хүсэл мөн үү? Энэ бүхнийг эзэмшдэг атлаа дотроо хонгио шиг явдаг хүмүүсийг бид мэдэхгүй гэж үү? Амьтны нүдэнд алтан аяганаас ус зооглож яваа мэт боловч, дотроо ямар нэг зүйлээр харангадаж яваа Холливүүдийн одод, бизнесмэнүүд, мэргэжлийн тамирчид, төр засгийн удирдагч нарыг бид мэдэхгүй гэж үү? Тэр ангаагаа дарах гэж зарим нь хар тамхи, архи, гаж сонирхол, нууц амраг руу эргэдэг бол, зарим нь дотроос нь шимж байгаа хоосролоо шашин, шинэ сүнслэг байдал, гаж шүтлэгээр дарах гэж үзнэ.

Чин үнэнээсээ ярих аваас, энэ бүхнээс чухал зүйл гэж байдгийг хүн болгон дотроо мэдэрч л явдаг. Эрэгтэй, эмэгтэй ямар ч хүний мэдээтэй, мэдээгүй үгүйлэн хүсч явдаг тэр зүйл нь гагцхүү Бүтээгчтэйгээ тогтоосон дотно харилцаанаас л олддог юм. Та Бурханы талаар юу гэж бодож явдаг нь хамаагүй. Гэхдээ Тэр л таны амин хүсэл мөн болой. Хүн бүр хайж явдаг хангалуун байдал, ханамжаа гагцхүү Бүтээгчтэйгээ эргэж нэгдсэнээр л олно.

Үнэндээ Бурхан “хүний зүрхэнд өнө мөнхийг суулгажээ” (Номлогчийн үгс 3:11). Худал хуурмагт нэг мөр залгиулчихаагүй л бол, бид “өнө мөнхийн Хааныг” зөн совингоороо л зүрхэндээ үгүйлэн санагалзаж явдаг юм (1Тимот 1:17-г үзнэ үү). Бурханы Үг хүн бүрийн талаар ингэж хэлжээ:

Учир нь Бурханы тухай мэдэж болох зүйл тэдний дунд илэрхий байдаг агаад Бурхан тэдэнд үүнийг ил болгосон юм. Ертөнц бүтээгдсэнээс хойш Түүний үл үзэгдэх чанарууд, Түүний мөнх хүч ба бурхан чанар нь бүтээгдсэн зүйлсээр дамжиж ойлгогдож, илэрхий харагдаж байгаа тул тэдэнд шалтаг байхгүй. (Ром 1:19-20)

Бурхан хүн бүрт Өөрийгөө мэдүүлдэг. Шударгаар хүлээн зөвшөөрөх аваас, хүн бүр амьдралынхаа аль нэг үе дээр жинхэнэ Бурханыг таньж мэдэхийг гүнээ хүсч, үгүйлэн хайдаг. Тэр бол бүхнийг мэдэгч, бүхнийг чадагч, хаа сайгүй оршигч Бурхан гэдгийг бид бүгдээрээ зөн совингоороо мэдэрдэг.

Бурхантай харилцаа тогтоосон хүн бүр Түүний оршихуй, хүч, сүр, эрхэмсэг байдлыг юутай ч эгнэшгүй, юугаар ч хэмжишгүйг мэднэ. Энгүй хүчирхэг тэр Бурханыг ертөнцийн хамгийн сүрлэг оршигч нар болох серафимууд тэнгэрт зогсоо зайгүй бишрэн, сүслэм аугаа байдлыг нь өөр хоорондоо тэнхээ мэдэн магтах ажээ. Тэрхүү сүрлэг оршигч нарын гал цогт, хүчирхэг магтаалын нүргээнээр тэрбум илүү оршигчийг тээх, тэнгэрийн үлэмж талбайн үүд доргих ажээ.

Бурханы цэц ухаан, ойлголт, бүтээлч чанар, суу ухаан, мэдлэг нь ухааны хязгаараас талийсан, үзүүргүй уудам ажээ. Олон зууны турш хүн төрөлхтний сор болсон сод ухаант эрдэмтэн мэргэд Бурханы бүтээлийн нууцыг хайсаар, судласаар ирсэн ч, эдгээрийн ээдрээ, гайхамшигийг бүрэн тайлахгүй.

Бурханы яндашгүй их хайр, өр зөөлөн сэтгэл, энэрэл хишиг, энэлэл өршөөлийг гүйцэт ойлгож, эдэлсэн хүн үгүй билээ. Бурханы хайранд хил хязгаар үгүй.

Миний бие Түүнтэй дөчин жил нөхөрлөсөн завшаант хүн боловч, өөрийнхөө толгой дээр буулгасан ялаас Бүтээгч маань биднийг аварсан шүү дээ гэж бодохоор л өнөө хэр хамар шархирдаг юм. Бурхан хүн төрөлхтөнд газрыг засаглах хамаг эрхийг өгсөн боловч, энэ эрхийг нь бид өөрийнхөө хамгийн том атаатан болох Сатанд болон түүний хамсаатнуудад өгчихжээ. Бурхан хүн төрөлхтөнийг увайгүй авирлаж, урвахыг урьдаас мэдэж байсан ч, биднийг боолчлолын шоронгоос чөлөөлөхийн төлөө төлж баршгүй их өрийг маань Өөрийн биеэр төлөхийг хүсч, үүнийгээ хэрхэн хийхээ ч төлөвлөв. Бид өөрийгөө ялласан боловч, Бурхан бидэнд Өөрийгөө үнэ төлбөргүй өгчээ. Тэрбээр үүнийг хийхдээ, Үгээ зөрчихгүйн тулд хүн болж ирсэн юм.

Бурхан дэлхийг хүнд өгсөн учраас, Бурханыхаа дүрээр буцааж авах боломжгүй байв. Дэлхийн эрхийг гагцхүү хүний Хүү л буцааж нэхэх мэдэлтэй байжээ. Онгон бүсгүйгээс мэндлэх нь Есүсийн сэдсэн цэц ухаан байв: Есүс зуун хувь хүн болсон ч, Аав нь Бурханы Сүнс тул Тэрбээр хүн төрөлхтөнийг дөнгөлсөн боолын мөн чанараас ангид байв. Есүс махан биеэр үзэгдсэн Бурхан байлаа. Тэрбээр биднийг боолчлолоос аварч, чөлөөлөхийн тулд ямар гээчийн аймшгийг хүлцэхээ мэдэж байсан ч, бидэнд дэндүү хайртайдаа, ямар ч төлөөсийг төлөхөд эргэлт буцалтгүй бэлэн байв. Түүний сайн сайхан, аугаа хайр, хүч, эрхэмсэг байдлыг хэдэн ботиор бичсэн ч барагдахгүй. Гэхдээ бид энэ номоороо арай өөр асуудлыг хөндөнө.

Зугтдаг асуулт

Учир зүйн талаасаа бодбол, ийм аугаа Бурханы хүүхдүүд чинь ер бусаар л амьдрах ёстой бус уу? Гэхдээ учир зүйгээс гадна Бичээс ч энэ гаргалгааг дэмждэг. Бидэнд дараах зүйлсийг амлажээ:

- Түүний тэнгэрлэг мөн чанар
- Амиа боддоггүй зан чанар

- Нөхцөл болзолгүй хайр, уучлал
- Зүйрлэхийн аргагүй баяр хөөр, амар тайван
- Ер бусын хүч
- Сайн сайхан
- Эрч хүч
- Эрүүл энх
- Тогтвортой, аюулгүй амьдрал гэх мэт энэ жагсаалт дуусахгүй үргэлжилнэ. Цаана нь ч өөр олон амлалт бий.

Түүнчлэн бидэнд:

- Тэнгэрийн цэц ухаан
- Мэдлэг
- Ойлголт
- Суу ухаан
- Гэгээрэл болоод бүтээлч байдлыг амладаг.

Энэ бүхэн нь бидний хүчин зүтгэлийг мялааж, үр жимс, амжилт авчрахын төлөө байдаг. Товчхондоо, бидэнд тэнгэрийн чанарыг амлажээ. Өөрийнх нь хаанчлал бидний дотор байгаа учраас, хүсэл нь тэнгэрт шигээ газар дээр биелнэ хэмээн Есүс баттай мэдэгдсэнийг санаж байна уу?

Гэтэл энэ бүх чанар макро төвшинд ч, хувь хүмүүсийн амьдралд ч үзэгдэхгүй л байх шиг. Шударгаар харах юм бол, Бурханы хүмүүс дэлхийн хүмүүсээс шальтай ялгарах болов уу? Есүсийн дагалдагч бид онцгойрч чадаж байна уу? Бид харанхуйн дунд гэрэлтэж чадаж байна уу? Салалтын харьцааг л харчих. Чуулган, нийгмийн хооронд ялгаа гэж байна уу? Бид атаархал, жөтөө, хов жив, тэмцэл, хуваагдлаас болж харилцаагаа нурааж байна уу? Бид ялзарсан улс үндэстэн дундаасаа зан чанар, шударга байдал, ёс суртахуунаараа илүүрхэж байна уу? Эрүүл мэнд, амьдралын чанарын хувьд итгэгч, итгэгч бус хүмүүсийн хооронд гойд ялгаа байна уу? Бид аливаа зүйлээр элбэг хангалуун байна уу? Бид бусдын хэрэгцээг хангаж, дэлхий даяар хүн бүрт Бурханы Сайн мэдээг хүргэж байна уу?

Энэ бүхэн хэт хүршгүй, өндөр сонсогдож байна уу? Хуучин гэрээний үед цалин цагаан мөнгө хайрга чулуу шиг л элбэг байсан тул ... тоогддоггүй байжээ (1Хаад 10:21, 27-г үзнэ үү). Гэтэл

өнөөдөр Шинэ гэрээнд хүмүүс улс нийгэмдээ туслая гэсэн ч, өөрөө улаан мөнгөгүй эсвэл байгаа хэдэн төгрөгөө яаж хүргэх ухаанаа олохгүй, толгой ганзаглаж явахтай зөндөө таарна. Энэ бүхэн нь тэгээд “тэнгэрт шигээ газар дээр” гэдэг шиг байж чадаж байна уу?

Юуны түрүүнд Түүний хаанчлал, зөвт байдлыг эрэн хайвал, хэрэгтэй бүхэн маань өгөгдөнө гэж Есүс амласан. Есүс Өөрөө ямарваа нэг зүйлээр гачигдсандаа, зорьсон ажлаа хөсөрдүүлж байсангүй. Харамсалтай нь өнөөдөр чуулганд чинээлэг байдал, баялгийн талаар туйлширсан сургаал заах болжээ. Ийм тэнцвэргүй сургаал нь хүмүүст баялаг бол муу зүйл гэсэн ойлголтыг суулгадаг. Гэтэл бид өөрсдөө хоосон байвал, бусдад юугаа өгөх билээ?

Бурханы хаанчлалыг мөшгисөн хүнийг Бурхан Өөрийнх нь хүслийг газар дээр дэлгэрүүлэхэд шаардлагатай бүхнээр хангана. Бурхан муу удирдагч биш. Бурхан дагалдагч нартаа ямар нэг даалгавар өгсөн бол, хийх багаж зэмсгийг нь заавал дагалдуулж өгнө. Гэхдээ үүнээс чухал нь Бурхан сайн Аав мөн. Бурхан хүүхдүүдээ ерөөхийг хүсдэг. Гэхдээ Бурхан биднийг эд хөрөнгөнд эзэмдүүлэхийг хүсдэггүй. Бүх ёрын муугийн үндэс нь мөнгө бус, харин “мөнгийг хайрлах хайр” билээ.

Нэг үе эртний Израиль ширхэг ч ядуу хүнгүй, хөгжин цэцэглэсэн улс байжээ. “Соломоны бүх өдрүүдэд Данаас Беершеба хүртэлх Иуда ба Израиль амар жимэр амьдарч, хүн бүр өөрийн усан үзэм, инжрийн модон дор суудаг байв” (1Хаад 4:25). Дан нь Израилийн умард хязгаарын хот, Беершеба нь өмнөд хязгаарын хот байсан тул улс даяар төр засгийн халамж шаардлагатай ширхэг ч хүн байгаагүйг Бичээс хэлж! Ийм баян чинээлэг байдлын шалтгаан нь юу байв?

Үнэндээ энэ нь ганц л тохиосон, үл давтагдах түүхэн тохиол байсангүй. Хуучин гэрээнд гайхаж бишрэм аргаар цэцэглэн хөгжиж, санхүү, эдийн засаг, нийгэм, цэргийн хүчээр бэхэжсэн Бурханы хүмүүс олон байлаа. Тэд мөнгө санхүү, хоол хүнс, баялгаар халгиж цалгидаг байв. Тэд дайн тулаанд ялагдах бус, бут ниргэдэг байв. Тэдний амьдралын чанар чансааг бусад улс үндэстэн үзээд таг болдог байв. Энэ бүх явдал Шинэ гэрээнээс хавьгүй дорой Хуучин гэрээн дор өрнөж байсныг бүү мартаарай!

Илүү дээр амлалт дээр байгуулагдсан илүү дээр гэрээний Зуучлагч нь Есүс байв (Еврей 8:6). Есүсийн амьдралыг харах юм

бол, Түүнд төр засгийн удирдагч, хүнд сурталтан (татвар хураагч), сурвалжтан, янхан, хулгайч, баян, ядуу - товчхондоо бүх төрлийн хүмүүс татагддаг байв. Есүс хаа очно - тэр нийгэм өөрчлөгддөг байв. Түүний багийг дайрч далайлгасан явдал бүрийг Есүс ашигтайгаар эргүүлэн, алив аюулт хор хохирлыг тасладаг байлаа.

Анхны чуулганы гишүүдийг “дэлхийг үймүүлэгсэд” (Үйлс 17:6) гэж дууддаг байжээ. Тэд ч бас юугаар ч дутаагүй. Учир нь “...тэд бүгдийн дээр бялхам их нигүүлсэл байсан билээ. Гачигдсан хүн тэдний дунд байсангүй” (Үйлс 4:33-34) гэдэг. Тэд үнэхээр ер бусын хүмүүс байв. Тиймдээ ч олон удаа цэрэг, төр нийгмийн удирдагч нарт: “Бид бурхад биш ээ, биднийг бүү шүт” хэмээн учирлан мэдүүлдэг байжээ. Дэлхийн хүмүүс тэднийг эрэгтэй, эмэгтэй супер баатрууд гэж үзсэн. Тэд харанхуй үеийнхэний дунд цацарч, өвчин эмгэгийг сөнөөжээ.

Тэгвэл би дахиад асууя. Бидний амьдралын хэв маяг нийгмээсээ илүүрхэж байна уу? Амьдрал маань “Бид Бурханы хүмүүс шүү!” гэтэл хурц цацарч байна уу? Эсвэл шалтаг дэлгэн, Бичээст маш тодорхой хэлсэн амлалтуудыг Шинэ гэрээний эхлэл үетэй холбоотой, одоогийн бидэнтэй ямар ч холбоогүй үгс мэт үзэж, теологийн зохицуулалт хийж байна уу? Энэ талаар Шинэ гэрээний бичээч нар тодорхой хариулсаар байтал, бид эдгээр хүнд асуултад хариулахаас зугтаж байна уу?

Бид Бичээсийн Үгд үнэхээр чих тавьсан бол, яах байсан бол?

Би хэнийг ч чичлэх гэсэнгүй. Гэхдээ бидний энэ царай “Таны хаанчлал ирэх болтугай, Таны хүсэл тэнгэрт шигээ газар дээр биелэх болтугай” гэсэн үгийг харуулж байна уу? “Бурханы хаанчлал нь та нарын дунд байна” (Лук 17:21) гэсэн Есүсийн үгийг бид мэдээгүй, сонсоогүй мэт царайлж чадахгүй. Тэгвэл Түүний хаанчлал энд, Христийн бие дотор байна уу? Бид Есүс шиг амьдарч чадаж байна уу? Бид “Түүний дотор оршдог гэж яригч нь Түүний явсанчлан өөрөө бас тийн явах учиртай” (1Иохан 2:6) гэсэн зааврыг хүлээж аваагүй юу?

Бид анхны чуулган шиг дэлхийг хүчирхэгээр өөрчилж байна уу? Хоёрхон жилийн дотор хавь ойрынхон маань бүгдээрээ Бурханы Үгийг сонсов уу (Үйлс 19:10)? Тэдэнд интернэт, фэйсбүүк тэргүүтэй олон нийтийн сүлжээ, зурагт байтугай радио ч байгаагүйг санаарай. Тийм боловч хүн бүр - зөвхөн хот юмуу

үндэстэн бус, харин бүс нутгаараа Сайн мэдээг сонссон юм шүү.

Тэгвэл бид ийм зүйл үзэж байна уу? Үнэнээ хүлээх үү?

Бид уулын чинээ зааныг харсаар байтлаа, тас аниад: “Бурхан тэгж ажиллахаа больсон шүү дээ” гэдэг. Тэгээд Сайн мэдээг нөхцөл байдлынхаа хэвд цутгадаг. Бид хүч, тэнхээ, амжилт, баялаг, үр жимстэй байдал юмуу эрүүл мэндийг дэмжсэн алив зүйлээс ухарч, заримдаа бүр зугтдаг. Бид ийм үгийг туйлширсан, тэнцвэргүй, өөрийнхөө хэрэгцээнд тааруулсан үг гэдэг. Ингэснээрээ бид зарим хэцүү асуултаас зугтаж, өөртөө Сайн мэдээг дэлхийд хүргэхгүй байх шалтаг бий болгодог.

Тиймээс л намайг бидний үр нөлөөгүй байдлын талаар асуухаар, бүгд биш юмаа гэхэд, дийлэнх хүмүүс мэл гайхдаг. Гэхдээ бид яагаад асуухгүй байна? Бид яагаад хариултыг нь хайхгүй байна? Асуулт асуугаад унабал, шийдмээргүй байгаа асуудал маань ил гараад ирэх вий гэхээс айж байна уу? Гэхдээ хэрэв бид асуухгүй, асуултынхаа хариулт дээр дөрөөлж ажиллахгүй юм бол, юун нөгөө амлагдсан, дуудагдсан амьдрал? Бид үлгэн салган амьдарсаар л дуусна.

Гучин тав илүү жил үйлчилсэн, жар дөхөж яваа миний бие энэ асуултыг тавих хүсэлтэй бөгөөд бэлэн байна. Үнэндээ тэнгэр намайг энэ сэдэвтэй тулахад ятгаж байна. Хэрэв бид үнэхээр булзаж нялзалгүй, Бурханы Үгээс энэ асуултыг хайх юм бол, дуудагдсан амьдралаа бүрэн дүүрэн эдлэнэ гэдэгт би итгэдэг.

Та ч бас надшиг хариулт авахыг хүсч байвал, хамтдаа Бичээсээр аялцгаая. Аялал маань түргэн биш, зарим үед зовиуртай - яг л чадвартай мэс засалчийн нарийн төвөгтэй хагалгаа мэт үйл явц байх болно.

Эмч хүн өвчтөнөө хайрлаж, амийг нь аврахын төлөө шаардлагатай эмчилгээг хийдэг.

Тэгвэл Ариун Сүнс чуулганд ч, хувь хүнд ч ямар ч мэс засалчаас илүү ханддаг. Уншихад хэцүү болохын цагт үүнийг бүү мартаарай. Эцэст нь та л өөрөө хүчирхэг, эрүүл саруул, амьд мэнд, хайраар дүүрэн, эрч хүчтэй хүн болно. Энэ хариулт бидний амьдрал, нийгэм, урсгалыг өөрчлөх хүчин чадалтай.

За, айгаагүй бол хөдөлцгөөе!

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Иаков 1:22 дээр “Гэхдээ өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид бай” гэдэг. Бид Бурханаас (Бичээсээс, Ариун Сүнснээс юмуу зөв сургаалаас) сонссон үгээ үйлдэхгүй бол, үнэндээ өөрийгөө хуурч байгаа хэрэг юм.

Бид хэн нэгний сургаалыг толгой дохисноороо бус, харин хэрэгжүүлснээрээ тэр зүйлд итгэж байгаагаа батлан харуулдаг. Тиймээс л бүлэг болгоны төгсгөлд байгаа хэрэгжүүлэлт хэсэг тийм чухал буюу. Энэ нь танд тухайн хэсгээс сурсан үнэнээ амьдрал дээр бодитой болгох түлхэц болно. Хэрэгжүүлэх хэсэг нь товчхон учраас их цаг авахгүй.

Та хэрэгжүүлэлтээ гүйцэтгээд явбал, номоосоо хавьгүй ихийг өөртөө шингээж, амьдрал чинь ч хавьгүй илүү өөрчлөгдөнө.



Хэцүү асуулттай тулах нь яг л өвчтэй шүдээ ломбодуулахаар шүдний эмч дээр орохтой адил юм. Гэхдээ хэрвээ та жинхэнэ ач тус хүртье л гэж бодож байгаа бол, зоригтой байж, нүүр тулах л ёстой.

Амьдрал чинь энэ дэлхийгээс юугаараа илүүрхэж байна? Хүмүүс таныг Есүс шиг амьдарч байна гэх болов уу? Энэ асуултаас бүү ухар, харин нүүр тул. Хэрэв та Есүс шиг амьдарвал, амьдрал чинь юугаараа өөр байх бол? Ямар зуршлаа эвдэх хэрэгтэй болох бол? Эргэн тойрныхоо жирийн хүмүүстэй яаж харилцах ёстой болох бол? Гэр бүлтэйгээ харилцах харилцаа чинь юугаараа өөр болох бол?

Эдгээр асуултад цаг гарган, сайтар бодож байгаад хариул. Бичээсийг хөтчөө болго. Ингэвэл баримжаатай болно. Зарим нэг асуултад хариулж бичсэн бол, түүнийхээ төлөө залбир. Яг одоо амьдралд чинь юу үйлдэж байгааг Ариун Сүнснээс асуугаад, түүнийгээ амьдралд чинь амилуулж, танд өөрчлөгдөх хүч хайрлахын төлөө гуйгаарай.

КРИПТОНИТТАЙ ТАНИЛЦ

Бид эхнийхээ бүлгээр Бурханы аугаа чанарыг дүрслэх гэж оролдлоо. Гэхдээ бид хичнээн нарийн төвөгтэй, боловсронгуй үг хэллэг хэрэглэсэн ч, Бурханы аугаа чанарыг дөхүүлж ч зураглаж чадахгүй учраас, “оролдлоо” гэж хэлж байгаа ухаантай. Бурхантай эгнэх нь бүү хэл, чигчий хуруунд ч дөхөж очих амьтан байхгүй. Өнгөрснөөс ирээдүй даяар өнө мөнх хаанчлагч Бурхантай өрсөлдөж, тэнцэх амьтан эрхэс гариг, ертөнц дэлхий, бөмбөрцөг дээр нэг ч үгүй! Тэр бол аугаа Бурхан!

Тэгвэл Бурханы энэ алдар суу хөвгүүд, охидынх нь амьдралд ч тусах ёстой. Бичээс ч: “Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг” (1Иохан 4:17) хэмээн үүнийг мэдэгддэг. Элч Иохан: “Бид нөгөө ертөнцөд Түүн шиг байна” гэж хэлээгүй. Иохан *биднийг яг энэ ертөнцөд Түүн шиг байна!* гэсэн. Энэ бол алмайрмаар үг. Тэгвэл өөр нэг үгийг харья.

Үүгээр Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхов. Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурхан чанарыг хуваалцагч болох юм. (2Петр 1:4)

Бодоод үз. Та бид хоёрт энэ дэлхийн хэн нэг суутны чанар бус, харин Бурханы Өөрийнх нь чанар өгөгдсөн бөгөөд Петр

биднийг эргэлзүүлэхгүйн тулд “бурхан” гэдэг үгийг нэмжээ. Энэ нь “ганцхан Бурханаас л гардаг, Бурханы зүйл” гэсэн утгатай теос хэмээх Грек үг юм (WSNTDICT). Харин “чанар” гэдэг нь “мөн чанар, үндсэн бүтэц, эдийг нь гаргаж ирэх” гэсэн утгатай *фюзис* хэмээх Грек үг юм (WSNTDICT). Энэ хоёрыг нийлүүлбэл “Эдгээр нь таныг *гагцхүү Бурханы Өөрийнх нь байх үндсэн мөн чанарыг* хуваалцах чадвартай болгодог” гэсэн утга бий болно.

Бид үнэхээр Бурханаар төрсөн!

Үйлчлэгч нар “Христэд итгэдэг хүн, итгэдэггүй хүний хооронд нэг их ялгаа байхгүй. Христэд итгэдэг хүмүүс зүгээр л уучлагдсан хүмүүс л байхгүй юу” гэж хэлэхийг сонсоод, би бачуурдаг. Энэ бол худал сургаал бөгөөд маш аюултай хоёр үр дагавартай: Нэгдүгээрт - энэ нь Есүсээр дамжуулж бидний төлөө Бурханы үйлдсэн үйлсийг үнэгүйдүүлдэг. Хоёрдугаарт - энэ нь Бурханы амлалтыг тэглэж, ингэснээрээ Бурханы хүмүүсийг нүгэлт хүслээр бүтээгдсэн энэ дэлхийн завхралаар аргамждаг.

Байгаль ч ийм худал сургаалаас дайждаг. Арслан хэрэм төрүүлэхийг эсвэл хурдан удмын хүлэг чийгийн хорхой төрүүлэхийг үзсэн үү? Бид Бурханаар төрсөн Бурханы хүүхдүүд мөн. Бидэнд “Хайртууд минь, бид одоо (хожим тэнгэрт очихоороо биш шүү) Бурханы хүүхдүүд (1Иохан 3:2) гэжээ.

Бид Бурханы хайртай хүүхдүүд байхаас гадна аминч бус зан, болзолгүй хайр, илэрхийлэшгүй баяр хөөр, ойлгогдошгүй амар тайван, ер бусын хүч, эрүүл мэнд, эрч хүч, бүтээлч байдал, тэнгэрлэг цэц ухаан, хурц ухаан, дээд мэдлэг, торгон ухаан гэх мэт үй олон чанарыг харуулах ёстой! Бичээс бидэнд амьдралын тал бүр дээр, төвшин бүр дээр эдгээр чанарыг амладаг. Тэгэхээр би дахиад асууя: “Тэгвэл бид яагаад үүнийг хувьдаа ч, хувьсгалдаа ч харахгүй байна?”

Энэ тэргүүтэй олон асуудлын талаар ярилцахаасаа өмнө би таныг номынхоо агуулгад бэлтгэхийг хүсч байна. Дараагийн хэдэн бүлэг нь жаахан сөрөг, хатуу санагдаж магадгүй. Гэхдээ бид тун удахгүй эцсийн хариултаа сонсох бөгөөд сонсоод тун сэтгэл дүүрэн үлдэхийг би танд амлая.

Ингэж төсөөлье: Эмч дөнгөж үүсч байгаа арьсны хорт хавдрыг оношлоод, бага хэмжээний мэс ажилбараар тайрч авах эмчилгээ бичиж өгсөн нь анхандаа өвчтөнд их сөрөг үйлдэл мэт харагдаж

болох. Тэгээд өвчтөн дотроо: “Яасан муухай юм бэ? Очиж очиж би хавдар тусчих гэж! Ийм муухай юм сонсмооргүй байна. Энэ өвчнөөс салах гэж биеэ огтлуулмааргүй байна. Гэхдээ би амьд явахын тулд эмчилгээгээ хийлгэнэ” гэж бодов. Тэгвэл энэ байдал тэс өөрөөр өрнөсөн бол, яах уу? Эмч нь өвчтөнийхөө асуудлыг хайхралгүй, “зөв сайхан хоолло, тогтмол дасгал хөдөлгөөнтэй бай, хямраад байлгүй өөдрөг бай” гэж зөвлөөд өнгөрбөл, тэр хүний арьсны хорт хавдар ургасаар ургасаар, удалгүй тэрбээр үхнэ.

Бурхан бидэнд дэндүү хайртайдаа, биднийг аргамжааж байгаад, эцэстээ алж ч мэдэх юмсын талаар мэдэн будлиад, дуугүй өнгөрч чадахгүй. Биднийг аргамжааж байгаа юмс нь зүгээр нэг өөдрөг хандлагаар аргалчихаж болдог юмс бус, харин нүүр тулж байгаад, огтлон зайлуулах ёстой юмс гэдгийг Бурхан мэднэ. Бурхан бол бидний эрүүл мэнд, сайн сайхны төлөө санаж сарвайж явдаг ганц Аав минь болой.

Тиймээс дараагийн хэдэн бүлгийг уншихдаа оношлуулж, засуулах ёстой юмс зөндөө гарахыг санаарай. Үүний үр дүнд амьдрал чинь Бичээсийн дүрслэн ярьсан шиг баялаг чанартай болно.

Асуулт

Бурханы хаанчлал бидний дотор байгаа юм бол, яагаад тэнгэрт шигээ газар дээр биелэхгүй байна? Яагаад Шинэ гэрээнээс хавьгүй бага амлалттай, хавьгүй “дорд” гэрээ болох Хуучин гэрээний зарим итгэгч нар биднээс хол аугаа гэрчлэлтэй, биднээс хол илүү амьдарч чадав? Бичээс энэ асуултад ахин дахин хариулсны нэг нь Коринтод бичсэн Паулын захидал болой:

Аливаа хүн өөрийгөө шалгаж байгаад талхыг идэг, аяганаас ууг. Учир нь идэж ууж буй хүн биеийг зөв нягтлалгүй идэж, уувал өөртөө шийтгэл авчирна. Үүнээс болж та нарын дунд сул дорой, өвчтэй нь олон байгаа бөгөөд нэлээд нь нойрсож байна. Бид өөрсдийгөө нягталсан бол шүүгдэхгүй байхсан. Харин бид шүүгдэхдээ ертөнцтэй хамт яллагдахгүйн тулд Эзэнээр сахилгаждаг. (1Коринт 11:28-32)

Тэгэхээр Коринтынхон Эзэний зоогт хүндэтгэлгүй ханджээ. Гэхдээ энэ авир үйлдлээс ургасан үр дагавар нь - олон хүний боддог шиг - зүгээр нэг үл хүндэтгэсэн явдал байсангүй. Тухайн үед Эзэний зоог нь өнөөгийн бидний ёслоод өнгөрдөг үйл явдлаас нилээд өөр байсан буюу бүрэн хэмжээний зоог барих үйл явц байжээ. Гэтэл тэд дуулгаваргүй авирлаж байгаагаа мэдсээр байж, үргэлжлүүлэн үйлдсээр байгаад шийтгүүлснийг бид судлалынхаа явцад олж мэднэ.

Энэ авир үйлдлийнхээ урхагаар тэр хүмүүс доройтох, өвчин тусах, биеэр үхэх гэсэн гурван хор хохирол үзжээ. Тэгэхээр сүүлийн хоёр үр дагавар нь ойлгомжтой байгаа бол, эхнийх нь юу гэсэн үг юм бол? “Доройтох” гэдэг нь хүчээр юмуу баг бөх чанараар дутаж, хүчгүй, дорой болох явдал юм. Энэ ойлголт нь амьдралын тал бүрт хамаатай. Үндсэндээ хүчин чадалдаа хүрэхгүй байхыг л хэлнэ.

Бүгдээрээ Супермэнийг эргэн саная. Криптонит нь ганцхан Супермэнд л үйлчилж, хамаг хүчийг нь сорж, тэнхээ тамирыг нь үхүүлдэг бодис ажээ. Ер нь бол Супермэн ер бусын мэдлэгтэй, ер бусын хурц мэдэрхүйтэй, ер бусын хүчтэй бөгөөд ер бусын гавъяа байгуулдаг атлаа маш тогтуун зан чанартай, харь гаригийн хүчтэн байсан ч, криптонитад нэг өртөхөөрөө, өвдөж, жирийн хүнээс ч дорой болтлоо сульдаад, тэр хэвээрээ удбал үхэх аюулд тулдаг байв.

Тэгвэл элч Паул үндсэндээ чуулганы криптонитыг л оношилжээ. Тэр криптонит нь итгэгч биднийг доройтуулж, тэнгэрлэг мөн чанарынхаа хүчийг гайхуулж амьдрах чадалгүй болгодог ажээ.

Давид хаан нэгэнтээ гэмшээгүй байсан нүглээ улайн: “Учир нь өдөр шөнөгүй Таны мутар намайг хүндээр дарж, шим шүүс минь зуны ганд хатсан буюу” (Дуулал 32:4) хэмээн гашуудсан байдаг. Мессеж Библи дээр “Амьдралын маань хамаг шим шүүс хатжээ” гэдэг. Бас өөр нэг ишлэл дээр: “Миний хүч тэнхээ хилэнцээс минь болж сулран яс минь тамирдав” (Дуулал 31:10) гэдэг.

Иаков: “Тэгээд тачаал нь үр тогтоон нүглийг төрүүлдэг. Нүгэл нь гүйцэд болохоороо үхлийг гаргадаг аж. Хайрт ах дүү нар минь, бүү мэхлэгдэгтүн” (Иаков 1:15-16) гэсэн. Иаков чухам итгэгч хүмүүст өгүүлсэн нь маш тодорхой байна. Тэрбээр биднийг нүглийн хүчинд урхидуулахгүй явахыг анхааруулжээ. Итгэгч хүн нүглийг шийдвэрлэхгүй бол, Супермэн криптонитын эрхшээлд

ордог шиг нүгэлд базуулж, эцэстээ амиа ч алдаж болзошгүй. Дараа нь Паул бидний сүнсний аав болохынхаа хувьд энэхүү сүнслэг криптонитын үр дагаврыг Коринтын чуулганд төдийгүй, бидэнд ч анхааруулан захижээ.

Хатуу сэрэмжлүүлэг

Паулын хатуу үгээс бид нэн түрүүнд анхааруулгыг нь сэтгэлдээ хадгалах ёстой. Паул: “Яг энэ урхагаар та нарын дунд сул дорой, өвчтэй нь олон байгаа бөгөөд нэлээд нь нойрсож байна” гэж хэлээгүй. Өөрөөр хэлбэл тэр бүх гаслан, өвчин, үхэл нь нүглээс болсон гэж хэлээгүй. Итгэгч бид дэлхий дээр жинхэнээсээ, бодитой оршдог чөтгөрийн зэвсэгт хүчинтэй үзэлцэж байгаа учраас, бэрхшээл зовлонтой тулалддаг.

Жишээлбэл, Есүс нэг удаа дагалдагч нартайгаа явж байгаад, төрөлхийн сохор хүнтэй таарчээ. Дагалдагч нар нь: “Хэн нүгэл үйлдсэнээс энэ сохор төрсөн юм бэ? Энэ өөрөө юу? Эцэг эх нь үү?” гэж асуув (Иохан 9:2). Дагалдагч нар тэр хүнийг нүглээс болж л ийм гачаалтай болсон гэж итгэжээ.

Гэтэл Есүс түүнийг аав, ээжийнхээ нүглээс болж сохроогүйг шууд хэлсэн. Есүс дагалдагч нарын худал, буруу сэтгэлгээг газар дээр нь тасар татжээ. Бүх өвчин, доройтол, цаг бусын үхэл нь нүглээс үүдэх албагүй юм.

Иовыг шүүмжилсэн Елифаз, Билдад, Зофар нар ч ийм сэтгэлгээтэй байжээ. Тэд Иовыг нүгэл үйлдсэндээ л зовж байна гэж ялласан (Иов 5:17, 8:4-6, 11:13-15, 22:1-11). Гэтэл Иовыг гай зовлонд өртөхийн яг өмнө Бурхан түүнийг: “Өөлөх өөгүй, зөв шударга агаад Бурханаас эмээж ёр муугаас хол явдаг түүн шиг нь газар дэлхий дээр үгүй” (Иов 1:8) хэмээн сайшаасан байдаг. Иовын зовлон шударга явдал дутагдсантай, нүгэлтэй ямар ч холбоогүй байв. Бурхан хэсэгтээ чимээгүй байснаа, эцэстээ Елифазд: “Та нар Миний тухай зарц Иов шиг минь зөвийг яриагүй тул Миний уур хилэн чиний эсрэг ба хоёр найзын чинь эсрэг дүрэлзэж байна” (Иов 42:7) хэмээн айлджээ. Бурхан хүнийг нүглээс нь болж сахилгажуулж, шийтгэлээ хэмээн амныхаа зоргоор буудах нь Бурханы зан чанарыг ялласан ноцтой хэрэг юм.

Намайг бага залуу итгэгч байхад, хэрэв чуулганы хэн нэг хүнд гай зовлон тулгарбал, түүнийг нүгэл үйлджээ хэмээн хэсэг бүлгээрээ зандалчих итгэгч олон байдаг байлаа. Өнөөдөр ийм сэтгэлгээ зарим газар оршсоор байгаа ч, золоор урьдынх шиг хүчтэй байхаа больжээ. Библийн сургаал, сайн номлолын ачаар чуулган энэ буруу сэтгэлгээнийхээ ихэнх хувиас салж чаджээ. Ийм сэтгэлгээтэй хүмүүс ямар ч мэдрэмжгүй, ялласан, тэр байтугай үзэн ядсан янзтай байдаг. Тэгээд энэ сургаалын гороор зарим хүмүүс итгэлээсээ хагацсан нь хамгийн харуусалтай.

Гэхдээ нөгөөтэйгүүр бид Есүс гучин найман жил зовсон хүнийг эдгээснийхээ дараа түүнд: “Харагтун, чи эрүүл болжээ. Чамд илүү муу юм тохиолдохгүйн тулд дахиж нүгэл бүү үйлд” (Иохан 5:14) гэж захисныг мартаж болохгүй. Тэгэхээр нүгэл зовлонгийн үүдийг нээдгийг Есүс батлан хэлжээ. Есүс тэр хүнд хайртайдаа л, түүний төлөө амиа өгсөн. Есүс түүнийг хайрлан энэрсэндээ л ингэж анхааруулжээ.

Гэтэл бид жинхэнэ хайраар дутсандаа л иймэрхүү сэдвээс булздаг. Бид харгис хатуу, буруушаасан, ялласан алив үйлдлээс зайлсхийх гэсэндээ, эсрэг туйл руу хадуураад, амаа үдчихдэг. Гэтэл бидний дунд Паулын хэлснээр доройтуулж, өвчлүүлж, үхүүлдэг нөхцөл байсаар байна. Энэ хайр мөн үү? Энэ жинхэнэ халамж мөн үү?

Бидэнд бусдад өгөх хариулт нь байсаар байтал, буруу зөрүү сэтгэгдэл төрүүлэхээс айсандаа дуугүй өнгөрдөг. Тиймээс шударгаар хариул: Бидний хайр чухам юун дээр төвлөрч байна? Бид Есүс шиг, Паул шиг чуулганыг хайрласандаа, үнэн байдлыг нь хэлж байна уу? Эсвэл бид өөрийгөө бодсондоо, нэр төрөө хайрласандаа, дагалдагч нараа цөөлөхөөс, буруу сэтгэгдэл төрүүлэхээс, буруу ойлгогдохоос айсандаа дуугүй өнгөрч байна уу?

Миний түүх

Би үйлчлэлээ эхлүүлэхдээ, эргэн тойрныхоо хүмүүсийг зогсоо зайгүй урамшуулдаг, дээд зэргийн өөдрөг хүн байв. Нүүрэлдэж, тулах явдлаас тахлаас зугтахтай л адил зугтана. Заримдаа зайлсхийх арга олж ядсандаа, худлаа тууж, хачин сайхан өөдрөг

үг ярина. Сүүлдээ “Манай Жон Бивэр шиг эелдэг, хайраар дүүрэн залуу энэ чуулганд байхгүй” гэсэн яриа гарч, би ч ийм магтаалд хөлчүүрхдэг болов.

Гэтэл нэг өдөр намайг залбирч байтал, Бурхан надаас: “Хүмүүс чамайг чуулганы хамгийн хайраар баян залуу гэдэг гэл үү?” хэмээн асуулаа.

Би ч: “Тэгдэг, Бурхан минь” гэж хариулахдаа, Бурхан таалж байна гэж бодтол, Ариун Сүнсний дуу хоолойд ямар ч таашаалын өнгө аяс байсангүй.

Миний энэ зовнилыг Ариун Сүнсний удаах үг ч батлав. Тэрбээр: “Хүү минь, чи энэ чуулганы хүмүүст хайргүй” гэх нь тэр.

Би ч мэгдээд: “Юу? Хайртай байлгүй яахав дээ. Тэд ч үүнийг хэлдэг” гэж бувтналаа.

Гэтэл Бурхан: “Чи өөрийгөө ямар учраас өөдрөг, өргөсөн, урамшуулсан үг хэлдгээ мэдэх үү?” гэв.

- “Мэдэхгүй, ямар учраас?”

- “Чи хүмүүсийн дургүйг хүргэхээс айдаг!”

Би ч хэлэх үггүй, гөлийгөөд, нам болов.

- “Чи хүмүүст үнэхээр хайртай бол, тэд чиний үгийг байтугай, чамайг эсэргүүцэж байсан ч, чи тэдэнд үнэнийг хэлэх болно.”

Энэ эгшинд миний амьдрал орвонгоороо эргэв. Тэгээд би газар дээрээ тэс өөр хүн болсон боловч, харамсалтай нь нөгөө туйл руу хадуурчихсан юм. Ингээд би зөвхөн үнэнийг ярьдаг хэдий ч, ямар ч энэрэл мэдрэмжгүй хүн болов. Надад жинхэнэ хайр гэдэг амин чухал орц дутаж байжээ. Би газар газрын жижиг чуулганд зочлон үйлчлэхдээ, хамаг хонийг нь балбаж жанчдаг байв. Одоо эргээд бодохдоо, надад хайр найргүй жанчуулсан хайран хүмүүсийг бас намайг явсны дараа миний тарьсан балагийг эмхлээд үлддэг байсан пасторуудыг санаад, өр өвддөг юм.

2001 онд би Европын нэгэн том цугларалтад үйлчлэв. Хэдэн сарын дараа тэр чуулганы пастор намайг харгис хатуу үгээр хоньдыг жанчдаг гэж нэр нөлөө бүхий олон удирдагчид ярьсан талаар би гурван тивийн эх сурвалжаас олж сонссон юм. Гэхдээ түүний зөв байв.

Энэ цочирдом мэдээ намайг өвдөг дээр минь сөхрүүлсэн юм. Тэгээд би залбирсан - залбирсан гэхээсээ илүү: “Бурхан минь,

намайг хүмүүсийг хайрлах хайр, халуун сэтгэлээр дүүргээч” гэж урьд хожид гуйж байгаагүйгээрээ орь дуу тавин, хашхирсан юм. Тэгтэл Бурхан ч хариулав. Тийнхүү би үйлчилж буй хүмүүсээ үнэн голоосоо хайрлана гэж юу байдгийг амьдралдаа анх удаа ойлгож ухаарав.

Зарим нь бус, олонх нь

Нэг зүйлийг санаж яваарай: Паул Коринтын чуулганыг үнэн голоосоо хайрладаг байсан. Үүнийг нь ч: “Яагаад? Би та нарыг хайрладаггүй учраас уу? (Хайртай гэдгийг) Бурхан мэднэ” (2Коринт 11:11) гэдэг үг нь гэрчилнэ.

Захидлынхаа өөр нэг хэсэг дээр Паул: “Та нарыг гашуудуулья гэсэндээ бус, харин надад байгаа та нарын төлөө гэсэн хайрыг та нарт мэдүүлэхийн тулд үлэмж зовлонгоос, бачимдах зүрхнээсээ би нулимс унаган та нарт бичсэн юм” (2Коринт 2:4) гэдэг. Тэр чуулган Паулыг буруугаар ойлгожээ. Тэд Паулын засал, сэрэмжлүүлгийг хатуурхал гэж үзсэн бөгөөд ийм явдал чуулганд ч, байгууллагад ч тохиолддог. Над мэтийн жинхэнэ хайр, халамж, халуун сэтгэлээр дутмаг, чанга, ширүүн, хатуу хүмүүс олон бий. Ийм хүмүүс хүчтэй царайлж, том том ярив ч, өөрөө л зөв байх гэсэн ганц сэдэлтэй байдаг. Иймэрхүү гажуудсан эрх мэдлээс болж олон хүн хохирдог. Гэхдээ тэглээ гээд жинхэнэ засал, сэрэмжлүүлгийг энэ мэтэд тооцож хэрхэвч болохгүй. Паул үе үе засч, зэмлэсэн хатуу үг хэлдэг байсан ч, үүнийгээ халуун хайрынхаа улмаас л хийдэг байсан юм.

Тэрбээр: “Би та нарын сүнсний төлөө ихэд баяртайгаар зарж үрэх бөгөөд өөрийгөө ч гэсэн үрэх болно. Хэрэв би та нарыг илүү хайрлавал өөрөө бага хайрлагдах уу?” (2Коринт 12:15) гэжээ. Паулын сэтгэлийн гуниг ил байна. Тэр хүмүүс өөрсдийнх нь сайн сайхны төлөө гэсэн Паулын сэтгэл зүрхийг ойлголгүй, түүнийг хүмүүсийг атгах санаатай, хатуу харгис удирдагч хэмээн зоргоороо дүгнэжээ.

Паул тэднийг үнэн голоосоо хайрласандаа л, юунаас болж тэдэн дундаас олон хүн доройтож, өвчилж, зуурдаар үхэж байгааг хатуу хэлжээ.

Уг нь Паул “зарим нь” гэж хэлсэн бол, залгихад арай л амар

байв. Гэтэл Паул “олонх нь” гэж хэлжээ. Бид түүний хэлсэн үнэнээс яаж булзах вэ? Хэрэв энэ үг Коринтын чуулганд хамаатай байсан юм бол, бидэнд ч бас хамаатай бус уу? Энэ бидэнд хамаагүй явдал байсан бол, Бурхан үүнийг Бичээст багтаана гэж үү? Энэ өнөөгийн бидэнд хамаагүй гэж үү? Үүнд ямар ч эргэлзээгүй “хамаатай” гэж хариулна.

Эцэст нь: Паул зүгээр нэг чуулган нэртэй байгууллагад зохион байгуулдаг Эзэний зоог гэдэг ёслолын талаар яриагүй юм шүү. Тэрбээр маш жинтэй үг хэлсэн атал олон хүн - тэр тусмаа би - түүний үгийн гол санааг гээчихдэг. Бид Паулын үгийн утгыг дараа дараагийн бүлгээрээ илүү тайлж ойлгоно.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Та ямар боломжтой хэн болохоо өөртөө дахин нэг сануулахын тулд бүлгийнхээ эхэн хэсгийг давтан уншина уу. Таны талаар “Үүгээр шүүлтийн өдөр биднийг зоригтой байлгахын тулд хайр нь бидний дунд төгс болов. Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг” (1Иохан 4:17) хэмээн мэдэгдэсэнийг санаарай. Бурхан таныг дараагийн амьдралдаа бус, чухам энэ амьдралдаа Есүс шиг амьдруулахаар дуудсаныг бүү мартаарай.

Энэ үг таны өдөр тутмын амьдралдаа хандах арга байдлыг чинь хэрхэн өөрчилж байна? Магадгүй та Христ дотор ямар хүчин чадалтай хүн болохоо олж мэдэхээсээ өмнө өөрийгөө сул дорой хүн гэж бодож яваагүй байх. Тэгвэл Христийн доторх хүчин чадлаа мэдэж авсныхаа дараа та өөрийгөө хүчтэй хүн гэх үү, сул дорой хүн гэх үү? Сул дорой хүн гэж хариулбал, та цэц ухаантай хүн аж. Учир нь биднийг сул дорой үед Бурханы хүч хамгийн сайн ажилладаг болохыг Бурхан айлдсан юм (2Коринт 12:9).

Бид Бурханы өмнө өөрийгөө даруу болгосон цагт л Бурхан бидний сул дорой байдлыг хүч чадал болгон хувиргана (1Петр 5:5). Амьдралд чинь ямар нэг сул дорой байдал байгаа бол, шалтгааныг нь Бурханаас асуу. Тэдгээрийг нэг бүрчлэн бичиж байгаад, нэг бүрээс нь чөлөөлөгдөхийн төлөө залбир. Сул дорой байдал бүрийг хүч болгон хувиргах Бурханы зааврыг нэг бүрчлэн бичиж тэмдэглэж аваарай.

3

НЭГ

Паул хайртай чуулгандаа юу гэж хэлснийг дахин нэг харцгаая:

Аливаа хүн өөрийгөө шалгаж байгаад талхыг идэг, аяганаас ууг. Учир нь идэж ууж буй хүн биеийг зөв нягтлалгүй идэж, *(Христийн биеийг хүндэтгэлгүйгээр)* уувал, өөртөө шийтгэл авчирна. Үүнээс болж та нарын дунд сул дорой, өвчтэй нь олон байгаа бөгөөд нэлээд нь нойрсож байна. Бид өөрсдийгөө нягталсан бол шүүгдэхгүй байхсан. (1Коринт 11:28-31)

Энэ бүлгээрээ бид Паулын “Христийн биеийг хүндэтгэлгүйгээр” гэж хэлсэн үг дээр төвлөрнө. Миний бие юуны түрүүнд хоёр сонирхолтой зүйлийг цохон тэмдэглэмээр байна: Нэгдүгээрт - Паул хувь хүнд хандаж ярьсан бус, харин тэр чуулганд хамрагддаг хүн бүрт буюу Коринт хотын итгэгчдийн нийгэмд хандаж ярьжээ.

Өнгөрөгч хэдэн арван жил бид Есүс Христтэй тогтоох хувийн харилцааны талаар маш их ярьлаа. Энэ бол Христэд итгэх итгэлийн маш чухал бөгөөд бодитой тал гэдэг нь яриангүй үнэн. Гэвч бид нэг бие байх, нэгдмэл бодит байдлыг яг ижил төвшинд авч үздэггүй. Товчхондоо бид Христийн дотор нэг болой. Энэ хоёр үнэний нэгийг нь авч, нөгөөг нь няцаалгүйгээр, аль алийг нь хараандаа байлгах нь чухал юм.

Хоёрдугаарт - ЭнКэйЖэйВи Библи Паулын үгийг арай өөрөөр орчуулдаг. Тухайлбал олон хүн “Эзэний биеийг тунгаан

шүүвэрлээгүйгээсээ болоод” сул дорой, өвчтэй болж, зуурдаар үхэж байна (29-ээр ишлэл) гэдэг. Бид аль аль хувилбарыг нягтлан судалснаараа, Паулын үгийн цаад ухааныг тодорхой ойлгож авна.

Ухаарч мэдэхийн тулд бүгдээрээ Израильчуудын Египетийн дарлалаас чөлөөлөгдөн гарсан түүх, тэдний цөл дэхь амьдралын талаар Паулын хүүрнэсэн 1Коринт номын бүлгийг үзэцгээе. Паул яриан дундаа: “Энэ бүхэн жишээ болон тэдэнд тохиолдсон бөгөөд үүнийг үеийн төгсгөл тохиож буй бидэнд *сануулга* болгон бичжээ” (1Коринт 10:11) хэмээн эл түүхийг хүүрнэсэн гол зорилгоо тодорхой хэлжээ. Паул зүгээр нэг түүхэн хичээл заагаагүй, харин биднийг аливаа шүүхээс хамгаалахын тулд сэрэмж сануулга болгосон байна.

Элч маань цөл дэхь Израилийн амьдралын талаар ярихдаа, юуны түрүүнд Бурхантай тогтоосон гэрээт харилцааг нь дүрсэлжээ. Тэрбээр “*бүгд* Бурханы Сүнсээр (үүлээр) хөтлүүлж, *бүгд* (дэлхий ертөнцийн төлөөлөл болсон) Египетээс чөлөөлөгдөж, *бүгд* баптисм хийлгэж (бид нэг бие рүү баптисм хийлгэсэн), *бүгд* ижилхэн сүнслэг хоол идэж, *бүгд* (Бурханы Үг болох) ижилхэн сүнслэг ус уусан” гэжээ. Энд *бүгд* гэдэг үгийг чухалчилсан байгааг хэн ч харахаар байна. Израильчууд бүгд нэг бие мэт байж, бултаараа гэрээгээ сахин биелүүлдэг Бурханд харъяалагдаж байсныг л Паул тодорхой хэлжээ. Энэ бүхэн нь Христийн бие болсон бидэнд нэгийг хэлж байна.

Гэтэл дараа нь Паул элэг эмгэртмээр мэдэгдэл хийв: “Гэсэн ч тэдний олонх нь Бурханы таалалд нийцээгүй тул цөлд хиарсан юм” (1Коринт 10:5). Биднийг хайрлах Бурханы хайранд бидний ухаан хүрэхгүй. Үнэндээ биднийг юу ч хийж байсан, биднийг хайрлах Бурханы хайр нэмэгдэх ч үгүй, хорогдох ч үгүй. Тийм боловч Бурханы хайрыг дааж, Түүнд таалагдаж амьдрах нь бидний үүрэг мөн (2Коринт 5:9). Энэ нь итгэгч та бидний эрхмийн дээд зорилго билээ.

Яагаад Хуучин гэрээний тэдгээр хүмүүс өөрсдөд нь өгсөн Бурханы хүслээс гажиж үхэх болов? Паул тэднийг унахад хүргэсэн таван нүглийг тоочжээ: тачаадах (Бурханы бус юмд эсвэл Бурханы хангамжаас гадуурх аливаа юмд шунан дурлах), шүтээн шүтэх, бэлгийн ёс бус явдал, Бурханыг сорьж шалгах, гомдоллох. Хэдэн ишлэлийн хойно Паул:

Ухаалаг хүмүүст хэлдгийн адил би хэлье. Хэлснийг минь та нар шүүцгээ. Бидний ерөөдөг ерөөлийн аяга нь Христийн цусан доторх оролцоо биш үү? Бидний хугачдаг талх нь Христийн бие доторх оролцоо биш үү? Талх нэг тул бид олуулаа ч нэг бие. Учир нь бүгд нэг талхнаас хуваалцдаг. Махбодын дагуух Израилийг хар. Тахилаас идэгчид нь тахилын ширээн дээрхээс хуваалцагч биш үү? (1Коринт 10:15-18) хэмээн өгүүлжээ.

Паул энд мөн л Эзэний зоогийг барих талаар өгүүлсэн боловч: *Эзэний биеийг тунгаан шүүвэрлэлгүйгээр* хэмээн 1Коринтын 11-ээр бүлэгт дурьдсан тодорхой асуудлаа хавьгүй том хэмжээтэй зураглажээ. Паул биднийг олуулаа буюу Есүс Христээр дамжин Бурхантай хувийн харилцаа тогтоосон янз янзын хувь хүмүүс болохыг маань хүлээн зөвшөөрчээ. Гэхдээ өөр нэг төвшинд аваад үзбэл, Бурханы мэлмийд бид нэг ажээ. Энэ бол Паулын хэлэх гэсэн хамгийн гол санаа. Бид Христийн нэг бие, бид цөлд байсан Израиль шиг л *нэгдмэл* юм.

Тиймээс бид одоо: “Сул дорой байдал, өвчин, зуурдын үхлийн шийтгэл нь нүгэл үйлдсэн хүмүүс дээр л буусан шийтгэл байв уу эсвэл чуулганы зарим нэг гишүүний авир үйлдлийн үр дагаварыг Коринт дахь Христийн бие бүхлээрээ үүрэв үү?” гэдгийг асуух ёстой. Намайг буруу ташаа бүү ойлгоорой. Хувь хүн нүгэл үйлдэх аваас үүнийхээ үр дагаварыг гарцаагүй хүртэнэ гэдгийг би өөрөө ч хатуу анхааруулдаг. Гэхдээ энэ удаа бид Паулын илчлээд байгаа үнэн дээр л тогтох ёстой юм. Харин Паул итгэгч хүмүүсийг нэгэн бие, нэгэн чуулган, нэгдмэл нэгэн хүмүүс гэдэг утгаар нь яриад байна.

Энэ тохиолдолд Коринт хотынхоныг Христийн нэг цул бие гэж үзжээ.

Нэгэн хүний тачаал

Тэгэхээр бидэнд сургамж болгосон Израильчууд руугаа эргэж орьё. Гэхдээ хойшоо нэг үе ахин, Иошуагийн удирдлага дор яваа хүмүүсийг авч үзье. Итгэгчдийн бие эрэлхэгээр Иордан голыг гаглаад, амлагдсан газраа зорьжээ. Тэгээд хамгийн түрүүнд

Иерихо гэгч нүсэр том хотыг арчих асар том даалгавар хүлээн авав. Аймшигтай даалгавар гэдэг нь эргэлзээгүй. Гэхдээ Бурхан дахиад л аугаа хүч чадлаа гайхуулах нь яриангүй байв. Бурхан Иошуд маш тодорхой заавар өгсөний дунд:

Хот болон түүн доторх бүх юмс нь ЭЗЭНийх. Энэ хот хориг цээр дор байх болно. Бидний явуулсан элч туршуулуудыг нуусан янхан эм Рахаб болон түүнтэй хамт гэрт нь байгаа бүх хүн л амьд үлдэнэ. Харин та нарын хувьд гэвэл, хориг цээртэй зүйлсэд шунаж тэдгээрээс аваад Израилийн хуаранг цээрлэлд хүргэж, түүнд лай тарихаас сэрэмжил. Харин бүх мөнгө, алт, мөн хүрэл ба төмөр эд зүйлс нь ЭЗЭНд ариун билээ. Тэр нь ЭЗЭНий эрдэнэсийн санд орох ёстой (Иошуа 6:17-19) гэсэн тухаал байв.

Иерихогийн олз тэр чигээрээ Эзэний сан хөмрөгт орох учиртай байв. Тэдгээр нь хувь хүмүүсийн олз ашиг бус, гагцхүү Эзэнийх байжээ.

Эзлэн тулааны өдөр Израильчууд ялагдашгүй байв. Тэд илдний ирээрээ тэр хотын эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгшид, хонь, ямаа, илжиг зэрэг амьтай голтой бүхнийг юутай хийтэй нь бүгдийг нь хүйс тэмтрэв. Тэгээд Эзэний сан хөмрөгт орох ёстой алт, мөнгө, хүрэл, төмрөөс бусад бүх зүйлийг түйрэмдэв. Тэнд нэг ч Израиль хүн алуулах нь бүү хэл, шалбараа ч үгүй нь ёстой л гайхамшиг юм.

Энэ бол нөгөө тэдний эцгүүдийн үед буюу Мосегийн үед тэр газрыг танадаад ирсэн туршуулууд: “Гэхдээ тэр нутагт амьдарч буй ард түмэн нь хүчирхэг, хотууд нь бэхлэгдсэн агаад маш том юм” (Тооллого 13:28) хэмээн Мосед тайлагнаж байсан тэр хот гэдгийг бид санах ёстой. Гэтэл тэдний үр хүүхэд эрийн цээнд хүрээд, өдгөө Иерихо хотыг ямар ч гарз хохирол үзэлгүй, үнсэн товрог болгосон нь энэ ажээ. Израиль ер бусын хүчийг олжээ. Гэтэл дараа нь ийм явдал болов:

Гэвч *Израилийн хөвгүүд* хориг цээртэй зүйлсийн тухайд итгэл эвдэв. Иуда овгийн Зерагийн гуч, Забдийн ач, Кармийн хүү Ахан хориг цээртэй зүйлсээс авчээ. Иймээс ЭЗЭНий уур хилэн *Израилийн хөвгүүдийн* эсрэг дүрэлзэв. (Иошуа 7:1)

Бичээс “Гэвч Ахан гэгч нь зааврыг зөрчив” гэж хэлэлгүй, харин “Израилийн хөвгүүд зааврыг зөрчив!” хэмээн айлдсан байгааг анхаарна уу. Түүнчлэн “Эзэн Аханд аймаар уурлав” гэж хэлэлгүй, харин “Израилийн хөвгүүдэд уурлав” гэж мэдэгдсэн нь тун гайхалтай. Израиль нэгдмэл нэг болсон учраас, нэг нь сувдаглан, Бурханы зааврыг зөрчсөн нь даяар Израилийг ялд унагажээ.

Харин хор уршиг нь төд удалгүй ил болдог. Израиль дараа нь Аи хотыг эзлэх ёстой байв. Аи хот нь хавьгүй жижиг хот байсан тул удирдагч нь: “Бүх ард олныг бүү явуул. Харин хоёр юмуу гурван мянга орчим хүн явуулан Аи хотыг цохиул. Тэд цөөхүүлээ учраас бүх хүмүүсээ тэнд бүү туйлдуул” (Иошуа 7:3-4) гээд, ойролцоогоор 3,000 цэрэг илгээжээ.

Эндээс бид Аи нь хамаагүй жижиг хот болохыг харж байна. Учир нь Иерихогийн тулаанд 600,000 гаруй цэрэг байлдсан байдаг. Гэтэл ийм явдал болжээ:

Ийнхүү ард олноос гурван мянга орчим хүн тийш очсон боловч Аин эрчүүдээс тэд зугтаав. Аин эрчүүд тэднээс гучин зургаа орчим хүнийг алж, тэднийг гулдан хаалганаас Шебарим хүртэл нэхэн хөөж, бэл газарт тэднийг хороов. Тиймээс ард олны зүрх үхэж, шалдаа буув. (Иошуа 7:4-5)

Энэ чинь нөгөө Иерихо хэмээх хавьгүй том, хүчирхэг хотыг ширхэг ч гарз хохиролгүй газрын хөрстэй нялсан улс мөн биз дээ? Гэтэл Аи хэмээх алгын чинээхэн хотын өмнө суларч, ухарч, далан таваараа буугаад өгөв гэнэ. Өөрөөр хэлбэл тэд криптонитад оногджээ.

Үүгээр барахгүй хамгийн эмгэнэлтэй нь хайран гучин зургаан хүнээ алдав. Гэтэл Иериход нэг нь ч доройтоогүй, нэг нь ч ухраагүй, нэг нь ч шархдаагүй, нэг нь ч алагдаагүй!

Бод доо: Ахан гэм хийсэн атал, тэр өөрөө ч, гэр бүл нь ч яагаа ч үгүй. Гэтэл Аигийн тулаанд ямар ч гэм нүгэл үйлдээгүй, гэм зэмгүй далан хоёр аав ээж хонгор хүүгээ, гучин зургаан эхнэр хань ижлээ, олон хүүхдүүд хайртай ааваа алджээ. Өөр нэг хүний гэр бүлээрээ үйлдсэн гэм нүглээс болж тэр!

Израилийг айдас нөмрөв. Иошуа тэргүүтэй удирдагч нар Бурханы өмнө нүүрээрээ хөсөр унав. Төсөөлж байна уу? Тэд уймарч, эргэлзэхдээ: “Аяа, БУРХАН Эзэн, юунд Та энэ ард олныг

Иорданыг гатлуулан авч ирэв? Зөвхөн аморичуудын гарт биднийг өгч устгуулахын тулд гэж үү?” (Иошуа 7:7) хэмээн халаглан, халаглан дуу тавьжээ. Тэгтэл Бурхан юу айлдсаныг үз: “Өндийн бос. Юунд чи нүүрээрээ унаад байна вэ? Израиль нүгэл үйлдэж, Миний тэдэнд тушаасан гэрээг минь тэд бас зөрчсөн” (Иошуа 7:10-11).

Бурхан: “Та нарын нэг чинь нүгэл үйлдэв!” гэж хэлээгүй, харин “Израиль нүгэл үйлдэв!” хэмээн мэдэгджээ. Ахан юу хийснийг хэн ч мэдээгүй. Түүний сувдаг явдалд хэн ч оролцоогүй. Гэтэл сүнслэг криптонитын хор уршгийг бие бүхлээрээ үүрчээ. Иошуа хэргийн эзнийг илрүүлээд, Ахантай нүүрэлджээ:

Тэгэхэд нь Ахан Иошуад хариулсан нь — Үнэхээр би Израилийн Бурхан ЭЗЭНий эсрэг нүгэл үйлдсэн. Миний хийсэн хэрэг гэвэл олзон дотор Шинарын гоёмсог өмсгөл, хоёр зуун шекел мөнгө болон тавин шекел жинтэй алтан гулдмай байхыг би үзээд, шунахайрч авсан. Үзэгтүн, тэдгээр зүйлс миний майхан дотор газарт булаастай, доор нь мөнгө нь байгаа гэв. (Иошуа 7:20-21)

Иошуа тэргүүтэй удирдагч нар Аханы хэргийг шуурхайлан шийдсэн бөгөөд үүний дараа “ЭЗЭН нүүр буруулахаа больж, Түүний догшин уур хилэн намдав” (Иошуа 7:26) гэдэг.

Жишээ

Хуучин гэрээний энэ явдал нь Коринтын чуулганд хандсан Паулын үгийг дүрслэж байна. Паул: “Үүнээс болж та нарын дунд сул дорой, өвчтэй нь олон байгаа бөгөөд нэлээд нь нойрсож байна” гэж бичсэн. Хэн нэг хүний үйлдсэн гэм нүгэл нь тухайн хэрэг явдалд хамаатай хувь хүмүүст төдийгүй, даяар чуулганд хэрхэн нөлөөлдгийг бүгдээрээ дараагийн бүлгээрээ сурна.

Өнөөдөр чуулганд яагаад үй олон итгэгч байнга л эмгэг өвчиндөө баригдаж, дорой буурай явдаг талаар та ер нь бодож байв уу? Тэдгээр сайн сайхан хүмүүс өвчнөөсөө эдгэхгүй явсаар, зарим нь бүр зуурдаар үхдэг. Яагаад бидний хүрээлэлд тусламжийн хоол хүнсээр өл залгуулж яваа, өрх толгойлсон ээж

ийм олон байна? Яагаад засгийн газраасаа халамж, хувь хишиг горьдсон, ажил төрөлгүй итгэгч ийм олон байна?

Энэ мэт үй олон тал дээрээ бид ялагдал хүлээн, дорой буурай амьдарч явна.

Соломоны цагт ажил төрөлгүй юмуу эсвэл халамжаар амьдардаг хүн ширхэг ч байгаагүй. Үйлс ном дээр хүмүүс юугаар ч дутаагүй гэдэг бөгөөд хүмүүс өвчин, эмгэг, доройтлоосоо газар дээрээ эдгэрч байсан гэдэг. Тэгвэл өнөөдөр яагаад ийм явдал болохгүй байна? Хэн нэгнийх нь гэм нүгэл бусдынхаа амьдралыг доош нь татаад байгаа юм биш биз? Аи хотод Израильд тохиолдсон шиг зүйл бидэнд тохиолдоод байгаа юм биш биз?

Мэдээж хүн өөрийнхөө үйлдсэн гэм нүглийн горьг амсах нь гарцаагүй гэдгийг би дахиад хэлмээр байна. Ахан эцэстэй аймшигтай шийтгүүлсэн. Тийм боловч түүний гэм нүглээс болж даяар Израиль сүнслэг криптониттай тулгарсан юм. Номоо цааш судлах тусмаа, та нэгэн цул биеийн нэгээхэн салшгүй хэсэг мөн гэдгээ ойлгож, үйлдсэн зүйл чинь биеийн бусад хэсэгтээ ерөөл юмуу хор хохирол авчирдаг гэдгийг мэдэх ухаарал чинь улам бүр зузаарч, Есүстэй хувьчлан тогтоосон харилцаа шиг чинь бэхжээсэй гэж үнэн голоосоо найднам.

Бүлгээ дуусгахаасаа өмнө нэг зүйлийг дахин хэлмээр байна. Эрх чөлөөнд хүргэх үнэний асуудлыг шийдвэрлэх нь гэдэн хөдөлгөсөн, сөрөг ажил шиг санагддаг. Тиймээс хүмүүс: “Яагаад заавал энэ тухай ярих ёстой юм бэ?” гэж өрвөгнөнө. Гэхдээ эцсийн эцэст үнэн ил гарахдаа, өмнөх саадуудыг таягдан, зам гаргаж, эрх чөлөө авчирдаг.

Есүс: “Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө” (Иохан 8:32) гэсэн.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Та *Гладиатор* гэдэг сайхан киног үзсэн бол, генерал Максимус: “Нэг хүн мэт нэгдмэл бай!” гэж хашхирдгийг санаж байгаа байх. Түүний энэ стратеги ч ялалт авчирдаг. Хувааж, эзлэх нь цэргийн хамгийн үр дүнтэй стратеги байдаг нь хэнд ч нууц биш юм.

Есүс ч үүнийг маш сайн мэдэж байсан учраас, дотроо хагаралдсан айл оршин тогтнохгүй” (Матай 12:25) хэмээн заасан

буюу. Христийн бие Христэд үнэнч байж чадахгүй бол, бүхлээрээ доройтно. Хэрэв хүн бүр дор бүрнээ өөрийгөө хичээж, Есүст бүрэн үнэнчээр зориулагдбал, даяар чуулганы даян дэлхийд үзүүлэх үр нөлөөлөлд хамгийн аугаа хувь нэмэр болно гэсэн үг. Өөрөөр хэлбэл өдөр тутмын тогтмол үйл хэргээ Бурханд зориулж, Түүнийг зүйл бүрээр хүндэтгэж явах.

Бурхан таны Бүтэн сайны өглөөний хоёрхон цагийг хүсдэггүй, харин бүхий л амьдралыг чинь хүсдэг. Хэрэв та ажил, гэр, сонирхол зэрэг бүхий л амьдралаараа Бурханыг хүндэтгэхгүй яваа бол, өнөөдөр гэмш. Бурханыг хүндэтгэсэн амьдрал гэж юу байдгийг Есүсээс асуу. Түүний харуулж, хэлсэн зүйлийг бичиж тэмдэглээд, Түүнд амьдралаа дахин шинээр бүрэн зориулахад чинь Өөрөөрөө дүүргэхийг Ариун Сүнснээс гуй.

4

ХАЛДВАРТ КРИПТОНИТ

Ингэснээр биед хагарал үгүй, харин эрхтнүүд нь бие биендээ адилхан халамжтай байх юм. (1Коринт 12:25)

Таны биеийн бүх хэсэг хоорондоо шууд биш юмаа гэхэд, дам хэлбэрээр заавал холбоотой байдгийг бодоод үз. Хөлийн чигчий - хамар чинь холбоотой, элэг - өвдөг чинь холбоотой, ам - нурууны яс чинь холбоотой. Биеийнхээ бусад хэсэгтэй ямар ч холбоогүй, бие даасан эрхтэн хүнд байхгүй. Байгаа бол тэр чинь таны биеийн нэг хэсэг байж чадахгүй.

Нэг эрхтэн өвдөхөд, бусад бүх хэсэг нь дагаад шаналдаг бус уу? Хүн ханиад юмуу аль нэг нянгийн халдвар авахад л, төд удалгүй хоолноос гарч, сульдаж, толгой нь хагарах дөхөж, хамаг бие нь янгинана. Нөгөөтэйгүүр биеийн аль нэг хэсэг алдаршихад, бусад бүх эд эрхтэн нь баясдаг. Хүн нуруугаа юмуу толгойгоо нэг сайхан бариулж, иллэг хийлгэхэд, хамаг бие нь тавирч, таашаал авдаг. Биед таатай байна гэсэн үг.

Чуулган бид нэг юм. Аханы санаатай нүгэл өөрийг нь төдийгүй, бидний хувьд үлгэр жишээ болсон, нэгдмэл нэг Израилийг бүхлээр нь хорложээ. Иерихотой ялагдашгүй мэт тулалдсан Израилийн хүчирхэг арми маань хэдэн өдрийн дараа алийгаа алдаж, дайснаасаа зугтаж, аймшигтай гарз хохирол үзэж, цэвэр ялагдсан. Зүйрлэх юм бол, тэр үндэстэн бүхлээрээ сүнслэг

криптонитын эрхшээлд оржээ. Коринтын чуулганд яг ийм зүйл тохиолдсон уу? Жаахан нарийн шалгабал, хариулт нь гарч ирнэ.

Эртний чуулган Эзэний зоогийг өнөөгийн биднийхээс тэс өөрөөр барьдаг байсныг өмнө хальт дурьдсан. Бид ёслол төдий үйлддэг бол, тэд бүрэн хэмжээний зоог барьдаг байжээ. Тиймээс Паулын яриад байгаа, тэдний онцгой зан үйлдэл нь өнөөгийн бидэнд тулгардгаас нилээд өөр ажээ. Гэхдээ гол асуудал нь тэдний гаргасан авир үйлдэлд биш, харин түүний цаадах үндэсд оршиж байгаа юм.

Коринтын чуулганы зарим хүмүүс бусад гишүүдээ цуглахыг хүлээдэггүй байсан нь тэдний гол асуудал байв. Эрт ирсэн нь хамгийн тансаг идээ цагаа, дарс зооглож, харин хожуу ирсэн хүмүүс нь шавхруу дээр нь шахуу буудаг байж. Ер нь бол ядуу зүдүү, доод ангийнхан л ад шоо үзэгдэж байсныг Библийн олон эрдэмтэн, түүхч нар хэлдэг. Одоо Паулын үгийг уншицгаая:

Учир нь идэх болоход хүн бүр (*зарим нь*) өөрийн хоолыг урьтаад авчихдаг бөгөөд нэг нь өлсөж байхад нөгөө нь согтуурч байна. ... Учир нь идэж ууж буй хүн биеийг зөв нягтлалгүй идэж, увал өөртөө шийтгэл авчирна. Үүнээс болж та нарын дунд сул дорой, өвчтэй нь олон байгаа бөгөөд *нэлээд* нь нойрсож байна. (1Коринт 11:21, 29-30)

Дээрх Бичээсээс ташуулдуулж тодруулсан “*зарим, нэлээд*” гэдэг хоёр үгийг харна уу. Тэгэхээр Паул *зарим нэгнийх* нь хийсэн нүглээс болж (21-ээр ишлэл) *олон хүн* доройтож, өвчилж, зуурдаар үхэж байгаа тухай л ярьжээ. Энэ нь Аханы түүхээс ялгарах юм алга. Нэг хүний илэрхий дуулгаваргүй явдлын үр дагаварыг тэнгэрлэг зааврыг зөрчих ямар ч санаагүй хэсэг бүлэг хүмүүс үүрчээ.

Пилларын Шинэ гэрээний тайлбар дээр:

“Өвчин тусч, зуурдаар нас барсан талийгаачдыг л нүгэл хийж явж, үхжээ гэж давшилж болохгүй. Харин Хуучин гэрээнд тэнгэрээс шийтгэл буухдаа, нийгмийг тэр аяар нь ташуурддаг байсантай адил, энэ гамшиг ч бас нийгмийг бүхлээр нь хамарсан бөгөөд үүнд гэмгүй хүмүүс ч шударга бусаар өртжээ гэж үзэх ёстой” гэдэг.

Төстэй явдал

Паул урьд өмнө захидалдаа бас л ялгаагүй нийгэмд хор хохирол учруулж байсан өөр нэг нүглийн асуудлыг хөнддөг. Тэрбээр: “Харийнхны дунд ч байдаггүй садар самуун та нарын дунд байдаг нь дуулдлаа. Нэг чинь эцгийнхээ эхнэртэй нөхөцдөг гэнэ” (1Коринт 5:1) гэжээ. Энэ удаа өөрийгөө Есүс Христийн дагалдагч гэдэг - Бурханы хүү, Христийн доторх ахан дүү, Христийн биеийн нэг хэсэг болох нэгэн эрэгтэй хүн бэлгийн нүгэл үйлджээ.

Паул ч дан ганц тэр хүний нүглийг зэмлэж зассангүй. Чуулганы удирдлага тэр хүнийг ахан дүүгээ, нэгэн гишүүнээ гэж тооцдог атлаа түүний нүглийг шийдвэрлэлгүй, нүдээ тас аньжээ.

Тэд яагаад тэр хүний зан үйлдэлд нүдээ анив? Магадгүй, асуудалтай нь нүүрэлдүүлж, гомдоохыг хүсээгүй байх. Магадгүй тэр хүн нэр нөлөө бүхий хүн, нийгмийн удирдагч, нэртэй тамирчин, ивээн тэтгэгч байсан ч юм уу. Коринт чинь урлаг соёлын төв болсон, нэр нөлөөтэй, том хот байсан шүү дээ. Магадгүй Коринтынхоо “Колливүүдийн” алдартай жүжигчин ч юмуу эсвэл хит дуутай нэртэй дуучин ч юмуу эсвэл магтаалын багийн урдаа барьдаг ганц дуучин ч байсан юм уу. Бичвэр дээрээ яг ийм, тийм гэж хэлээгүй боловч, ямар ч байсан тэр хүн явчихбал, чуулган түүгээр их л дутах байсан болтой гэмээр санагдана.

Магадгүй өөр шалтгаантай ч байж мэднэ. Түүнийг явуулчихбал, тэр Бурханы Үгийг сонсохоо больчихно ч гэж бодсон байж болох. Тэд түүнийг “Сайн мэдээгүй дэлхий рүү явуулж байснаас, өөрийнхөн дундаа байлгаж, Сайн мэдээг сонсгож байсан нь дээр” гэж үзсэн ч байж болно. Эсвэл тэр чуулганы гол зорилго нь хүмүүсийг цуглаанд ирүүлэх байж. Тиймээс хүмүүсийн нүглийг хамаа намаагүй сөхөж, гомдоогоод байвал, тэдний хамаг зорилго нурах гээд байсан байх. Эсвэл тэд магадгүй бүр: “Тэр чинь нялх итгэгч. Жаахан цаг хугацаа өг” гэж бодсон байх. Ямар ч байсан, тэд түүнийг эцэстээ “ухаан сууж”, нүглээ хаяна гэдэгт үнэхээр найдсан болтой.

Гэтэл Паул тэр хүнийг хөөхийг Коринтын чуулганы удирдлагаас хатуу шаарджээ. Яг юу гэж хэлснийг нь жагсааж үзье:

- Та нар түүнийг нөхөрлөлөөсөө зайлуулах ёстой (1Коринт 5:2).
- Та нар түүнийг гаргаж хаях ёстой (1Коринт 5:5).
- Дундаасаа ёрын муу хүнийг зайлуулснаараа, хуучин “хөрөнгөөс” сал (1Коринт 5:7).
- Дундаасаа ёрын муу хүнийг зайлуулах ёстой (1Коринт 5:13).

Паул нэг жижиг бүлгийн дотор дөрвөн тэсэлгээ хийв! Бод л доо. Элч маань тэр этгээдийг чуулганаасаа зайлуулахыг дөрвийн дөрвөн удаа - нэг удаа бүр “Түүнийг гаргаж хая!” хэмээн түс тас мэдэгдэн, хатуу тушаасан байна (арван гуравхан ишлэлийн дотор шүү). Аймшигтай хатуу үг! Гэхдээ Паул тэр чуулганд ч, тэр хүнд ч хайртай гэдгийг санаарай!

Та: “*Паул тэр хүнд хайртай гэж үү? Ай мэдэхгүй!*” хэмээн сэрдэж болох. Гэхдээ Паул түүнд хайртай гэдэгт эргэлзэх хэрэггүй. Яагаад гэвэл Бичээс дээр бичигдсэн бүхэн хайрын сэдлээр л бичигдсэн бөгөөд өөрөөр ч байх аргагүй юм. Учир нь Бурхан Өөрөө Бичээсийг хөглөсөн бөгөөд Бурхан Өөрөө хайр болой (2Тимот 3:16; 1Иохан 4:8-ыг үзнэ үү).

Паул үгээ Коринтын чуулганы удирдагч нарт төдийгүй, бүхэл чуулганд хандаж хэлснийг санана уу. Өөрийнх нь захидлыг чуулган даяар уншиж өгөхийг Паул байнга зааварладаг байв. Паул яагаад энэ зүйлд тийм хөдлөшгүй, дөжир хандана вэ? Хариулт нь: “Зуурсан гурилыг жаахан хөрөнгө бүхэлд нь исгэгдийг та нар мэдэхгүй гэж үү?” (1Коринт 5:6) гэсэн мэдэгдэл үгд бий. Дан ганц хувь хүн төдийгүй, нийгэм бүхлээрээ өртөж байгаа нь дахиад л харагдаж байна. Үүнийг уншина уу:

Та нар исгэгдээгүй юм шиг шинэ зуурсан гурил байхын тулд хуучин хөрөнгийг цэвэрлэ. Учир нь *Алгасал баярын хурга* маань болох Христ ч нядлуулсан. Иймд бид хуучин хөрөнгөөр бус, хорсол ба ёр муугийн хөрөнгөөр ч бус, харин чин сэтгэлийн ба үнэний исгээгүй талхаар баяраа тэмдэглэе. (1Коринт 5:7-8)

Паул дахиад л Эзэний зоогийн талаар яриад эхэллээ. Израилийн Алгасал баяр нь тэр чигээрээ тахилын хургыг тойрон өрнөдөг байв. Гэтэл Есүс бидний өө сэвгүй, тахилын Хурга.

Анхны Алгасал нь Египетийн дарлалаас гарсан Израилийн эрх чөлөөг тэмдэглэж байсан бол, Эзэний зоогийн амин утга болсон Христийн тахил бүхий үхэл нь бидний нүглээс чөлөөлөгдсөн эрх чөлөөг тэмдэглэж байгаа юм.

Үүнээс гадна: Анхны үр жимсний, Пентекостын, Бүрээний, Гаслан зовлонгийн, Майхан сүмийн зэрэг олон баяр байдаг ч, эдгээр нь Христэд итгэх амьдралын арай төлөвшсөн талыг билэгддэг. Хамгийн энгийнээр хэлбэл, Алгасал нь аврагдсаны баяр юм. Тиймээс Паул Алгасалын баярын тухай бичихдээ, биднийг анх хаанчлалд орсон талаар ярьжээ. Паул Алгасалыг “ёрын муу, муу муухайгийн хуучин талхаар” тэмдэглэж болохгүй гэсэн. Тиймээс: “Тэр чинь нялх итгэгч шүү дээ” гэдэг сэтгэлгээ нь тухайн хүний хувьд ч, бидний хувьд ч буруу шалтгаан болно. Бид энэ шалтгаанаар голдуу “нүгэлд буугаад өгчихсөн” (нүглээ хийгээд дадчихсан) хүнийг хаацайлаад байдаг. Гэтэл чуулганд дадал болсон, илт нүглийг орогнуулах газар байхгүй учраас, энэ нь төөрөгдүүлсэн, зальжин сэтгэлгээ юм (Би дадал болсон, илт нүгэл болоод “нүгэлд унахын” ялгааг дараа дараагийн бүлгээрээ ярина).

Хоёрдугаарт - Паул мөнөөх хүний нүглийн үйлдэл нь яг хөрөнгө шиг гэж хэлсэн байгааг анхаарна уу. Хөрөнгийг зуурсан гурилд цацаж хийхэд, гурил өсдөг. Алгасалын баярын тал дээр Израильд “Та нар долоо хоногийн турш исгээгүй талх идэх ёстой бөгөөд эхний өдөрт хөрөнгийг гэрээсээ зайлуул. Эхний өдрөөс долоо дахь өдөр хүртэл ямар нэг исгэсэн зүйлийг идэгч аливаа хүн Израилиас таслагдах болно” (Гэтлэл 12:15) хэмээн хатуу анхааруулсан байдаг. “Таслагдах” гэдэг үг нь Паулын зааварт гардгаас дутахгүй, шийдэмгий үг юм. Бурхан Өөртэй нь гэрээ тогтоосон хүмүүсийн нэг нь ч “нүгэлд бууж өгөх” ёсгүйг Израильд ч, бидэнд ч харуулахын тулд ингэжээ. Бүх хүн Бурханы Үгтэй зөрчилдсөн, дадал болсон, илт нүглээ гэмших ёстой. Эс бөгөөс нүглийн хөрөнгө тээсэн тэднээс болж, нийгэм бүхлээрээ хохирно.

Пилларын Шинэ гэрээний тайлбар дээр:

“Чуулганы багахан хувь - за, яг үнэндээ ганцхан хүн юм даа гээд хайхралгүй орхисон муу муухай нь алгуур идсээр, адагтаа заавал нийгмийг бүхлээр нь бузарладгийг Паул

цохон тэмдэглэжээ (Грек хэл дээрээ их тод үгээр эрэмбэлэн хэлсэн байдаг). Чуулган доторх санаатай нүгэл нь тун ноцтой үр дагавар авчирж чадна. Хайхралгүй орхисон чуулганы нүгэл нь талхны хөрөнгө мэт тархаж, бүхлээр нь зайлшгүй хөмөрнө” гэдэг.

Миний хувьд энэ тайлбарын ганцаас бусад зүйлтэй нь санал нийлнэ. Би хөрөнгөний талаар судлаад, хөрөнгө *аажмаар* биш, харин *маш хурдан* тархдагийг олж мэдсэн юм. Гэхдээ дээрх тайлбарт хэлснээр, нийгэм даяар баттай тархдаг нь гарцаагүй үнэн билээ.

Тэгвэл бид цуглаандаа гэм нүгэлтэй холбогдсон хэнийг ч оруулахгүй байх болж байна уу? Мэдээж үгүй! Чуулгануудад олон, олон итгэдэггүй хүн ирэх ёстой. Гэхдээ тэд дадал болсон, илт нүглээ гэмшиж, амьдралаа бүхлээр нь Есүс Христэд өгөхөөс нааш, тэднийг чуулганы *гишүүд* болгох юмуу эсвэл *өөрсдийгөө гишүүд* болчихлоо гэж бодоход хүргэж болохгүй. Паул ч үүнийг маш тодорхой хэлсэн:

Садарлагчидтай холбогдож болохгүй гэж би та нарт захидалдаа бичихдээ, энэ ертөнцийн садарлагчид эсвэл шунахайрагчид эсвэл дээрэмчид эсвэл шүтээн шүтэгчидтэй холбогдож болохгүй гэж ерөөсөө хэлээгүй. Хэрэв тийм байсан бол та нар энэ ертөнцөөс гарч явах ёстой болно. (1Коринт 5:9-10)

Христийг дагадаг бид дэлхийд хүрч очоод, дэлхийн хүмүүст хүрч, тэднийг Бурханы Үгийг сонсохоор чуулганд ирээрэй гэж урьж болох ч, тэдний сүнслэг байдлыг тайтгаруулан илбэж, хялбарчлан хураангуйлсан үнэнийг танилцуулж болохгүй. Бид яг л Есүс шиг үл итгэгч хүмүүст хүрсээр, хооллосоор, найзласаар, хайрласаар, үйлчилсээр байх ёстой.

Тэгтэл Паул өөрийгөө итгэгч гэж мэдэгддэг хүний тухайд тэс өөр зүйл хэлжээ:

Харин би та нарт, ах дүү гэж нэрлэгддэг нэг чинь садарлагч эсвэл шунахайрагч эсвэл шүтээн шүтэгч эсвэл хараалч

эсвэл архичин эсвэл дээрэмчин бол тийм хүнтэй холбогдож болохгүй тухай бичсэн юм. Түүнтэй хамт хооллож ч болохгүй. (1Коринт 5:11)

Паул “нүгэлд унасан” итгэгч хүний тухай яриагүй, харин өөрийгөө итгэгчид тооцдог, “нүгэлд бууж өгсөн” хүний талаар ярьжээ. Чуулганы эцэг болсон энэ хүн яагаад энэ талаар ийм хатуу ярина вэ? Чуулганыг хайрласандаа л тэр шүү дээ. Чуулган нүглээ хийсээр байгаа “итгэгч хүнд” *итгэл хүлээлгэж байна гэж эндүүрснээсээ* болоод, бултаараа гай зовлонд унаасай гэж Паул хүсээгүй.

Жишээлбэл: Амьсгалын замаар халдварладаг, маш хүнд халдварт өвчин туссан хүнийг яадаг билээ? Тэр өвчтөнг тусгаарладаг. Ингэж байж л бусад хүнийг хамгаална. Эс бөгөөс өвчин чухам түймэр лугаа адил тархаж, хүмүүс бөөн бөөнөөрөө өвчилж, үр дагаварыг нь амсдаг. Үүнээс болж юу болох уу? Цөөн хэдэн жишээ татахад: ажлын газрууд хоосорч, бүтээмж доголдож, олон нийтийн үйлчилгээ таслагдаж, эдийн засаг хямарна.

Дараа нь Паул нүгэлд бууж өгсөн хүний тухай яриу:

махбодыг нь сүйрүүлэхийн тулд тийм хүнийг Сатанд тушаая гэж шийдэв. Ингэснээр түүний сүнс Эзэн [Есүсийн] өдөр аврагдаж болох юм. (1Коринт 5:5)

Ах хүү өөрчлөгдөхгүй аваас, мөнхөд мөхөх үхлийн аюулд тулжээ. Тиймээс л би түрүүн “итгэл хүлээлгэж байна гэж эндүүрснээсээ болоод” гэж хэлсэн билээ. Хамгийн аюултай нь юу гэхээр, хэрэв санаатайгаар нүгэл үйлдэж байгаа хүнийг авч үлдээд, өгшүүлээд байвал, тэрбээр Бурханыг өөрийнхөө талд байна гэж бодсоор яваад, шүүхийн өдөр мөнхийн мөхлөөс аврагдахад дэндүү хождох аюултай.

Харин Бурханы хамгаалалтаас гаргаад хаячихбал, шалдаа бууж, үстэй толгойгоо зулгаагаад ирэхээрээ (Паулын Коринтод бичсэн хоёрдугаар захидалд гардаг) нөгөө хүн шиг сэхээ орж, бүх зүрх, сэтгэлээрээ Есүс дээр эргэж ирэхэд хүрнэ. Зовлон бидэнд ухаарлын шанаа өгдөг. Нөгөө тэнэмэл хүүг санаж байгаа биз дээ? Хүү нүгэлт амьдралынхаа үр жимсийг хүртэх үедээ л гэртээ

харьсан. Гэтэл аав нь хөөрхийлж бөмбөрүүлээд л, мөнгө явуулаад л байсан бол, хүү өөрийгөө ямар гээчийн тэрслүү байдалд байгаагаа хэзээ ч ухаарахгүй байв.

Тэнгэрт хийж болоод байхад...

Тэгэхээр гол санаандаа орцгооё. Сүүлийн хоёр бүлгээс бид өөрсдийгөө Христийн бие гэдгээ бас нэг бие учраас, нэгнийхээ хувь нэмрээр ерөөгдөх юмуу нэгнийхээ дадал болсон, илт нүглээс болж зовдгоо сурлаа.

Хайхралгүй орхиж болдоггүй үнэн гэж бий. Гэтэл Христийн бие дотор ийм амин чухал ярианаас зайлж зугтах үзэгдэл байсаар байгаа нь нэн харамсалтай. Асуудлыг няцаасаар байгаа цагт үр дагавар нь оршоор л байна.

Тиймээс асуудалтайгаа аль болох түргэн, аль болох зоригтой халз тулья. Тэнгэр тэр аяараа биднийг уухайлан дэмжиж байна! Бид ялгуусан чуулган байхаар, яг л Есүс шиг барьж хорихын аргагүй Христийн бие байхаар дуудагдсан. Өвчин, эмгэг, ядуурал, юм бүхнээр гачигдах зэрэг дайсны хамаг ажлыг Эзэний чуулганы өмнө тахимдан сөхрүүл.

Бид эрх мэдэлтэйгээр хаанчилж, тэнгэртэй арцалдсан дайсныг уландаа гишгэчих ер бусын хүчээр бадрахаар дуудагдсан. Харин үүнийг өөрийг нь эрхшээсэн хэцүү асуудалтайгаа нүүр тулахаас айгаагүй хүн л хийнэ.

Үүнийг тэнгэрт хийж болоод байхад, яагаад газар дээр хийж болдоггүй юм гэдэгт итгэх зориг зүрхтэй бай!

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Энэ бол амин чухал сэдэв. Харамсалтай нь эдгээр үнэнийг зүй ёсоор нь гаргаж ирээд, чангаар заадаг чуулган өнөөдөр дэндүү ховорджээ. Товчхондоо ийм байна: Нэгдүгээрт - Бурхан таныг бүрэн бүтнээрээ Түүнийх байж, нүглээс чөлөөтэй амьдраасай гэж хүсдэг. Хоёрдугаарт - итгэгч хүн ингэж амьдарч чадахгүй бол, үр дагавар нь дан ганц тэр хүнд төдийгүй, Христийн бүхэл биед нөлөөлнө.

Энэ тухай эргэцүүлэн тунгаах цаг гарга. Эдгээр үнэнийг дажгүй санаа төдий үзээд, цаашаа яваад өгч болохгүй шүү. Эдгээр үнэнтэй барьцалдаж ав. Тунгаан бод. Залбирч, таны амьдралд ямар утга илэрхийлэхийг Бурханаас асууж шалгаа. Эдгээр нь таны дотор шингэж, яг л Паулын хувьд амь амьдрал шиг чухал байсан шигээ таны хувьд чухал болох болтугай.

ӨӨРӨӨ ӨӨРЧЛӨЛТ НЬ БАЙ

Миний бие итгэгч бид нэгэн бие гэдгийг заахаасаа илүү, Есүстэй л хувийн харилцаатай байвал болох нь тэр хэмээн заалгаж өссөн үеийнхэний нэг билээ. Үнэндээ чуулганы талаарх энэ үнэнийг би саяхнаас л тодорхой ухаарсан юм. Үгийг минь гуйвуулах бий. Мэдээж би энэ үнэнийг ойлгодог л байсан - гэхдээ өнөөдрийн хэмжээнд биш.

Ариун Сүнс надад энэ үнэнийг ойлгуулсны дараа миний санаанд Хуурай газар, Агаар, Далайн тусгай хүчин байн байн бодогдох болов.

Миний нэг найз тэр тусгай хүчний шилмэл цэргүүдийн нэг. Найз маань тусгай хүчинд арван таван жил алба хаасан бөгөөд эдүгээ командлагч болсон билээ. Тэгээд би Христийн биеийн талаар нилээд бодохдоо, тэр нөхөртэйгээ холбогдохоор шийдэв. Учир нь би тусгай хүчнийхэн яаж тийм амь нэгтэй байдгийг олж мэдэхээр хорхойсч байлаа. Тэгээд найз руугаа яриад, хамгийн түрүүнд: “Танай тусгайгийнхан ер нь бие биеэ хэн гэж үздэг, өөр хоорондоо яаж харилцдаг вэ? Та нар яаж тийм амь нэгтэй байдаг юм бэ? Цэргийн сургуулиар яг юу заадаг юм бэ?” гэж асуулаа.

Тэгтэл нөхөр маань надад: “Тусгайгийнхан өөрийгөө хамгийн сүүлд тавьдаг” гэж хэлсэн юм.

Нөхрийн маань түс тас хариулт намайг догдлуулав. Энэ бол харилцуураар дамжин өрнөж буй амин чухал яриа гэдгийг би

мэдэж байсан тулдаа нөхрийнхөө цааш хэлэх үгийг амьсгаа даран сонслоо.

“Бид ахан дүүгээ өөрөөсөө дээр тавьдаг. Тусгайгийн хэн нэг ахан дүү маань бидний арыг хамгаалж байдаг учраас, бидэнд ар нуруугаа хамгаалах шаардлага байхгүй.”

Нэг мэдсэн нөхөр маань надад “номлож байв”: “Ефесийн зургадугаар бүлгийг үзэх юм бол, Бурхан дандаа нүүрэн талаа хамгаалах хуяг дуулга өгсөн байдаг. Тэнд араа хамгаалах хуяг хамгаалалт байхгүй. Яагаад гэвэл Бурхан биднийг өөрсдийгөө яг л тусгайгийнхан шиг нэгдмэл нэгэн бие хэмээн сэтгэж, бие биеийнхээ арыг хамгаалж яваасай гэж хүсдэг. Хэрэв бид ингэж ажиллахгүй бол, би өөрөө өөрийнхөө ар нурууг л хамгаалах ёстой болно. Гэтэл хэрэв бид багаар ажиллалбал, ангийн маань цэрэг бүр миний ар нурууг хамгаалах болно.”

“Тусгай хүчний цэрэг хүнийхээ хувьд би бүхнийг хамтран зүтгэж буй нөхрийнхөө төлөө хийнэ. Бид ингэж боддоггүй. Бид ингэж амьдардаг юм. Бид өөрийгөө хувь хүн бус, харин нэг анги гэж бодож сурсан. Хэдийгээр бид бүгдээрээ тэсэлгээний, харилцааны, мэргэн бууны, эмнэлгийн, техникийн, зэвсгийн, холбооны зэрэг янз бүрийн талаар мэргэшсэн хүмүүс боловч, бүгдээрээ л нэгдмэл нэг анги шиг ажилладаг. Бид даалгавар хүлээж аваад явахдаа: *“Зарим маань эргэж ирэхгүй, зөвхөн дөчин хувь маань л эргэж ирэх байх” гэж хэзээ ч боддоггүй. Бид: “Бид зуун хувь л явсан, зуун хувь эргэж ирнэ” гэж боддог.*

Би түүний яриаг соотойн сонссоор, хамгийн сүүлд нь: “Тэгээд та нар энэ хандлагаа шинэ цэргүүддээ яаж заадаг юм бэ?” гэж асуув.

Гэтэл нөхөр маань: “Заахгүй шүү дээ!” гэж хариулаад: “Ер нь бол гүний сөнөөх анги буюу тусгайгийн цэргийн сургууль нь хамгийн хүнд бэрх, аюултай бэлтгэл сургуульд тооцогддог. Тиймээс ч тусгайгийн хөтөлбөрт элсэгчдийн бараг ерэн таван хувь нь нэг бол өөрөө гардаг, нөгөө бол хасагддаг. Үүний үр дүнд маш өндөр төвшинд сургагдсан, бүрэн боловсорсон анги л тунаж үлдэнэ. Тэд бол дор бүрнээ хамтран зүтгэгчээ өөрөөсөө дээр тавьж, өөрөөсөө том зорилгын төлөө амиа өгөхөөс ч буцахгүй хүмүүс!” гэж ярьсан юм.

Тэгээд дараа нь: “Жон, чуулган ийм байдаг бол, юу болох бол?” гэж хэлэв.

Би ч гунигтайгаар толгой дохилоо. Гэхдээ хамгийн гол нь бидэнд ингэх хүчин чадал бий шүү дээ. Биднийг дахин төрөх үед маш бодитой энэ тэнгэрлэг мөн чанар бидний дотор суулгагдсан юм. Тийнхүү бид цэргийн сургууль болох номлол, сургаалаараа дамжуулан тэр мөн чанараа олж илрүүлээд, гаргаж ирэх ёстой. Харин хэрэв бид Сайн мэдээг хэрэглэгчийн хэмжээнд л сонсоод байвал, буруу зүйлээ буюу аврагдаагүй биеэ өөгшүүллэ. Орчин цагийн чуулган маань үндсэндээ үүнээс болж л ийм дүр царайтай болчихоод байгаа юм. Бидний дунд амьдарсан шиг амьдаръя гэх бус, харин намайг эвийлээч, намайг тэврээч гэсэн суунги, хэвтэрийн хүмүүс л их байх.

Миний нөхөр цэрэг хүн атлаа өнөөгийн чуулганы сул дорой дүр төрхийг олж харжээ. Хэрэв тусгайгийн нэг л цэрэг сул дорой, няцамхай байх юмуу эсвэл постоо орхибол, түүний журамгүй, залхуу зангаас болж ангийнх нь бүх цэрэг гарз хохирол үзэх юмуу амиа алдана. Тэр цэргүүдийн дотор суулгагдсан зүйл Христийн биеийн гишүүдийн сэтгэлгээнд суусан байх ёстой.

Өөрөө өөрчлөлт нь бай

Бидний ярьж байгаа зүйлд ямар нэг эерэг тал байна уу? Мэдээж - Бурхантай байхад ямагт байдаг!

Магадгүй та өмнөх хэдэн бүлэгт өгүүлсэн үнэнийг маш гутрангиар хүлээн авч, урам хугарч, гундсан байж болох. “Бидний амьдрал бусдын авир үйлдлийн хөлд үрэгддэг юм байна шүү дээ” гээд л бодоод байвал, үнэхээр зүрх үхнэ. Гэхдээ энэ үнэнийг ил гаргах болсон нь ганц л шалтгаантай: Бултаараа өсөн дэвшиж, Бурханы аугаа чанар, хүчийг тултал үзэхийн тулд билээ. Хэрэв бид өөр юмд итгэхгүй, өөр зүйл хийхгүй байгаад байвал, юу ч өөрчлөгдөхгүй. Тэгэхээр: *Та өөрөө өөрчлөлт нь бай.* Та бид хоёроос эхлэхгүй бол, энэ өөрчлөлт хэрхэн эхлэх вэ? Бурхан биднийг өөрчлөлтийн элч байхаар дуудсан!

Зарим хүн хөнгөн хийсвэр амьдарч яваад, яваандаа бусдын төлөө үүрэг хариуцлагаа үүрсэн, төлөвшсөн хүн болохыг та үзсэн үү? Тэрбээр ингэснээрээ улам л чанаржиж, улам л шижир болдог. Жишээлбэл нэгэн бүсгүй байжээ. Тэрбээр ганц бие байхдаа

зэрлэгтэж, галзуурч, тэнэглэхийг үзүүлдэг байж гэнэ. Гэхдээ түүний энэ үйлдэл өөрөөс нь өөр хүнд гэм болдоггүй байв. Гэтэл тэрбээр хүнд дурлаж, гэрлэж, үр хүүхэдтэй болжээ. Мөнөөх үе үе галзуурчихдаг байсан, томоогүй бүсгүй чинь амьдралаа цэгцлэв. Тэр нөгөө л тэнэг, танхай, аюултай чигээрээ байгаад байвал, өөртөө төдийгүй, хайртай нөхөр, хүүхэддээ чирэгдэл учруулна.

Чуулганы тал дээр ч бид яг ингэнэ. Бид бие биедээ хайртай. Тэгвэл Бурханы Үгийг зөрчих нь дан ганц бидэнд нөлөөлөхгүй гэдгийг бид ойлгох ёстой. Бид чинь нэг биеийн хэсгүүд шүү дээ! Магадгүй иймээс л Паул Коринтын чуулганд Эзэний зоогийн талаар ярих дундаа дараах тушаалыг бичсэн байх:

Бүх юм зөвшөөрөгддөг, харин бүгд тустай биш. Бүх юм зөвшөөрөгддөг, харин бүгд босгон байгуулдаггүй. Хэн ч өөрийнхийг бус, харин бусдынхыг эрэг. (1Коринт 10:23-24)

Паул мөн Филиппой чуулганд ч ялгаагүй үг хэлсэн:

Юуг ч аминч санаархал эсвэл ихэрхэг зангаар бүү хий. Харин даруугаар бие биенээ өөрөөсөө дээр гэж үзэж... Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой (хандлага хийгээд зорилготой бас даруу бодолтой) бай. (Филиппой 2:3, 5)

Есүс яг ийм сэтгэлгээтэй байсан. Ийм зүрх л Түүнийг ирээд, бидний төлөө амиа өгөхөд хүргэсэн юм. Тэр амиа аварч болох л байсан. Тэр үй түмэн тэнгэрэлч нараа дуудаад, цаазлагчийн савраас авруулж болох байсан ч, Түүний толгойд бид л байжээ. Тэр Өөрийгөө биш, биднийг боджээ.

Тэгэхээр ийм сайхан мэдээ байна: Бид дор бүрнээ Бурханы Үгийг дуулгавартай дагавал, эцэстээ ерөөгдөнө. Бид биеийн аль нэг хэсгээс болж хүнд бэрх, зовлонтой үеэр туулж болох ч, эцсийн эцэст заавал цэцэглэнэ.

Елиа бол бусдаас болж зүдэрсэн хүний жишээ билээ. Ахаб, Иезебел хоёрын эцэсгүй нүглээс болж бас Израилийн нүгэлдээ дөжирсөн байдлаас болж хэдэн жил тэр нутгаас хур бороо татрав. Елиа Давид хааны, Соломон хааны үед хүмүүс элбэг дэлбэгээр идэж ууж байсан шиг идэж ууж чадаагүй. Тэрбээр хэдэн жил

хэрээнүүдийн авчирч өгсөн талх, махаар л голоо зогоосон нь ерөөсөө ч сайхан байсангүй! Элбэг дэлбэг цаг үетэй адил ногоо, бал, шүүс, амттан гэж байсангүй. Бусдаас болж зовно гэдэг улам ч зовлонтой. Гэвч Елиа тэр нэг үндэстэн, нэг хүмүүс, нэг биеийн нэгээхэн хэсэг байв. Эцэстээ түүний дуулгавартай зангийн ачаар өөрчлөлт ирж, бороо оржээ. Үүний ачаар ард түмэн ерөөгдсөн бөгөөд хамгийн гол нь тэр өөрөө ерөөгдсөн юм.

Энх тайвны гэрээ

Елиагаас ч өмнө болсон нэгэн явдлыг үзье. Бас л *хэдэн* хүний үйлдлээс болж олон хүн зүдэрчээ. Израиль цөлд Хуайсын шугуйд байв:

Израиль Шитгимд амьдарсан бөгөөд ард түмэн (*зарим эрчүүд*) Моабын охидтой садарлаж эхлэв. Тэд бурхдынхаа тахилд ард түмнийг урьсан бөгөөд ард түмэн идэж, тэдний бурхдад мөргөжээ. Израиль өөрсдийгөө Пеорын Баалтай нийлүүлжээ. Тэгэхэд ЭЗЭНий уур хилэн Израилийн эсрэг дүрэлзэв. (Тооллого 25:1-3)

Энд бас л “зарим” гэдэг үг гарч байна. Бурхан хүмүүстээ өөр бурхдыг шүтэж болохгүй, харийн эмэгтэйчүүлд зориулагдаж болохгүй, бэлгийн ёс бус явдалтай хутгалдаж болохгүй гэж тушаасаар байтал, үүнийг *зарим* нь зөрчин, чуулган даяар (үндэстэн даяар) шийтгэл авчирч, улмаар энэ шийтгэлд зарим хүн бус, харин олон хүн өртсөнийг бид харж байна.

Мосед ЭЗЭН —Ард түмний бүх удирдагчийг авч, тэднийг гэгээн цагаан өдрөөр ЭЗЭНий өмнө дүүжлэгтүн. Ингэснээр ЭЗЭНий догшин хилэн Израилиас эргэх юм гэж айлдав. (Тооллого 25:4)

Мөн л удирдагч нарын (*хэсэг хүмүүсийн*) үйлдэл бүхэл Израиль дээр Эзэний хардалт хилэнг бадраасныг бид харж байна. Тэд нэг үндэстэн, нэг хүмүүс, нэг бие байв.

Мосе удирдагч нарыг цаазлах тушаал өгч байтал, Мосе тэргүүтэй хамаг Израилийн нүдэн дээр Симеон гэгч Израиль эр Козби гэдэг Мидиан хүүхнийг майхандаа авч оржээ. Тэд Бурханы Үгийг мэдсээр байж, өршөөгдөх аргагүй зөрчил үйлдэв. Гэтэл үүнийг үзсэн Елиазарын хүү Финехас, Аароны ач нар тэр даруй жадаа шүүрэн авч, Симеоны майханд гүйж ороод, Симеоныг төдийгүй, Козбиг ч нэг нэг хатгалгаар сүлбэж алжээ. Үүний дараа “Тийнхүү Израилийн хөвгүүд дээр байсан гамшиг зогслоо. Гамшгаар үхэгсэд хорин дөрвөн мянга болжээ” (Тооллого 25:8-9) гэдэг. Мөн л хэсэг хүмүүсээс болж олон хүн өртөж, зүдэрч, үхжээ. Учир нь Бурхан тэднийг нэг хэмээн үзэв.

Дараа нь Бурхан “Мосетэй ярин —Би Израилийн хөвгүүдийг Өөрийн хардалтаар устгахгүйн тулд тэдний дунд Миний төлөө хардсанаараа тахилч Аароны ач, Елеазарын хүү Финехас Израилийн хөвгүүдээс Миний уур хилэнг эргүүлжээ” (Тооллого 25:10-11) гэсэн. Финехас улс үндэстнээ бүхлээр нь гэсэн Бурханы зүрх сэтгэлийг өвлөсөн хүн байв. Тиймээс ч тэрбээр сайн сайхны төлөөх өөрчлөлтийг авчирсан юм. Өөрчлөлтийг бүх хүн бус, ганц л хүн авчиржээ.

Паул ч Коринтын чуулганыг гэсэн Бурханы сэтгэлийг өвлөсөн хүн байв. Тиймээс ч тэрбээр ганцаараа эрэлхэгээр тэр чуулганыг үнэнтэй нүүрэлдүүлж, өөрчлөлтийг авчирсан юм. Паул Бурханы Үгийг - Сүнсний илдийг авч бэлгийн гажуу амьдралаар амьдарч байгаа нэг хүний үйлдлийг цавчжээ. Хуучин гэрээнд бодитой зэвсэг хэрэглэдэг байв. Тэгвэл Шинэ гэрээнд буюу өнөөдөр ойр тойрны маань хүн нүгэл үйлдэж байхад, бусад нь нүдэн балай, чихэн дүлий байсан ч, бид эрэлхэгээр босоод, үнэнийг ярих нь бидний “зэвсэг” болдог.

Паул өөрийгөө ер бодоогүй. Тэрбээр яг л манай тусгайгийн найз шиг л байжээ. Паул бусдын сайн сайхныг өөрийнхөө тав тух, алдар нэрээс дээр тавьжээ. Тэр бүү хэл Коринтын чуулган тэр аяараа түүний өөдөөс босоод ирэх вий ч гэж айгаагүй. Паул тэдний төлөө яахаас ч буцахгүй байв. Үнэндээ Паул тэднийг хайрлах тусам, улам л тэдэндээ нүд үзүүрлэгдэж байлаа.

Финехас ч өөрийгөө бодоогүй. Тэрбээр харгис, зэрлэг, сэтгэлгүй, хоцрогдсон, туйлширсан итгэлтэй, хуучирсан сэтгэлгээтэй гэж хэлүүлэхээ мэдэж байсан. Гэтэл хэн ч хөдлөөгүй байхад, тэр л ганцаараа хөдлөсөн. Магтаалч: “Финехас босч,

шүүлтийг гүйцэтгэсэн бөгөөд тахал зогссон” (Дуулал 106:30) гэдэг. Финехас Бурханы төлөө, Бурханы санаж сарвайдаг хүмүүсийн төлөө шатаж явжээ. Тэрбээр хүмүүстээ хайртай байв. Тэр өөрчлөлт авчирдаг хүн байв!

Тэгэхээр Бурхан түүний талаар юу айлдсаныг үз:

“Тиймээс ийн хэл “Харагтун, *Би түүнд амар тайвны гэрээгээ* өгч байна. Тэр өөрийн Бурханы төлөө хардаж, Израилийн хөвгүүдэд эвлэрүүллийг хийсэн учраас *түүнд болон дараах үр удамд нь* энэ нь мөнхийн тахилчийн үйлчлэлийн гэрээ байна” хэмээн хэл гэв.” (Тооллого 25:12-13)

Би олон жил Библи судлахдаа, энэ үгийг биширсээр ирсэн юм. Үүнийг Мосе бичээд зогсохгүй, бүр хожим хойно магтаалч ч Финехасын шагналыг дөвийлгөн сайшаасан байна:

Тэр үед Финехас босч, шүүлтийг гүйцэтгэсэн бөгөөд тахал зогссон. Энэ нь үеэс үед мөнхөд Түүнд зөв зүйтэй гэж тооцогдсон.” (Дуулал 106:30-31)

Эрсдэлийг үл тоон, Бурханы дуртай зүйлийн төлөө эрэлхгээр зогссон энэ залуугийн шагналыг анх үзээд, яаж ангайснаа би санадаг юм. Зүгээр нэг ганц удаагийн шагнал биш, харин гэрээгээр баталгаажуулсан, мөнхийн шагнал! Бурхан гэрээгээ хэзээ ч зөрчдөггүйг бүү мартаарай! Энэ аугаа шагнал ганц Финехаст хүрээд зогсохгүй мөн түүний үр хүүхдэд, үр хүүхдийнх нь үр хүүхдэд гэх мэтчилэн тэднээс хойших бүх үеийнхэнд хүрэх нь байна - тэр дунд бид ч багтана! Бурханы мэлмийд зөвд тооцогдох зүйлийн төлөө бат зогсох Финехасын хүслийн ачаар хожмын үе үеийн хүмүүс шагнуулах ажээ.

Би Финехасын жишээг үзээд, хүмүүс Паулыг нүд үзүүрлэсэн шиг намайг хайрлахаа больсон ч хамаагүй, хэзээд үнэнийг ярьж байхаар шийдсэн юм. Би ганц надад ирэх бус бас Лизад, хөвгүүдэд маань, үр хойчид маань ирэх шагналыг харав. Энэ бол хэзээ ч зөрчигдөхгүй, үеийн үед уламжлагдах энхийн гэрээ болой.

Тийнхүү өнөөдөр хөвгүүд маань Бурханд халуун зүрхээр үйлчилж явааг харах дэндүү жаргалтай байдаг. Аав нь хөвгүүдээ

яг өсч яваа насан дээр нь жилийн тэн хагаст нь Сайн мэдээний үйлчлэлээр яваад, эзгүй байдаг байлаа. Тийм боловч өөрчлөлтийн төлөө явдаг хүмүүст өгсөн Бурханы амлалт үр хүүхдэд нь ч баталгаажин хэрэгждэг юм.

Бидний энэ хүртэл анхааран сурсан үнэний цаана ерөөл нуугдаж байна уу? Нуугдаж байна! Энэ нь хүмүүс хайхрахгүй байсан ч, Бурханы үнэн замын төлөө шатаж, өөрчлөлтийн дуу хоолой болж яваа хүнд өөрт нь төдийгүй, үр хойчид нь амлагдсан энхийн гэрээ юм.

Нүгэл өндийж, итгэгчдийн нийгмийг залгихыг үг дуугүй харж суухын оронд сүнсний илдийг хайраар далайн, дуу хоолойгоо өргөх нь ямар чухал болохыг бүгдээрээ харж байна уу?

Миний хувьд хариулт нь маш тодорхой байгаа ч, шийдвэрийг нь танд үлдээе.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Би танд хүсэн хүлээсэн сайхан мэдээ дуулгая: Та Бурханы төлөө, Бурханы хүмүүсийн төлөө үнэн дээр бат зогссоноороо, Бурханаас таны төдийгүй, үр удмын чинь ирээдүйг шийдсэн, өнө мөнхийн, ерөөлийн гэрээний амлалтаар шагнуулсан хүмүүсийн эгнээнд багтана.

Үр удмынхаа төлөө хийж чадах үүнээс хүчирхэг зүйл гэж байх уу даа? Энэ дэлхийн, ямар ч биет өв ийм амлалт тээхгүй. Мөнгийг ганц, хоёр үеийн дотор л идэж дуусгана. Мэдлэг, цэц ухаан ч ийм олон үе амьдрахгүй. Гагцхүү Бурханы итгэмжтэй чанарын амлалт дээр суурилсан өв л ийм урт удаан амьдарна.

Та үр хойчдоо ямар өв үлдээх гэж байна? Та энэ дэлхийгээс явахдаа хэрхэн дурсагдаж, тэнгэрт очихдоо хэрхэн танигдахыг хүсч байна? Энэ хүсэл чинь биелэх гол оньсон түлхүүр нь та дэлхий дээрх зуурдын амьдралдаа хайр, үнэн дотор хэр бат зогсоход чинь л оршино.

6

ХӨДӨЛГҮҮР

Саяхан миний ухаалаг утас мессеж илгээж чадахгүй, гацчихав. Би ч алдааг нь олж засах гэж хамаг ухаанаа сүвэгчиллээ - унтраалаа, асаалаа, аппаа хаалаа, адагт нь хүчээр унтраалаа. Дараа нь бүр ч нарийн түвэгтэй арга хэрэглэсэн боловч, ядаргаатай асуудал арилсангүй.

Энэ явдал надад ухаалаг утас гэдэг эд хүний өдөр тутмын хэрэглээнд ямар чухал байр эзлэж, бид ч үүнээс хичнээн хамааралтай болсныг илтгэсэн юм. Ядаж байхад яг тэр үеэр отгон хүү маань Энэтхэг яваад, конференц дээр пастор удирдагч нарт ном тарааж таарсныг хэлэх үү. Хүү минь асуудалтай тулгараад, аав руугаа мессеж бичээд байхад нь, аав нь гажиг утаснаасаа болоод, хэдэн цаг хариу илгээж чадсангүй. Ганц, хоёрхон өгүүлбэр бичээд л, утас маань өөрөө бичгийг маань устгаад байсан тул, би дахиад л эхнээс нь бичих хэрэгтэй болж байв. Тэгж бүтэн дөрвөн цаг ноцолдож байж, ганц богино өгүүлбэр илгээлээ. Уг нь бичээд л баймаар байвч, чадсангүй. Хичнээн бухимдсаныг минь төсөөлж байгаа байх.

Эцэстээ би утсаа засварчинд үзүүлтэл, тэд миний хэдэн өдөр ноцолдоод янзлаж бараагүй асуудлыг арван тавхан минутын дотор л олж тогтоолоо. Хэдэн цагийн дараа гэхэд, миний утас зүв зүгээр ажиллаж байв. Тэгтэл санамсаргүй хийсэн үйлдэл маань утасны маань үйл ажиллагааны системийг гацаасан байжээ.

Хэрэв би шийдэл хайгаагүй, мэргэжлийн хүмүүстэй зөвлөлдөөгүй бол, яах байсан бол? Би утсаа тултал нь ашиглаж чадахгүй, маш их цаг хугацаа алдах байв. Үүнээс болж гэр бүл, багийнхан, найз нөхөдтэйгээ бүрэн харилцаж чадахгүйд хүрэх байлаа.

Тэгвэл нэг алхам лавшруулж үзье. Би мессеж гэж юу байдгийг мэдэхгүй хүн байлаа гэж бодъё. Гучин жилийн өмнө хүн төрөлхтөн ухаалаг утас байтугай мессежтэй манатай л байлаа шүү дээ. Зуун жилийн өмнө утсан харилцаа ч гэж байгаагүй. Тэр үед байсан бол, би Энэтхэгт байгаа хүүдээ ганц мессеж илгээх гэж дөрвөн цаг ноцолдсон ч, баярлах байлаа. Огт харилцаа байхгүйгээс ямар ч хамаагүй харилцаатай байна гэдэг жаргал юм.

Би хэрэв өөрт буй нөхцөл бололцоогоо мэддэггүй хүн байсан бол, шийдэл олж, зам дээрх саадыг даван туулах гэж тэгтэл зүтгэхгүй байв. Гэтэл би ухаалаг утасны ашиг тусыг эдлэхээрээ нэг болж, мэдэхийн дээдээр мэддэг байсандаа л тэгтэл уурлаж цухалдсан билээ.

Хүчин чадлаа мэдэхгүй бол, аливаад тэмүүлэх хүсэл, хөдөлгүүр ч дундуур байна. Тусгайгийнхан яаж ажилладгийг найз минь мэддэг бол, жирийн бидэн цэргийн нэгдсэн хүчийн талаар тийм их мэдэхгүй. Хэрэв тэдний ангид ямар нэгэн доголдол гарбал яах бол? Магадгүй найз маань уурлах байтугай, амиа алдах биз.

Хуучин гэрээний нөгөө түүхийг эргэцүүлбэл, Израильчууд Аханд хэр зэрэг хилэгнэснийг төсөөлж байна уу? Иериход гайхамшигтай тулалдаж, ганган ялалт байгуулсан улс чинь Аи хотын дараа гучин зургаан дотно нөхрөө оршуулж, амь үрэгдсэн цэргүүдийн ар гэрийг тайтгаруулжээ.

Хайртай Коринтын итгэгч нар нь сүнслэг криптонитын аймшигт үр нөлөөнд автаж, доройтож, эдгэшгүйгээр өвчилж, зуурдаар үхэхийг үзээд Паул хичнээн шаналсныг төсөөлж байна уу? Паул тэдний хүчин чадлыг сайн мэдэж байхад, харин тэд өөрсдөө сохор байжээ. Тэд нийтийн сайн сайхныг биш, хувийнхаа үзэл санааг чухалчилжээ.

Тэгвэл таны хувьд? Таныг хүрээлэн буй Христэд итгэдэг олон нийтийн хувьд? Үнэндээ та сэтгэлийнхээ цөмд Христэд итгэх амьдрал бол үүнээс хавьгүй том зүйл гэдгийг мэдээд байгаа учраас л, энэ амаргүй номтой зууралдаж байгаа гэдэгт би итгэлтэй байна. Энэ хүслийг Бурхан таны зүрхэнд суулгажээ. Та үнэний хэсэгхэн зовиураас зугтахын оронд, Бурханы оршихуйд амьдарсан шиг амьдарч, нийгэмдээ эрч хүчтэй, сүнслэг өөрчлөлтийг гэрчлэн харуулахыг хүсч байгаа.

Та нарын гэрэл ирлээ

Энэ номын судлал маань хоёр чухал ач тустай: Эхнийх нь танай нийгмийн үр өгөөжийг эрс нэмэгдүүлэх бол, нөгөө нь таныг өөрийг чинь улам үр жимстэй, бүрэн дүүрэн, Бурхантай ойр дотно болгож өсгөнө. (Энэ хүртэл бид олон нийт дээр төвлөрч ярьсан бол, яваандаа эргээд тан дээр хувьчлан төвлөрнө).

Бид олон нийтийнхээ төлөө ямар алсын хараатай байх ёстой вэ? Ухаалаг утасны талаарх түрүүний жишээтэй адил энэ асуултын хариулт нь тасралтгүй эрэл хайгуул хийсээр, хүчин чадалд маань саад хийгч зүйлийг зассаар явах хүсэл, хөдөлгүүрийг маань дүүргэнэ.

Исаиа ийнхүү эш үзүүлжээ:

Бос, гэрэлт. Учир нь гэрэл чинь ирж, ЭЗЭНий алдар чиний дээр мандаж байна. Үзэгтүн, газрыг харанхуй, хүмүүсийг гүн харанхуй бүрхэнэ. Гэвч ЭЗЭН чиний дээр мандаж, алдар нь чиний дээр үзэгдэнэ. (Исаиа 60:1-2)

Исаиа энд тэнгэрийн талаар яриагүйг хамгийн түрүүнд хэлмээр байна. Түүнчлэн Илчлэл номд гардаг, Есүсийн газар дээр тогтоох Христийн мянган жилийн хаанчлалын талаар ч яриагүй. Мөн Петр тэргүүтэй бичээчдийн зөгнөн хэлсэн шинэ тэнгэр, газрын талаар ч яриагүй. Исаиа газрыг харанхуйлал хучих цаг үеийг дүрслэн өгүүлжээ. Тиймээс энэ эш үзүүлэл нь манай үеийн талаар ярьж байгаа гэдэгт би итгэдэг.

Эш үзүүлэгчийн хэлснээр, харанхуйлал нь нэг хэсэг газар дээр бус, харин даян дэлхийн хүн төрөлхтөн дээр буух ажээ. Бид өдөр өдрөөр түнэр харанхуйлж буй нийгэмд аж төрж байна. Бид Бүтээгчийнхээ зүрхээс улам улам холдсоор. Би атеист, агностик юмуу аль нэг гаж сүсгийн талаар яриагүй, харин өөрийгөө Христэд итгэдэг гэдэг олон хүний талаар ярьж байна. Өнөөдөр бол Паулын “...хүмүүс эрүүл сургаалыг тэвчихгүй болж, харин хүслийнхээ дагуу, чихийг нь гижигдсэн багш нарыг өөрсдөдөө цуглуулах” (2Тимот 4:3) яг тэр үе юм. Дараа нь Паул “чих нь үнэнээс эргэж, үлгэр домгуудад хандах болно” (2Тимот 4:4) хэмээн гаслажээ.

Гэтэл Исаиа, “тэр үед жинхэнэ итгэгч нар онцгойрч - гэрэлтэнэ” гэжээ. Ингээд төсөөлөөд үз: Та харанхуй өрөөнд ороод гэрэл асаабал, харанхуй тэр даруй арилна. Харанхуй гэрлийг тэвчихгүй. Гэрэлтүүлэх зориулалттай төхөөрөмж л байдгаас биш, харанхуйлах зориулалттай төхөөрөмж байдаггүй. Учир нь хичнээн харанхуй байсан ч, гэрэл ялж, харанхуй зайлдаг.

Есүс биднийг дэлхийн гэрэл хэмээн мэдэгдсэн. Бид гэрэлтэх ёстой, харанхуйгаас хурц байх ёстой ч, байдал ямар байна? Исаиагийн хэлснээр, бид үл итгэгч хүмүүс Бурханы *алдрыг* үзтэл гэрэлтэх ёстой ажээ.

“Алдрыг” Еврейгээр *кабод* гэх бөгөөд энэ нь сүр жавхлан, үлэмж аугаа чанар, баялаг, хүч, элбэг дэлбэг, хүндэтгэл, эрхэм дээд, хүнд байдал гэсэн утгатай юм. Ямар, ямар үг байгааг дахиад нэг хар даа. Библи Бурханы алдрын талаар ярихдаа, Бурханы сүр жавхлан, аугаа байдал, баялаг, хүч чадал, элбэг дэлбэг байдал, хүндэтгэл, эрхмийн дээд чанарын талаар өгүүлдэг. Төгсгөлийн “хүнд байдал” буюу “жин” гэдэг үг нь дээрх чанарууд нь Бурханд алаг цоог оршдог бус, харин хэмжээ хязгааргүй оршдог гэсэн утгатай юм. Товчхондоо энэ нь Бурханы аугаа чанарын жин болой.

Бурхан бидэнд Өөрийнхөө “... алдрыг мэдүүлэх гэсэндээ зүрхэнд маань” энэ мэдлийг суулгасныг (2Коринт 4:6) Паул хэлжээ. Тэгээд араас нь:

Хүчний давамгайлал (бидний аугаа их хүч) нь биднийх биш, харин Бурханых гэдгийг харуулахын тулд бид энэхүү эрдэнэсийг шавар савнуудад тээдэг (2Коринт 4:7) хэмээв.

“Бидний аугаа их хүч” гэдэг үгийг анхаарна уу. Бурханы сүр жавхлан, үлэмж аугаа байдал, баялаг, элбэг дэлбэг байдал, хүндэтгэл, эрхмийн дээд чанар нь бидний зүрхэнд хамаг хүчээрээ гэрэлтдэг ажээ. Тиймээс л Паул *бидний аугаа их хүч нь* биднээс биш, харин Бурханаас юм гэдгийг мэдэгджээ. Энд бидний даалгаврын зам дээр хөндөлсөхийг санаархсан алив харанхуйг сүлбэх хүчний талаар ярьж байна.

Тусгайгийнхан даалгавар биелүүлэхээр явахдаа, ялагдахаар явдаггүй. Ялагддаг ч үгүй. Гэтэл бидэнд тусгайгийнханд байдгаас ч баттай амлалт бий! Энэ нь тусгайгийнханд байдгаас хавьгүй аугаа хүчээр баталгаажсан амлалт болой!

Би энэ утгыг маш тодорхой байлгахын тулд номоо дуусан дуустал “Түүний алдар”, “Түүний аугаа байдал” гэж байн, байн ярих болно. (Гэхдээ үүнийхээ хажуугаар дээрх параграфуудад жагсаасан бусад тодорхойлолтыг ч санаж яваарай)

Исаиа Бурханы аугаа байдал нь бидэн дээр *бууж ирнэ* гэж хэлээгүй, харин бидний *дээрээс мандана* гэжээ. Хаанаас мандах гэж? Бидний зүрхнээс! “Бид энэ эрдэнэсийг шавар савнуудад тээдэг” (7-аар ишлэл) гэж хэлсэн шүү дээ.

Тиймээс би: “Тэгвэл яагаад Бурханы яруу алдарт аугаа чанар биднээр дамжин нийгэмд маань илэрхийлэгдэхгүй байна вэ?” гэж асуумаар байна. Яагаад ийм олон хүн доройтож, өвчилж, тэр бүү хэл цагаасаа эрт үхэж байна? Магадгүй бид сүнслэг криптонитыг үл тоосноос тэр бус уу?

Олны хүчин чадал

Өнөөгийн нийгмийн эерэг хүчин чадал нь юу байж болох вэ? Чуулганы эхлэлийг авч үзье. Пентекост өдөр 120 орчим дагалдагч дээд өрөөнд нуугдаж байжээ. Тэднийг “нэгэн санаатай” байсан гэдэг. Тэгвэл юу тэднийг тэгтэл нэгтгэв? Есүс үхлээс амилуулагдсаныхаа дараа “дээд өрөөнд ороод Аавын амлалтыг хүлээгээрэй” хэмээн дор хаяж таван зуун хүнд хэлсэн байдаг (1Коринт 15:6; Лук 24:33-53-ыг үзнэ үү). Гэтэл яахаараа арван өдрийн дараа 120-хон хүн байж байдаг билээ? Яахаар тэд бүгдээрээ хүлээдэггүй билээ? Нөгөө 380 нь хаачихсан бэ? МЭ 56 онд Паул Коринтынхонд захидал бичих үед зарим нь амьд байсан гэснээс өөр тэдний талаар дахиж юу ч дурьдаагүй байдаг. Гэхдээ тэр хүмүүс Есүсийн хүлээгээрэй хэмээн тушаасан Аавын амлалтыг Иерусалимд хүлээгээгүй гэдгийг л бид баттай мэднэ (Үйлс 1:1-15-ыг үзнэ үү).

Тэдгээр 380 хүн Есүсийн зааврыг сайхан санаа төдий сонголт гэж үзсэн байж болох уу? Эсвэл биелүүлэхийн аргагүй хүнд даалгавар гэж үзсэн үү? Магадгүй тэд өөрийнхөө боломж бололцоогоор л түүнд үйлчилье гэж санасан байх. Зарим нь Есүсийн амиллын талаар хүртэл номлож явсан гэдэгт эргэлзэх юм алга.

Гэхдээ тэр 380 хүнийг *алдрын* Сүнс хэмээгдэх (1Петр 4:14-ийг

үзнэ үү) Бурханы Сүнс дүүргээгүй билээ. Бурханы аугаа байдлын Сүнсний баптисмыг 120 хүн л хүлээн авсан юм. Тэгвэл юу тэднийг нэгэн хүн мэт нэгтгэв? Тэд нөгөө 380 шигээ өөр өөрийн гэсэн санаатай байгаагүй. Үнэндээ тэд Бурханы Үгийг сонголт гэж үзэлгүй, тушаал мэт шийдмэгээр, дуулгавартай дагасандаа л нэг болсон гэдэгт би итгэдэг.

Бурханы алдар (үүнд Түүний хүч ч багтана) тэднийг дүүргэж, яг тэр өдрөө гурван мянга гаруй хүн дахин төрөв! Тэд танилцуулга тараагаагүй, Еврейчүүдийн сэтгүүлд зар сурталчилгаа нийтлээгүй, олон нийтийн сүлжээгээр бөмбөгдөөгүй, уриа лоозон намируулсан онгоц нисгээгүй. Үнэндээ тэд ямар ч цуглаан хийхээр төлөвлөөгүй байв. Гэтэл хотынхон бүхлээрээ Бурханы яруу алдрыг үзжээ.

Төдөлгүй төрөлхийн суунги хүн үсэрч босоод, сүм рүү гүйж орох үед дахин таван мянган эрчүүд (энэ бол хүүхэд, эмэгтэйчүүдийг оруулаагүй тоо шүү) дахин төрсөн байдаг. Хүмүүс ямар ч зай завсаргүй аврагдаж байсныг Петр, Иохан хоёр баривчлагдаж явахаасаа өмнө хүмүүсийг авралд дуудаж ч амжаагүй гэдэг баримтаас харж болно!

Өрнөж буй үйл явдлаас болж Иерусалим хот тэр аяараа шаагижээ. Тэд бүгдээрээ хүчит салхины чимээ сонсов. Дагалдагч нар урьд нь сурч байгаагүй харь хэл, аялгаар Бурханы суу алдрыг гайхамшигтай сайхнаар тунхаглахыг хотын иргэд үзэв. Есүсийн нэрээр анзаарахгүй байхын аргагүй гайхамшиг үйлдэгдэж байхыг хүн бүр харжээ.

Хэд хоногийн дараа тэд нийтээрээ залбирсанд, тэдний цуглаад байсан барилга тэр чигээрээ доргижээ. Библи юуг ч давсладаггүй. Барилга доргисон гэсэн бол, доргисон л гэсэн үг. Тэдгээр итгэгч хүмүүсээс аугаа хүч, элбэг дэлбэг байдал, эдгэрэл урсаж байв.

Тэдний дунд “гачигдсан хүн байсангүй” (Үйлс 4:34) гэдэг. Петрийг гудмуудаар явахад - ганц гудмаар биш, харин *олон гудмаар* шүү - гудмаар өрж хэвтүүлсэн өвчин, эмгэгтэй хүмүүс дээр Петрийн сүүдэр тусах төдийд л тэд бүгд эдгэж байжээ (Үйлс 5:16). Бурхан ийм л аугаа! Яг л итгэгч хүн эмнэлгийн корридороор алхахад бүх өвчтөн эдгэхтэй адил юм.

Нэгэн цуглаан дээр эхнэр, нөхөр хоёр пастортаа эрээ цээргүй худлаа яриад, үхэдхийн унасан. Энэ тухай мэдээ хот даяар тархаж сонссон хүн бүрт “үлэмж айдас” төрүүлсэн ч, хүмүүс дагалдагч

нарыг бүр ч ихээр үнэлж хүндэтгэв (Үйлс 5:1-3-ыг үзнэ үү). Энэ эрүүл саруул айдас хүмүүсийг зугтаалгах нь бүү хэл, харин ч бүр олноор нь татжээ: “Эзэнд улам олон хүн итгэж, эрэгтэй, эмэгтэйчүүд олноороо тогтмол нэмэгдэж байлаа” (Үйлс 5:14).

Ийм үзэгдэл дан ганц Иерусалимд болсонгүй. Есүсийн дагалдагч нар эр зоригтой гэрчилж, хотууд бүхлээрээ аврагдаж, эдгэрч байв. Зоогийн газарт бэлбэсэн эмэгтэйчүүлд зориулж ширээ засдаг байсан Филип гэдэг эр Самари хот руу явжээ. Тэгээд “Учир нь бузар сүнстэй олноос тэдгээр нь чанга дуугаар хашхиран зайлж байсан юм. Саа өвчтэй болон эрэмдэг олон эдгэрч байв. Тэр хот үлэмж баяр баясалтай байв” (Үйлс 8:7-8) гэдэг. Зартай илбэ жатгач Симеон “Филипийн үйлдэх гайхамшиг, тэмдгийг үзээд гайхшаа бардаг байв” (13-аар ишлэл). Хот бүхлээрээ нэг бол Есүсийн тухай сонсож эсвэл аврагдахаар иржээ.

Өөр нэг удаа Петр найман жил хэвтэрт байсан, саажсан хүнийг газар дээр нь эдгээдэг. Үүний дараа “Луддад болон Шаронд амьдрагсад бүгд түүнийг хараад, Эзэн уруу эргэжээ” (Үйлс 9:35). Ганц бус хоёр хот - бүр нарийндаа бол “нийт хүн амаараа” аврагдсан байна.

Иоппад Табита гэдэг эмэгтэй үхлээс амилуулагдахад, энэ тухай мэдээ хот даяар тархжээ. Өөрөөр хэлбэл бас нэгэн хот бүхлээрээ доргижээ.

Сүүлээрээ Петр баривчлагдсан боловч, түүнийг хорьж байсан чанга дэглэмтэй шоронд шөнө дөлөөр тэнгэрэлч хүрч ирээд, Петрийг чөлөөлжээ.

Бурханыг алдаршуулаагүй захирагч өтөндөө баригдаж үхсэн. Бурханы аугаа чанар үндэстэн даяарх харанхуйллыг илчлэн, тууж гаргажээ. Гэрлээс зугтах арга байхгүй!

Гайхамшиг, аугаа их хүч, аврагдсан хувь хүмүүс нь тэр хотууд дахь Харь хүмүүст халдварлаж эхлэв. Үнэндээ нэг удаа бүр “Ингэсээр Азид суурьшсан бүх иудей, грекүүд хоёр жил өнгөрөхөд Эзэний үгийг сонсоцгоожээ” (Үйлс 19:10) гэдэг. Ганц нэг суурин газар, хот биш, харин бүс нутгаараа бүгд сонссон! Тэдэнд Фэйсбүүк, Инстаграмм, Твиттер энээ тэрээ байгаагүй. Мөн цахим хуудас, хиймэл дагуулын харилцаа, зурагт, радио ч байгаагүй. Унадаг тэрэг байтугай, бушуухан угсраад хөл залгуулчих дугуй ч байгаагүй! Гэтэл бүс нутаг тэр аяараа Эзэний

үгийг сонссон! Чуулган нэг болох үед - Бурханы Үг Христэд итгэдэг хүмүүсийн нийгэмд залрахад ийм юм болдог.

Энэ бол эртний чуулганы дунд үзэгдсэн тэнгэрийн гайхамшиг. Гэхдээ бидний үеийнхэнд Бурхан бүр ч аугаа төлөвлөгөө зэхсэнийг дараагийн бүлгээр үзнэ. Бидний Эзэн, Хаан Есүс Христийг эргэж ирэхийн өмнөтээ өрнөх тэнгэрийн гайхамшиг, хүчинд эртний чуулганы үйл явдлууд дөхөж ч очихгүй!

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бид Шинэ гэрээний ер бусын гайхамшгийг үзэхдээ, өөрийн эрхгүй: *“Мэдээж, тэд ийм мундаг юм хийлгүй дээ. Харин би ийм зүйл хэзээ ч хийж чадахгүй”* гэж боддог. Тиймээс л энэ бүлгийн утга агуулга нь амин чухал юм шүү. Тэр хүмүүс мундагтаа гайхамшиг, тэмдэг үйлдээгүй, харин зүгээр л итгэж, дуулгавартай дагасны үр дүнд л Бурханы аугаа чанар тэдний дотроос манджээ.

Бурханы аугаа чанар зүгээр л хар бор ажил хийдэг, хашхичиж гуагчсан, эрдэм номгүй, балчир залуу, туршлагагүй, хээгүй танхай хүмүүс дотор мандаж чадсан. Тэгвэл чухам “ийм хүн л тэнгэрийн аугаа чанарыг тээнэ” гэсэн жишиг газар дээр байдаггүй ажээ. Хамаг учир нь Бурханы Үгд итгэж, итгэмжтэй дагахад л оршино.

Ахин ийм гайхамшиг - үүнээс ч илүү гайхамшиг бүр ч өргөн дэлгэр өрнөх боломжтой юу? Чуулганд чинь ийм зүйлс болоод эхлэбэл, та хоёр хөлөөрөө харайгаад орох уу? Бурхан танд өгөхийг хүсч байгаа зүйлийг бүгдийг нь авмааргүй байна гэж үү? Хариултаа Бурханд залбирал болгон өргө. Тэгээд энэ амьдралд өөрийгөө чадахгүй, нийцэхгүй, тэнцэхгүй гэж үздэг тал байгаа бол, гэмшээрэй. Хамаг зовнилоо Бурханд даатгаж, өөрийгөө Бурханд хийгээд Бурханы танд л гэсэн бүхэнд өргөөрэй.

ГАНЦ ХҮНИЙ ХҮЧ

Есүс цовдлогдохоосоо өмнө эцсийн удаа Өөрийнхөө багийн төлөө төдийгүй, бидний төлөө залбирсан юм. Тэгээд хүсэлтийнхээ оршилд: “Би зөвхөн тэдний төлөө бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө мөн гуйж байна” (Иохан 17:20) хэмээн айлджээ. Тиймээс Есүс залбиралдаа та бид хоёрыг багтаасан гэдгийг няцаах үндэс байхгүй. Бид дагалдагч нарын үгийг нэг бол шууд уншихдаа эсвэл хэн нэг хүн бидэнд дагалдагч нарын бичсэн үгийг хэлж өгөх үед Есүсийг мэдэх болсон билээ.

Тиймээс Хүний Хүү Есүс Аавынхаа хүслийг тэнгэрт шигээ газар дээр биелэхийг гуйх эрх мэдэлтэй юм. Тэрбээр юу гэж залбирсныг үзнэ үү:

Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгд нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Та Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ. Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Надад өгсөн сүр жавхланг тань Би тэдэнд өгсөн билээ.
(Иохан 17:21-22)

Тэрбээр Есүс Христ бол хүн төрөлхтөний Аврагч гэдгийг дэлхийд мэдүүлэхийн тулд бид нэг байхын төлөө залбирчээ. Энэ үгийг дэлхийд юу хүргэх вэ? Үүнийг Түүний *алдраас* өөр юу ч хүргэхгүй. Үүнийг мэдэх нь бидний даалгаварт чухал юм шүү.

Тэрбээр алдраа (илчлэгдсэн аугаа байдлаа) нэг болсон хүмүүст хадгалжээ. Гэхдээ хамгийн гол нь бид: *Есүс Аавтайгаа нэг байхын адил Түүний дотор нэг байх ёстой.*

Есүс яаж Аавтайгаа нэг байсан бэ? Есүс юм л бол: “Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг” (Иохан 5:30), “Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус харин Намайг Илгээгчийн хүслийг үйлдэхээр тэнгэрээс бууж ирсэн” (Иохан 6:38), “Бурхан минь, Хүслийг тань үйлдэхээр Би ирлээ. Миний тухай хуйлмал номд бичигдсэн” (Еврей 10:7) хэмээн айлддаг байв. Есүс Аавынхаа хүслийг эрэн хайж, заримдаа бүр таатай юмуу алдартай биш байсан ч, түүнийг нь биелүүлдэг байсан тул, Аавтайгаа нэг байжээ.

Дагалдагч нарын хувьд ч ялгаагүй юм. Бурхан дэлхий ертөнцөд дагалдагч нараараа дамжуулан Өөрийнхөө аугаа байдлыг илчилсэн тэр өдөр дагалдагч нар яг нэг хүн болсон байжээ. Есүсийг газар дээр гурван жил байхад нь сургаалыг нь сонсож байсан хэдэн арван мянган хүн тэнд байгаагүй. Тэнд 120 дагалдагч л байсан. Тэд бол Есүсийг амилуулагдсан байхыг биеэр үзсэн атлаа сонсох эсэх нь сонголт гэж үзсэн 380 хүн биш, тэд бол итгэлээр нэгдсэн хүмүүс байв.

Паул биднээс “амар тайвны холбоосд Сүнсний нэгдлийг хадгалахыг хичээгтүн” (Ефес 4:3) хэмээн хүссэн - за үнэндээ бүр хичээнгүйлэн гуйсан. Тэгээд араас нь Есүсийн Өөрийн биеэр чуулгандаа өгсөн бэлэгүүдийг тоочив: элч нар, эш үзүүлэгч нар, сайн мэдээ дэлгэрүүлэгч нар, пасторууд, багш нар. Чуулганыг байгуулах тэдний үүрэг хариуцлага нь дараах зорилготой байв:

Бид бүгд итгэхүй ба Бурханы Хүүг мэдэхүй дор нэгдэх хүртэлээ, төлөвшсөн хүн болтлоо, Христийн дүүрэл чанарын хэмжээнд хүртэлээ ингэх ажээ. (Ефес 4:13)

Бидний даалгавар буюу зорилго ч эртний чуулганыхаас ялгарах ёсгүй: нэг байж, хожим Бурханы аугаа чанарыг (алдрыг) илчлэх. Өөр зам байхгүй! Манай үеийнхэн нэг болж - итгэл, мэдлэг дотроо нэгдэх ёстой. Бид Есүс шиг, дагалдагч нар шиг Бурханы Үгийг дагаж байж л жинхэнээсээ нэг болно. Энэ бол цорын ганц зам.

Бодоод үз. Израиль нэг байхдаа, Иерихог ядах юмгүй ялсан. Израиль Соломоны хаанчлал дор байхдаа, улс нь ч ялагдашгүй,

хувь хүмүүс нь ч амжилттай, ханамжтай аж төрж, тун цөөхөн үеийнхэний үзсэн жаргалыг эдлэсэн. Үүн шиг олон жишээ хэлж болно. Гэхдээ гол санааг нь та ойлгосон байх.

Тэгвэл эсрэг нөхцлийг нь харцгаая. Паул Коринтын сүнслэг криптонитын талаар ярихдаа: “Учир нь нэгдүгээрт, та нар чуулгандаа цуглахдаа хагаралтай байгааг чинь би сонсов” (1Коринт 11:8) гэсэн үгээр яриагаа эхлэжээ. Тэгэхээр тэд нэг байгаагүй нь тодорхой байна. Тэгвэл эндээс: “Тэд юунаас болж нэг байж чадсангүй вэ?” гэдэг асуулт ургана. Тэд Бурханы Үгийг дуулгавартай дагалгүй, криптониттай сүлбэлджээ. Яг л Ахан дуулгаваргүй үйлдлээрээ Израилийг Аи руу довтлохдоо нэг хүн мэт байж чадалгүй, ялагдахад хүргэсэн шиг.

Дараа нь Паул яриагаа эргүүлээд, жаахан гайхмаар үг хэлжээ:

...Зарим талаар би үүнд үнэмшиж байна. Учир нь та нарын дунд шалгарсан хүмүүс тодрохын тулд дунд чинь бүлэглэлүүд үүсэх нь зайлшгүй. (1Коринт 11:18-19)

Бурханы тааллыг олсон хүмүүс танигдах нь яагаад чухал вэ? Хариулт нь итгэл, мэдлэг дотор нэг байхад чухал үүрэгтэй. Энэ нь яг л Аханы дуулгаваргүй байдал нь бүх ард түмний дуулгавартай байдлаас ялгаран илчлэгдсэнтэй л адил чухал юм (энэ нь даяар Израилийн болон тэдний гүйцэтгэх даалгаврын тусын тулд байв). Энэ нь мөн 120 бат дуулгавартай дагалдагч нар өөрийнхөө дураар явсан 380 хүнээс ялгарах нь чухал байсантай л адил Коринтын чуулганд байв. Дуулгавартай олонх, дуулгаваргүй *цөөнх (зарим)* нь ялгарах ёстой. Ялгарахгүй бол, нэгдэлд хүрэх зам түгжирч, Бурханы алдар (аугаа байдал) чуулганд илчлэгдэхгүйд хүрнэ. Түүнчлэн Эзэний зоогт хүндэтгэлтэй хандсан боловч, хүндэтгэлгүй хандсан зарим хүмүүсийн гайгаар зовсон (доройтож, өвчилж, цаг бусаар үхсэн) гэмгүй хүмүүст эдгэрэл авчрах нь ялгаагүй чухал байв.

Эв нэгдлийг нэн тэргүүнд тавих нь хичнээн чухал болохыг Паул сайн мэдэж байсан. Тэрбээр Иерусалим, Антиох, Самари тэргүүтэй бусад хот Бурханы аугаа байдалд нэвт шувт автах үед юу болсныг сайн мэднэ. Тиймээс л Паул нэгдмэл байхыг ганц Коринтын чуулганаас гуйж гувшаад зогсохгүй мөн Ефес, Филиппой, Колоссайн итгэгч нарт болон өнөөгийн бидэнд ч

анхааруулж байна. Харин энэ нэгдмэл нэг байдлыг маань илтгэн харуулах ганц талбар бол Бурханы Үгийг дуулгавартай дагах байдал болохыг бид Есүсийн жишээнээс мэднэ.

Илүү аугаа

Тэгвэл өнөөдөр байдал хэрхэв? Бид бас л итгэлээр нэгдэхийг зорьсоор байна уу? Намайг нэг удаа залбирч байтал, хэзээ ч мартагдашгүй нэгэн үйл явдал болсон юм. Тэгэхэд Бурхан: “Хүү минь, Миний Хүүг эргэж ирэхийн өмнө Миний үйлдэх зүйлсийн дэргэд Үйлс ном дээрх үйл явдал нь хүүхдийн тоглоом юм” хэмээн маш тод айлдсаныг би санаж байна.

Би ч мэл гайхав. Үнэндээ би чихэндээ ч итгээгүй. Тэгээд өөдөөс нь: “Аав аа, би үүнийг чинь батлах Библийн гурван хэсгийг үзэж байж л үүнд чинь итгэнэ” гэж хэлсэн юм. Хамгийн сонирхолтой нь ингэж асуусанд минь Бурхан ер дургүйцээгүй юм. Угаасаа биднийг бүхнийг шалгаж байгаарай (1Тесалоник 5:21) бас “Хоёр юмуу гурван гэрчийн амаар ямар ч үг батлагддаг” (1Коринт 13:1) гэж хэлсэн байдаг шүү дээ.

Тэгээд Бурхан надад дараах ишлэлийг сануулав:

“Тун удахгүй Би дахин нэг удаа (хэсэг хугацааны дараа) тэнгэр ба газар, далай ба хуурай газрыг сэгсэрнэ. Би бүх үндэстнийг сэгсэрнэ. Тэд бүх үндэстний эд баялагтай хамт ирнэ. Би энэ өргөөг цог жавхлангаар дүүргэх болно” гэж түг түмдийн ЭЗЭН айлдав. ...Энэ өргөөний хожмын сүр жавхлан, урьдынхаасаа илүү агуу байх болно” гэж түг түмдийн ЭЗЭН айлдаад “Энэ газарт Би амар тайвныг өгнө” гэж түг түмдийн ЭЗЭН тунхаглаж байна.” (Хаггаи 2:6-7, 9)

Бяцхан түүх ярья: Израиль эхлээд Вавилонд, дараа нь Перс улсад олзлогдоод, олон жил өнгөрчээ. Тэгтэл Бурхан Персийн хаан Сирусын зүрхэнд нутаг буцаж, Небухаднеззарын толгойлсон Сирийн цэргүүдийн устгасан сүмийг дахин барихын хүслэн болсон Еврейчүүдийг суллаж явуулах хүсэл өгчээ. Олон хүн нутаг буцаж, барилгын ажлаа ихэд идэвхийлэн эхлэсэн боловч, удалгүй хувийн ашиг сонирхол, нутгийн хүмүүсийн залхаам

эсэргүүцлээс болоод ёохолзож эхэлжээ. Тэр үед Хаггаи, Зехариа тэргүүтэй удирдагч нарын эш үзүүлэл л Бурханы өргөөг дахин барихын төлөө нэгдэх хүслийг өрдөж байв.

Гэхдээ нэг чухал асуудал бий: Эш үзүүлэгч бидний дуусгах гэж байгаа сүмийн талаар ярьсан уу эвсэл өөр нэгэн сүмийн талаар ярьсан уу? Хожим Есүс: “Энэ сүмийг нураа. Би үүнийг гурван өдрийн дотор босгоно” (Иохан 2:19) хэмээн айлдсан байдаг. Есүс хэдийгээр биет сүмийн дунд зогсож байсан ч, үнэндээ тэр сүмийн талаар хэлээгүй, харин Өөрийнхөө биеийн талаар ярьсан юм. Тэгвэл энэ тохиолдол ч бас яг ийм учиртай юу?

Библийн тайлбарлагч, түүхч нар “Израилийн далан жилийн цөллөгийн дараа баригдсан сүм нь үзэмжээрээ ч, Бурханы оршихуйн жингээрээ ч Соломоны сүмийн сүр жавхлангаас хол дутсан” гэдэг. Үзэмжийн тухайд гэвэл, үүнээс хэдэн зуун жилийн дараа Херод хааны ч гараа гарган зассан сүм Соломоны анхны сүмийн сүр жавхланд хүрээгүй гэдэг. Харин оршихуйн тухайд гэвэл, Соломон анхны сүмээ Бурханд даатгаж байхад, Бурханы оршихуйн жин лүг хийтэл бууж, барилга тэр чигээрээ өтгөн үүлэн мананд автаад, тахилч нар үйлчлэлээ үргэлжлүүлж чадахгүй, алингаа алдсан гэдэг. Тэгвэл сэргээн босгосон сүмд ийм уран сайхан үйл явдал болж байсан талаар түүхэнд байхгүй.

Фарисайчууд “гурав хоногийн дотор сүмийг нурааж, дахин барина” гэсэн Есүсийн үгийн нарийн учрыг ойлголтгүй, биет сүмийн талаар ярьж байна гэж боджээ. Тэгэхээр, хэрэв бид Хаггаийн үгийг биет сүмийн тухай хэлсэн үг хэмээн гөжих аваас, мөн л ялгаагүй буруу утгаар ойлгоно.

Тэгвэл Хаггаи ямар сүмийн талаар яриа вэ? Мөн ямар цаг хугацааны талаар яриа вэ? Паул: “*Та нар өөрсдөө* Бурханы сүм бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршдог гэдгийг мэддэггүй юм уу?” (1Коринт 3:16) гэсэн байдаг. Соломоны сүмийг дүүргэсэн тэр л Сүнс бид бүгдийн дотор оршдог. Тэгвэл Хаггаи чухам энэ сүмийн талаар ярьсан бөгөөд хожмын сүм болох чуулганы алдар (Бурханы аугаа байдал) нь өмнөх биет сүмийнхээс ч аугаа байна гэдэгт би итгэдэг. Паул “Арилж буй нь алдартай байсан бол мөнх үлдэх нь илүү их алдартай байна” (2Коринт 3:11) гэсэн буй.

Хуучин гэрээний алдрын (аугаа байдал, хүчийн) талаар бодоод үз: Бурханы яруу алдраар цацраад, болохоо байсан Мосегийн царайг гивлүүрээр хааж байж амарсан гэдэг. Майхан сүмийг баригдаж

дууссаны дараа Бурханы оршихуй дийлдэхийн аргагүй хүчтэй бууж ирсэн тул, хүн амьтан дөхөж ойртох аргагүй байсан гэдэг. Соломон сүмээ барьж, даатгах үед Бурханы оршихуй тахилч нарыг үйлчлэлээ хийхийн аргагүй болтол дахин илчлэгдсэн гэдэг. Бурханы яруу алдарт оршихуй нь үнэхээрийн аюуж сөгдмөөр, алмайрч биширмээр зүйл байсан ч, Паулын хэлснээр бол “...урьд алдартай байсан зүйл нь давамгай алдраас болж хэдийнээ алдаргүй болжээ” (2Коринт 3:10).

Тэгвэл цаг хугацааны хувьд яах уу? Хаггаи чуулган мэндэлсэн цагаас чуулган төгсөх хүртэл үргэлжлэх цаг хугацааны талаар ярьсан уу? Өөрөөр хэлбэл энэ нь Есүсийн тэнгэр өөд өргөгдсөн цагаас дэлхий дээр дахин ирэх хүртэлх хугацаа юу?

Хаггаийн бичсэн Бурханы Үгийг дахин харна уу:

“...Тун удахгүй Би дахин нэг удаа тэнгэр ба газар, далай ба хуурай газрыг сэгсэрнэ. Би бүх үндэстнийг сэгсэрнэ. Тэд бүх үндэстний эд баялагтай хамт ирнэ. Би энэ өргөөг цог жавхлангаар дүүргэх болно” гэж түг түмдийн ЭЗЭН айлдав. (Хаггаи 2:6-7)

Хаггаийн өгүүлсэн алдар нь сэгсрээний үеэр тохиох ажээ. Үүнийг Еврей номын бичээч ч батладаг:

Тэгэхэд Түүний дуу дэлхийг доргиосон. Харин эдүгээ Тэр “Би дахин нэг удаа зөвхөн дэлхийг бус, тэнгэрийг ч мөн сэгсэрнэ” гэж амласан. “Дахиж нэг удаа” гэдэг нь үл ганхах нь үлдэхийн тулд, бүтээгдсэн ганхах нь зайлуулагдахыг хэлж байгаа юм. (Еврей 12:26-27)

Еврей ном нь Иерусалим хотын гудмаар өвчтэй хүмүүсийг тавьж, хот даяараа Эзэн дээр ирж, бүс нутгаараа Бурханы Үгийг сонсох зэрэг миний өмнөх бүлэгт ярьсан үйл явдлууд өрнөсний бүр дараа буюу МЭ 68 онд бичигдсэн юм. Тиймээс Еврей ном дээрх амлалт нь Үйлс номын үеийн талаар яриагүй, харин ирээдүйн талаар - хамаг бүтээл сэгсрүүлэх төгсгөл үеийн талаар ярьжээ. Энэ нь Эзэн Есүс Христийн эргэж ирэхийг харах, эцсийн үеийнхэн байх юм.

Бурхан шилдгийн шилдгээ хамгийн сүүлд гаргаж ирдгийг Бичээс ч үлгэрлэн харуулдаг. Тэгээд ч: “Хэргийн төгсгөл нь

эхлэлээсээ чухал” (Номлогчийн үгс 7:8) гэдэг бус уу? Есүс ч Кана хотод хамгийн нарийн нандин дарсаа хамгийн сүүлд гаргаж ирснээрээ энэ үнэнийг батлан харуулсан. Хожим нь Тэрбээр: “Надад итгэдэг нь Миний хийдэг үйлсийг бас хийх бөгөөд эдгээрээс ч агуу ажлуудыг хийх болно” (Иохан 14:12) хэмээн айлдсан байдаг. Яагаад Есүсийг өөдөө өргөгдсөн хойно илүү аугаа юмс болох гэж? Яагаад гэвэл Тэр хамгийн шилдгийг нь хамгийн сүүлд гаргаж ирдэг.

Тэгвэл чуулганы хувьд ч адилхан. Чуулганы төгсгөл нь эхлэлээсээ аугаа байна. Үйлс ном гайхмаар сайхан эхлэл харуулсан. Тэгвэл газар дээрх чуулганы төгсгөл нь эхлэлээсээ дор сүр жавхлантай, дор хүчтэй, дор нөлөөтэй байна гэдэгт та итгэж чадах уу? Паул: “итгэл чинь хүмүүний мэргэн ухаанд бус, харин Бурханы хүчинд байхын тулд байх ёстой”, “Учир нь Бурханы хаанчлал ярианд бус, харин хүч дор байна” (1Коринт 2:5, 4:20) хэмээн догдлонгуй хэлснийг санаарай. Хүч нь газар дээр илэрхийлэгдсэн Бурханы чуулганы маш чухал хэсэг юм шүү.

Сэргээн босголт

Тэр өдөр Ариун Сүнс намайг олон, олон ишлэл рүү дагуулсан ч, миний ярьсан цөөн хэдэн жишээнээс та “итгэгч бидний алсын хараа тэлэх ёстой - үнэндээ Үйлс номд гардгаас ч том болох ёстой” гэдгийг тодорхой ойлгосон байх аа. Ариун Сүнсээр дүүрсэн элч Петр:

“та нарын төлөө томилогдсон Христ болох Есүсийг Тэр илгээх болно. Бурхан ариун эш үзүүлэгчдийнхээ амаар эрт цагаас айлдсанчлан бүхнийг сэргээх үе хүртэл Тэрээр тэнгэрт байх учиртай юм” (Үйлс 3:20-21) хэмээн айлдсан байдаг нь тун сонирхолтой.

Энэ үгийг нарийн харцгаая. Эхлээд - ямар нэг зүйл болох хүртэл Есүс тэнгэртээ байх ёстой аж. Өөрөөр хэлбэл Аавын амлалт биелэх хүртэл Есүс эргэж ирж чадахгүй. Эш үзүүлэгчийн яриад буй тэр амлалт нь юу вэ? Энэ нь сүмийн сэргээн босголт юм. Өөрөөр хэлбэл Бурханы сүр жавхлан, аугаа байдал, баялаг, элбэг дэлбэг байдал, хүндэтгэл, эрхэм байдал нь газар дээр жаал

жуулхан хүртээгдэх бус, харин Түүний сүмээр дамжин тултлаа илчлэгдэх ажээ.

Одоо ийм юм болж байна уу? Багтаж ядсан чуулганы хүчээс болж бүс нутаг, хот бүхэл бүхлээрээ аврагдаж байна уу? Эмнэлгүүд эзгүйрэн хоосорч байна уу? Нүдгүй нь нүд орж, төрөлхийн саажилттай хүмүүс дэвхцэн, Бурханыг магтаж байна уу? Залбирлын хүчээр барилга байшингууд чичрэн доргиж байна уу? Үйлчлэл, чуулганууд дутагдаж гачигдахын зовлонг мэдэхгүйгээр, төөрсөн улс үндэстний төлөө ажиллаж байна уу? Магадгүй иймээс Хаггаи:

“Та нарын дунд үлдсэн, энэ өргөөг урьдын сүр жавхлантай байдлаар нь үзсэн хүн байна уу? Одоо энэ сүм та нарт ямар харагдана вэ? Энэ нь та нарын нүдэнд юу ч биш мэт харагдахгүй байна гэж үү?” (Хаггаи 2:3) хэмээн асуусан юм биш байгаа?

Хаггаи үүнийг өмнөө зогсох хүмүүсээс асуусан боловч, Бурхан үүнийг биднээс асууж байна. “Өнөөдөр бидний үзэж байгаа Бурханы амьд оршихуй нь Үйлс номын *хаа ч хүрэхгүй!*” гэдгийг шударгаар хүлээн зөвшөөр. Бид байдлыг чин үнэнээр харахгүй бол, чуулган дотор Бурханы аугаа хүч сэргээгдэхийн төлөө өмөрч өвдөхгүй, бахь байдгаараа, дорой чуулган хэвээрээ үлдэнэ.

Биднийг нэрвэсэн криптонитаас болж эв нэгдлээ үл хайхарч байгаа явдлаа бид хүлцэж чадна гэж үү? Намайг сонс - маш анхааралтай сонс! Бид Түүний дотор нэг байх зорилгынхоо төлөө давшсаар байх ёстой. Харин үүнийг гагцхүү итгэж, Бурханы Үгэнд орж байж л хийх боломжтой.

Тэгэхээр бидний зорих алсын хараа нэгэнт тодорхой болсон болохоор, одоо итгэгч бидний хувийн бөгөөд “хувьсгалын” өсөлтийг сааруулагч криптонитыг олж тогтоох ажилдаа эргэж орёё.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Хүн өөрийнхөө жинхэнэ боломж бололцоог олж мэдсэн хойноо л дассан сурсан өчүүхэн зүйлээ чамлаж эхлэдэг. Гэхдээ таны хувьд юу боломжтой гэдгийг энэ бүлгээс олж мэдсэн учраас, одоо та маш тодорхой шийдвэртэй нүүр тулаад байна: Нэг бол, чуулганы өнөөг хүртэл мэддэг байсан, тарчиг нөлөөтэй, амьгүй, хүчгүй амьдралтайгаа эвлэрэх. Эсвэл Есүс Христийн жинхэнэ, бүтэн аугаа чанарыг гайхуулсан хүчирхэг амьдралын араас насан турш хөөх.

Та үүнд хүрч чадна гэдэгтээ бүрэн итгэх хүртлээ хөдлөж чадахгүй. Хөдлөхгүй бол, та нэг л дутуу, нэг л хүчгүй амьдарна. Тэгэхээр, одоо өөрийнхөө дуудагдсан, энэ багтаж ядсан хүчтэй амьдралаа тунхаглаж бич. Тухайлахын бол “Миний ертөнцийг өөрчлөх гэж Есүс намайг Ариун Сүнсээрээ дүүргэсэн” эсвэл “Бурхан алдагдсан хүмүүсийн төлөө Өөрийнхөө аугаа чанарыг миний дотроос мандуулдаг”, “Би найз нөхөддөө нөлөөлж, ажлын газраа өөрчлөхийн төлөө тослогдсон” гэдэг ч юм уу. Дараа нь эдгээр тунхаглалаа өдөр бүр өөртөө хэл. Тэгээд өөртөө итгэх итгэл чинь өдөр өдрөөр тууштай ургахыг үзээрэй.

「ХЭСЭГ 2」

КРИПТОНИТЫГ ОЛЖ ТОГТООХ НЬ

8

ГЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

Дараагийн хэдэн бүлэг танд яг л туулайтай хөөцөлдөөд байгаа юм шиг санагдаж магадгүй шүү. Гэхдээ хэд хэдэн чухал үнэнийг мэдэж авсны дараа чуулганыг нэрвээд байгаа сүнслэг криптонитыг заавал олж тогтооно гэдэгт итгээрэй.

Ердийн гэрлэлт?

Бидний Бурхантай тогтоох хосгүй харилцааг нэгэн түүхээр дүрслэн ойлгуулмаар байна. Энэ түүх таны орой руу орно гэдэгт итгэлтэй байна: Жастин гэдэг залуу Анжела хэмээх бүсгүйтэй жил гаруй үерхжээ. Жастины хувьд Анжела шиг үзэсгэлэнтэй, биширмээр зан аальтай бүсгүй үгүй. Жастин Анжелад үнэн голоосоо дурлаж, үлдсэн амьдралаа түүнтэй л өнгөрөөхийг хүсэв.

Тэгээд онцгой үдэш төлөвлөж, үдшийнхээ оргил үе дээр өвдөг сөгдөөд, бүсгүйдээ жижиг хайрцагтай, нүд гялбам, алмазан бөгж барив.

Анжела ч зог туслаа. Тэрбээр ихэд цочирдсондоо, нүүрээ дараад баярын нулимс асгав. Тэгээд амьсгаагаа дарж байгаад, чимээгүй хэр нь хамаг зүрхээрээ, итгэл дүүрэн толгой дохилоо. Дараа нь жаал уужирсан хойноо: “Гэрлэнэ, гэрлэнэ, чамтайгаа

гэрлэнэ!” хэмээн баясалтайгаар жингэнэв.

Тэгээд хэдэн сарын дараа үлгэрийн хурим болов. Дараа нь хайр, инээд, адал явдал, алсын мөрөөдлөөр цалгисан бал сар залгав. Залуу гэр бүлийн хүсч мөрөөдөж чадах бүхэн тэдэнд байлаа.

Цаг хугацаа өнгөрөх тусам, Жастин Анжелад улам бүр дурлав. Анжела адал явдал, хөгжөөнд дуртай, өөрөө ч хөгжилтэй хошин зантай. Тэр гоц ухаан, ухаалаг байдлаараа цаг үргэлж Жастиныг хошуучилна. Мөн Жастины гэр бүл, найз нөхөд, ер нь хэнтэй ч хэл амаа хурдан олохоос гадна төсөөлөн бодох ур чадвартай, тун бүтээлч, соёлч бүсгүй ажээ. Цаг үргэлж орон гэрээ гоёж гоодохыг нь нөхөр нь ч биширнэ. Анжела нөхрөөсөө илүү тогооч төдийгүй, дээрээс нь ямар цэвэр цэмцгэр гээч? Товчхондоо Жастин шиг аз нь шовойсон эр байсангүй. Тэдний ирээдүй гийж байв.

Тийнхүү хэдэн сар өнгөрч, тэд гэр бүлийн амьдралд дадаж байтал, нэгэн үйл явдал болжээ. Нэг орой Жастин ажлаасаа тарж ирээд, Анжелагаа урьдын адил ирээд тэврээд үнэрлэхийг нь хүлээлээ. Тэгээд гэргийгээ том өрөө, гал тогоо, гэрийнхээ арын цэцэрлэгээр хайсаар хайсаар, эцэстээ унтлагынхаа өрөөнд байхыг нь олов.

Анжела ямар нэг юмд явахаар зэхэж байлаа. Өрөөнд нь уянгын дуу эгшиглэж, гэргийнх нь хэрэглэдэг танил сүрчгийн үнэр хан хийнэ. Эхнэр нь бэлтгэлээ хэдийн базаагаад, өмнө нь нөхөртэйгээ дуртай ресторандаа орохдоо л өмсөж байсан гоёлын даашинзаа углаж байв.

Анжела нөхрийгөө орж ирэхэд цаашаа хараад зогсож байсан болохоороо анзаарсан ч үгүй. Энэ бүхнийг ажигласан Жастин баахан тэвдээд: *“Оройн зоог барина гэж тохирсон юм байх даа? Замдаа цэцэг авдаг байж!”* хэмээн дотроо бодлоо.

Тэгээд амьсгаа авч байгаад: “Сайн уу, хонгор минь!” хэмээн цовоо дуугаар мэндлэв.

Гэргий нь бондгос хийтэл цочсон боловч: “Өө, чи минь!” хэмээн баясалтай хариулав.

Тэгтэл нөхөр нь: “Найз нь өнөөдөр болзоогоо мартжээ дээ. Хоёулаа юу төлөвлөлөө?” гэж ирээд л гэмшингүй асуулаа.

Гэтэл гэргий нь: “Өө, үгүй, үгүй!” гэх нь тэр.

Яльгүй эргэлзэж, яг юу болоод байгааг ойлгох гэж хичээсэн нөхөр нь гэргийгээ гэнэтийн бэлэг бэлджээ гэж ойлгоод, дотроо: *“Гэртээ бут авах юм болов уу эсвэл гадагшаа гарах юм болов уу?”* хэмээн гайхаж ядав. Тэгсээр байтал, гэргий нь хувцаслаж

дуусаад, төлөвсөн ажилдаа бэлэн болов. Нөхөр нь: “Хөөрхөн байна!” хэмээн магтлаа.

Гэргий нь ч: “Баярлалаа, хонгор минь!” хэмээн талархав.

Гэргийгээ юунд явах гэж байгааг тааж ядсан Жастин: “Найз нь бас хувцаслах уу?” гэж асуулаа.

Анжела нэг том харснаа: “Хувцасламаар байвал, хувцасла, хувцасла” гэв.

Яах гэж байгааг бас л ойлгоогүй Жастин: “Чи минь ийм сайхан хувцаслачихсан байхад, найз нь яаж паарайгаад зогсож байх билээ. Найз нь ч бас гангарна аа” гэлээ.

Тэгтэл тэдний хооронд тааварт байдал өрнөөд байгааг ойлгосон Анжела: “Хонгор минь, найз нь өнөөдөр гадагшаа гарлаа” гэж хэлэв.

“Харин тийм байна. Тэгээд л найз нь чиний төлөө гангалах гээд байна шүү дээ” хэмээн эргэлзэж гүйцсэн Жастин хариулав.

Асуудлыг цэгцлэх гэсэн Анжела: “Үгүй дээ хонгор минь, найз нь өнөөдөр Тонитай гадагшаа гарлаа. Бид хоёр оройн хоол идээд, кино үзээд, Фэйрмонт зочид буудалд хононо. Тэгээд найз нь өглөөний ес гэхэд ирчихсэн байна” гэлээ.

Тэгтэл Жастин өөдөөс нь: “Тони гэж хэн юм?” хэмээн түрэмгий асуув.

“Миний арван жилийн найз хөвгүүн” хэмээн Анжела баримттай өгүүллээ.

“Юу? Чи тэрэнтэй уулзана гэж байхгүй!”

“Яахлээрээ?”

“Яагаад гэвэл чи надтай гэрлэсэн. Чи эр нөхөртэй хүн. Эр нөхөртэй хүн чинь өөр хүмүүстэй болздоггүй юм!”

“Чи нээрэнгээсээ хэлж байна уу? Надад ойр дотны хар мянган залуу байдаг. Би хүнтэй гэрлэлээ гээд, тэр харилцаануудаа хаях ёстой болж байна уу?”

“Тийм ээ, хаях ёстой. Гэрлэсэн хүмүүс чинь тэгдэг! Тэд чинь гэрлэсэн хүндээ л бүрэн бүтнээрээ зориулагддаг” хэмээн шархалсан зүрхтэй, уурссан дуутай Жастин хариулав.

Хэрэг бишдэхийг мэдсэн Анжела байдлыг намжааж, шийдэл олохын тулд: “Жастин, би чамдаа л хамгийн их хайртай. Тиймээс ч би дийлэнх цагаа чамтай л өнгөрөөдөг. Би чамайг өмнөх бүх найз залуугаасаа илүү ихээр хайрладаг. Гэхдээ чи намайг тэдэнтэй уулзуулахгүй гэж барьж хорьж болохгүй. Би тэдний заримтай нь

олон жил ойр дотно явсан, одоо ч бас хайртай учраас, хааяа ч гэсэн уулзаж жаргамаар байна. Үүнд чинь юу нь буруу байгаа юм?” гэж хэлэх нь тэр.

Энэ түүх амар сайхандаа жаргаагүйг та бүхэн гадарласан байх.

Харьцуулалт

Амьдрал дээр ийм юм байдаггүй байх. Гэхдээ Анжелагийн өчиг үгийг дэмжих үүднээс хэдэн зүйл асууя: “Анжела Жастинд л хамгийн их хайртай гээ биз дээ? Тэрбээр Жастиныг бусад бүх найз залуугаасаа илүү ихээр хайрладаг гээ биз дээ? Тэрбээр Жастинтай тогтоосон харилцаагаа үхүүлэхийг хүсээгүй биз дээ? Тэрбээр дийлэнх цагаа Жастинд л зориулсан биз дээ? Анжела бүх талаараа шахуу мундаг гэргий байж чадсан биз дээ?

Бодоод үз: Жастин гэр орноо ч өөд нь татдаггүй, хоол ч хийж чаддаггүй, ямар ч ахиц дэвшилгүй, амьдралд ширхэг ч нэмэргүй, урагшгүй хүүхэнтэй суучихсан бол яана? Тийм байж, Анжелагаас бүх талаараа төгс байхыг шаардаад байгаа юм уу? Зүгээр л хааяа нэг гэргийгээ ганц, хоёр эртэй хуваалцахад л болно шүү дээ. Жастин Анжелагийн амьдралын ерэн хувийг эрхшээж байна. Тэгээд үүнээс илүү юу хүсээд байгаа юм?

Ингэж ярьбал, мэдээж дийлэнх хүний хөх инээд хүрэх байх.

Анжела гэрлэлтийн суурь үндсийг огт мэддэггүй болтой. Гэрлэлт бол эр, эм хоёрын хоёр биедээ л зориулагдах гэрээт харилцаа гэдгийг хэн ч түүнд хэлж өгөөгүй ажээ. Өөрөөр хэлбэл Жастин нэг бодолтой, Анжела өөр бодолтой хурим хийжээ. Анжела гэрлэлтийг хөгжилтэй, ашигтай, бодит талаас нь харжээ. Тэрбээр гэр бүлийн сайхан амьдрал цогцлоонгоо хажуугаар нь өөр янз бүрийн харилцаагаа ч эдлэхинэ гэж санажээ. Гэтэл энэ нь ариун гэрлэлтийн гэрээг зөрчинө.

Тэгвэл энэ үнэнийг маш энгийнээр тайлбарлая. Эмэгтэй хүн цагаан гоёлоо өмсөөд, гэрлэх ёслолын ордны танхимаар нөхөр болох хүн рүүгээ алхахдаа, маш чухал зүйл хийдэг: Тэрбээр газар дээрх бүх эрчүүдтэй тогтоох ойр дотно харилцаандаа баяртай гэж хэлж байгаа юм. Мөн тэр өдрөөс эхлэн урьд өмнөх бүх харилцаандаа цэг тавьж, ирээдүйд ч ямар нэг шинэ янаг

амрагийн харилцаа тогтоохгүй гэдгээ тунхагладаг. Танхимын урд эмэгтэйгээ хүлээн зогсох эрэгтэй ч мөн адилхан зүйл үйлдэнэ.

Тиймээс энэ явдлыг өөр дээрээ тусгаж үзье. Та Жастин шиг байдалд орбол яах уу? Эсвэл таны гэрлэхээр сүй тавьсан хүн чинь гэрлэсэн хойноо ингэнэ гэвэл, та яах уу? Нүдээ аньж байгаад л гэрлэхчиг үү?

Үгүй л болов уу. Ёстой л: “*Битгий солиор!*” гэх байлгүй.

Яагаад ийм итгэлтэй хариулж байна? Тун энгийн. Яагаад гэвэл та тэс өөр санаатай хүнтэй гэрээ байгуулахыг хүсэхгүй. Та үнэнч биш, журамгүй хүнтэй суусандаа насаараа амаа барьж амьдрахыг хүсэхгүй.

Тэгэхээр, та ийм нөхцөл тулгаж байгаа эсвэл гэрлэсэн хойноо ийм санаанд оромгүй юм хийнэ гэж байгаа хүнтэй хэзээ ч гэрлэхгүй. Тэгвэл одоо өөртөө шударгаар хариулаарай: “Есүс Анжела шиг авиртай сүйт бүсгүйн төлөө эргэж ирэх үү дээ?” Бодоод үз. Есүстэй тогтоох бидний харилцааг эхнэр, нөхрийн харилцаагаар жишсэн байдаг. Паул:

... эр хүн эцэг эхээ орхин, эхнэртэйгээ нийлж, хоёул нэг махбод болно. Энэ нууц нь агуу юм. Гэвч би Христ ба чуулганы тухайд ярьж байна (Ефес 5:31-32) гэсэн.

Бурхан анхнаасаа л Өөртэй нь тогтоох бидний харилцааг дүрслэхийн тулд гэрлэлтийн харилцааг тогтоож өгчээ. Шинэ гэрээнд Есүсийг сүйт хархүү, чуулганыг Христийн сүйт бүсгүй хэмээн дүрслэдэг. Тэгтэл бид яагаад заримдаа Сүйт хархүүдээ Анжела мэтээр хандчихаад, үүндээ шалтаг тоочих нь бүү хэл, үнэндээ энэ байдлаа бүр хөхиүлэн дэмждэг вэ?

Иаков дараах үгээ Христэд итгэдэг хүмүүст хэлжээ:

Та нар гуйгаад хүлээн авдаггүй. Учир нь та нар өөрсдийн тааламжид зарцуулъя хэмээн буруугаар гуйдаг байна. Завхай эмс ээ, ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр хорвоотой ходий хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм. Эсвэл Бичвэр дэмий хоосноор “Бидний дотор Түүний нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг” хэмээсэн гэж та нар

бодож байна уу? ... Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Нүгэлт та нар гараа цэвэрлэ. Хоёр санаат та нар зүрхээ ариусга. Шанал, гашууд, уйл. Инээд чинь гашуудал болог. Баяр хөөр чинь уйтгар гуниг болог. (Иаков 4:3-5, 8-9)

Маш хатуу үг. Үнэндээ хүмүүс бие биеэсээ эхний боломжоор л урвахад бэлэн байдаг болсон ийм үед эдгээр нь бүр туйлширсан, хэтрүүлсэн үг шиг сонсогдож болох. Би залуу байхдаа юмыг их хэтрүүлж ярьдаг байлаа. Ямар ч амьдралгүй сэтгэлийн хөдөлгөөнтэй, ихэсгэлтэй, туйлшралтай мэдэгдэл хийнэ. Гэхдээ хамгийн харамсалтай нь үүнээс минь болж гэр бүл, найз нөхөд маань миний үгийг тоохоо больсон юм.

Хүн бүр л хэзээ нэгтээ их бага хэмжээгээр ийм алдаа гаргадаг байх. Залуу аав, ээж нар хүүхдүүдээ: “Дахиж ингэх юм бол, шийтгэнэ шүү!” гэж зандраад, орхидог. Эхний нэг хоёр удаа хүүхэд энэ үгээс үнэхээр айна. Гэхдээ эцэстээ тэрбээр дахиж буруу хэрэг хийсэн ч аав, ээж яах ч үгүй юм байна гэдгийг ойлгодог. Тэр үед хүүхэд аав, ээжийнхээ үгийг тоохоо болино. Яг ийм явдал сургууль, бизнес, засгийн газар, хэвлэл мэдээлэл, найз нөхөд, гэр бүлийн гишүүдийн дунд болдог. Бид өөртөө тустай анхааруулгыг хайхрахгүй өнгөрөх нь даанч их.

Гэхдээ бид Бичээсийн анхааруулгад яг ийм сэтгэлгээгээр ханддаг нь хамгийн эмгэнэлтэй. Бурхан хэлэх гэж л хэлдэг, хэлсэн бол тэр нь үнэн гэдгийг бид санах ёстой юм. Бичээс бүхэн Бурханаас гэдгийг (2Тимот 3:16-г үзнэ үү) сана. Тиймээс Иаковын бичсэн үгийг үнэндээ Бурхан айлджээ.

Миний бичиж байгаа үгийг зүрхээрээ хүлээн авсан хүнд энэ үг эрүүл саруул айдсыг авчирна. Бурхан, дэлхий хоёрын дунд гүйдэг Христэд итгэгч нь үнэндээ завхайрагч мөн. Энэ хатуу үг шүү. Хань ижил нь эхнэр юмуу нөхрийнхөө эсрэг хов жив, худлаа ярих, хулгайлах, хашхичих, бүдүүлэг авирлах зэрэг үй олон нүгэл үйлдэж болох. Эдгээр нь бүгд гэрлэлтийн харилцаанд хортой бөгөөд альд нь хөнгөн хандаж болохгүй боловч, нэг нь ч завхайрал шиг онц ноцтой биш юм. Тиймээс л Жастин Анжелад тэгтлээ уурласан. Анжела нөхрөөсөө хамгийн аймшигтайгаар урвасан атлаа үүнийгээ юмын чинээ бодоогүй.

Элч Иаков сүнсээр завхайрагч нь Бурханы дайсан болдгийг хэлжээ. Бид өөрсдөө л үгээр хэлэхийн аргагүй аймшигтай ноцтой

энэ байдалд хүргэдэг. Бурхан бидэнд дэндүү хайртай учраас, бидэнтэй дайсагнахыг хүсдэггүй. Гэтэл бид дэлхийн юмст шунан дурласнаараа, сайн дураараа Бурханы дайсан болдог ажээ.

Ийм үгд хөнгөн хандаж болно гэж үү? Иаковын үгийг яг л Шинэ гэрээнд байхгүй мэт аашилж, үл хайхарч болно гэж үү? Иаков ганцаараа ингэж бичээгүй юм шүү. Шинэ гэрээний бичээчдийн дунд Бурханы нигүүлслийг дээд зэргээр хүлээн авсан Паул ч энэ тухай бичсэн, хайрын элч Иохан ч энэ тухай бичсэн. Петр, Иуда ч энэ тухай бичсэн. Гэхдээ хамгийн гол нь Есүс амилуулагдсаныхаа дараа Азийн чуулганд яг адилхан үг айлдсан билээ.

Сүнслэг завхайрал нь яаж биднийг Бурханы дайсан болгодгийг бид дараа, дараагийн бүлгээрээ дэлгэрүүлэн үзэж, энэ хандлага, үйлдэл нь үнэхээр бидний яриад байгаа криптонит мөн болохыг сурна.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бидний Бурхан хартай Бурхан. Бичээс ингэж хэлснийг ихэнх маань аль эртнээс мэддэг боловч, ухаж боддоггүй эсвэл зөвхөн Хуучин гэрээнд л тийм байсан мэт боддог болтой. Гэхдээ үүн шиг худлаа юм байхгүй. Есүсийн тахил нь бидэнд Түүний хайр бол хамгийн үнэнч сүйт хархүүгийн хайр гэдгийг харуулсан бус уу?

Тиймээс Бурхан биднийг зүгээр нэг хайрласан болох биш, харин хардаж хайрлаасай хэмээн хүсч, эргээд Түүнийг яг ийм халуун сэтгэл, үнэнч зориулалтаар хайрлахыг зөвшөөрсөнд нь талархах ёстой. Гагцхүү ингэж байж л бид Бурхантайгаа ойр дотно байж чадна.

Яг одоо зүрхээ нягтлан шалга. Юутай ч эгнэшгүй байх ёстой Есүсийг хайрлах хайр чинь ямархуу байна? Бурханы өмнө завхайрах аюулд хүргэж байгаа ямар нэг өөр хайр амьдралд чинь байгаа эсэхийг Ариун Сүнснээс асуу. Ариун Сүнс ямар нэг зүйл илчилж өгбөл, зайлшгүй өөрчлөлт хий. Бурхантай тогтоох хосгүй харилцаагаа өнөөдөр шинээр шүүн тунгааж, Бурхандаа яг л гэрлэлтийн тангаргаа шинэчлэн өргөх мэт шинээр зориулагдаарай.

БУРХАНЫ ӨМНӨ ЗАВХАЙРАХ

Элч Иаковын хэлсэн (*Завхай эмс* ээ, ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү?) хатуу үгийг чуулганы Сайн мэдээ, конференц, хувийн ярилцлага хэлэлцүүлгээс барагтай л олж сонсохгүй. Тийм боловч бид энэ үгийг хайхрахгүй өнгөрч болно гэж үү? Библи энэ талаар байнга ярьдаг учраас, Иаковын үг нь хаа холын сэдэв биш юм.

Иаковын үгийг нарийвчлан судлаж, анхааралдаа авах юм бол, тэр үгийн талаарх аливаа эргэлзээ, айдас тайлагдана. Тэгэхээр тэр үгийг бүрэн эхээр нь толилуулья:

Завхай эмс ээ, ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр хорвоотой ходий хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм.
(Иаков 4:4)

Нэгдүгээрт - Бурхан бидэнтэй дайсан болдоггүй, харин бид л Түүнтэй дайсан болдог. Яаж ч бодсон, аль аль нь аймшигтай үзэгдэл боловч, хоорондоо жаахан ялгаатай юм.

Бид нэг талаас эхтэй зөрчлийг мэднэ. Өөрөөр хэлбэл нэг тал нь дайн зарлаж, нөгөө тал нь хэдий хүсэхгүй байгаа ч, дайнд оролцдог. Жишээлбэл 1941 онд Япончууд Сувдан эргийг бөмбөгдөхдөө, өөрийгөө Америкийн дайсан болгосон юм.

Америк ийм зөрчлийг сонгоо ч үгүй, хүсээ ч үгүй боловч, Япон энэ өдөөн хатгалгаасаа болж, эцэстээ өөрөөсөө хол хүчирхэг улсын уур хилэнд тавчуулсан билээ.

Иаков үүнийг л хэлсэн юм. Бурхан хүмүүстэй - Өөрийнхөө хүүхдүүдтэй дайсагнах өчүүхэн ч хүсэлгүй боловч, хэрэв бид дэлхийтэй нийлж далдганаад байвал, Тэрбээр энэ тулаанаас буцахгүй. Энд “дайсныг” эктра, эктрос гэсэн хоёр янзын Грек үгээр тус тус нэрлэжээ. Эдгээр нь утгын хувьд адил бөгөөд эхнийх нь нэр үг, удаах нь тэмдэг нэр гэдгээрээ ялгарна.

Тэгвэл энэ үгийг Англи хэлний орчуулагч нар хэтэрхий хүнд үгээр буулгачихсан уу? Эх хэл дээрээ арай ч “дайсан” биш, арай зөөлөн үгээр хэлсэн байдаг уу? Үгүй, тийм юм байхгүй. Нэгэн Грек толь бичиг дээр эдгээр үгийг “дайсан, дайсагнал, өсөрхөл” хэмээн тодорхойлсон бол (CWSB), өөр нэгэн толь бичиг дээр “хэн нэгэнтэй дайсагнах явдал” хэмээн тодорхойлдог (LOUW-NIDA). Энэ ишлэлд “дайсан” гэж өөр үг сонгох шалтгаан байхгүйг батлан харуулахын тулд би дээрх нэр хүндтэй толь бичгийн тодорхойлолтыг эшлэн бичлээ. Гэхдээ үүнээс чухал нь бид энэ үгийн цаана буй ноцтой нөхцөл байдлыг л ухаарах ёстой.

Байдал ямар ноцтой болохыг батлан харуулах өөр нэгэн шинж Иаковын үгд бас бий. Иаков ийнхүү анхааруулсан хойноо “Би дахиад хэлье” гэж бичсэн нь тэрбээр амин чухал зүйл хэлж буйг л илтгэнэ. Үгийн давтамж нь эртний Еврейчүүдийн хэл харилцаанд өргөн хэрэглэгддэг байсан бичгийн хэв маяг юм. Хэдийгээр Шинэ гэрээний дийлэнх гар бичмэл Грек хэл дээр бичигдсэн боловч, бичсэн эзэд нь Еврей хүмүүс юм шүү.

Бид Англи хэлнээ аливаа үгийг онцлохдоо тодруулах, ташуулдуулах, доогуур нь зурах, том үсгээр бичих, анхаарлын тэмдэг тавих гэх мэт янз бүрийн арга хэрэглэдэг. Тухайн үг, мэдэгдлийг онцлон тэмдэглэх олон арга бий. Гэтэл аливаа санааг хэтрүүлж дөвийлгөхөөс сэрэмжилсэндээ, бичих үгдээ тун нарийн хянамгай ханддаг зантай Еврей бичээч нар аливаа үг, хэллэгийг давтах хэлбэрээр онцлон тэмдэглэдэг байжээ.

Тиймээс Иаков тун ноцтой бөгөөд хатуу үгээр анхааруулахаас гадна үүнийг бүр дахин давтан цохжээ. Товчхондоо тоохгүй өнгөрч болохгүй л гэсэн үг.

Завхайрагчид

Тэгвэл Иаков “завхайрагчид” гэдэг үгээрээ чухам юу хэлэв? Нэгдүгээрт - Иаков хүн төрөлхтөнд хандаж хэлээгүй, гагцхүү итгэгч нарт хандаж хэлжээ. Яаж мэдэж байгаа юм гэж үү? Яагаад гэвэл Иаков захидлаа дуусан дуустал: “Хайрт ах, эгч дүүс минь ээ” гэдэг. Хоёрдугаарт - итгэдэггүй хүн Бурхантай гэрээний харилцаа тогтоогоогүй учраас, Бурханы эсрэг завхайрах боломжгүй юм.

Тухайлбал: Миний бие Жэйн Смиттэй гэрлэлтийн гэрээ байгуулаагүй, Лиза Бивэртэй гэрлэлтийн гэрээ байгуулсан учраас, би Жэйн Смитийн эсрэг “завхайрч, гэрлэлтээсээ урвана” гэсэн ойлголт байхгүй.

Тэгэхээр, Есүс Христийг Эзэнээр бөгөөд Аврагчаар хүлээн авсан хүмүүс л Бурханы эсрэг завхайрч чадна. Бусад нь Бурхантай гэрээний харилцаа тогтоогоогүй, Түүнээс хол хөндий, хар элгийн хүмүүс юм.

“Завхайрагчдыг” Грекээр *мойкос* гэжээ. Энэ нь үнэндээ Грек хэлний эм үг боловч, Англи дээр эр үгийн хэлбэрээр буулгажээ. Тиймээс “завхай эмс ээ” гэвэл зөв болно. Библийн КэйЖэйВи, ЭнКэйЖэйВи гэдэг хоёр хувилбар энэ саналын зөрүүг зөөлрүүлэх гэж оролдохдоо, “завхай эрчүүд, эмс ээ” гэж орчуулжээ. Гэтэл ЭнЭлТи тэргүүтэй Библийн хэд хэдэн алдартай хувилбарын орчуулагч нар эмэгтэй хүйс дээр ярьсан явдалтай эвлэрч чадаагүй болтой. Тэд уншигч нар Иаковыг зөвхөн эмэгтэйчүүлд хандаж ярьсан гээд бодчих вий хэмээн зовнисон болтой. Гэхдээ Иаковын захидлыг бүрэн эхээр нь унших юм бол, тэрбээр бүх итгэгчдэд хандаж хэлсэн нь маш тодорхой байдаг. Иаков дан ганц эмэгтэйчүүдийг онилоогүй гэдэгтэй Библийн тайлбарлагч нар ч санал нийлдэг тул яагаад орчуулагч нар “завхай эмс ээ” гэж орчуулаагүй нь надад төдийгүй, Библийн тайлбарлагч нарт ч оньсого болдог.

Түүнчлэн “завхай эмс” гэдэг эм хүйсийн үг нь Бичээсийн ерөнхий өрнөлтэй зохицдог нь дээрх оньсогыг бүр ч лавшруулдаг. Бурхан Өөрийнхөө хүмүүсийн талаар ярихдаа, Өөрийгөө нөхөр, биднийг гэргий болгон, бидэнтэй тогтоосон харилцаагаа гэрлэлтийн харилцаагаар байнга илэрхийлдэг.

Хуучин гэрээний эш үзүүлэгч нар ч байнга ингэж ярьдаг байв. Исаиа: “Учир нь чамайг Бүтээгч нь чиний нөхөр мөн. Нэр нь

түг түмдийн ЭЗЭН. Чиний Аврагч нь Израилийн Ариун Нэгэн бөгөөд Бүх дэлхийн Бурхан хэмээн нэрлэгдсэн билээ” (Исаиа 54:5) гэж бичсэн. Хожим Израиль шүтээн шүтэж, Эзэнээс тас урвахдаа, завхайралд яллагдсан байдаг. Езекиел: “Тийнхүү завхайрлыг үйлдсэн эсвэл цус урсгасан эмийг шүүх мэт чамайг Би шүүх болно (Езекиел 16:38) гэж бичсэн. Бурхан Иеремиагаар дамжуулан: “Эмэгтэй хүн итгэл эвдэн амрагаа орхидгийн адил, Израилийн гэр ээ, чи Надад итгэл эвдэн хандсан билээ гэж ЭЗЭН тунхаглаж байна” (Иеремиа 3:20) хэмээн айлдсан.

Хосеагийн хамаг үйлчлэл нь нөхрөөсөө урвадаг, журамгүй эхнэрийг дүрслэн харуулдаг. Эзэн Хосеад янхантай гэрлэхийг тушаасан. Бодит үзүүлэнтэй энэ номлол дээр Хосеа нь Эзэнийг төлөөлсөн бол, түүний гэргий Гомер нь Бурханы хүмүүсийг төлөөлж байв. Бурхан Израильчуудад тэдний шүтээн мөргөл нь эр нөхрөөсөө ганц биш, хэд хэдэн амрагтай явалдан, урваж байгаа эхнэрийн явдлаас өөрцгүй болохыг харуулж ухааруулахын төлөө л үүнийг хийжээ. Израиль завхай эм болжээ.

Иохан Баптист: “Сүйт бүсгүйг авагч нь сүйт залуу мөн. Харин зогсоод чагнагч найз нь сүйт залуугийн дуунд үлэмж баясдаг” (Иохан 3:29) гэж хэлэхдээ, дээрх дүрслэлийг үргэлжлүүлсэн юм. Энд мөн л Есүсийг Сүйт хархүү, Бурханы хүмүүсийг сүйт бүсгүй хэмээн үзжээ.

Есүс ч Бурханы хүмүүсийг “ёрын муу, завхай үеийнхэн” (Матай 12:39, 16:4) хэмээн айлдахдаа, бас л ялгаагүй эр үг биш, эм үг хэрэглэсэн байдаг.

Бид бол сүйт бүсгүй, Есүс бол Сүйт хархүү гэдэг дүрслэлийг элч Паул ч хэлдэг (Ефес 5:31-32). Тиймээс Хуучин гэрээ ч, Шинэ гэрээ ч - Бичээс бүхлээрээ Бурханы хүмүүсийг Бурханы эхнэр хэмээн өгүүлэхийг бид харж байна. Тиймээс Иаков “завхай эмс” гэдэг нэр үгийг хэрэглэсэн нь Библийн тогтсон үлгэр загвартай таарч байгаа юм.

Шүтээнд мөргөх завхайрал

Хуучин гэрээнд Иуда ч, Израиль ч шүтээнд мөргөхдөө Бурханы эсрэг завхайрсан ялд унадаг байв. Товчхондоо тэд Бурханд үнэнч байгаагүй. Шүтээн мөргөл гэхээр бидний санаанд хөшөө баримал, овоо тахилга, бурхдын сүм дуган буудаг. Гэтэл Есүс

бурхдын сийлмэл дүрийг шүтдэг хүмүүсийг завхай зайдангаар нь дуудаагүй юм. Есүсийг Өөрийг нь Мессаиа мөн гэдгээ батлан, тэмдэг үйлдэхийг шаардсан хүмүүсийг тийнхүү дууджээ.

Иаков ч мөн баримал, овоо тахилга, сүм дуган босгосон Бурханы хүмүүсийг садар завхайгаар нь дуудаагүй. Үнэндээ Иаков Коринтынхонд Паулын хэлсэнтэй адил ах, эгч, дүүсээ ялгаварлан гадуурхах (Иаков 3:1-12), атаархал, хардалт, хар амиа бодох (Иаков 3:13-18), өөрийнхөө дур хүсэлтэй хөөцөлдөх (Иаков 4:1-3) явдлын талаар л ярьсан юм. Эдгээр нь завхайрал ажээ.

Тэгвэл яг үүн дээр Бичээсийн урсгал доголдож эхлэв үү? Бичээс Бурханы хүмүүсийг шүтээн шүтээгүй байхад нь шүтээн шүтлээ хэмээн яллав уу? Үүнд: “Үгүй!” л гэж хариулна. Учир нь энэ бүхэн нь өөр хоорондоо нягт холбоотой юм.

Энэ тал дээр өнөөгийн чуулганууд Есүс, Паул, Иаков тэргүүтэй Шинэ гэрээний бичээч нарын анхааруулгыг нэг их ойшоодоггүй. Товчхондоо бид шүтээн шүтэх гэдгийг харийн бурхдын баримал, овоо тахилга, сүм дуганаар л төсөөлж ойлгодог. Гэтэл шүтээн шүтэх явдал нь орчин цагийн Барууны Христэд итгэх итгэлтэй л илүү холбогдох болжээ. Үнэндээ сүм дуган, баримал хөшөө, овоо тахилгатай улс үндэстний дэргэд бидний шүтээн шүтэх явдал л хэрээс хэтрээд байна.

Шүтээн мөргөл нь манай соёлд суурьшихаар барахгүй, энэ нь Иуда, Израилийг элгээр нь мөлхүүлсэн, Коринтын чуулганд байна хэмээн Паулын зэмлэсэн, Шинэ гэрээний Иаков тэргүүтэй бичээч нарын өгүүлсэн яг тэр криптонит мөн болохыг би та нарт батлах болно. Өнөөдөр энэ криптонит л хувь хүнийг ч, чуулганы хамт олныг ч нүдэн дээр нь мөхөж байгаа дэлхий, төөрөгдөд хүрэх хүчгүй, Бурханы аугаа байдлыг харуулах чадалгүй болгоод байна.

Дэлхийн хөдөлгүүр

Энэ шүтээн мөргөлийн талаар ярихаасаа өмнө Иаковын хатуу үгийг үргэлжлүүлэн харъя. Тэрбээр: “Та нар дур хүслийг чинь хангах зүйлсийг л хүсдэг” хэмээн зовнин хэлээд, энэ нь “дэлхийн” хөдөлгүүр болохыг заажээ. Аюулгүйн зураас Шинэ гэрээнд ч тасралтгүй үргэлжилсээр байна! Товчхондоо, дэлхий амин хувийн хүслээр л хөдөлдөг юм. Элч Иохан ч энэ тухай хэлдэг:

Учир нь хорвоод байгаа бүхэн тухайлбал, махбодын хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардамнал нь Эцэгээс бус, харин энэ хорвоогоос юм. (1Иохан 2:16)

Иохан энд бүхэн хэмээн бүгдийг багтаасан үгийг хэрэглэжээ. Тэгэхээр энэ дэлхий дээр байдаг үй түмэн шүтээн нь бүгд энэ ишлэл дээрх ганц ангилалд л багтах ажээ. Дэлхийтэй завхайрна гэдэг нь махан биеийн мэдэрхүйд таашаал авчирдаг юмд эсвэл Бурханаас ангид байдаг зүйлээр өөртөө үнэ цэнэ авчрах гэж шунан дурлах явдал юм. Өөрөөр хэлбэл бардамнах юм.

Товчхондоо “өөрийнхөө дураар байхыг хүсэх, бүхнийг өөртөө хүсэх, чухал байхыг хүсэх” гэж Мессеж Библи хэлдэг. Энэ бол дэлхийг хөдөлгөдөг хүч юм. Энэ нь: “Надад юу хэрэгтэйг би өөрөө мэдэж байна, би үүнийгээ л хүсч байна” гэсэн лоозонтой байдаг.

Гэхдээ Бурхан ч танд хамгийн сайн сайхныг хүсч, мөрөөсч, шатаж явдаг юм. Үүнийг хүн бүр зүрхэндээ сийлэх ёстой. Яагаад гэвэл энэ дэлхий биднийг Бурханаас салгахын төлөө янхан мэт улайран өддөг. Дэлхий өөрийгөө таныг Бурханаас дээр хангачихна хэмээн бугуйлддаг. Тиймээс л Иаков:

Хайрт ах дүү нар минь, бүү мэхлэгдэгтүн. Аливаа сайн соёрхол ба аливаа төгс бэлэг нь дээрээс, гэрлүүдийн Эцэгээс бууж ирдэг (Иаков 1:16-17) хэмээн бүх зүрхээрээ захисан билээ.

Иаков хамгийн түрүүнд биднийг дэлхийд мэхлүүлж, төөрөгдөж, уруу татагдаж болохгүй гэжээ. Тэрбээр ердөө л: *“Бурханы хүслээс өөр сайн зүйл байхгүй шүү”* гэжээ. Энэ үнэнийг зүрхэндээ хадгалсан хүн уруу татлагаас амиа аварна. Нийгэм ямарваа нэг зүйлийг сайн сайхан, ашигтай, аз жаргалтай, хөгжилтэй, зугаатай, хэвийн хэмээн үзэж байсан ч, тэр нь ч утга төгөлдөр санагдаж байсан ч, тэр бүү хэл таныг алдартай, баян тарган болгож байсан ч, Бурханы Үгтэй зөрчилдөж байвал, танд ямар ч сайн сайхан юм авчрахгүй - адагтаа таныг огт гадарлаагүй үхэл рүү дагуулна: *“Хүнд өөрт нь зөв мэт зам харин эцэс нь үхлийн зам”* (Сургаалт үгс 14:12).

Энэ зам нь хүн бүрийн хувьд өөр, өөр бөгөөд дэлхийтэй завхайрах түмэн зам байдаг ч, тэдгээр нь хоорондоо нэг л талаараа адилхан юм: бүгдээрээ л зөв - *сайн*, ашигтай, өгөөжтэй, хэвийн, ухаалаг харагддаг. Тийм боловч тэдгээр нь Бичээсийн ерөнхий зөвлөгөөтэй зөрчилдөж байвал, бүгд үхэлтэй нөгцөгсөд ажээ.

Тиймээс л Бурхан бидэнд:

Иймд хөвгүүд минь, намайг сонс. Амнаас гарах үгэнд минь анхааралаа хандуул. Зүрх чинь тэр эмийн зам уруу бүү эргэг. Жим уруу нь бүү төөрөлд. Түүнд шархлуулан хаягдасад олон түүнд алуулсан эрс тоймгүй. Ийм эмийн гэр үхэгсдийн оронд хүрдэг зам агаад үхлийн танхимууд хүртэл уруудмуй (Сургаалт үгс 7:24-27) хэмээн анхааруулсан гэдэгт би итгэдэг.

Соломон үүнийг бэлгийн ёс бус явдлаар төлөөлж бичсэн боловч, үүний цаана илүү гүн эш үзүүлэл оршино: Уруу татагч дэлхийн замаас сэрэмжтэй яваарай. Тэр зам хүчирхэг бөгөөд наалинхай юм. Яагаад Израиль, Иуда тэргүүтэй үй олон улс үндэстэн тийм амархан мөхөв? Гэтэл бид ийм хүч одоо байхгүй хэмээн гэнэдсээр явах уу? Тэгвэл тэр нь ямар аймаар бодитой бөгөөд атгаг болохыг дараагийн бүлгээсээ эхлүүлэн үзье.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Хүнээ байчихсан, адгийн новш л садарлана, завхайрна гэсэн санаа өвөрлөж гэрлэдэг байх. Хэдийгээр гэрлэлтийн амлалт өргөх нь сүйт хархүүд ч, сүйт бүсгүйд ч сүрдмээр боловч, хэн хэн нь байгуулсан гэрээгээ сахихын төлөө хичээнгүйлэн амьдардаг. Тэгвэл яагаад завхайрлаас болж ийм олон гэрлэлт сүйрдэг юм бэ? Хариулахад хэцүү. Гэхдээ үндсэндээ харилцааг устгагч хүчнээс өөрийгөө хамгаалаагүйгээс л болдог.

Бурхантай тогтоох харилцаа чинь үнэхээр таны амьдрал юм шүү. Бурханаас гадуур амьдрал гэж байхгүй. Дэлхий биднийг Бурханаас маань урвуулж, садарлуулах гэж улайран хөөцөлдсөөр байна. Харин бид Бурханыг бүрэн дагавал, баттай хамгаалагдана.

Бурханд бүрэн зориулагдаж буй эсэхээ яаж мэдэх вэ?

Цагийн хуваарь чинь ямархуу байна? Та Бурханд зориулсан цагаа, Үгийг унших цагаа, залбирах цагаа, мацаг барих цагаа

хэрхэн хамгаалж байна? Та Бурханы төлөө чуулгандаа, ажил дээрээ, нийгэмдээ үйлчлэх боломжийг хайдаг уу? Та ажлаа хийхдээ, Бурханыг алдаршуулж байна уу? Аль талаараа Бурханы өмнө завхайрлаас ангид амьдрахыг хүсч байгаагаа эрс шийд. Төлөвлөгөө гарга, бич, тэгээд үйлдэж эхлэ.

「ЗАВХАЙРЛЫН ЦААНА ЮУ БАЙНА?」

Бид завхайрлын оньсыг тайлах хэрэгтэй. Мэдээж амар, хялбар байхгүй ч, үүнийг сийрүүлэх нь бүх талаараа гэрэлд гарган илчилсэн, ач тустай хэрэг болно. Хамгийн том ач тус нь яаж үүнийг амьдралаасаа олж илрүүлэхийг сурах явдал юм. Ингэснээрээ бид сүнслэг криптонитыг урьдаас таних чадвартай болно. Тиймээс үндсээс нь эхлэх үү?

Нэгдүгээр бүлэгтээ Бурхан “хүний зүрхэнд өнө мөнхийг суулгасан” (Номлогчийн үгс 3:11) гэж хэлснийг санаж байна уу? Энэ гаригийн хүн бүр төрөлх зөнтэй төрдөг. Паул: “Харийнхан хуульгүй боловч хуулийн шаарддаг зүйлсийг зөнгөөрөө үйлдвэл, хэдийгээр хуульгүй авч тэдгээр нь өөрсдөд нь хууль болдог. Хуулийн шаарддаг зүйлс зүрхэнд нь бичигдсэнийг тэд ийнхүү харуулж байна. Тэдний мөс чанар ч хамт гэрчилж, бодол санаа нь ч нэг нэгнээ буруутгадаг эсвэл өмгөөлдөг” (Ром 2:14-15) гэж хэлэхдээ, үүнийг батласан.

Тэгвэл үнэнийг хэлье: Хүн бүр ухамсартаа Бурханы арга замыг сийлүүлж төрдөг учраас, үүнийг зөнгөөрөө мэдэрдэг юм. Лиза, бид хоёр дөрвөн хүүгээ өсгөж байхдаа, үүнийг маш тодорхой харсан билээ. Тэд маань “болохгүй” гэдэг үгийг заалгаж ч амжаагүй нялх байхдаа, ах дүүгээ зодох, хоолоо цацах, аав ээждээ аашлан савж унасныхаа дараа буруу хэрэг хийснээ мэдэж байгаа нь нүднээс нь ил харагддаг байв.

Хүн бүрийн зүрхэнд мэдэгдэхээс гадна энэ нь бүхий л бүтээлээр илхэн харагдана:

Учир нь Бурханы тухай мэдэж болох зүйл тэдний дунд *илэрхий* байдаг агаад Бурхан тэдэнд үүнийг ил болгосон юм. Ертөнц бүтээгдсэнээс хойш Түүний үл үзэгдэх чанарууд, Түүний мөнх хүч ба бурхан чанар нь бүтээгдсэн зүйлсээр дамжиж ойлгогдож, *илэрхий харагдаж* байгаа тул тэдэнд *шалтаг* байхгүй. (Ром 1:19-20)

Энэ хоёр бүлэгт онцолсон “*илэрхий*”, “*илэрхий харагдаж*” гэдэг үгсийг тунгаан бод. Тэгэхээр ийм байна: Хүн Бурханыг үл ойшоох явдалд ямар ч зөвтгөл байхгүй. Шударга хандаж, үнэнийг хүсдэг хүн бүрт Бурхан Өөрийгөө мэдүүлдэг.

Хүн: “Христийн тухай хэзээ ч сонсоогүй, Африкийн алс бөглүүд амьдардаг хүн яах вэ? Тэд яаж аврагдах вэ? Бурхан тэднийг итгээгүйнх нь төлөө яллаж чадна гэж үү?” гэж асуухыг та сонсож явсан уу?

Тэгвэл эдгээр асуулт нь гол төлөв хэдийнээ тэдний мэддэг эсвэл сурахыг хүсдэггүй зүйлийг онгичсон, эсэргүүцлийн мэдэгдэл байдаг. Тэд Бурхан бодитой гэдгийг ухамсраараа мэддэг ч, үнэнийг няцаадаг ажээ. Тэд эрж хайдаг хүнд Бурханы өгдөг мэдлэгийг мэдэхийг хүсдэггүй. Яг шударга хандбал, асуулт тавигсад нь Бурханыг няцааж байгаагаа хүлээн зөвшөөрнө. Магтаалч цааш нь бүтээлүүд дуу хоолойгоороо Бурханыг зогсоо зайгүй тунхаглаж байдгийг баглан хэлжээ.

Тэнгэр нь Бурханы сүр жавхланг зарлаж,
Огторгуй гарынх нь бүтээлийг тунхаглаж байна.
Өдрөөс өдөрт тэдгээр нь ярьж,
Шөнөөс шөнөд мэдлэгийг илчилмүй.
Хэл яриа хийгээд үг үгүй,
Дуу ч сонсогдохгүй,
Дуу хоолой нь бүх газарт,
Үгс нь ертөнцийн хязгаарт хүрсэн.
Тэдгээрийн дотор Бурхан
Наранд зориулж майхан барьжээ. (Дуулал 19:1-4)

Бурханы аугаа байдал нь жилийн 365 хоногийн хорин дөрвөн цаг тутамд, цагийн минут тутамд, минутын секунд тутамд дэлхий даяар тунхаглагддаг ажээ. Энэ нь алс Африкийн бөглүү ширэнгэд аж төрдөг “харанхуй” хүнд ч хамаатай бус уу? Хүн Бурхан байхгүй мэт аяглаж, Бурханыг мэдэхгүй юм шиг амьдарч болох ч, төрөхдөө л зүрхэндээ үнэнийг тээж мэндэлсэн төдийгүй, тэр үнэн нь өдрөөс өдөрт, шөнөөс шөнөд зогсоо зайгүй ярьж байдаг юм. Хүн шалтаглаж, өөр зүйлд үнэмшиж, мал болтлоо ухамсраа хатаачихдаггүй л юм бол, үнэнээс зугтаж чадахгүй.

Шийдвэрлэх эгшин

Хүн амьд Бурханыг хайх уу эсвэл өөр бурхан, бурхад руу эргэж, ухамсраа тайтгаруулах маягаар Бурханыг хайх хүслээ “дарах” уу гэдгээ шийдэх нь хамгийн чухал эгшин юм. Та яг одоо: *“Би Баруунд амьдардаг. Манай Баруунд бурхад шүтдэггүй. Манайд хөшөө баримал, дүрүүд, сүм дуган зэрэг нь байхгүй”* гэж бодож байгаа байх. Тэгвэл намайг анхааралтай сонсоорой. Баруун бол бусад бүх соёл иргэншилтэй адил бурхдаар дүүрсэн газар гэдгийг би та нарт харуулаад өгнө.

Бурхад хаанаас үүсдэг вэ? Хүн төрөлхтөн эдгээр *бурхад, шүтээнүүдийг* бүтээсэн гэдгийг бид санах ёстой. Хүн Бурханы талаар тээж төрсөн энэ ухаарлаа бас Түүнтэй эв түнжинтэй зэрэгцэн орших хүслээ хангахыг хүсдэг. Тиймээс сонголтоороо өөр нэг бурхан бүтээчихбэл, тэр бурхнаа юугаар хангахыг бүтээсэн эзэн нь өөрөө шийдэж, тэр бурхан нь ч зохион бүтээгчийнхээ хүсэл тааллыг нь хүлээн авч хангахын сацуу, тээж төрсөн мөнөөх хүндэтгэж мөргөх хэрэгцээг нь ч хангачихна. Тэгвэл Паул энэ талаар юу хэлснийг сонсоно уу:

Тэд Бурханыг мэдсэн атлаа Бурхан гэж Түүнийг алдаршуулсан ч үгүй, Түүнд талархал өргөсөн ч үгүй. Тэгээд ч тэд бодол санаандаа хоосорч, ухваргүй зүрх нь харанхуй болжээ. Өөрсдийгөө мэргэн гэж хэлдэг атлаа тэд мунхаг болсон бөгөөд үл муудагч Бурханы алдрыг мууддаг хүн, шувууд, дөрвөн хөлт амьтад хийгээд мөлхөгчидтэй адил дүрээр сольжээ. (Ром 1:21-23)

Энд бид дүр (шүтээн) бүтээх тухай яриагүй, харин илүү гүн гүнзгий асуудлыг буюу жинхэнэ *Бурханыг хүндэтгэхгүй байх* асуудлыг сөхөж байна. Энэ тохиолдолд жинхэнэ “хүндэтгэл” гэж юу болохыг тогтоох нь чухал юм. Магтаалын цагаар “уртын дуу” тоглуулахыг хүндэтгэл гэнэ гэж бодож байвал, та юу ч ойлгоогүй байна. Жинхэнэ *хүндэтгэл* нь дуу хөгжим биш, харин *дуулгавартай байдал* юм.

Хэд хэдэн ном бичсэн хүнийхээ хувьд би аливаа ном дээр цоо шинэ ойлголт танилцуулахдаа, эхлээд ерөнхий тодорхойлолтыг нь шууд хэлэх юмуу эсвэл хүнд ойлгогдохоор утгачлан дүрслэх маягаар хэлэх хэрэгтэй байдгийг мэднэ. Ер нь бүх зохиолч тэгдэг. Бурхан ч ялгаагүй.

Хэрэв та Библийн хамгийн түгээмэл орчуулгыг (ЭнКэйЖэйВи, ИйЭсВи, ЭнЭйЭсБи, ЭнАйВи зэрэг) үзэх юм бол, “хүндэтгэл” гэдэг үг анх Эхлэл 22:5 дээр гарахыг харна. Абрахам хүү Исаактайгаа уулан дээр очиж, юу хийх гэж байгаагаа зарц нартаа хэлжээ: “Хүү бид хоёр тийшээ очиж *мөргөчихөөд* та нар уруу эргэж ирнэ.” Абрахам тэр хол явж, юу хийх гэж байсан бэ? Бурханд уртын дуу өргөхөөр явж байсан уу эсвэл чуулган дээрээ хөгжимчид, дуучдыг цуглуулаад магтаал хүндэтгэл хөтлүүлэх гэж байсан уу? Үгүй. Абрахам гурван өдрийн өмнө Бурханы айлдсан *үгэнд орж*, хүүгээрээ тахил өргөхөөр явж байжээ.

ЭнЭлГи Ром 1:21 дээр “хүндэтгэж мөргөх” гэдэг үгийг хэрэглэдэг бол, хэд хэдэн өөр орчуулга дээр “алдаршуулах” юмуу “хүндэтгэх” гэж хэлдэг. Эдгээр нь бүгд холбоотой үгс юм. Бид Бурханыг юмуу аливаа эрх мэдлийг дуулгавартай дагаснаараа, алдаршуулах юмуу хүндэтгэдэг бол, дагахгүй байснаараа дорд үзэж, үл хүндэтгэдэг. Бид амаараа хүндэтгэж, сайшааж, магтаж, Бурханы тухай дуу бичиж болох ч, Бурханы хүссэнийг биелүүлэхгүй бол, энэ нь Түүнийг доромжилсон хэрэг бөгөөд хүндэтгэлтэй (хүндлэлийн) сөргөлдсөн зүйл юм.

Бурхан Өөрийнхөө хүмүүст: “Найр наадмуудыг чинь үзэн ядав, Би тэднээс татгалзав. Тусгай чуулаануудыг чинь Би эс таалав. Дуунуудынхаа чимээг Надаас зайлуул. Ятгын эгшгийг чинь ч эс сонсоно, Би. Харин шүүлт ус мэт, зөвт байдал мөнх урсах урсгал мэт хуйлран бууг (Амос 5:21, 23-24) хэмээн айлджээ. Зөвт амьдрал гэдэг нь Бурханы эрх мэдэлд дуулгавартай байх явдал

болохоос биш бидний санаанаасаа зохиосон зүйл нь бурханлаг амьдрал биш юм.

Ямар тахилыг таалдаг болохоо Хуучин гэрээн дор Бурхан Мосед зааварлажээ. Хүмүүс Бурханд зүйл бүрийн тахил өргөдөг байв: хурга (Гэтлэл 29:39-41), бух (Гэтлэл 29:10-14), идээн өргөл (Гэтлэл 29:41) гэх мэт. Түүнчлэн тэд хүндэтгэл болгон майхан сүмд болон сүмд гүгэл нэртэй ариун утлагыг уугиулна (Леви 2:2-ыг үзнэ үү). Тийм боловч нэгэн өдөр Бурхан:

Энэ бүх юмсыг Миний мутар бүтээсэн бөгөөд энэ бүхэн байдаг болжээ” гэж ЭЗЭН тунхаглав. “Харин даруу, гэмшсэн сэтгэлтэй, үгэнд минь чичирдэг нэгнийг л Би анхаарна. *Үхэр* алдаг нэгэн нь хүн алаачтай адил, *хургаар* тахил өргөгч нь нохойн хүзүү мушгигчтай адил, *идээн өргөл* өргөгч нь гахайн цус өргөж байгаа мэт, *үнэртнээр* санамж өргөл хийгч нь шүтээнийг магтагчтай адил юм. Тэд замаа сонгодог бөгөөд сэтгэл нь ёс бусдаа баярладаг (Исаиа 66:2-3) хэмээн айлджээ.

Бурхан хамгийн түрүүнд Өөрийнх нь ерөөл дор орж, *Өөрийнх нь үгд чичирдэг* хүмүүсийг тодорхойлохдоо, дуулгавартай байхыг л чухалчлан үздэг хүнийг дүрслэн хэлжээ. Бурхан ийм хүнд л анхаарлаа хандуулна гэсэн.

Дараа нь Бурхан Өөрийг нь хүнийхээ арга замаар хүндэтгэдэг (дагадаг) хүмүүс дээр ирэв. Тэдний хүндэтгэл мөргөлийн үйл нь хүлээн зөвшөөрөхийн аргагүйгээс гадна хүнээр тахил өргөх мэт явдал (цуст аллага), нохойн өргөл, гахайн цус, шүтээнийг ерөөхтэй адил байжээ. Эдгээр үйлдэл нь Бурханы мэлмийд жигшүүр юм. Хэрэв хэн нэг хүн эдгээр жигшүүрт зүйлсээр тахил өргөх юмуу аллага үйлдсэн бол, Израилийн нийгмээс таслагдах юмуу үхлийн ял авдаг байв. Энэ бол маш хатуу, шийдэмгий ял! Тиймээс тэдний хүндэтгэл нь хэдийгээр яг Гэтлэл, Леви номын зааврын дагуу үйлдэгдэж байсан ч, жинхэнэ хүндэтгэл огт биш байжээ.

Мессеж Библи үүнийг “Та бүхний хүндэтгэл мөргөл чинь үнэндээ нүгэл юм” гэж хэлдэг.

Тэд Бурханы амлалтыг хүлээн авсан, Түүний гэрээний хүмүүс гэдгийг бүү мартаарай. Тэгээд яагаад ийм хатуу үг хэлэх болов? Яагаад гэвэл тэд Бурханы үгэнд оролгүй, өөрийнхөөрөө

хүндэтгэжээ. Тэгвэл энэ үнэн бидэнд ч хамаатай юм: Бид яг Шинэ гэрээний арга замаар Бурханд дуу дуулж, хүндэтгэлийн цуглаанд сууж, Бурханы тал болохоо мэдэгдэж болно. Гэхдээ үүнийгээ дуулгавартай зан дээр үндэслэж хийхгүй бол, энэ бүхэн нь хүндэтгэл биш болно. Бидэнд: “Та нар Бурханы дуулгавартай хүүхдүүд шиг амьдрах ёстой (1Петр 1:14) гэж хэлээгүй билүү?

Паулын дурьдсан өөр нэг үндсэн асуудал нь Бурханд баярлалаа гэж хэлэхгүй, талархалгүй амьдрах явдал юм. Хэрэв бид өөрийгөө тодорхой нэг амьдралаар амьдрах ёстой, тодорхой нэг материаллаг эд зүйлийг хүртэх ёстой, ямар нэгэн байр сууринд очих ёстой гэж итгэдэг бол, амиа бодож - үндсэндээ талархалгүй амьдарч байна гэсэн үг. Эцэстээ бид хүнд хүчир ажиллаж, төлөвлөж, зорилго тавьж, мөрөөдөж чадсандаа л өдий зэрэгт хүрч, энэ бүхнийг бүтээлээ хэмээн өөрийнхөө байгуулсан гавьяад эрдэж барддаг.

Гарсан үр дагавар

Дуулгавартай дагах, хүндэтгэх, талархах дотоод үндсэн хандлагаа Бурханаас Өөр юмд өргөх нь хувь хүн, нийгэм, үндэстэнд шүтээн мөргөлийг хөхиүлэн дэмждэг байна. Дараа нь Паул:

Иймд Бурхан тэднийг зүрхнийнх нь хүсэл тачаалын бузар юмстай зөнд нь орхиж, тэд бие махбодоо өвөр хоорондоо гутаажээ. Учир нь, тэд Бурханы үнэнийг худал хуурмагаар сольж, Бүтээгчээс илүүгээр бүтээлд нь мөргөн, зарагджээ. Бурхан бол үүрд магтагдах Бүтээгч мөн. Амен (Ром 1:24-25) гэжээ.

Энэ бүхний үндэс нь Бурханд дуулгаваргүй, талархалгүй байх явдал гэдгийг санаарай. Ийнхүү бид өөрийнхөө гэмт мөн чанарын хүслийг хүндэтгэдэг (дагадаг) болсон. Бид хараалтай, доголдолтой бүтээлд захирагдах болсон. Ёс суртахууны маань чиглүүлэгч доголдож, *үнэнийг худлаар сольсон*. Хүний шүтдэг цэц ухаан нь хэрэг дээрээ мунхаглал юм. Дэлхий хэвийн гэж үздэг зүйл нь үнэндээ хэвийн зүйл огт биш юм. Энэ нь жинхэнэ *сайн* нь өдгөө *мууд* тооцогдож, *муу* нь *сайнд* тооцогдох хүртэл үргэлжилнэ. Дараа нь:

Ийм учраас Бурхан тэднийг гутамшигт хүсэл тачаалтай нь зөнд нь орхиж (Ром 1:26) гэсэн байна.

Энэ мэдэгдлийн дараа Паул нийт 137 үгээс тогтсон (ЭнЭлТи Библи) дараагийнхаа хэдэн ишлэл дээр Бурханы эсрэг чиглэсэн хорин хоёр зөрчлийг жагсаажээ. Тоочбоос: аллага, хорт явуулга, үзэн ядалт, шунал, эцэг эхдээ дуулгаваргүй байх, ижил хүйстэнтэйгээ явалдах зэрэг болно. Паул 137 үгийнхээ ерэн тавд (буюу дөч орчим хувьд) нь ижил хүйсийн хүнтэй явалдах талаар ярьсан боловч, үлдсэн хорин нэгэн зөрчлийг нь илүү дутуу тайлбар хийлгүй, ганц, ганц үгээр л илэрхийлсэн байх юм. Яагаад тэр вэ? Бурхан ижил хүйсийн явдлыг бусад нүглээс тусгаарлаж, хамгийн адгийн нүгэлд тооцох эрхийг бидэнд өгөө юү? Хэрхэвч үгүй! Бурхан ердөө л ижил хүйстнийг хүлээн зөвшөөрөх хандлага нь манай нийгэм шүтээн мөргөлд толгойгоороо живж байгааг илтгэх хамгийн сайн үзүүлэлт болохыг л харуулахыг зорьжээ. Буцаад Паулын үгийг харцгаая:

Ийм учраас Бурхан тэднийг гутамшигт хүсэл тачаалтай нь зөнд нь орхиж. Тэдний эмэгтэйчүүд ч бэлгийн төрөлх харьцааг төрөлх бусаар сольцгоожээ. Түүнчлэн эрчүүд ч эмэгтэй хүнтэй бэлгийн төрөлх харьцаатай байхаа орхиод, нэг нэгэндээ тэмүүлэх хүсэлдээ шатаж, эрчүүд эрчүүдтэйгээ ичгүүрт зүйлийг үйлдэж, өөрсдийн алдааны зохих цээрлэлийг өөрсдөдөө хүртэж байна. (Ром 1:26-27)

Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй, талархдаггүй, дуулгавартай дагадаггүй нийгэм нь бэлгийн завхралыг буюу нэн ялангуяа ижил хүйсийн явдлыг эхлээд хүлээн авч, дараа нь баталгаажуулж (зөвшөөрч), эцэстээ дэмждэг (хөхиүлэн дэмждэг). Энэ үйлдлийг Паул ичгүүртэй бөгөөд эрүүл бус хэмээв.

Үнэнийг худлаар сольсон нь эцэстээ хүйсийн самууралд оруулжээ.

Нэйшинэл Жеографик сэтгүүл 2017 оны Нэгдүгээр сарыг бүхлээр нь “Хүйсийн хувьсгалын” нэрэмжит сар болгон, бүх хэвлэл нийтлэлээ энэ сэдэвт зориулсан юм. Эрхлэгч нар нь хүйс, бэлгийн төрөл төрлийн чиг хандлагатай хувь хүмүүсийг танилцуулав.

Мөн хүйсийн ангиллын талаар мэргэшсэн тэргүүлэх хүмүүстэй ч зөвлөлдөв. Тэд хүйс, бэлгийн чиг хандлагыг: “эжендер, квиер, андрожинос, трансжендер, сисжендер, жендерквиер, интерсекс, стрэйт, бижендер, интерсекс нонбинари, трансбой, трансгёл” гэх мэт зүсэн зүйлийн үгээр дүрслэв. Их ухаалаг дуулдаж байгаа ч, харамсалтай нь энэ бүхэн нь заль мэх буюу тэнэглэл гэдэг ангилалд орно.

Ийм нэр томъёо зохиосон хүмүүс нь ухаантай, боловсролтой, цаг үеэ тэргүүлэгч мэргэжилтэнд тооцогддог. Ийм сэтгэлгээтэй нийгэм юунд хүрэх вэ? Америкийн засгийн газар ижил хүйстэн, хүйс тодорхойлох асуудал дээр хоёр тэрбум доллар зарцуулсан гэдэг¹. Энэ их мөнгөөр хичнээн их юм бүтээж болох байсныг төсөөлж байна уу? Энэ сангаар улсын сургуулийн байр байшинг сайжруулах, цагдаагийн хүчийг бэхжүүлэх, нисэх онгоцны буудал, олон нийтийн газрыг засварлах тэгээд хамгийн гол нь орон гэргүй хүмүүс, ганц бие ээжүүд, тахир татуу хүмүүст туслаж болох байсан. Гэтэл ийм их хэмжээний мөнгийг Бурханы бүтээгээд өгсөн байдлыг эсэргүүцэн, өөрөө хүйсээ сонгох гэсэн хүмүүсийн төлөө зориулжээ. Бичээс эхнээсээ л: “Ийнхүү Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр бүтээхдээ эр эмээр нь бүтээжээ (Эхлэл 1:27) гэдэг. Тэр л бидний хүйсийг шийддэг, Тэр бидэнд хайртай учраас, юу нь хамгийн сайн болохыг мэднэ.

Гэтэл цэц ухааны нэрийг барин хүмүүсийн хийж байгаа энэ бүх завхрал нь үнэндээ хайран хөрөнгийг мунхагаар үрэн таран хийж байгаа явдал юм. Хамгийн харамсалтай нь энэ бүхэн нь гаж зан үйлдлийг хөхиүлэн дэмжиж, хүмүүсийг бүтээгдээгүй амьдралынх нь хэв маягаар хүлдэг.

Бид худлыг “хүний эрх” нэрийдлээр нийгэмдээ нэвтрүүлэхдээ, хүн амын өчүүхэн хувь болсон нэг хэсэг хүмүүст өөрсдийнхөө авир үйлдлийг яс, үндсээр гадуурхах явдалтай хольж хутган, дайрч давшлахыг зөвшөөрчихжээ. Мэдээж хүнд эдлэх ёстой эрх гэж бий. Гэхдээ өөрийгөө хэн байхаар бүтээгдсэнээсээ өөрөөр байлгах гэж зүтгэх нь эрхийн асуудал биш юм.

¹ Mat Staver: Homosexuality Costs The Government Tens Of Billions Of Dollars
Brian Tashman | April 16, 2015 12:40 pm - <http://www.rightwingwatch.org/post/mat-staver-homosexuality-costs-the-government-tens-of-billions-of-dollars/>

Паулын эш үзүүлсэн энэ жигшүүртэй зан үйлдэл нь Бурханыг жинхэнээсээ хүндэтгэхээ болих (дуулгавартай дагах), Түүнд талархахаа болих үед болдог. Тиймээс удирдагч нар яагаад дуугарч, эдгээр төөрөлдүүлэгч итгэл, хүчин зүтгэлийг таслан зогсоохгүй байна? Бид үнэнээс айж, худал, заль мэхийг хүлээн зөвшөөрөх болжээ. Бид шүтээн мөргөлд урваж, улс үндэстнээрээ хүчирхийлүүлэн дарлагдах болжээ.

Нийгэм энэ бүхнийг хөгжил дэвшил гэж үзэж болох ч, үнэндээ энэ нь мунхаглал руу уруудан доройтох явдал юм. Аль дээр бичигдсэн Паулын үг нь хүйс, бэлгийн завхрал нь шүтээн мөргөлөөс үндэстэй болохыг илчилдэг. Үүнийхээ дараа Паул үр дагаврыг нь тоочжээ:

Тэд Бурханыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тул тэднийг Бурхан завхарсан сэтгэл болон хийх ёсгүй үйлдэлд нь орхижээ. Тэд элдэв зүй бус, хилэнц, шунал, бузар булайгаар дүүрэн агаад атаа жөтөө, аллага, хэрүүл, заль мэх, хар санаагаар дүүрсэн, хов жив яригч, гүтгэгч, Бурханыг үзэн ядагч, дээрэлхүү, их зантай, сагсуу, хорон мууг санаачлагч, эцэг эхдээ дуулгаваргүй, ухваргүй, найдваргүй, үл хайрлагч, өршөөл үзүүлдэггүй хүмүүс ажээ. (Ром 1:28-31)

Та үүнийг хэт нухацтай авч үзэн, хэрэг нээж, нийгэмд байгаа энэ төрлийн зан үйлдлийн талаар дүн судалгаа хийх хэрэггүй. Энэ явдал барьж хорихын аргагүй газар авч, амьдрал, гэр бүл, улс үндэстнийг сүйрүүлж байна. Нийгмийн энэ завхралыг хүлээн зөвшөөрсөн явдлаас болж нийгэм ялзарч, харилцаа сүйрч, янз бүрийн дажин болж байна.

Энэ бүхнийг нэг их эмгэлэнтэй гэж үзэхгүй байгаа бол, Паул:

“Ийм зүйлсийг үйлдэгч нь үхвэл зохино гэсэн Бурханы зарлигийг тэд мэддэг хэрнээ өөрсдөө үйлдээд зогсохгүй, бусдыг үйлдэхэд нь ч сайшаадаг байна” (Ром 1:32) гэж хэлжээ.

Засгийн газар, хэвлэл мэдээлэл, зурагт, кино продюсерууд, нийгмийн ажилтнууд, удирдагч нар, нөлөөлөгч нар, нийгэм

бүхлээрээ Бүтээгчийгээ өдөөн хатгасан энэ нөхцөл байдлыг мэдэхийн дээдээр мэдэж байгаа боловч, ухамсрынхаа хэлээд байгаа, бүх бүтээлийн хашхираад байгаа үгийг үл тоодог. Тэгээд ухамсрынхаа дуу хоолойг замхруулж, зүрхэн дэхь үнэнээ намжаахын тулд бусдыг ч яг адил зүйлд уриална.

Дээр жагсаасан бүх үйлдэл нь шүтээн шүтлэг буюу Бурханыг хүндэтгэхгүй (хүндэтгэж, үгэнд нь орохгүй), Бурханы хүлээн авах бүрэн эрхтэй талархлыг нь өргөхгүй байх үндсэн асуудлын үр дагавар юм. Бид Бурханыг амаараа бус, харин Түүнд хандах хариу зан үйлдлээрээ л жинхэнээсээ хүлээн зөвшөөрдөг. Энэ нь бүх хүн төрөлхтөнд хамаатай. Гэхдээ бүгдээрээ энэ бүхэн нь Бурхантай харилцаа тогтоосон хүн дээр яаж хэрэгждэг дээр анхаарлаа хандуулья.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Хүндэтгэл мөргөл нь Бурханыг дуулгавартай дагах, хүндэтгэх, талархах сонголт юм. Бид энэ жинхэнэ хүндэтгэлийн аль нэг бүтцийг орхигдуулбал, шүтээн мөргөл рүү дагуулдаг заль мэхд урхидуулна. Энэ нь хувь хүмүүст ч, соёл иргэншилд ч хамаатай.

Абрахам Бурханы үгэнд орж, Исаакийг тахил болгон өргөхөөр явсан нь Бичээс дээр тэмдэглэсэн анхны хүндэтгэл мөргөл байв. Тэгвэл Бурхан танд юу хий гэж хэлсэн бэ? Библи уншиж байхад чинь Ариун Сүнс таныг уриалан дуудсан ямар нэг зүйл байж болно. Эсвэл танд онцгой сэтгэгдэл төрүүлсэн зүйл байж болно.

Энэ бүлэг Бурханаас хүлээн авсан даалгавартаа хандах бодлыг чинь өөрчлөв үү? Өөрчилсөн бол, одоо тэр даалгавраа биелүүлэхийн төлөө ямар, ямар алхам хийх ёстойг Бурханаас асуухын сацуу энэ даалгаврын төлөө таныг сонгосонд, танд айлдсанд, даалгаврынхаа төлөө Бурханыг хүндэтгэж, дуулгавартай алхаж явахад чинь тантай хамт байгаад нь Түүнд талархаарай.

ИТГЭГЧ ХҮМҮҮСИЙН ШҮТЭЭН МӨРГӨЛ

Дэлхийн хүмүүсийн шүтээн мөргөл адгийн явдал боловч, энэ явдал амьд Бурхантай гэрээ тогтоосон хүмүүсийн дунд байна гэдэг үгээр хэлшгүй аймшигтай.

Иаков ийм төрлийн шүтээн мөргөлийг завхайрал гэсэн. Учир нь бид Бурхантай гэрээ тогтоосон улс учраас, шүтээнд мөргөхдөө өөрийнхөө нөхөр Есүс Христээс яг л хань ижилдээ үнэнч бус эхнэр, нөхөр шиг урваж байгаа юм.

Саул хаан ба Амалекууд

Одоо Хуучин гэрээг эхлээд, Шинэ гэрээ рүү хөдөлцгөө. Израиль Бурханаас өвөг Абрахамаасаа эхтэй гэрээг хүлээн авчээ. Бурхан эш үзүүлэгч Самуелаараа Израилийн хаан Саулд: “Тиймээс одоо ЭЗЭНий үг ба дуу хоолойг сонсогтун” (1Самуел 15:1) гэж хэлүүлжээ. Бурханы хүсэл ямар ч алдаагүй, тодорхой байдаг. Бурхан Саулд Амалекийг хүйс тэмтэрч, эр эм, хүүхэд хөгшид, мал сүрэггүй бүгдийг нь хядахыг тушаав. Бурхан Египетээс дөнгөж чөлөөлөгдөөд, ядарч явсан Өөрийнх нь хүмүүс рүү Амалекууд дайрч давшилж байсан эртний өсийг санан, тэднийг арчиж хаяхыг хүсчээ. Саул ч үтэр түргэн цэргээ цуглуулаад, Амалек руу довтлов. Гэтэл ийм явдал болов:

Саул Хавилагаас Египетийн өмнө орших Шурын хязгаар хүртэл амалекчуудыг бут цохив. Тэрээр амалекчуудын хаан Агагийг амьдаар нь барин олзолж, ард олныг нь илдийн ирээр хүйс тэмтрэв. Харин Саул ба түүний ард олон нь Агагийг бас хамгийн сайн хонь, үхэр, тарган тугал, хурга хийгээд сайн бүхнийг хэлтрүүлж, тэр бүгдийг бүрмөсөн сүйрүүлэхийг үл хүсэв. Тэд муу, үнэ цэнэгүй малыг харин бүрмөсөн устгажээ. (1Самуел 15:7-9)

Израильчууд Саулыг Эзэний үгийг дагалаа л гэж үзсэн байх. Гэтэл Бичээс: “Би Саулыг хаан болгосондоо харамсаж байна. Учир нь тэр Намайг дагахаас буцан эргэж, Миний үг зарлигийг үл сахив гэв. Самуел уурлан бухимдаж, бүхэл шөнөжингөө ЭЗЭНд хандан хашхиран уйлав” (1Самуел 15:10-11) гэж хэлсэн байх юм. Саул Бурханыг зохих ёсоор хүндэтгэж, дуулгавартай дагалгүй, урважээ.

Нэг аав надтай уулзаж, зөвлөгөө авч билээ. Өсвөр насны хүү нь үгэнд нь дутуу хагас орсон болоод, дараа нь дураараа аашилдгаас нь болоод (голдуу найзуудтай гадуур тэнэдэг) тэр аав яах учраа олохоо больжээ. Тэрбээр хүүтэйгээ тулж ярихаар хүү нь: “Та дандаа ингэж хатуурхах юм! Би таны хийгээрэй гэснийг чинь бараг ерэн хувь хийдэг. Гэтэл та дандаа чамладаг. Та миний хийсэн ерэн хувийг хэзээ ч хардаггүй, дандаа хийгээгүй арван хувийг хардаг” гэж уцаарладаг гэнэ. Тэгээд тэр аав бүр яах ухаанаа олохоо больжээ.

Тэгэхээр нь би тэр аавд: “Зүгээр ээ, Бурхан ч чамладаг” гэж хэлсэн юм. Тэгээд Саулын дээрх түүхийг ярьж өгөв. Саул наад зах нь зуун мянган эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдийг алсан байх. Дээрээс нь авч үлдсэнээсээ хэдэн мянга илүү хонь, ямаа, мал сүргийг хядсан байх. Тиймээс Саул Бурханы үгийг бараг ерэн хувь биелүүлсэн гэж чөлөөтэй үзэж болно. Гэтэл Бурхан Саулыг Өөрийнх нь үгнээс гарсан гэхээр барахгүй, түүний үйлдлийг “гэрслэл” (23-аар ишлэл) хэмээн үзжээ.

Библийн энэ түүхээс тэр аав хүүгийнхээ алдаатай хандлагыг олж ухаарсан юм.

Үнэндээ Саул хаан Бурханы хий гэснийг бараг ерэн есөн хувь биелүүлсэн байх. Гэтэл Бурхан яагаад Саулын хийсэн зүйлс дээр биш, хийгээгүй ганц хувь дээр төвлөрнө вэ? Хүмүүс үүнийг чамламтгай зан гэж үзэх байх л даа. Гэтэл Бурхан дутуу

хагас дуулгавартай байдлыг дуулгавартай байдалд эс тооцохоор барахгүй, харин ч бүр тэрслэл гэж үздэг. Энэ нь Бурханд очих ёстой, бүрэн эрхт хүндэтгэл мөргөлийг нь зүй ёсоор өргөхгүй байх явдал юм.

Буруугаа хүлээлгүй, биеэ зөвтгөж байгаа Саултай Самуел нүүр тулахдаа, тахилд өргөсөн малын талаар ярьжээ. Саул хамаг бурууг хүмүүс рүү чихэх гэж оролдсон ч, Самуел түүнд шууд: “Үгүй ээ, хариуцлагатан нь чи! Чи л Бурханы үгэнд ороогүй” гэсэн утгатай үг хэлжээ. Тийнхүү эш үзүүлэгчийн үгд шахуулсан Саул Самуел шүтээн мөргөлийн талаар нэг гайхмаар үнэнийг хэлэв:

Тэрслэл нь мэргэ төлгийн *адил* нүгэл бөгөөд гөжүүдлэх нь ёс бус агаад шүтээнд мөргөх *адил* билээ. Чи ЭЗЭНий үгийг үл хэрэгссэн тул ЭЗЭН бас чамайг үл хэрэгсэж, чи хаан байхаа болилоо гэв. (1Самуел 15:23)

Эхлээд “гөжүүдлэх нь... шүтээнд мөргөх *адил*” гэсэн үгийг үзье. Гөжүүдлэх гэдэг нь “түлхэх”, “дарах” гэсэн утгатай болно. Саул үнэнийг, бүрэн төгс дуулгавартай байдлыг түлхэж холдуулжээ.

Дараа нь ташуулдуулж тэмдэглэсэн “*адил*” гэдэг үгийг (энэ үг эх сурвалж дээрээ байхгүй) авч үзье. Үнэндээ Еврей дээрээ ийм үг байхгүй бөгөөд уншихад урсацтай болгохын тулд орчуулагч нар энэ үгийг нэмжээ. Яг үнэндээ: “гөжүүд зан нь ... шүтээнд мөргөх явдал мөн” гэж орчуулбал зөв болно.

Үнэндээ хүн үнэнийг мэдэхдээ, Бурханы хүслийг мэддэг, Бурханы юу айлдсныг мэддэг боловч, өөрөөсөө зайлуулж түлхээд, дуулгавартай дагахгүй байх нь шүтээнд мөргөх явдал ажээ. Шалтгаан нь? Тэд хүсэл, хүслэн, санаа, зоргоо Бурханыхаас дээгүүр тавьдаг ажээ. Энэ бүхэн нь Бурханаас дээгүүр орших бөгөөд харин Бурханаас дээгүүр тавьж байгаа бүхэн нь шүтээн болдог.

Саул өөрийгөө “Бурханыг дагасан” гэдэгт итгэсэн бөгөөд үүнийгээ ч мэдэгдсэн боловч, үнэндээ бүрэн дагалгүй, харин хүмүүсийн хүслийг (үнэндээ бол өөрийнхөө хүслийг) Эзэний Үгээс дээгүүр тавьж, урьтал болгосон нь шүтээнд мөргөх явдал байв. Шүтээн мөргөл нь түүнийг Эзэнд хүндэтгэлгүй хандаж байгаагаа ч харах нүдгүй болгожээ.

Ром ном дээрх бүх хүн төрөлхтөний талаар хэлсэн үг нь Саулд ч бас хамаатай буюу. Саулын шүтээн мөргөлийн үндэс нь баримал хөшөө, дүр дүрс, овоо тахилга, сүм дуган байгаагүй. Харин Бурханыг бүрэн хүндэтгээгүй, илчилж өгсөн үгийг нь бүрэн дагаагүй явдал байв. Саулын энэ гол авир үйлдэл нь түүнийг өөрийн мэдэлгүй үнэнийг худлаар сольж, мэхлэгдэхэд хүргэжээ. Тэгээд үүнээсээ болж “мунхагаар сэтгэн”, “хийх ёсгүй зүйлээ хийв”. Шүтээн мөргөлийн эмгэнэлт үр дагавар нь Саулыг бүр ч илүү ёрын муу хэрэг хийхэд хүргэсэн юм. Тэр атаархуу, нэхэн шаардагч, үндэслэлгүй, уур хилэндээ баригдсан, Бурханы зарц нар руу дайрч давшилсан, алуурчин, тэр бүү хэл Бурхантай биш, харин илбэ жатгач нартай зөвлөлддөг нэгэн болсон юм. Эдгээр нь Саулын шүтээн мөргөлийн үйлээс үр хөвөрсөн нэг хэсэг л зан чанар нь юм шүү.

Бурхантай харилцаатай атлаа Түүний Бичээст тов тодорхой илчилсэн зүйлээс хувийнхаа хүслийг дээгүүр тавьдаг хүмүүс нь өөрийнхөө дуулгаваргүй байдалд сохрох нь олонтаа. Шүтээн мөргөл нь Саулыг сохлосон шигээ биднийг ч сохлодог. Тийнхүү тэд үнэнийг худлаар солиод, Бурхан тэдний талд байсаар, тэдний зүрх сэтгэлийг ойлгосоор байгаа учраас, зан үйлдлийг нь хүлцэж, амьдрах хэв маягийг нь зөвшөөрч байна гэж боддог ч, үнэндээ өөрсдөө Бурханы эсрэг талд гарчихсан, Бурханы дайсан болчихсон явж байдаг.

Ханамж

Дараагийн түлхүүр үгсийг онцлон тэмдэглэж, шүтээн мөргөлийн удаах талыг танилцуулъя. Эхнийх нь “хангалуун” (ханамж). Үүнийг *Мириам-Вебстер* дээр “өөрийнхөө эзэмшил, байр суурь, нөхцөл байдалдаа сэтгэл хангалуун байгаагаа мэдрэх юмуу харуулах байдал” гэж тодорхойлжээ. Үүнийг Грекээр голдуу *аркео* гэж хэлдэг бөгөөд энэ нь “хангах, хангалттай байх, ханамжтай байлгах; хүчтэй байж, хэн нэгэнд туслах” гэсэн утгачилсан утгатай болно.” (WSNTDICT)

Бид сэтгэл хангалуун байсан нөхцөлд л зүй ёсоор үйлчилнэ. Энэ чанараар хомс хүн юм бүхэнд: “Энэ надад ямар ашигтай вэ?” гэдэг үүднээс ханддаг. Тэрбээр гаднах үг үйлдлээрээ амиа бодоогүй,

өөрийгөө няцаасан байр байдалтай байж болох ч, сэтгэлдээ хангалуун биш бол, амиа бодсон сэдлээр л дүүрсээр байна.

Паул чуулганд: “Би үүнийг дутагдсаны улмаас ярьж байгаа юм биш. Учир нь би байгаадаа сэтгэл хангалуун байж сурсан юм” (Филиппой 4:11) гэдэг. Паулд хэрэгтэй бүхэн нь байжээ. Гэхдээ тэрбээр өөрийнхөө ашгийн төлөө бус, харин тэдний төлөө бэлэг хайдгаа үйлчилж байсан хүмүүстээ дөнгөж сая хэллээ. Паул Бичээсийг худлаа юмуу давслаж бичиж чадахгүй учраас, энэ нь “политиктай” мэдэгдэл биш, харин үнэхээр түүний сэдэл байсныг мэдэж болно. Тэгвэл гагцхүү үнэхээрийн төгс хангалуун хүн л жинхэнэ хэрэгцээ дундаа ийм амиа эрээгүй байж чадна.

Энэ шалтгаанаар л Паул итгэгчид бидэнд “Харин итгэл сүсэг ба сэтгэл хангалуун байдал нь хамтдаа агуу ашиг мөн ... Хэрэв хоол хүнс, хувцас хунар байвал эдгээрээр бид сэтгэл хангалуун байх болно” (1Тимот 6:6, 8) гэжээ.

Энэ нь яг ямар хангалуун байдал болохыг би Эзэнээс асууж билээ. Гэтэл Эзэн зүрхэнд маань: “*Миний хүсэлд бүрэн төгс хангалуун байх*” гэж хариулсан юм. Эзэн Есүс маань яг ийм хангалуун байдлыг амьдралаараа харуулсан билээ. Үүнийгээ ч тэрбээр байнга хэлдэг байв: “Миний хоол бол Намайг илгээсэн Түүний хүслийг үйлдэн, ажлыг нь гүйцэлдүүлэх явдал юм” (Иохан 4:34). Түүний Бурханы хүсэлд хичнээн хангалуун, бүрэн үнэнч байсныг Мессаиаг эш үзүүлсэн магтаал дээр ч хэлдэг: “Бурхан минь ээ, Таны тааллыг би гүйцэлдүүлэх дуртай. Таны хууль зүрхэнд минь бий” (Дуулал 40:8). Бурханы хүслээс гадуур дур хүсэл гэж Түүнд байсангүй. Түүнд Аавынхаа хүслийг биелүүлэх ганц хүсэл зорилго л байжээ.

Хангалуун байдлыг өөртөө хахсан байдалтай эндүүрч болохгүй. Энэ хоёр нь тэс өөр ойлголт юм. Есүс “...чанга хашхиран, нулимсаараа залбирал ба гуйлтаа өргөж...” (Еврей 5:7) байсан. Есүс мөнгө солигчдын ширээг хөмөрч, зовлон туулахынхаа өмнө дагалдагч нартайгаа зоог барихыг ихэд хүсэмжилсэн. Есүс хүмүүсийг хүлээстэй, өвчтэй, төөрөлдсөн байгаатай эвлэрээгүй. Есүс дарлагдсан хүмүүсийг өмгөөлдөг Дайчин байв. Тийм боловч Есүс Өөрийнхөө хувийн хэрэгцээ, хүслийн тал дээр хангалуун байжээ.

Энэ хангалуун байдлаас л Түүний: “Амьд Эцэг маань Намайг илгээсэн бөгөөд Би Эцэгээр амьдрахын адил Намайг идэгч нь мөн

Надаар амьдарна” (Иохан 6:57) гэдэг үг гарчээ. Энэ хангалуун байдлынхаа улмаас л Есүс: “Би хаанаас ирснээ, хаашаа явахаа мэднэ” (Иохан 8:14) хэмээн зоригтой мэдэгдэж, дэлхийн мэдэхгүй тогтвортой, аюулгүй байдлыг авчирсан юм. Үүнийхээ улмаас л Есүс эргэлзээгүй, айгаагүй бөгөөд төгс Зарц байв!

Шунал

Шүтээн шүтлэгийг тодорхойлогч хоёрдахь үг нь “шунал” бөгөөд энэ нь хангалуун байдлын эсрэг зүйл юм. Өнөөдөр бид энэ үгийг өдөр тутамдаа нэг их хэрэглэдэггүй боловч, Бичээсийг хүлээн зөвшөөрч, ойлгохын тулд утгыг нь тодорхой болгох ёстой.

Тэгэхээр эхлээд Англи дээр юу гэж тодорхойлсон байдгийг үзье. Вебстерийн нэг тодорхойлолт нь “аливаа нэг эд хөрөнгийг өөрийн болгох, эрхшээх үлэмж дур хүсэл” гэжээ. Тэгвэл Грек үг нь бүр ч хүчтэй дүрслэлтэй үг байдаг. Энэ талаар үзэхээсээ өмнө эхлээд Колоссай дахь *шуналын* талаар Паул юу гэж хэлснийг үзье:

Тиймээс хэрэв та нар Христтэй хамт амилуулагдсан л юм бол дээгүүрхийг хай. Тэнд Бурханы баруун талд Христ заларч байгаа. Газар дээрхийг бус дээгүүрх зүйлсийг эрмэлз. Учир нь та нар үхсэн бөгөөд та нарын амь Христтэй хамт Бурханд нууцлагдсан. Бидний амь болох Христ илчлэгдэх үед та нар ч бас яруу алдар дотор Түүнтэй илчлэгдэх болно.
(Колоссай 3:1-4)

Паул бидэнд *хангалуун байх* түлхүүрийг хэлжээ. Бид Есүс Христээр дамжин Аугаа хүчирхэг Бурхантай гэрээ байгуулсан гэдгээ өөрийн болтол ойлгох юм бол, юугаар ч дутахгүй - нэг ч дутахгүй гэдгээ ухаарна. Хаанчлал биднийх болохыг Есүс айлдсан. Тиймээс бид Түүний хаанчлалыг хоёрдугаарт, гуравдугаарт биш, нэгдүгээрт тавих юм бол, хэрэгтэй бүхэн маань бидэнд нэмэгдэх болно.

Дайсан ч анх Есүсийн энэ тал руу л довтолсон байдаг. Цөлд Сатан Есүсийг хэрэгцээгээ Аавынхаа хүслээс гадуур хайхад уруу татсан. Нөхцөл байдал ч үнэхээр хүнд байв. Дөч хоногийн өлсгөлөнгийн дараа Есүс аймшигтай их өлсөж байлаа. Дайсан

Есүсийг сувдаг байдалд урвуулж дөнгөнө хэмээн найдсан боловч, Есүс тагталзжээ. Үүний дараа тэнгэрэлч нар ирж, Есүсийг тэнгэрийн хоолоор хооллов! Есүсийг дөнгөх дайсны төлөвлөгөө нурсан хэдий ч, тэр энэ төлөвлөгөөгөө бидний эсрэг ашиглахгүй гэсэн үг биш юм! Дайсан биднийг тэнгэрийн хангамжид ханалгүй, өөрийнхөө замаар хангалуун болохыг эрэлхийлдэг хүмүүс болгохыг л зорьдог.

Бурханыг хайдаг хүмүүс нь хүссэнээ авах гэж Бурханыг ашигладаг бус, харин Бурханы зүрх, тааллыг хүсэн тэмүүлж, дээд зүйлсийг бодож явдаг хүмүүс юм. Бид ийм байж чадбал, Есүс шиг л болж, Илгээгчийнхээ хүслийг биелүүлэх хүсэл тэмүүлэлтэй болно. Гэхдээ хамгийн гайхамшигтай нь бид яг Есүс шиг хаанчлалын жинхэнэ зарц болсон учраас дахин айж, төөрөлдөхгүй!

Паул цааш нь:

Тиймд та нар газар дээрх эрхтнүүдийг үхүүл. Энэ нь садар самуун, бузар булай, тачаал, муу хүсэл, шунахайрал болох шүтээн шүтэх явдал юм. Эдгээрээс болж Бурханы хилэн [дуулгаваргүй хөвгүүд дээр] ирэх болно (Колоссай 3:5-6) гэжээ.

“Шунахайрал нь шүтээн шүтэх явдал юм” гэсэн Паулын үгийг үзнэ үү. Энэ бол шүтээн мөргөлийг таних дараагийн оньс юм. Хөшөө баримал, овоо тахилга, сүм дугантай улс үндэстэн дундаас шүтээн мөргөлийг таних амархан. Тэгвэл “соёлжиж иргэншсэн” улс дундаас шүтээн мөргөлийг танихын тулд нарийн ойлголт, ялгах хараа хэрэгтэй. Паул биднийг хангалуун сэтгэлээ алдаж, ханаж цадахаа мэдэхгүй сувдаг болбол, Бурхантай тогтоох ойр дотно харилцаагаа алдаж, шүтээн мөргөл, завхайралд унана гэжээ.

Одоо дээрх ишлэлд шунал хэмээн буулгасан *плеонексия* гэдэг Грек үгийг авч үзье. Би үүний утгыг гурван баталгаат эх сурвалжаас тодорхойлъё:

Пиллар: “Улам ихийг хүсэх зохисгүй хүсэл.”

БиДиЭйЖи: “Байх ёстойгоосоо илүүг хүсэх.”

СиСиИй: “Энэ бол өөрийгөө шүтсэн, булаагч сүнс юм.”

“Өөрийгөө шүтсэн, булаагч сүнс” гэсэн хамгийн сүүлийн тодорхойлолт дээр анхаарлаа хандуулъя. Бид хаанчлалыг бүхний түрүүнд тавихгүй, анхаарлаа хаанчлал дээр хандуулахгүй бол, амьд үлдэх гэсэн горим руу гулсаж орно. Тийнхүү бид ханамж өгнө гэж бодсон зүйлээсээ л зуурч, өөрийгөө шүтсэн байр сууриасаа таалал, баялаг, материаллаг олз, алдар нэр, хэргэм зэрэг, байр суурь, нэр хүнд, нөхөрлөл, амжилт, хүч, эрх мэдэл, тачаал зэргийг хайж, юунд ч сэтгэл ханахаа болино. Тэгээд Бурханы өгдөг амар тайван, амралтыг алдах учраас, зогсоо зайгүй хөдөлмөрлөнө. Бид Бурханы бидэнд зориулсан төлөвлөгөө, үйл явцтай сөргөлдөнө.

Хангалуун байдал, шунал нь эсрэг тэсрэг хүч болох нь тодорхой байна. Хангалуун байдал нь биднийг шүтээн мөргөлөөс холдуулж, Бурханд улам ойртуулдаг бол, сувдаглал нь биднийг Бурханаас холдуулж, шүтээн мөргөлийн тахилын ширээ рүү ойртуулдаг. Энэ хоёр эсрэг тэсрэг үгийн эсрэг тэсрэг утга нь тэдгээрийн ялгааг бүр ч тодорхой болгож байна. Еврей номын бичээч яагаад ийм зоригтой үг хэлэх болсон нь ч ойлгомжтой ажээ:

Байгаа юмандаа сэтгэл *хангалуун* байж, амьдрал чинь мөнгийг хайрлахаас (*шуналаас*) чөлөөтэй байг. Учир нь Тэр Өөрөө “Би чамайг хэзээ ч орхихгүй мөн чамайг хаяхгүй” гэж айлдсан. Тиймд бид зоригтойгоор “Эзэн миний туслагч. Би айхгүй. Хэн надад юу хийж чадах вэ?” (Еврей 13:5-6)

Бурханлаг ханамж нь ямар ч хорон нөхцөлд бидэнд итгэл өгдгийг дараагийн бүлгээрээ сурна. Энэ нь биднийг итгэгчдийг урхихдах санаатай дэлхийн занганаас хамгаална. Хангалуун байдалд хүний ухаанаас давсан ашиг, амар тайван оршдог.

Тэгвэл шунал нь эсрэгээрээ тайвшралгүй байдлын оршихуй бөгөөд дуусашгүй хүсэл, тэмүүллээр дүүрдэг. Энэ нь мэхлэл, сүйрэлд зайлшгүй хүргэх нөхцөл юм.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бурханы Үгийн үнэнийг тодорхой ойлгох нь амин чухал буюу. Энэ нь бичигдчихсэн учраас, бидэнд ямар ч шалтаг байхгүй. Хэн ч Бурханы өмнө зогсоод: “Гэхдээ Эзэн минь, би мэдээгүй!” гэж хэлж чадахгүй. Бурхан бүтээлээрээ дамжуулан Өөрийгөө хүн төрөлхтөнд илчилсэн учраас, тэдэнд шалтаг байхгүй гэдэг шиг Бурхан хүслээ Бичээстээ илчилсэн учраас, бидэнд ч шалтаг байхгүй.

Дутуу хагас дуулгавартай байдал нь шүтээн мөргөл гэдгийг сонсох нь амаргүй боловч, бид үүнийг мэдэж авсандаа баярлах ёстой. Шалгалтан дээр юу ирэхийг мэдбэл, тухай бүр амархан даваад гарна. Энэ бол Бурханы сайн сайхан бөгөөд өршөөл юм!

Хэзээ хаана дутуу хагас дуулгаваргүй авирлаж, гөжүүдлэж, сувдагласнаа мэдэх амаргүй учраас, Ариун Сүнснээс лавлаж асуу. Ариун Сүнсний харуулсан аливаа зүйлийг гэмшиж, дараа нь Түүний цэвэрлэгээг гуйгаарай. Эцэст нь Түүнээс амьдралыг чинь цоо шинээр дүүргэж, Түүнийг бүх зүрхээрээ дуулгавартай дагах хүч хайрлахыг гуйгаарай.

ДАРАМТАА ХӨНГӨЛӨХ

Өмнөх бүлэгт шүтээн мөргөлийн: гөжүүдэл, шунал гэсэн хоёр талыг танилцуулсан. Тэгвэл эдгээр нь хөтлөлцөж явдаг учраас, одоо хоорондын уялдаа холбоог нь авч үзье. Эдгээр нь хэрхэн гар нийлж ажилладгийг мэдэж авбал, итгэгч хүнийг юу криптонитад эмзэг болгодгийг мэдэх мэдлэг маань нэг шат ахина.

Хүнд байдал

Саулын тухай яриандаа эргээд оръё. Тэрбээр Бурханы хүсэл дотор байгаадаа сэтгэл хангалуун байгаагүй. Гөжүүд зан нь түүнийг шунаг болгожээ. Амалек дээр гаргасан алдаа нь Саулын гаргасан анхны алдаа биш юм. Саул хаанчлалынхаа эхэн дээр Филистинчүүдтэй тулалдахдаа бас л том алджээ. Филистинчүүд гурван мянган тэрэгтэй (тухайн үеийн танк), далайн эргийн элс мэт тум буман явган цэрэгтэй, нүсэр том арми цуглуулаад, Израиль руу дайрахаар Михмашт буудаллав.

Хажууд нь Саулын цэргүүд юу ч биш байв. Тэд дөнгөж байгуулагдсан, шинэхэн ардын арми байв. Тэгээд ийм явдал болжээ:

Израильчууд аюулд орсноо (цэргүүд хүчтэй шахагдсаны улмаас) хараад агуй, бут сөөг, хавцал, газар доорх нүх, худагт нуугдав. Мөн еврейчүүдийн зарим нь Иорданыг гаталж, Гад болон Гилеадын нутагт очжээ. Харин Саул Гилгалд байсаар, түүнтэй цуг байсан ард олон айн дагжиж байлаа.

(1Самуел 13:6-7)

Саулын дээр ямар их дарамт ирснийг төсөөлж байна уу? Та бол удирдагч, командлагч, хаан бөгөөд танай нялх арми туршлагатай, хүчирхэг олон тооны цэрэгтэй нүүр тулжээ. Тиймээс Саулын цэргүүд сайн дураараа тарцгаан, түүний хамгийн том айдас нүдэн дээр нь биелж байв. Гэтэл тэр өдөр Саулын ганц “олимпийн найдвар” болсон эш үзүүлэгч Самуел ирж, Эзэнд тахил өргөснөөрөө цэргүүдийн хаандаа итгэх итгэлийг сэргээж, тулаан хийх эр зоригийг нь бадрааж өгөх ёстой байсан боловч, харамсалтай нь нэг асуудал гарчээ:

Самуелын тогтоосон хугацаа болох долоо хоног Саул хүлээсэн боловч Самуел Гилгалд ирсэнгүй. Ард олон түүнийг орхин тарцгааж байв. Тэгэхэд Саул —Шатаалт тахил болон эвийн тахилуудыг надад энд авчрагтун гэв. Тэгээд тэр шатаалт тахил тахив. (1Самуел 13:8-9)

Бурхан Саулд тахил өргөх эрх олгоогүй нь хэнд ч нууц биш байв. Энэ ёслолыг тахилч л (Самуел эш үзүүлэгч бөгөөд тахилч байв) гүйцэтгэх ёстой байлаа. Гэхдээ “Ийм дарамттай нөхцөлд аргагүй шүү дээ. Саулын зөв. *Арга ядсан үед арга ядсан л арга хэрэглэнэ*” гэж үзэж болох. Гэтэл энэ үзлийг Самуелийн дараах үг шувтарч хаяжээ:

Үзэгтүн, түүнийг шатаалт тахил тахиж дуусмагц Самуел ирэв. Саул түүнийг угтан мэндчилэхээр гарчээ. Харин Самуел —Та юу хийв? гэсэнд Саул —Ард олон намайг орхин тарцгаахыг би харж бас та ч тогтоосон хугацаандаа ирсэнгүй, филистчүүд ч Михмашт цугларсан тул би “Филистчүүд Гилгалд миний эсрэг одоохон ирэх нь, бас ЭЗЭНий тааллыг би гуйгаагүй байна” гээд би өөрийгөө хүчилж, аргагүй

шатаалт тахил тахив гэж хариулав. *Самуел*, Саулд —Та мунхаг хэрэг үйлдэв. Та Бурхан ЭЗЭНийхээ танд тушаасан зарлиг тушаалыг сахисангүй. Ингээгүйсэн бол ЭЗЭН таны хаанчлалыг Израильд мөнхөд тогтоох байсан. Гэвч одоо таны хаанчлал үргэлжлэхгүй. ЭЗЭН Өөртөө зүрх сэтгэлийнхээ дагуух хүнийг хайн олж, тэр хүнийг Өөрийн ард түмний удирдагчаар томилсон. Учир нь танд ЭЗЭНий тушаасныг та сахин биелүүлсэнгүй гэв. (1Самуел 13:10-14)

Эш үзүүлэгч нар яг л ингэдэг - аливаа эргэлзээг шувтарч хаяад, биднийг Эзэний тушаал дээр авчирдаг. Хүнд хэцүү үед хүмүүс Бурханы хүслийг дороо мартдаг. Саул хангалуун бус, аймхай зангийнхаа үйлдлээр “бэрх цагт Бурханыг дагахгүй ч байж болно” гэдэг санааг Израилийн эрчүүдэд халдаажээ. Гэхдээ энэ худлаа! Хэцүү үед ч, амархан үед ч Бурханыг дагах ёстой.

Саулын аймхай зан нь зүгээр л түүний хангалуун бус байдлын илэрхийлэл байв. Саул эргэн тойрныхоо бүх зүйлийг хяналт дороо байлгахыг хүссэн боловч, нөхцөл байдал тэс өөр байв. Саул өөр дээрээ ирсэн дарамтыг үзэн ядаж, үүнээс дайжихын түүс болжээ. Түүний сэтгэл хангалуун бус байдал нь хүссэн амар тайвнаа ямар ч аргаар хамаагүй олж авахад хүргэсэн байна.

Бид бүгдээрээ нэг үнэнээс тас зуурах ёстой: Бид Бурханд үйлчлэхдээ, дайсагнал, бэрхшээл, зовлон үзнэ. Есүс ч үүнийг баталгаажуулсан: “Ертөнцөд та нар зовлонтой байна” (Иохан 16:33). Дайсагнал нь бидний итгэлийн хүчийг тодорхойлдог. Итгэл маань ганхаж байвал, бид итгэлийн хэмжүүрт хүрэхгүй байвал, энэ нь Бурханыг тэнхээ мэдэн дуудах, Түүний Үгийг эрэн хайх, Түүний Сүнснийг хүлээх цаг юм. Бид эдгээрийг хийбэл, урьд урьдаасаа ч хүчтэй хүн болж гарна.

Итгэл бол газар дээрх бүх эд хөрөнгөөс үнэтэй эд юм. Ингээд бодоод үз: Хэрэв танд баталгаатай бизнесийн төлөвлөгөө, дээрээс нь хөрөнгө оруулах мөнгийг нь өгбөл, та яах вэ? Гомдол гаргаад л: “Дэндүү хэцүү юм, дэндүү их ажилтай юм!” гэж хэлэх үү? Эсвэл боломжийг шүүрч аваад, тэр баттай төлөвлөгөөг биелүүлэх үү? Шууд ажилдаа ороод, онцсайн үр дүн хүлээх бус уу?

Тэгвэл та өөрөөсөө том дайсантай тулгарах бүрийдээ, яг ингэх ёстой юм шүү. Бурхан ч танд заавал ийм боломж олгоно. Бурхан

таныг зовоох гэсэндээ бус, харин илүү *том итгэлийн шагналд* хүргэх гэсэндээ л тэр.

Өөр нэгэн хүнд байдал

Тэгвэл Давидыг аваад үз. Тэр бүр ч аймшигтай нөхцөл байдалд орж явсан.

Давид болон түүний “газар дээрх зургаан зуун найзаас” хүмүүс нүүр буруулжээ. Амьдрал амар байсангүй. Тэгтэл нэг өдөр бүр ч хэцүүджээ. Давид Зиклаг дахь гэртээ эргэж иртэл, эзгүй хойгуур нь Амалекууд довтлоод, эхнэр хүүхдүүд, эд хөрөнгө - хамаг л өнгөтэй өөдтэй бүхнийг нь авч, үлдсэнийг нь шатаагаад, юу ч үлдээлгүй арилсан байв!

Давидад ямар байсныг төсөөлж байна уу? Тэрбээр арван хоёр жил Израилийн цөлөөр нэг ил гарч, нэг далд орж зугтаж явна. Давид энэ хугацаанд гэр бүл, багын найзуудтайгаа уулзаж, хүндэтгэл мөргөлд сууж, олон нийтийн болоод улсын ажилд оролцсонгүй. Тэрбээр өөрийг нь мөрөөр нь мөшгих Израилийн шилдэг цэргүүдээс нэг нуугдаж, нэг бултаж явав.

Байдал дордсоор, сүүлдээ Давид хүмүүсээ дагуулаад хоёр жил харь газар орогножээ. Хэдий болтол ийм байх вэ? Бурханд үйлчилсний шагнал хаана байна вэ? Хэд хэдэн удаа Давидад Саулыг хөнөөх хосгүй боломж олджээ. Тэгсэн бол, энэ их дарамт, зовлон хөнгөрөөд л явчих байв. Гэтэл Давид итгэмжтэй байж, хүлцэн тэвчиж, ийм янзаар арван дөрвөн жилийг өнгөрөөжээ.

Одоо тэгвэл түр зогсоод, өөрийгөө бодоод үз. Та гурван долоон хоногийн зовлонгийн дараа шалдаа буугаад, далан таваараа бууж өгдөг үү? Эсвэл гурван сар, гурван жилийн дараа юу?

Гурван жил тасралтгүй зүдэрнэ гэдэг хэцүү. Гэхдээ Давидын зовлонгийн хажууд бас л юу ч биш юм. Тэгвэл Саул долоо хоног дарамтад байгаад, шууд бууж өгсөн. Тэрбээр Бурханд дуулгаваргүй загнасан ч, хүмүүсийнхээ нүдэнд нэр хүнд, хэргэм зэргээ л авч үлдэхийг сонгожээ. Тэрбээр Бурханаас ирдэг гарцыг хүлээлгүй, өөрийгөө өргөж, нөхцөл байдлыг хөнгөвчлөх замыг сонгосон юм.

Эргээд Давидын түүхээ үзье. Тэрбээр эрчүүдтэйгээ Зиклагт эргэж ирээд, хамаг бүхнээ алдсанаа мэдээд, бөөнөөрөө тамираа

бартлаа уйлжээ. Давид өөрийгөө шалдаа буулаа гэж бодтол, тун удахгүй үүнээс ч дор байдал нүүрлэж, түүний “газар дээрх ганц найз” болох зургаан зуун эрчүүд нь эргээд Давидад уурлаж, тасчиж хаяхдаа тулав!

Түүнээс гадна ард олон бүгд өөр өөрсдийн хөвгүүд охидынхоо төлөө сэтгэл гашуудсанаас болж, Давид уруу чулуу шидэж, алахаар ярилцаж байсан учраас Давид ихэд шаналав. Гэвч Давид өөрийн Бурхан ЭЗЭНээр өөрийгөө зоригжуулав. (1Самуел 30:6)

Ийм ноцтой нөхцөлд Саулын эрчүүд зугтсан. Баталгаа, хүндэтгэл, нэр төр ус агаар шиг хэрэгтэй цагт Саул ганцаараа үлдсэн. Тэгээд Бурханы удирдамжийг зөрчин байж, энэ байдлаасаа гарах арга зам хайжээ.

Тэгвэл Давидын эрчүүд зугтаагүй боловч, Давидыг алахыг хүссэн! Давидын нөхцөл Саулынхаас ч хүнд байна. Саулын сэтгэл ханамжгүй байдал нь Бурханд найдаж, эш үзүүлэгчийг хүлээхийн оронд, дарамтаа хөнгөлөх арга хайхад хүргэжээ. Тэгвэл Давид нилээд өөр үйлдэл хийв:

Түүнээс гадна ард олон бүгд өөр өөрсдийн хөвгүүд охидынхоо төлөө сэтгэл гашуудсанаас болж, Давид уруу чулуу шидэж, алахаар ярилцаж байсан учраас Давид ихэд шаналав. Гэвч Давид өөрийн Бурхан ЭЗЭНээр өөрийгөө зоригжуулав. Дараа нь Давид, Ахимелехийн хөвгүүн тахилч Абиатарт хандан —Ефод авч ирэгтүн гэж гуйсанд Абиатар, Давидад ефодыг авчирч өгөв. (1Самуел 30:6-8)

Давид энэ байдлаас зугтахыг ч хүсээгүй, өөртөө түшсэн төлөвлөгөө ч гаргаагүй. Тэрбээр: “Хангалттай! Бурханд итгэмжтэй үйлчилсэний ашиг гэж байна уу? Би Бурханд хамаг залуу насаа зориуллаа. Тэр л намайг ийм дарангуйлагчийн дор тавьсан. Энэ там шиг амьдралын жинхэнэ хэргийн эзэн нь Бурхан!” гэж хэлээгүй.

Давид хэзээ ч Бурханыг буруутгаагүй. Давид ордонд ч шунаагүй. Тэрбээр зовлон дунд байхдаа, Саулыг алж, Бурханы амласан ёсоор өөрийгөө хаан сэнтийд залж болох байсан ч, тэгээгүй. Давид

Бурханыг хүлээсэн бол, харин Саул хүлээгээгүй. Давид хангалуун зангаа хадгалж, урьгаар Бурханаас асуухыг сонгожээ.

Бурханы чөлөөлөлт, хангамж заавал ирдэг боловч, Бурханы Үгийг зөрчих боломжийн дараа л ирдэг гэх үү дээ. Тухайлбал цөлд Есүс Сатанаар өдөөгдсөний дараа л тэнгэрэлч нар ирж Түүнд үйлчилсэн байдаг. Тэгэхээр ер нь бол ийм маягаар л өрнөдөг. Бид хангалуун байх юм бол, өөрийнхөө аргаар хангагдаж, дэвшихээс сэргийлдэг.

Эргээд Амалек руу

Тэгэхээр Саул - Амалекуудын түүхээ үргэлжлүүлэн үзье. Энэ явдал нь Филистинчүүдтэй өрнөсөн явдлын дараа болжээ.

Тэгвэл Саул юунаас болж Амалекуудын тал дээр дуулгаваргүй загнах болов? Бурхан тийм тодорхой тушаасаар байтал, Саул яагаад хааных нь амийг өршөөж, тарган мал сүргийг нь авч үлдэв. Энэ нь мөн л Саулын Бурханы хүсэлд ханамжгүй, аймхай байдлаас үүдсэн үйлдэл байлаа.

Нэгдүгээрт - яагаад хааныг өршөөх болов? Улс үндэстнийг эзлэх нь том гавьяа бөгөөд тэр үед ялалт байгуулсан хаад ялагдсан улсын хааныг ордондоо авчирдаг заншилтай байжээ. Харь улсын хааныг дундаа авчирна гэдэг нь яг л амьд цом шиг байв. Түүн рүү харах тоолондоо байгуулсан гавьяагаа санана гэсэн үг. Хааны албат, зарц нар нь ялагдсан хааныг барьж үзэх тоолондоо өөрийнхөө хаанаар бахдана. Энэ үйлдэл нь хүний өөрөөрөө сайрхаж, гайхуулах сэтгэлийг бадраадаг бөгөөд нэн ялангуяа аймхай удирдагч нарт энэ тун чухал байв.

Хоёрдугаарт - яагаад тарган хонь, ямаа, үхэр тэргүүтэй мал сүргийг авч үлдэж болохгүй гэж? Гэвч энэ ч бас цэрэг, ард түмнийхээ хүндэтгэл, эрхэмлэлийг хүлээх гэсэн Саулын битүү санаа байжээ. Хэрэв хүмүүстээ Амалекийн сүргийн дээжээс таслаж өгбөл, тэд Саулын өгөөмөр занг нэг насаараа дурсах байв. Тэгээд ирээдүйд сүргээ харах тоолондоо, Саулын шижигнэсэн ялалт, сүр хүч, арга санаа, цэц ухааныг сайрхан ярина. Тэд Бурхан Саултай хамт байгааг харж, удирдлагад нь эргэлзэхээ болино.

Саул шуналаасаа болоод цаг үргэлж магтуулж, сайшаалгаж байхыг хүсэх болжээ. Үнэндээ тэрбээр ялалтынхаа дараа өөртөө

хөшөө босгосон байдаг. Эш үзүүлэгч Самуел Саултай дуулгаваргүй авираас нь болж нүүрэлдэх үед Саул Бурханд дуулгаваргүй хандсандаа зовоогүй атлаа удирдлагын баг, ард иргэдийнхээ өмнө нэр хүндээ алдаж дууслаа гэдэгт л зовниж байжээ (1Самуел 15:30-ийг үзнэ үү). Самуел тогтоосон цагаасаа хоцорч, дээрээс нь бас дөнгөж сая зэмлэснээрээ өөрийнх нь нэр төрийг сэвтээв хэмээн Саул үзжээ. Тэгээд Бурханы өгсөн удирдлагын эрх мэдэл, үнэ хүндийг л дахин сэргээхийг хүссэн нь үнэхээр жигтэй. Саул юу юунаас илүү хүндэтгэл, нэр төр, аугаа байдал, эрх мэдэлд шунажээ. Тэгээд энэ шуналаасаа болоод Бурханы удирдлагыг дагалгүй, гэжсэн юм.

Товчхондоо Саул Бурханы хүсэлд сэтгэл дундуур байв.

Эх ундарга

Тэгэхээр шүтээн мөргөл нь бидний хувьд өөрийнхөө шунаг занг цатгах аливаа зүйлийн эх ундарга болдог байх нь. Энэ нь амьдралын аль ч тал дээр тохиож болно.

Шүтээн нь Бурханы эзлэх ёстой байр суурийг эзлэдэг. Шүтээн нь бидний баяр хөөр, тайвшрал, амар тайван, эрх мэдэл, хүндэтгэлийн эх ундарга болж болно. Бурхан: “Та нар бөхийн мөргөх гэж шүтээн ба сийлмэл хөрөг бүү хий, чулуун багана ч бүү босго, нутагтаа хэлбэрт чулуу ч бүү байрлуул. Учир нь Би ЭЗЭН, та нарын Бурхан” (Леви 26:1) гэсэн. Бид л шүтээнийг бүтээдэг. Бүтээх бүтээхдээ заавал чулуу, мод, үнэт металаар бүтээсэн байх албагүй. Учир нь шүтээний хүч нь бидний зүрхэнд оршдог юм.

Бурханаас дээгүүр тавьдаг аливаа зүйл нь шүтээн юм! Энэ нь Эзэнээс илүү хайрладаг, дурладаг, хүсдэг, анхаардаг зүйлс юм. Шүтээн мөргөл нь хүний хүчээ авдаг бас хүчээ өгдөг зүйл болохыг Эзэн Лиза бид хоёрт илчилж билээ. Итгэгч хүн сэтгэл ханамжгүй болж, Бурханаас өөр эх сурвалжаас сэтгэл ханамжийг хайхдаа шүтээн мөргөлд татагддаг. Энэ нь хүн, эд хөрөнгө, үйл ажиллагаа - ер нь юу ч байж болно.

Тэгэхээр шүтээн мөргөл гэдэг нь зүгээр нэг дүр дүрс, баримал, овоо тахилга, сүм дуганаас хавьгүй том зүйл болохыг та одоо ойлгосон байх аа. Хүмүүс шүтээн мөргөлийг үүгээр л

хязгаарлаж ойлгосноосоо болоод, Бичээсийн амин чухал олон анхааруулгыг тоодоггүй. Бүгдээрээ дараа дараагийн бүлгээрээ шүтээн мөргөлийн үнэн дүр төрхийг үргэлжлүүлэн тайлж, энэ нь манай хорин нэгдүгээр зууны Барууны соёлд хичнээн газар авч, хор хөнөөлөө тарьсаар байгааг харуулна.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бурханаас өөр зүйлээс хүчээ авч, эргүүлээд хүчээ өгөх нь шүтээн мөргөлийн үндсэн хэлбэр ажээ. Шүтээн нь бидний хувьд ямар нэг зүйлийн эх ундарга болдог. Гэхдээ: “Бурхан бидэнд бүхнийг хангаж өгнө, бүгдээрээ ажлаасаа гарцгаа” гэж хэлэх нь буруу юм. Учир нь Бурхан биднийг ажил хөдөлмөрөөр дамжуулж хангадаг болохыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Бурхан гэр бүлээр маань дамжуулан биднийг хайрлаж, бид ч эргүүлээд тэднийгээ хайрладаг ч, Бурханыг эх ундаргаа хэмээн хүлээн зөвшөөрч, хүндэтгэх ёстой. Тэгээд хамгийн чухал нь бид Бурханыг амьдралынхаа эх ундаргаа хэмээн хүндэтгэн, Түүнээс холдуулах бүх сонголтыг эсэргүүцэх ёстой.

Тэгэхээр шүтээн мөргөл нь зүгээр нэг баримал хөшөөнд мөргөхөөс гүн утгатай болохыг одоо та ойлгосон байх аа. Танай хот, нийгмийг эрхшээсэн шүтээн мөргөлийг харуулж өгөхийг Бурханаас гуйгаад, үүний төлөө зуучлан залбир. Тэр газар дээр Бурхан үнэний гэрлээ тусгаж, хүүхдүүдээ гэрэл болгон илгээж, Өөрийгөө Эзэн гэдгийг мэдүүлэхийн төлөө залбир.

КРИПТОНИТ!

Тэгэхээр сүүлийн хэдэн бүлгээрээ сурсан зүйлээ товч сэргээн давъя.

Шүтээний амин сүнс нь хөшөө баримал, дүр дүрс, овоо тахилга, сүм дуган биш юм. Эдгээр нь илүү гүн асуудлын дайвар бүтээгдэхүүн гэж хэлж болно. Шүтээн мөргөл гэдэг нь Бурханы хүсэлтэй нийцэхгүй гэдгийг нь мэдсээр байж, амин хувийнхаа тачаал, хүслийг цагтахын төлөө Бурханы хүслийг хойш тавихыг хэлнэ.

Бурханы талаарх эрэмдэг үзэл нь энэ шуналын л дайвар бүтээгдэхүүн юм. Эцсийн дүнд - хэрэв хүн шүтээн мөргөлтэй нөхцсөн бол, Бурхан Өөрийгөө татаж аваад, түүнийг завхарсан мөн чанарынх нь хүсэн дурласан ичгүүрт зүйлсийг нь үйлдүүлэхээр нүгэлт мөн чанарт нь тушаадаг. Зугаа, таашаалтай хөөцөлдөх нь улам гаарч, эцэстээ амь бус, үхэл ирнэ.

Итгэгч хүн ч ялгаагүй. Христэд итгэдэг хүн аль нэг зүйлийг авах гэж улайрч, Бурханы тодорхой илчилсэн зүйлд хүндэтгэлгүй хандахдаа, шүтээн мөргөлтэй хутгалддаг. Тиймээс шүтээн мөргөл нь үндсэндээ Бурханы хүсэлд *санаатайгаар дуулгаваргүй хандах явдал* юм. Энэ нь итгэгч хүн нүгэл үйлдэж, гэмшихээс өөр юм. Итгэгч хүн *нүгэлд бууж өгөхдөө* шүтээн шүтдэг. Тэр эрэгтэй эсвэл эмэгтэй хүн өөрийнхөө хүслийг Бурханы хүслээс дээгүүр тавихдаа, шүтээн бүтээдэг.

Шүтээн мөргөл нь *сунслэг криптонит* мөн.

Өмнөх бүлгүүдээр үзсэн төрөл бүрийн жишээг эргэцүүлэн бодбол, тэр дунд дандаа зөрчил явж байхыг харна. Иерихогоос олзлосон бүхэн нь Эзэнд зориулагдах ёстойг Ахан мэдэж байсан. Тийм боловч Ахан баригдах үедээ: “Би тэдгээрийг үзээд... шунал хөдлөж, авсан” (Иошуа 7:21) гэж хэлсэн байдаг. ЭнЭлГи Библи дээр “авах гэж улайран хүссэн” гэдэг.

Аханы хувьд өөрийнх нь хүсэл Бурханы хүслээс чухал байв. Түүнд Бурханаас эмээх сэтгэл дутаж, тэрбээр Бурханы Үгийг санаатайгаар зөрчжээ. Аханы санаатай нүгэл нь *шүтээн мөргөлөөс* буюу *сүнслэг криптонитаас* өөр юу ч биш юм. Түүний шүтээн мөргөл нь өөр дээр нь бас гэр бүл дээр нь шийтгэл авчраад зогсохгүй, нийгмийг бүхлээр нь зэрэмдэглэжээ. Израиль доройтож, бусдыг байлдан дагуулах ямар ч чадваргүй болсон.

Коринтын чуулган байс хийгээд л Бурханы илчлэл үгийг үл хэрэгсэн, махан биеийнхээ хүслийг хангадаг байв. Үнэндээ Паул бүр: “махбодынхоороо буюу хүний жишиг дагуу байгаагийнх” (1Коринт 3:3) гэж хэлжээ. Тэд атаархан, бутралдаж, өөр хоорондоо маргалдаж, завхайрч, завхайрлыг үл хайхарч, бие биетэйгээ шүүхдэж, Эзэний зоогт ирэхдээ Есүсийг дурсдаггүй байв. Тэд махан биеийн хуял тачаалаа хангахад л хамаг байдгаараа анхаарч, мэдсээр байж тэнгэрлэг зааврыг зөрчжээ. Тиймээс л Паул: “Тиймд ах дүүс минь, та нар идэхээр цуглахдаа нэг нэгнийгээ хүлээ. Та нар цуглахдаа шийтгэлд унахгүйн тулд өлссөн хүн байвал тэр нь гэртээ идэг. Үлдсэнийг нь би очоод зохицуулъя” (1Коринт 11:33-34) гэж бичжээ. Тэдний шуналаас (шүтээн мөргөлөөс) болж, олон хүн доройтож, өвдөж, зуурдаар үхжээ. Тэд тэнгэрийн элч нар шиг амьдраагүй.

Иаковын үгээ хэлсэн хүмүүсийн хувьд ч ялгаагүй юм. Тэд бие биедээ хорсон атаархаж, амиа бодсон үзлээр хөдлөж, маргалдаж, зодолдсон. Иаков тэдэнд: “Та нар шунадаг бөгөөд та нарт байхгүй” (Иаков 4:2) гэдэг. Энд ч бас итгэгч нар амин хувийнхаа хүслийг хангах гэж л нүгэл үйлджээ. Тэд ийм шүтээнд мөргөснөөсөө болж л “завхай эмсээрээ” дуудуулснаас биш, хөшөө баримал, дүр дүрс, сүм дуган, овоо тахилга босгосныхоо төлөө ингэж дуудуулаагүй. Тэдний хайхрамжгүй хандсан, нэр нь үл мэдэгдэх сүнслэг криптонит нь тэднийг сүнслэг бусаар амьдрахад хүргэсэн байна.

Шүтээн мөргөл нь зүгээр нэг нүгэл биш, харин *мэдсээр байж хийдэг, санаатай* нүгэл юм. Өөрөөр хэлбэл Бурхан юу ч гэж хэлсэн - бид өөрийнхөөрөө л үйлдэнэ.

Цэцэрлэгт ч ингэж л эхэлсэн. Адам, Ева хоёр өөрсдийг нь цэц ухаантай болгочихмоор сайн, ашигтай, ачтай, таатай гэж үзсэн зүйлдээ шунажээ. Тэд Бурханы маш тодорхой хэлсэн зүйлийг зориуд зөрчсөн юм.

Яг энэ үед мэхлэл хойморт гарна. Бид Бурхантай сайн харилцаатай хэвээрээ гэдэгт итгэдэг ч, хэрэг дээрээ худлаа болдог. Харин Бурхан биднийг хайрлаж, санаж сарвайж явдаг учраас, энэ үед бидэн рүү элчээ буюу бидэнд үнэнийг хэлэх зориг зүрхтэй элч, эш үзүүлэгч, пастор, найзыг маань илгээнэ. Нэгэнт мэхлэлийн цайз босч амжсан бол, үүнийг нураах боломжтой ч, чөлөөлөгдөх бас л амаргүй юм. Ийм төрлийн зан үйлдэлд оролцсон хүн “Үнэнийг зүй бусаар нуун дардаг” (18-аар ишлэл) гэж Ромын нэгдүгээр бүлэгт хэлдэг. Бурханы талаарх, Бурханы арга замын талаарх үнэн чөдөрлөгдсөн учраас, өдгөө үүнийг ухаарч, ойлгох хэцүү болжээ. Эцэстээ тэд “... бодол санаандаа хоосорч, ухваргүй зүрх нь харанхуй... өөрсдийгөө мэргэн гэж хэлдэг атлаа тэд мунхаг болдог” (Ром 1:21-22). Тийнхүү үнэн алдуурч, нүглийг өөгшүүлсэн, дураараа амьдралыг хөхиүлэн дэмжсэн элдэв дэмий, завхарсан гаж сургаал бүрэлдэн бий болно.

Шүтээн мөргөлд урвасан итгэгч хүний хувьд ч ялгаагүй. Иаков юу хэлснийг үз: “Гэхдээ өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид байг” (Иаков 1:22).

Бид Бурханы Үгийг тодорхой сонсчихоод, дагахгүй бол, зүрх маань “мэхлэлийн” торонд орно. Тэгээд бид өөрсдийгөө Бурханы, Есүсийн, хаанчлалын өмнө бүрэн зөв алхаж яваа гэж итгэдэг ч, үнэндээ Бурхантай хэдийнээ хөл нийлэхээ больсон байдаг. “Мэхлэх” гэдэг үгийг “үнэ цэнэгүй, хуурамч зүйлийг үнэн бөгөөд үнэ цэнэтэй мэтээр хүлээн авахад хүргэх” гэж тодорхойлжээ (Мириам-Вебстер). Энэ үг таны дотор миний дотор суулгасан шигээ эрүүл саруул айдсыг суулгаж байгаа эсэхийг мэдэхгүй ч, ямар ч байсан тэгж байгаа гэдэгт найдаж байна. Санаатай дуулгаваргүй авир нь хөнгөн хуумгай хандаад байх зүйл биш шүү.

Бурханы нигүүлсэл, уучлал, хайр бүхнийг шийдсэн учраас, Шинэ гэрээний эдгээр анхааруулгыг хэрэгсэхгүй байж болно гэвэл, өөрөөрөө л даажигнасан явдал болно. Шинэ гэрээнд бидэнд Өөрийнхөө нигүүлсэл, уучлал, хайрыг илчилсэн тэр л Бурхан санаатай дуулгаваргүй авирлахын аюулыг илчилдэг юм шүү.

Бид дуртай ишлэлээ сонгоод л, дургүй ишлэлээ өнгөрүүлээд л хаяад байж болохгүй. Энэ сэтгэлгээ нь дуулгаваргүй байдал юм. Бид Бурханы Үгийн зөвлөгөөг бүрэн эхээр нь сонсох ёстой. Харамсалтай нь үл тоох хандлага нь орчин цагийн чуулганы хувьд гамшиг болжээ. Бурхан үнэнийг нуугаад байгаадаа биш, харин чуулган шүтээн мөргөлд идэгдсэн учраас л тэр юм.

Иаков цааш нь:

“Учир нь сонсоод эс үйлдэгч нь төрөлх царайгаа толинд харж байгаа бөгөөд тэрээр өөрийгөө хараад, эргэхдээ ямар байснаа даруй мартдаг хүнтэй адил юм” (Иаков 1:23-24) гэжээ.

Бурханы Үгийг сонсдог атлаа дагадаггүй хүмүүс өөрийгөө Христийн дотор хэн болохыг мартдаг. Тэд Бурханы Үгийг ярьж, чуулган дотор, жижиг бүлэгт, конференц дээр нэг янзаар ашилдаг ч, тэндээс гарахаараа дэлхийн хүнээс ямар ч ялгаагүй авирладаг. Бурханы Үг нь толь бөгөөд тэд тольдож байх үедээ зүй ёсоор л үйлддэг. Эцэстээ бид яагаад дэлхийн хүмүүсээс ялгаагүй амьдарч болох вэ гэдгээ тайлбарлах муруй хазгай сургаал зохиох хэрэгтэй болно. Тэгээд бид: “Тэгэхээр байна шүү - Христэд итгэдэг хүмүүс чинь итгэдэггүй хүмүүстэй л адилхан шүү дээ. Учлагдсан л болохоос биш” гэх юмуу эсвэл “Бурхан хүнийг нүгэлт мөн чанартай учраас, гаднаа хэзээ ч ариунаар амьдарч чадахгүйг мэднэ. Тиймээс л биднийг нигүүлслээрээ хучсан юм шүү дээ” гэж хэлдэг болно.

Бид алдаатай теологио дэмжихийн тулд Бичээсийн захын ишлэлийг утга агуулгаас нь ховхлож аваад, ашиглаж болох ч, анхааруулсан бусад олон ишлэлийг нь хуу хаях ёстой болно.

Бид:

- Нүглийн намагтаа амьдарсаар байхыг хүсч байна уу?
- Бурханы элч болсон бид хүчээ криптонитод соруулмаар байна уу?
- Өөрсдийнхөө зохиосон хуурамч сургаалд итгэхийн тулд байх ёстой хэм хэмжээнээсээ хол доор амьдрахыг хүсч байна уу?
- Дэлхийгээс ялгарах юмгүй амьдарсаар, энэ амьдралаа дуусгаад, тэнгэрт очихыг хүсч байна уу?

- Эсвэл хэдэн бүлгийн өмнө үзсэн шигээ хаанчлалыг өргөжүүлэн тэлж, хожмын алдарт сүмийн (чуулганы) алсын харааг биелэл болгохыг хүсч байна уу?

Бид криптонитыг хүлээн авахдаа, амьд байдал, эрч хүч, дэлхийн бус хүч, дэлхийг орвонгоор нь эргүүлэх чадвараасаа хагацдаг. Үндсэндээ үнэнийг түлхдэг. Бид үнэнийг түлхээд, Есүсийг харуулахгүй гэж дэлхийгээс нуудаг. Тиймээс л Паул Коринтынхон руу:

Та нар зөв ухааралд ир. Нүгэл үйлдэхээ боль. Учир нь заримд нь Бурханы тухай мэдлэг алга. Би та нарыг ичээх гэж үүнийг хэлж байна (1Коринт 15:34) хэмээн хашхичсан юм.

Энэ чуулган Есүс шиг амьдрах чадвартай атлаа шүтээнд мөргөөд байгааг нь Паул хэлжээ. Тэдэнд өөрсдийнхөө зүйлийг Бурханы Үгийн илчлэгдсэн үнэнээс илүү чухал гэж итгэсэн байв. Тэд Бурханы Үгээр сул наадаж, амьдралаасаа үнэнийг түлхэн зайлуулсныхаа гороор хүчээ алдан, догонцож, нийгмээ өөрчлөх чадваргүй болжээ.

Энэ нь олон талаараа эмгэнэлтэй зүйл боловч, тэдгээр шүтээнд мөргөгчдийн эргэн тойронд байгаа хүмүүс, төөрөгсөд Есүсийн жинхэнэ дүр төрхийг олж үзэхгүй нь л хамгийн аймшигтай. ЭнКэйЖэйВи Библи дээр энэ ишлэлийг “Зөв байдалд сэргэг байж, нүгэл бүү хий. Учир нь зарим нь Бурханыг мэдэхгүй. Би та нарыг ичээсэй гэсэндээ л хэллээ” гэдэг. Паул тэр чуулганд: “Коринтын төөрөгсдийн харж чадах цорын ганц Есүс бол та нар. Тэд та нараас Есүсийн амиллын хүч, мөн чанарыг гэрчлэн харахгүй бол, өөр хаанаас ч харахгүй. Та нар яагаад үнэнийг өөрөөсөө болон чуулганаас төдийгүй, нийгмийнхээ аврагдаагүй хүмүүсээс дарна вэ?” гэж хэлжээ.

Бид Бурхантай зэрэгцсэн цагтаа л амьдралтай ч зэрэгцэж алхдаг.

Бидний эргэн тойронд байгаа төөрөгсөд яагаад бидэнд огт татагддаггүй эсвэл татагдсан ч, буруу шалтгаанаар татагддаг юм бол гэж бодож байсан уу? Тэд бидний зугаатай байдал, ухаантай арга зам, цэвэрхэн хошигнол, зугаа цэнгэл, хөгжимд л татагдаж

байна уу? Эсвэл биднээс болон бидний дундаас хүчирхэг Хааныг олж үзэндээ татагдаж байна уу? Анхны чуулганы талаар бодоод үз: тэднийг юм л бол “бурхад” хэмээн үздэг байсан тул, тэд газар унаад: “Үгүй ээ, бид бурхад биш! Бид бол дээдийн дээд Бурханы хүүхдүүд!” гэж хашхирахад хүрдэг байв.

Петр Ромын цэргийн даргад: “Бос, би ч гэсэн хүн шүү дээ” (Үйлс 10:26) гэж хэлсэн.

Паул Лустрын иргэдэд хандан: “Бид та нартай адил жирийн хүмүүс шүү дээ” (Үйлс 14:14-15) гэж хашхирсан.

Мальтын иргэд Паулыг “бурхан байж гэж ярьж эхлэсэн” (Үйлс 28:6).

Тесалоникийн “үдшийн мэдээгээр”: “Дэлхийг үймүүлсэн эд бас ийшээ ирлээ” (Үйлс 17:6) гэж мэдээлсэн.

Иерусалимын иргэд “гэднийг... өндөр үнэлдэг байв” (Үйлс 5:13).

Гэтэл Коринтод ийм мэдээ гараагүй. Манай Барууны нийгэмд ч ийм мэдээ дутагдаж байна. Энэ бүхэн нь бидний криптонитаас болсон юм биш байгаа? Миний бодлоор бид мессеж ч илгээж чадахгүй, эвдэрхий ухаалаг утсаа ашиглахаар шийдсэн болтой. Үүний оронд “наад утас чинь ямар ч найдваргүй болчихож” гэдэг үг сонсбол дээрсэн. Тэгвэл бид ядаж утасгүйгээр цаашаа яаж амьдрахаа бодно.

Харин миний хувьд би ингэж амьдарч чадахгүй. Би дэлхийд амьд Аврагч, Хааныг маань харуулах Бурханаас өгөгдсөн эрч хүч, амь, хүч чадал, эрүүл мэнд, чадвараа алдахгүй. Олон хүн дөнгөн данган амь зогоох энэ байдлаасаа залхаж байгаа байх.

Би энэ үгийг тэнгэрийн ятгалга, Бурханы захирамжаар танд бичиж байна. Хэрэв та энэ дэлхийн бохир, хог, шавхруугаар амьдрахаас залхаж байгаа бол, энэ танд зориулсан үг мөн. Хэрэв та амилуулагдсан, дээд амьдралыг хүсч байгаа бол, энэ танд зориулагдсан үг мөн.

Бурхан Аав чинь танд ийм амьдралыг хүсч байна - үгүй ээ, зүгээр нэг хүсэх бус, харин бүр хүслэн болж байна! Тэрбээр таныг Өөрийнх нь тэнгэрлэг мөн чанар, хүчийг хүссэн хэмжээнээсээ давуулан, давуулан аваасай гэж хүсдэг.

Бурхан биднийг барьж хориогүй. Бид энэ бүхнийг авч чадахгүй байгаа бол, өөрийнхөө шүтээн мөргөлийн явдлаас л болжээ.



Цааш цаашдаа бүгдээрээ орчин цагийн чуулганы олон хүнийг сохолдог мэхлэлийн талаар илүү гүн судлана. Эрүүл саруул Христэд итгэх итгэл хэмээн бодсон зүйл маань тэнгэрийн жишгээр бол огт эрүүл саруул зүйл биш байсныг бид харна.

Биднийг хүлээж буй дуудлага, хувь тавилан, аугаа байх тосолгоотой. Дуулгаваргүй, үлбэгэр байдлаа сэгсэрч хаяад, Есүс Христийн дотор аугаа байдал, алдар, эрхэмсэг байдал, хүчээр хувцасла.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бурханы хэлсэн зүйлд зүрхээ хатууруулах үед шүтээн мөргөл эхэлдэг. Энэ бол шүтээн мөргөлийн үндэс. Тиймээс л Бурхан Израильд хувцсаа биш, зүрхээ харж хандахыг айлджээ. Бурхан асуудлын үндсийг хөндөөгүй, өнгөц гэмшлийг хүсээгүй. Харин асуудлын үндэс нь тэдний Бурханы дуу хоолойг сонсдог ч үгүй, анхаардаг ч үгүй, хатуурсан зүрх сэтгэл байв.

Иймээс л Дэд хууль 8 дээр Бурхан хүн зөвхөн талхаар бус, Бурханы амнаас гарах Үг бүрээр амьдардгийг Израильд ойлгуулахын тулд тэднийг хүмүүжүүлсэн гэдэг. Бид Бурханы Үгээр амьдарч, Түүний дуу хоолойг амьдралынхаа эх сурвалж болгосноороо, шүтээн мөргөлөөс хамгаалагдаж, Бурханы бидэнд хүссэн хүчирхэг амьдрал руу давшдаг.

Таны амьдралд Бурханы Үг ямар үүрэгтэй байна? Хэзээ хамгийн сүүлд шийдвэр гаргахдаа, Түүний хувь нэмрийг хүлээн авсан бэ? Залбирахдаа, ганцаараа л яриад байна уу, Бурхантай харилцан ярьж байна уу? Яг одоо Бурхантай ярилцахдаа, Бурханыг урин залах цаг гарга. Чимээгүй байж, Бурханы дуу хоолойг сонс. Бурхантай харилцан ярьж, хэлсэн үгийг нь дуусахаараа тэмдэглэж аваарай.

НҮГЭЛ

Нүгэл. Энэ талаар ярихгүй гэж эсэргүүцэж байна уу? Хэтэрхий ярвигтай асуудал уу? Бид яагаад дайснаа таньж, түүний эсрэг зүй зохистой алхам авах аргыг эзэмшихийг хүсэхгүй байна?

Нүгэл гэдэг нь хүмүүсийн хувьд нэг бол хөнгөн хуумгай ханддаг эсвэл хуулийн ялласан, сургаал номлолын хар гайгаар зугтаж дайждаг үг болжээ. Тэгвэл Бичээс юу гэдгийг харцгаая.

Харин хилэнц чинь та нарыг Бурханаас хагацуулсан.
(Исаиа 59:2)

Нүглүүдийг Еврейгээр *авон* гэнэ. Хуучин гэрээнд энэ үгээр нүглийг хэлдэг байв. Гэхдээ толь бичгээс үзбэл, энэ нь “санаатайгаар гуйвуулах, завхаруулах гэсэн санаа агуулдаг учраас, онц ёрын нүгэл” (WSOTDICT) гэсэн утгатай үг ажээ. Энэ нь санаатай нүгэл буюу бидний сурснаар биднийг Бурханаас салгадаг *сүнслэг криптонит* юм. Энэ нь биднийг биднээс бурханлаг амьдрал шаарддаг тэнгэрлэг мөн чанараас салгадаг. Бид эрээ цээргүйгээр нүгэл үйлдэхдээ, шүтээн мөргөлд оролцож, завхайрагч нар болдог. Бид өөрсдийгөө Бурханы дайсан болгодог.

Шинэ гэрээнд “нүглийг” *хамартиа* (буюу үйл үгээр бол хамартано) гэдэг. Шинэ гэрээ нүглийг гол төлөв энэ хоёр үгээр дууддаг. Толь бичиг дээр (WSNTDICT) *хамартиа* үйлдэгч нь

“амьдралынхаа жинхэнэ зорилго, цар хүрээгээ буюу Бурханыг алддаг” гэжээ.

Одоо түр зогсоод, бод! Бид нүгэл үйлдэхдээ, үндсэндээ хэзээ ч гарахыг хүсэхгүй замаасаа гардаг (эрүүл саруул ухаанаа алддаг). Бид амьдралынхаа эх ундаргаас эргэж, баяр хөөр, амар тайван, цэц ухаан, хангалуун байдал, бүрэн зориулалт, хангамж зэрэг нэрлэж баршгүй олон зүйлээ гээнэ.

Олонбагш нар нүглийг *байнаасаа зөрөх явдал* гэж тодорхойлдог. Энэ нь оновчтой хэдий ч, хэрэв та дээрх тодорхойлолтыг харах юм бол, нүглийн ноцтой мөн чанарыг зүгээр нэг “байнаасаа зөрөх явдалтай” зүйрлэж болмооргүй.

Шинэ гэрээнд нүглийг муу муухай, зөрчил, шударга бус явдал, хүчирхийлэл зэрэг янз бүрээр хэлдэг. Гэхдээ би эдгээрийг нэг бүрчлэн ухаж судлах бус, харин хүмүүсийг жинхэнэ амиас урвуулан урхиддаг нүглийн амин судас, хүчийг илчлэхийг зорьж байна.

Нүгэл нь хүний эрч хүч, хайр, тамир тэнхээ, эрүүл ухаан, хүсэл тэмүүлэл, зорилгыг зэрэмдэглэдэг. Нүгэл нь хортой, уршигтай гэдгийг баттай мэдээрэй. Үнэхээр таатай байж болно. Гэхдээ энэ нь хэсэгхэн л үргэлжилнэ. Үндсэндээ нүгэл үйлдэх явдал нь богино хугацааны эерэг талтай, урт хугацааны сөрөг талтай. Учир нь үйлдэж дууссаны дараа нүгэл нь биднийг үхэн үхүүлтлээ удаан хугацаанд хордуулсаар байна. Хүний махан бие нүгэлд ухаан мэдрэлгүй татагддаг боловч, Бурханы мөн чанарыг өвлөсөн, Христийн дотор шинэ бүтээл болсон бид нүгэлд дурлах төрөлх хүсэлгүйгээс гадна нүглийн уруу татлагыг ч эсэргүүцэж чадна.

Бурхан Каинд: “Хэрэв чи сайныг хийхгүй бол гэм нүгэл үүдэн дээр чинь гэтэн, нүгэл хилэнц чамайг хүсэх болно. Гэвч чи түүнийг дийлэх ёстой” (Эхлэл 4:7) гэж хэлсэн байдаг. Хүний амьдралд нүглийг оруулдаг хаалга гэж байдгийг хараарай. Тэр хаалгыг “хүсэл” гэх бөгөөд Иаков “Тэгээд тачаал (хүсэл) нь үр тогтоон нүглийг төрүүлдэг” (Иаков 1:15) гэжээ. Хүслээ хэрхэхээс шалтгаалан, энэ хаалга нэг бол хаагдана, нөгөө бол нээгдэнэ. Нүгэл нь биднийг хянахыг хүсдэг. Нүгэл ч бас өөрийн гэсэн хүсэлтэй бөгөөд энэ нь биднийг боолчлох хүсэл юм. Есүс “Нүгэл үйлдэгч бүр нүглийн боол мөн” (Иохан 8:34) хэмээн айлдсан.

Есүсийн айлдсан үгийг Паул ч бас итгэгч хүмүүст дахин хэлжээ: “Та нар өөрсдийгөө дуулгавартай боол болгон хэн нэгэнд өгөхдөө, үхэлд хүргэх нүгэл ч бай эсвэл зөвт байдалд хүргэх дуулгавар ч бай,

дагах нэгнийхээ боол нь болдогоо мэдэхгүй гэж үү?” (Ром 6:16). Паулын үг ч хангалтгүй байгаа бол, Петр ч бас нүгэл байнга үйлдэх талаар хэлсэн: “Учир нь хүн юунд дийлдэнэ түүндээ боолчлогддог ажээ” (2Петр 2:19). Боолчлол гэдэг аятайхан зүйл биш бөгөөд нүгэл нь харгис эзэн юм. Нүглийг үхлийн аюултай гэж өхөөрдөөгүй, харин сэрэмжлүүлсэн юм шүү. Нүгэл нь улам л хүчтэй хүслийг бадраасаар, алсдаа хордож үхэхэд хүргэдэг.

Нүгэл биднийг боолчлох санаагаа наанаа харуулахгүй. Нүгэл зальжин бөгөөд зүрхийг маань хатууруулах маягаар биднийг хянан захирч (Еврей 3:13), Ариун Сүнсний удирдамжийг мэдэрч, мэдэж, сонсоход хэцүү болгодог. Нүгэл биднийг сэм сэмээр аймшигт шүтээн мөргөлд нэвтрүүлнэ. Бурхан Соломонд хоёр удаа үзэгдсэнийг санаж байна уу? Төсөөл дөө! Гэтэл тэр хүн хожим худал бурхдад мөргөсөн байдаг. Та “*Ямар хүн Бурханыг харчихаад, худал бурхдад мөргөж чаддаг байна аа?*” гэж бодож байгаа байх. Тэгвэл хариуль: мэхлэгдсэн хүн! Бурханыг харсан Соломон мэхлэгдсэн бол, Бурханыг хараагүй хүн ямар амархан мэхлэгдэх бол?

Нүгэлтэй тоглож болдоггүй юм. Нүгэл нь маш хүчирхэг бөгөөд хүний зүрхийг эгшин зуур хувиргаж чадна. Хатуурсан зүрх нь мэхлэгддэг тул, үнэндээ шал буруу яваа атлаа өөрийгөө зөв гэж итгэсээр байдаг нь хамгийн аймаар. Ийнхүү бид завхарсан байдалдаа таг сохорно. Тиймээс: “Нигүүлсэл намайг хаацайлсан тул, би нүгэл хийсэн ч, гайгүй өнгөрнө” гэдэг худалд бүү мэхлэгдээрэй. Энэ бол галаар наадсан хандлага. Үнийг одоо тайлбарлая.

Санаатай нүгэл нь байнгын нүгэлд хүргэдэг

Санаатай нүгэл нь адагтаа *дадсан* нүгэл болдог. Энэ үйл явц хэрхэн өрнөдгийг харууль. Хүн анх дуулгаваргүй зан гаргах үед ухамсар маань бидэнтэй ярьдаг. Энэ нь дуу хоолой гэхээсээ илүү таагүй мэдрэмж байдаг. Зүрх маань: “Чи байнаасаа зөрчихлөө, амьдралынхаа замаас хазайчихлаа, гэмшиж, уучлал эрж, замаа зас!” гэсэн мэдрэмжээр хашхирдаг. Тэр үед нь бид жинхэнээсээ гэмшиж, нүглээ хаях юм бол, зүрх маань цэвэршиж, бид Сүнсний дуу хоолойд мэдрэг байна. Бичээс: “Гэмт үйлдлээ далдлагч хэзээ ч үл дэвжюү гэвч улайгаад, орхигч хайр энэрлийг хүртюү” (Сургаалт үгс 28:13) гэдэг.

Гэхдээ хэрэв бид ухамсрынхаа дуу хоолойг үл тообол, өмнөх бүлэгт хэлснээр зүрх маань бүрээсээр хучигддаг. Тэгээд дахиад дуулгаваргүй загнабал, бидэнд таагүй мэдрэмж ч төрөхгүй. Харин ч нөгөө дуу хоолой улам нарийсч, “чимхийн төдий л таагүй мэдрэмж” төрнө гэх үү дээ. Ухамсар маань илүү хатуурсан бол, ухамсрын чих ч хатуурдаг. Гэхдээ тэр үед ч бид нүгэлд хандах бодол, зүрхээ жинхэнээсээ өөрчилбөл, уучлал эрж, сэргээгдэх бас л боломжтой.

Харин ятгалга, ухамсрын тэр намуун дуу хоолойг үл тоосоор байвал, зүрх маань давхар бүрээстэй болж, бидний ухамсарлах чадвар улам доройтно. Бурханы Үгд дуулгаваргүй байхад, дотор маань час час төдий л таагүй мэдрэмж төрнө. Одоо ухамсар маань бараг мэдрэлгүй болсон тул, юу ч сонсохгүй. Нүгэлд хандах бодол, зүрхээ өөрчилсөн хүний хувьд уучлагдаж, сэргээгдэх боломж байсаар байдаг ч, алдаагаа ойлгох тун хэцүү юм.

Хэрэв бид дахиад л тэр ятгагч дуу хоолойг үл тообол, зүрх маань гурван давхар бүрээстэй болно. Энэ үйл явц давтагдах тусам, ухамсар маань бүрэн мохож, шүтээн шүтлэгт таг сохор болдог. Бид мэдрэмжийг өнгөрөөж, Сүнсэнд ямар ч мэдрэмжгүй болно. Одоо бид ямар ч ял мэдрэхгүйгээр тогтмол нүгэл үйлдэж чадна. Өөрөөр хэлбэл байнгын нүгэл үйлдэгч болно. Бид уучлагдаж, сэргээгдэх боломжтой ч, харамсалтай нь нүглийг нүгэл гэж үзэхээ байсан тул гэмшиж, сэргээгдэх ч хүсэлгүй болдог.

Энэ үед Бурхан биднийг аврахаар эш үзүүлэгч, пастор, найзыг маань илгээнэ. Харин хэрэв бид тэр мэдээ дамжуулагчийг сонсохгүй бол, дараа нь Бурхан бидний анхаарлыг татахын тулд бидэнд хүнд бэрх нөхцөл байдал, бэрхшээл, гай тогторыг ч зөвшөөрдөг. Давид “Зовж шаналахынхаа өмнө би буруу зүгт явсан байжээ” (Дуулал 119:67) гэж хэлсэн байдаг.

Тэгэхээр Бурханаас сурах хамгийн сайн арга зам бол Түүний илчилсэн зүйлсийг дуулгавартай дагаж, нүглээс хол байх явдал юм. Үүнийг хийхгүй бол, Бурхан бидэнд дэндүү хайртайдаа, биднийг амийн зам дээр буцааж гаргахын тулд маханд маань сургадаг юм. *Нью Ливинг Транслэйшн* Библи дээр Давидын үгийг “Та намайг сахилгажуулах хүртэл би уяанаасаа алдуурдаг байжээ. Харин одоо би Таны Үгийг нэг ч алдалгүй дагадаг” гэдэг.

Хэрэв бид Коринтод хандсан Паулын үгийг дахиад харбал, яг адилхан тэнгэрлэг оролдлогын талаар дүрслэн хэлсэн байхыг

харна. Паул Коринтод “Харин бид шүүгдэхдээ ертөнцтэй хамт яллагдахгүйн тулд Эзэнээр сахилгаждаг” (1Коринт 11:32) гэжээ. Бурхан биднийг ухааруулж, үхлийн замаас гаргаж, амийн зам дээр тавих гэсэндээ л зовлон, гай, асуудал зөвшөөрдөг юм.

Тэгвэл ээжтэйгээ унтдаг эрийн талаар ярихдаа, Паул яг ийм ойлголтыг гаргаж ирснийг бид харж байна. “Махбодыг нь сүйрүүлэхийн тулд тийм хүнийг Сатанд тушаая гэж шийдэв. Ингэснээр түүний сүнс Эзэн [Есүсийн] өдөр аврагдаж болох юм” (1Коринт 5:5). Чуулганы эцэг болсон тэр хүн “түүнийг гаргаж хая” гэж хэлэхдээ, тэр түргэн халдварлагч нүглийн завхралаас Коринтын чуулганыг хамгаалахын төлөө төдийгүй бас нүгэл үйлдэгч тэр хүний төлөө хэлжээ.

Бурхан хүүхдүүддээ дэндүү хайртай. Тиймээс л биднийг боолчлолын аль үе шатанд явж байгаагаас хамааран, янз бүрийн арга хэрэглэдэг юм. Үндсэндээ Бурхан бидний өнөөгийн тав тухаас илүүтэй амь насанд маань юу нь чухал болохыг нэн тэргүүнд тавьдаг.

Еврей ном дээр нүглийн үйл ажиллагааг сайтар ухааруулсан мэдэгдэл бий:

... амархан урхиддаг нүглийг хажуу тийш нь тавьж (биднийг удаашруулагч жин бүрийг - ялангуяа биднийг ядах юмгүй урхиддаг нүглийг хуу тайлцгаая) (Еврей 12:1) гэдэг.

“Биднийг ядах юмгүй урхиддаг” гэсэн үгийг анхаарна уу. Намайг дороо урхиддаг нүгэл таныг дороо урхидахгүй байж болно. Миний хувьд архи, шунал, хар тамхи, хов жив зэрэг илэрхий нүгэл ямар ч асуудал болдоггүй байв. Миний хувьд порнограф л зовлон болдог байв. Энэ миний амьдралын хамгийн том тэмцэл байсан бөгөөд тэр харгис боолын эзнээс би 1985 онд бүр мөсөн чөлөөлөгдсөн тухайгаа хожим хуваалцана. Миний хэлэх гэсэн хамгийн гол санаа нь бид өөрийгөө ямар өдөөлтөд хамгийн эмзэг болохоо тогтоож, тэр боломжийг тасар татахын төлөө шаардлагатай зүйлийг хийх ёстой. Есүс:

Гар чинь чамайг бүдрүүлвээс тас цавчиж хая. Унтаршгүй галтай тамд хоёр гартайгаа очсоноос гаргүйгээр аминд орох

нь чамд дээр. ...Хөл чинь чамайг бүдрүүлвээс тас цавчиж хая. ...Нүд чинь чамайг бүдрүүлвээс ухааж хая (Марк 9:43, 45, 47) хэмээн айлджээ.

Есүс жинхэнээсээ гар, хөлөө тасдаад, нүдээ ухаад хаячих гэж хэлээгүй. Есүс биднийг ядах юмгүй урхиддаг нүгэлд боломж бүү олго, энэ боломжийг тасдаад хая л гэдгийг хэлсэн юм.

Надад архи уудаг байсан олон найз бий. Би тэдний нэгийг нь архинаас гарахад нь туслаж явсан завшаантай хүн. Одоо тэр найз маань дарс ч амсдаггүй бөгөөд идэж уусан орчноос тун их болгоомжилдог. Энэ бол түүний дороо урхидуулдаг нүглийн талбар гэдгийг найз маань мэднэ. Тэрбээр боолчлолд хүргэх аливаа боломжийг тас татаарай гэсэн Христийн үгд сайтар захирагдаж, цэц ухаантай хандаж явна.

Би өөрөө ч Христэд итгэхээсээ өмнө Их сургуульд сурч байхдаа, хуурай ахан дүүс, найз нөхөдтэйгээ ууж, согтуурдаг байв. Нэг удаа Христмасын амралтаараа найзуудтайгаа бааранд орж, найзууд маань шал согтсон тул би тэднийг хүргэж өгөөд, шөнийн 12.30 гээд гэртээ иртэл, ээж маань намайг хүлээж суув. Би ээждээ тэр орой болсон явдлыг яриад, бараг л: “Тэгж ярих юм бол, би архи уух ч дургүй!” гэж хэлэв.

Тэгсэн ээж маань инээд алдаад: “Жинхэнэ Бивэр мөн дөө!” гэж хэлж билээ.

Тэр үед би аавыгаа үнэртүүлчихсэн явахыг амьдралдаа нэг ч удаа хараагүйгээ санасан юм. Манай гэрийнхэн архидахыг мэддэггүй байв. Архи Бивэрийн гэр бүлийг амархан урхидаж чаддаггүй боловч, амархан урхиддаг өөр нүглүүд бидэнд байлаа. Тэдгээр нь үүдээрээ нэвтрүүлэхгүйн тулд орох бүх боломжийг нь тасар татах ёстой нүглүүд байсан юм.

Дараа нь Еврей номын бичээч:

Та нарт хөвгүүд шигээ хандсан тэрхүү сэнхрүүллийг та нар мартжээ. “Эзэний сахилгажууллыг бүү хөнгөн үз, хүү минь, Тэр чамайг зэмлэх үед сэтгэлээр бүү уна. Учир нь, хайрладаг хүнээ Эзэн сахилгажуулдаг. Хүлээн авдаг хүү болгоноо Тэр ташуурддаг” гэжээ (Еврей 12:5-6) хэмээв.

Биднийг нүгэлтэй хутгалдах үед Эзэн биднийг сахилгажуулдаг. Энэ үйл явцсыг товч авч үзье: Эхлээд Үгээр зүрхэнд маань ухаарал өгч, биднийг засна. Үүнийг нь сонсохгүй, ухамсраа хаах юм бол, найз, пастор, эш үзүүлэгчээр дамжуулан ухааруулна. Ингээд ч сонсохгүй бол, Бурхан бэрхшээл, дайсагнал, гай гамшгийг ашиглана.

Бодоод үз: Яагаад дээрх ишлэлд Бурхан сахилгажуулж байхад (энэ нь мэдээж амаргүй л байж таараа) “битгийг бууж өгөөрэй” гэж бичсэн гэж бодож байна? Дараа нь юу бичсэнийг үз:

Тэд үзэмжийнхээ дагуу биднийг хэсэг зуур сахилгажуулсан бол харин Тэрээр бидний сайн сайхны төлөө сахилгажуулсан ажээ. Тэгснээр бид Түүний ариун чанарыг хуваалцах юм. Бүх сахилгажуулал нь тухайн үедээ баяр хөөр бус, харин үй гашуу мэт санагдавч дараа нь энэ нь түүгээр дасгалжсанд нь зөвт байдлын амар амгалан бүхий үр жимсийг гаргаж өгдөг. (Еврей 12:10-11)

Сахилга баг зовиуртай гэдгийг анхаарна уу! Мэдээ алдуулах боломжгүй. Бурхан хүүхдүүддээ “сахилгын савааны” амт үзүүлэхээс айхгүй. Тиймээс Бурханы хүсэлтэй зөрчилдсөн хүслийг дагах нь бидний хувьд үнэхээрийн мунхаг явдал юм. Бодоод үз: Нүглийн хэсэгхэн зуурын амттай хөөцөлдөөд дараа нь баахан зовж байснаас, нүглээс холхон байвал, бага л зовно.

Бурханы Сүнс элч Паулаар дамжин Коринтынхонд төдийгүй, аавынхаа гэргийтэй завхайрсан хүнд ч гараа сунгажээ. Биднийг амийн зам дээр буцааж гаргаад, ариун чанараа хуваалцуулах гэсэндээ л Бурхан энэ бүхнийг хийдэг. Үүнд хоёр замаар хүрэхгүй. Бид нэг бол Бурханы Үгд дуулгавартай байж, бүрэн дүүрэн амьдралыг эдлэнэ эсвэл алсдаа асар гаслан, зовиур авчрах шүтээн мөргөлийн буюу санаатай нүгэл - сүнслэг криптонитын төлөө амь биеэ барах болно.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Нүгэл нь цаанаасаа мэхлэгч мөн чанартай. Нүгэл нь өөрийгөө амттай, таатай гэж худлаа ярьдаг. Нүгэл өөрийгөө бидний үгээс гардаггүй, номхон гэж худлаа ярьдаг ч, үнэндээ адагтаа биднийг нэг мөр залгидаг. Гэхдээ хамгийн аймшигтай нь нүгэл биднийг амьдрахаар дуудагдсан, жинхэнэ алдрын амьдралаас маань салгаж, Христтэй жинхэнэ амьд харилцаа тогтооход саад хийж, мэхлэдэг.

Тийм боловч хэрэв бид Бурхан бидний амьдралд юу хийх боломжтойг (хүч, супер үр нөлөө, эрх чөлөө, Өөртэй нь ойр дотно байх зэрэг үй олон зүйл) харсаар явбал, нүгэл нь зүсээ хувиргасан мэхлэгч болохыг таньж харна.

Амьдралынхаа аль тал дээр Бурханаас өгсөн алсын хараагаа алдаж байгаагаа, аль тал дээрээ нүгэл, найраанд автаж байгаагаа Түүнээс асуу. Тэгээд амьдралдаа цоо шинэ алсын хараа гуйгаад, хэлсэн зүйлийг нь бичиж тэмдэглээрэй.

КРИПТОНИТЫН ҮР НӨЛӨӨ

「ХЭСЭГ 3」

НҮГЛИЙН ХҮЧ (1 –р хэсэг)

Хуучин гэрээнд Каинд “Хэрэв чи сайныг хийхгүй бол гэм нүгэл үүдэн дээр чинь гэтэн, нүгэл хилэнц чамайг хүсэх болно. Гэвч чи түүнийг дийлэх ёстой” (Эхлэл 4:7) гэж хэлсэн байдаг. Энэ үг бүх хүнд хамаатай. Нүгэл биднийг хүсдэг. Нүгэл өөрийгөө илэрхийлэхийн тулд биднийг боолчилж, эрхшээхийг хүсдэг. Нүгэл нь мэхлэдэг, өддөг хүчирхэг дайсан.

Тэгвэл нүглийг яаж дарж авах вэ? Бурханы Үг, замыг дуулгавартай дагаснаараа! Бурхан Каинд дээрх үгээ хэлэхээсээ өмнө эхлээд юу гэж хэлснийг сонс: “Хэрэв чи сайныг үйлдбэл, тэргүүнээ өргөх биш үү? Хэрэв чи сайныг хийхгүй бол гэм нүгэл үүдэн дээр чинь гэтэн, нүгэл хилэнц чамайг хүсэх болно. Гэвч чи түүнийг дийлэх ёстой” (Эхлэл 4:7). Жинхэнэ дуулгавартай байдал нь нүгэл үйлдэх үүдийг хаадаг.

Паул итгэгчдэд:

Та нар өөрсдийгөө дуулгавартай боол болгон хэн нэгэнд өгөхдөө, үхэлд хүргэх нүгэл ч бай эсвэл зөвт байдалд хүргэх дуулгавар ч бай, дагах нэгнийхээ боол нь болдогоо мэдэхгүй гэж үү? (Ром 6:16) гэж хэлснийг санаарай (Паул Бурханы нигүүлслийн илчлэлийг хэзээ ч хэний ч хүлээж аваагүй, гүн гүнзгий хэмжээнд хүлээн авсан хүн гэдгийг бүү мартаарай)

Паулын үг нь Каинд айлдсан үгтэй төстэй байна. Гэхдээ нэг том ялгаа бий. Хуучин гэрээнд хүмүүсийн сүнс үхмэл байсан. Тэдний дотроос амийн урсгал гардаггүй байсан. Тэгвэл одоо Шинэ гэрээнд Есүст итгэдэг хүний сүнс нь амьд бөгөөд тэрбээр Бурхантай нэгдмэл болж, Бурханы тэнгэрлэг мөн чанарыг тээх болсон. Тиймээс бид дотоод хүнээ дагахыг сонгож болно эсвэл гадаад хүнээ буюу махан биеэ дагахыг сонгож болно.

Бурханы нигүүлсэл ч хүчин төгөлдөр ажилладаг. Бурханы нигүүлсэл нь биднийг аварч, уучлаад зогсохгүй мөн бидэнд үнэнийг дагах хүчийг өгдөг. Биднийг “Бурханд тааламжтайгаар үйлчлэх нигүүлсэлтэй байцгаая” (Еврей 12:28) хэмээн ятгасан буй. Нигүүлсэл биднийг Бурханыг дагах чадалтай болгодог.

Петр: “...та нарт нигүүлсэл ... улам арвижиг. Алдар ба давуу чанараараа биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжин бурхан хүч (*нигүүлсэл*) нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон” (2Петр 1:2-3) гэж бичжээ. Энэ хоёр ишлэлд болоод Шинэ гэрээний өөр олон ишлэлд нигүүлслийг хүчирхэгжүүлэгч хүч гэж хэлдэг. Бидэнд Бурханы нигүүлслийн бэлэгээр хүчирхэгжсэн шинэ мөн чанар байгаа бол, Хуучин гэрээний хүмүүст - тэр дундаа Каинд ийм бололцоо байгаагүй.

Тэгвэл яагаад маш олон итгэгч хүн нүглийг захирч чаддаггүй вэ? Бид хүчийг эзэгнэж чадах ч, үүнийгээ ашиглаж чадахгүй бол, ашиг тусыг нь хүртэж чадахгүй гэдгийг санах хэрэгтэй. Бурхан хүн бүрт сонгох чадвар өгдөг бөгөөд бидний сонголтыг хүндэтгэдэг. Тиймээс Христэд итгэдэг олон хүмүүс Бурханы үгээс гарах үед түүний жолоог нүгэл гартаа оруулдаг байна. Яагаад ийм юм болдог вэ? Нүгэл итгэгч хүнд “хүсээд байгаа зүйл нь Бурханыг дагаснаас илүү ач тустай” хэмээн итгүүлж дөнгөх үед ийм зүйл болдог. Тиймээс л Паул:

Үхлийн хатгуур нь нүгэл (1Коринт 15:56) гэсэн юм.

“Хуулийн ачаар нүгэл хүний дээр хүчээ тогтоодог” гэхээр тун гайхмаар, хүнд сонсогдож магадгүй. Тиймээс та шууд: “*Би Мосегийн Хууль дор байхгүй!*” гэж хэлэх байх. Энэ үнэн. Гэхдээ Бичээс “хууль” гэж ярихдаа, дан ганц Мосегийн хуулийн талаар яриагүй гэдгийг мэдэх нь чухал шүү. Иаков хөршөө хайрлах

“хаан хуулийн” (Иаков 2:8-ыг үзнэ үү) талаар ярьсан. Итгэгч хүмүүсийн зүрхэнд бичээтэй “Бурханы хууль” (Ром 8:7, Еврей 8:10-ыг үзнэ үү) гэж бас бий. Бие биеийнхээ ачааг үүрэлцсэнээр биелдэг “Христийн хууль” ч (Галат 6:2-ыг үзнэ үү) бий. Түүнчлэн бидний шүүгдэх “эрх чөлөөний хууль” (Иаков 2:12) гэж бас бий. Эдгээрээс гадна өөр олон “хууль” бий. 1Коринт 15:56 дээр Паул эдгээр хуулийн талаар юмуу Мосегийн хуулийн талаар яриагүй.

Тэгвэл Паулын ярьсан, итгэгч хүний дээр эрхээ тогтоодог тэр нүгэл нь ямар хууль вэ? Үүнийг нэрлэхээсээ өмнө эхлээд жаахан дүрслэе. Паулын хэлсэн хуулийн дор байгаа хүн: “Энэ кинонд шалдан нүцгэн хүмүүс, хараал гардаг учраас, би үүнийг үзэхгүй.” Эсвэл “Би аравны нэгээ өргөх ёстой.” “Би тэнд зогсож байгаа, ил задгай хувцасласан эмэгтэй рүү харах ёсгүй” гэх маягаар бодож, ярьдаг.

Эдгээр үг нь ямар хуулийг илэрхийлнэ вэ? Энэ хүн нь Бурханы Үгд дурлахаасаа илүүтэй Бурханы Үгээр хязгаарлагддаг хүн юм. Тэрбээр Бурханы Үгийг хориглодог, хүлдэг гэж үздэг бөгөөд энэ нь: “Таны тааллыг би гүйцэлдүүлэх дуртай. Таны хууль зүрхэнд минь бий” (Дуулал 40:8) гэж хэлсэн магтаалчийн үгтэй зөрчилдөж байна. “Хууль дор” байгаа хүн нь “Бурханы хүслийг” (Иохан 7:17-г үзнэ үү) халуун сэтгэлээр үйлддэггүй.

Үүнийг үндсэндээ: “Би тэгмээр л байна... Гэхдээ Бурханы Үг болохгүй гэсэн” гэж хэлж болно. Үүнийг Хуучин гэрээний нэгэн жишээ төгс харуулдаг.

Манарсан эш үзүүлэгч

Балаам эш үзүүлэгч байв. Тэр Бурханы дуу хоолойг ч мэддэг, Эзэний арга замыг ч таньдаг байлаа. Тэр үеэр Мидианы хүмүүсийг харгалзан захирдаг Балак нэртэй Моабын хаан байв. Гэтэл Израильчууд айсуу гэдэг сургаар тэр улсын ард иргэд үнхэлцгээ хагартал айцгаажээ. Харин Израильчууд энэ дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн Египетийг самарчихаад, Улаан тэнгисийг гатлаад явж байв. Египетийн цэргийн хүчин, хөдөө аж ахуй, эдийн засаг үлэмж гарз хохирол үзэж, айл бүр ууган хүүгээ алджээ.

Израиль Египетээс гарсныхаа дараа Аморичуудын эсэргүүцэлтэй тулаад, тэднийг ч ядах юмгүй ялжээ. Тэгээд одоо

Израиль Моабын талд түр буудаллаад байтал, тэр улсын ард иргэд ч, хаан ч “Израиль Египет, Аморийг сүйрүүлсэн шигээ одоо биднийг сүйрүүлэх нь” хэмээн айдаст автжээ.

Балак хаан ерөөсөн бүхэн нь ерөөгддөг, хараасан бүхэн нь хараагддаг увидастай, Балаам хэмээх алдарт эш үзүүлэгч байдаг тухай дуулаад, түүн рүү удирдагч нараа илгээн: “Тиймээс ирээч. Энэ ард түмэн (Израиль) миний хувьд хэт хүчирхэг тул миний төлөө эднийг хараагтун. Тэгвэл би тэднийг цохин дийлж, нутгаасаа хөөн гаргаж чадах байх. Учир нь чиний ерөөдөг хүн ерөөгдөж, чиний хараадаг хүн хараагддаг гэдгийг би мэднэ” (Тооллого 22:6) гэж хэлүүлэв.

Балаам ч мэдээ хүргэгч нарт:

Шөнийг эндээ өнгөрүүлэгтүн. ЭЗЭНий надад айлдах үгээр би та нарт хариу хэлье (Тооллого 22:8) гэж хариулжээ.

Балаам “Эзэн” гэж хэлсэн байгааг анхаарна уу. Балаам цорын ганц жинхэнэ Бурханы эш үзүүлэгч болохоороо, зүсэн зүйлийн харийн бурхадтай зөвлөлдөөгүй. Тэрбээр “Эзэнийг” Иавэ гэсэн нь жинхэнэ Бурханы алдар нэр бөгөөд Хуучин гэрээний бичээч нар энэ нэрээр хэзээ ч хуурамч бурхдыг нэрлэж байсангүй.

Бид Есүсийг бөгөөд Бурхан Аавыгаа Эзэн хэмээн дуудахдаа, Бүтээгч, Дээдийн дээд Эзэн, бидний төлөө амиа өгсөн Нэгэнээс өөр хэний ч тухай ярьдаггүй. Тэгвэл Балаам ч тэгжээ.

Тэр шөнө Бурхан Балаамд юу айлдсаныг анхааралтай харцгаая. Бурхан Балаамыг Өөр дээр нь хүрч ирэхийг хүлээсэн ч үгүй:

Чамтай хамт байгаа энэ хүмүүс хэн бэ? (Тооллого 22:9)

Эзэн Балаамд: “Энэ хүмүүс Миний хувьд хэн бэ? Тэд Надтай ямар ч гэрээгүй! Чи Миний гэрээний хүмүүсийг харааж болох эсэхийг үнэхээр Надаас асуух гэж байгаа хэрэг үү? Энэ талаар залбирах гэж байгаа хэрэг үү? Ойлгомжтой бус уу?” гэжээ.

Бид зарим зүйлийн талаар залбирах ч хэрэггүй! Бурхан энэ талаар ямар хүсэлтэй байгааг Түүний бичмэл гэрээ нь хэлээд өгдөг. Бусад итгэгч нартайгаа цуглах ёстой үгүй талаар залбирах хэрэггүй. Учир нь Бурхан хэдийнээ “хамтран цуглахыг умартан зуршил болгосон зарим хүмүүсийг үл дага” (Еврей 10:25) хэмээн айлдсан.

Танд үйлчилж буй хүмүүст өргөл өгөх эсэх талаар залбирах хэрэггүй. Учир нь Бичээс “Түүнчлэн сайнмэдээг тунхаглагчид сайнмэдээгээр амь зуухыг Эзэн тогтоосон ажээ” (1Коринт 9:14) гэж хэлсэн.

Ижил хүйсийн хүнтэй нөхцөж, энэ явдлыг хөхиүлэн дэмжих талаар асуух шаардлагагүй. Учир нь Бурхан:

Зөвт бусчууд ер нь Бурханы хаанчлалыг өвлөхгүйг та нар мэддэггүй хэрэг үү? Бүү мэхлэгдэгтүн. Садарлагчид ч, шүтээн шүтэгчид ч, завхайрагчид ч, янхан эр ч, ижил хүйстэнтэйгээ нөхцөгчид ч, хулгайч нар ч, шуналтнууд ч, архичид ч, хараалчид ч, дээрэмчид ч Бурханы хаанчлалыг өвлөхгүй (1Коринт 6:9-10) хэмээн тодорхой айлдсан.

Татварын тал дээрээ залилж болох эсэх талаар Бурханаас асуух хэрэггүй. Энэ бол хулгай. Эсвэл найз залуу, охинтойгоо гэрлэхээсээ өмнө унтаж болох эсэх талаар асууж болохгүй. Учир нь энэ бэлгийн нүгэл юм. Эсвэл өөр хүний эхнэртэй харилцаанд орох нь завхайрал гэх мэт. Шинэ гэрээний олон тушаал Бурханы хүслийг хэдийнээ төгс тодорхой болгодог.

Үндсэндээ Бурхан: “Балаам минь, чи юу ч ойлгоогүй учраас - нарийндаа бол ойлгохыг хүсээгүй учраас, Би чамд хүслээ тодорхой хэлээд өгье...” “Тэдэнтэй хамт бүү явагтун. Тэр ард түмэн *ерөөгдсөн* учир чи тэднийг харааж болохгүй” (Тооллого 22:12) хэмээн айлджээ.

Энд ямар ч тайлбар шаардлагагүй.

Тэгвэл энэ тэнгэрлэг зааварт Балаам хэрхэн хандсаныг үзнэ үү:

Өглөө нь Балаам босож Балакийн түшмэдэд —Намайг та нартай явахыг ЭЗЭН татгалзсан тул нутаг уруугаа буцаж явцгаа гэв. (Тооллого 22:13)

Ихэнх хүн Балаамд алга таших байх. “Үнэн бурханлаг ах шүү!” хэмээн бурханлаг занг нь хурайлах байх. Гэхдээ Балаамын мэдэгдэлд түүний битүү санааг илтгэх нэг оньс бий. Тэр: “Эзэн *татгалзсан*” гэж хэлжээ. Тэр: “Эзэн надад хүслээ тодорхой илчиллээ. Тиймээс би явахгүй” гэж хэлээгүй. Тэр *татгалзсан* гэдэг үгийг хэрэглэжээ.

Ингэж төсөөлье: Ахлах ангийн хэдэн хүүхэд дэлгүүр хэсч, кино үзэхээр шийджээ. Энх аав, ээжээсээ зөвшөөрөл гуйсанд, аав, ээж нь: “Энх ээ, өнөөдөр бид гэр бүлээрээ хамт байхаар тохирсон шүү дээ. Тиймээс гэртээ байгаарай” гэж хариулжээ.

Найзууд нь Энхийг авахаар машинтайгаа давхиж ирээд, хаалгыг нь тогшоод, хаалгаа тайлсан Энхэд: “За, явах уу?” гэнэ.

Энх хөмсгөө зангидаад: “Би явж чадахгүй нь ээ” гэж хэлэв. Өөрөөр хэлбэл: “*Би та нартай явмаар л байна. Даанч өнөөдөр гэртээ байх ёстой*” гэж хэлжээ. Энх аав, ээжийнхээ үгээр хүслээ хязгаарлуулжээ. Аав, ээжийнх нь үг түүний хувьд хууль болов. Тэгвэл Балаамтай яг ийм явдал тохиолджээ.

Бүр аятайхан санал

Моабын удирдагч нар эргэж ирээд, Балаамын хариултыг хаандаа дуулгав. Гэтэл хаан тэр хариултад ханасангүй. Тиймээс Балаам руу бүр олон удирдагчийг илгээгээд, бүр их хүндэтгэл, шан харамж амлажээ. Хаан: “Танаас би гуйя. Над уруу ирэхэд танд юу ч бүү саад болог. Учир нь би таныг үлэмж ихээр хүндэтгэж, надад хэлсэн болгоныг тань хийх болно. Тэгэхээр ирээч, миний төлөө энэ ард түмнийг хараагаач” (Тооллого 22:16-17) гэж хэлүүлэв.

Хэрэв танай хөрш: “Хамаг байдгаа өгье” гэвэл, тэр нь магадгүй сүйдтэй юм байхгүй л байх. Харин нэг улсын хаан хамаг байдгаа өгье гэвэл, тэр нь нилээд юм гэсэн үг шүү.

Намайг ахлах ангид байхад, Флип Уилсон гэдэг маш алдартай хошин шогийн жүжигчин байлаа. Тухайн үед түүний “Чөтгөр л надаар хийлгэчихлээ” гэдэг үгийг мэдэхгүй хүн байсангүй.

Тэр хөгжилтэй үг хүн бүрийн амны зугаа болдог байсан ч, үнэндээ энэ нь худлаа үг юм. Диавол итгэгч хүнээр юу ч хийлгэж чадахгүй. Яагаад гэвэл “... тачаалдаа автаж, татагдахдаа хүн бүр уруу татагддаг (Иаков 1:14) гэж маш тодорхой хэлсэн байдаг.

Гол үг нь *татагдах*. Диавол итгэгч хүнийг татаж л чадна. Гэхдээ хүн хүсэхгүй юмдаа татагдахгүй. Хэрэв та миний өмнө кокаин тавьбал, би: “Наадахаа зайлуул” л гэнэ. Би хар тамхийг тоодоггүй учраас, та намайг түүгээр татаж чадахгүй.

Гэхдээ диавол хойрго биш, маш айхтар нэгэн. Тэр чөтгөрүүддээ таны амьдралыг төдийгүй, аав ээж, өвөө эмээг чинь хэдэн үеэр нь

судлаж мөрдөхийг даалгачихсан байдаг. Хүслийн тал дээр диавол танай гэр бүл аль тал дээрээ эмгэг байдгийг мэдэхтэйгээ.

Тэр бас Балаамын амьдралыг судлаад, тэрбээр эд баялаг, шан харамж, зэрэг дэв гэхээр хоёр нүдээ ч ухаад өгөхөд бэлэн байдгийг олж мэджээ. Тиймээс л Сатан Балаамд татгалзахын аргагүй санал тавихыг бурханлаг бус хаан Балакт хэлж өгсөн байх. Гэвч болоогүй ээ, Балаам үлэмж шан харамжид ч эрс хариулжээ:

Балак надад алт мөнгөөр дүүрэн гэрээ өгсөн ч би өөрийн Бурхан ЭЗЭНий тушаалыг зөрчин их, бага ямар ч зүйлийг хийж чадахгүй. (Тооллого 22:18)

Чамлахааргүй хэмжээний шан харамжтай ажлын саналд Бурханы Үгээс гарахгүй хэмээн татгалзсан Балаамын зоригтой хариултад бас л алга ташмаар. Гэвч эш үзүүлэгчийн үг дотор нөгөө л оньсон үг бас л явж байна. Эш үзүүлэгч: “Би хийхгүй” гэж хэлэлгүй, харин: “Би чадахгүй” гэж хэлжээ. Өөрөөр хэлбэл юу ч өөрчлөгдөөгүй байна. Тэр бас л хууль мэт үзсэн Бурханы Үгдээ баригдсаар л байна. Үүнийг нь ч дараагийн үг нь батладаг:

Харин та нар өнөө шөнө эндээ үлдэгтүн. ЭЗЭН надад өөр юу айлдахыг нь би мэдье гэлээ. (Тооллого 22:19)

Юу вэ? Өөрөөр хэлбэл илүү ашигтай санал ирбэл, Бурхан саналаа өөрчилж магадгүй гэж үү? Бурхан Балакийг элч нараараа илүү ашигтай санал ирүүлэхийг нь хүлээсэндээ, анх “Үгүй” хэмээн айлдсан болж таарч байна уу? Үүнд итгэх хүн байна уу? Ямар хөгийн бодол вэ? Бурхан Балаамыг илүү дээр санал сонс гэж хүлээлгээгүй! Балаам эхний удаа залбирах хэрэггүй байсан юм бол, хоёр дахь удаагаа залбирах бүр ч хэрэггүй байв! “Чи явахгүй шүү!” гэдэг хүслээ Бурхан эхний элч нараар л тодорхой айлдсан.

Тийм байтал Балаам тэр шөнө залбирахаа амлажээ. Гэтэл Бурхан юу гэж хариулсаныг үз:

—Хэрэв энэ хүмүүс чамайг дуудахаар ирсэн аваас босож тэдэнтэй хамт явагтун. Харин зөвхөн чамд Миний хэлснийг л чи хийх ёстой. (Тооллого 22:20)

Байзаарай! Бурхан одоо Балаамыг “тэдэнтэй яв” гэнэ үү? Зөв уншсан байгаа даа? Юу болоод байна аа? Тэгэхээр нөхцөл байдал орвонгоороо эргэж, Балаам Бурханаас Моабын язгууртан, ахлахуудтай явах зөвшөөрөл авчээ. Тиймээс тэр Бурханы Үгийг ягштал дагаж, тэнгэрийн зааврыг үг дуугүй биелүүлсэн. Гэхдээ дараа нь юу болсныг харна уу:

Гэвч түүний явснаас нь болж Бурхан уурласан бөгөөд
ЭЗЭНий тэнгэрэлч түүнд садаа болохоор зам дээр зогслоо.
Балаам илжгээ унаж явсан бөгөөд хоёр зарц нь хамт байлаа.
(Тооллого 22:22)

Юу вэ? Бурхан орон гаран юм уу? Балаам урьд шөнө Өөрийнх нь хийгээрэй гэсэн зүйлийг л хийсэн шүү дээ. Тэгээд яахаараа түүнд уурладаг билээ? Энэ бүхэн ямар учиртай вэ?

Бичээс үүнд тун учир зүйтэй хариулдаг бөгөөд энэ нь ч танд ихийг ойлгуулна. Энэ нь *нүгэл хуулиас хүчээ авдаг* гэдэг үнэнийг тойрон эргэдэг юм. Учрыг нь дараагийн бүлгээс үзнэ ээ.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Олон итгэгч “Та нүглийн хүчээс бүрэн чөлөөлөгдөж чадна!” гэдэг найдварын үгийг сонсох хэрэгтэй.

Тийм ээ, та зөв уншлаа. Христэд итгэдэг хүн нүглийнг уландаа гишгэх боломжтой. Есүс алуулахдаа, танд ердөө л тэнгэрийн тасалбар атгуулах гэж үхээгүй юм. Есүс алуулахдаа, таныг нүглийн болоод үхлийн хүчээс чөлөөлсөн билээ. Тийнхүү одоо нүгэл таны дээр эрх мэдэлгүй, харин та нүглийн дээр эрх мэдэлтэй болсон.

Үүнийг хүний хүчээр гүйцэтгэх боломжгүй зүйлийг үйлдэгч тэнгэрлэг хүч болох Бурханы нигүүлслээр л хийх боломжтой. Бид нигүүслийг үнэ төлбөргүй хэрэглэж, үнэ төлбөргүй эзэмших эрхтэй болсон ч, ашиглаж чадахгүй бол, ашиг тусыг нь хүртэж чадахгүй. Итгэгч хүмүүс голдуу өөрт нь ийм хүч байдгийг мэддэггүй учраас, хэрэглэж ч чаддаггүй.

Нүглийн дээр эрх мэдэлтэй болохыг чинь илчилсэн Бичээсийг тунгаан бодож нүглийг сөрөх тамираа бэхжүүл. Энэ үнэнийг амьдралдаа бодитой болгох хүртлээ тунгаан бод. Энэ талаар

Бурхантай ярилцаж, нүгэлд бууж өгсөн арга зам бүрээ гэмшиж, өнөөдөр таныг чөлөөлж байгаад нь таларх. Өөрийнхөө өнгөрсөн алдааг уучилж, Бурханаас таны ирээдүйг хэрхэн харж байгааг нь асуу. Тэгээд Бурханы харуулж, хэлсэн бүгдийг бичиж тэмдэглээрэй.

НҮГЛИЙН ХҮЧ (2-р хэсэг)

Өмнөх бүлэгт Балаамын талаар ярьж байгаад зогссон хэсгээсээ үргэлжлүүлье.

Балаам Эзэнээс Моаб, Мидианы элч нартай хамт явахгүй байх заавар хүлээн авсныхаа дараа илүү алдар нэртэй элч нарыг төлөөлөн хоёр дахь удаагаа Эзэнд бараалхав. Балаам Эзэнээс өөр хариулт горьджээ.

Та ийм байдалд орж байв уу? Бурхан юу хэлэхийг зүрхэндээ мэдсэн атлаа Түүнийг хариултаа өөрчилнө байх гэж найдсандаа дахин залбирч байв уу? Магадгүй зохисгүй хүслээ “Би энэ талаар залбиръя” эсвэл “Би дахиад нэг залбираад үзье” гэх мэт үгээр хаацайлж байв уу?

Та яасныг мэдэхгүй. Харин би ийм алдаа гаргаж явсан бөгөөд энэ гунигт жишээгээ удахгүй хуваалцана аа.

Балаам тэр хүчирхэг хааны өргөл барьцад ч, үнэ хүндэтгэлд ч шунасан боловч, Бурханы зааврын “дээсийг” зөрчиж зүрхлэсэнгүй. Санаатайгаар дуулгаваргүй загнах юм бол, ерөөлтэй манатай болно гэдгийг Балаам мэдэхтэйгээ байв. Заримдаа энэ нь улам том заль мэхд оруулах хангалттай мэдлэг болдог.

Тиймээс Бурхан: “Босоод, тэдэнтэй яв” гэж айлдахад, Балаам хичнээн гайхсаныг төсөөлөх байх. Балаам дотроо: *“Гайхмаар аа! Ахин дахин залбирсан нь онож дээ”* гэж бодсон байх.

Тиймээс Балаам маргааш өглөө нь босоод, урьд шөнө Бурханы хэлсэн үгийг яг хэлснээр нь хийсэн боловч, хамгийн гайхмаар нь “Гэвч түүний явснаас нь болж Бурхан уурласан” (Тооллого 22:22) гэдэг.

Юу? Бурхан орон гаран юм уу? Энэ бол утгагүй асуулт гэдгийг бид мэднэ. Учир нь үүнд яриангүй “Үгүй!” л гэж хариулна. Тэгвэл Бурхан юундаа уурлав? Өөрөө л яв гэсэн болохоор Балаам явсан шүү дээ. Тэгээд явсанд нь уурлаад байдаг. Хачин юм аа?

Энд илчлэгдсэн үнэнийг олон хүн мэддэг ч үгүй, ойлгодог ч үгүй. Би ч өөрөө олон жил зүдэрч байж ухаарсан юм. Тэгэхээр ийм байна:

Хэрэв Бурхан аль нэг зүйлийн талаар хүслээ илэрхийлчихээд байхад (Үгээрээ юмуу эсвэл залбирч байхад чинь), бид түүнийгээ дэндүү ихээр хүссээр л байвал (шунасаар байвал), тэр зүйл бидэнд сайн биш бөгөөд хожим хойно бид түүгээрээ шүүгдэнэ гэдгийг мэдэж байсан ч, Бурхан бидэнд тэр зүйлийг өгдөг.

Энэ үг таныг цочроож мэдэх ч, үнэн юм. Үүнийг Библийн жишээгээр батлая.

Биелсэн хүсэлт

Израиль хаантай болохыг хүссэн. Удирдагч нар нь Самуел дээр очоод, хүсэлтээ мэдүүлээд: “Та одоо настай болжээ. Хөвгүүд тань ч таны замаар явахгүй байна. Бусад үндэстнүүдэд байдаг шиг биднийг захирах хааныг бидэнд томилж өгнө үү” (1Самуел 8:5) гэж хэлжээ.

Самуел тэдний хүсэлтийг Эзэнд барьж, Эзэн ч эш үзүүлэгчээрээ дамжуулан удирдагч нарт хариулахдаа, яагаад тэдэнд хаан тохирохгүйг анхааруулав. Хаан хөвгүүдийг нь цэрэгт татна. Хаан хөвгүүдээр нь талбайгаа хагалуулж, ургацаа хураалгаж, зэр зэвсэг, багажаа хийлгэнэ. Түүнчлэн охидыг нь хүчээр хөдөлмөрлүүлж, хоол, цэвэрлэгээ, үнэртэн зэрэг үй олон ажилд зүтгүүлнэ. Үүгээр барахгүй, хаан тэдний талбай, усан үзмийн талбай, чидун жимсний цэцэрлэг, мал сүргийг аваад, өөрийнхөө

албатуудад өгнө. Тэгээд эцэстээ хүмүүс хүслэн болсон хаанаасаа салахын түүс болон шалан гуйх боловч, тэдэнд туслахгүй гэдгээ Бурхан хэлжээ.

Гэтэл ингэв: “Гэсэн ч ард олон Самуелын дуу хоолойг сонсохоос татгалзан —Үгүй. Бидний дээр хаан байх ёстой. Бид ч бүх үндэстний адил байж, манай хаан биднийг шүүн захирч, бидний тэргүүнд явж дайн тулаанд маань тулалдах болтугай гэцгээв (1Самуел 8:19-20).

Тиймээс Самуел хүмүүсийн шалаад байгаа зүйлийг нь Эзэнд давтан хэлэв. Тэгэхэд Бурхан зүрхэндээ хүсээгүй хариултаа Самуелд айлджээ: “Тэдний дуу хоолойг сонсож, тэдэнд хааныг томилогтун” (1Самуел 8:22). Хэдийгээр шунан дурлаад байгаа зүйл нь хүмүүст өөрсдөд нь хор хохиролтой байсан ч, Бурхан тэдэнд шунасан зүйлийг нь өгч, тэд ч хаантай болж, яг Бурханы хэлснээр тэд үе үеийн хааддаа дарлуулах болов.

Бас нэгэн жишээ. Израиль Египетээс чөлөөлөгдөх үед Эзэн тэднийг тэнгэрийн хоолоор хоолложээ. Энэ нь манна нэртэй тэнгэрийн талх байсан бөгөөд үүнийг Бичээсийн өөр нэгэн хэсэгт “тэнгэрэлч нарын хоол” (Дуулал 78:25) гэдэг. Маш шим тэжээлтэй энэ хоолоос хоёрхон зүсэм идсэн Елиа үүнийхээ хүчээр дөч хоног зогсолтгүй гүйсэн байдаг. Би ч бас үе үе ийм хоол идчихмээр л болдог!

Гэтэл Израиль энэ талхаас залхаад, мах нэхсэн. Тэд хүсэлт тавьсан. Магтаалч “...Тэрээр бөднө шувууг авчирч, Тэнгэрийн талхаар тэднийг хангасан” (Дуулал 105:40) гэдэг. Бурхан тэдний хүсэлтэд гайхамшгаар хариулжээ:

Тэнгэрт дорнын салхийг үлээлгэж,
Хүч чадлаараа өмнөдийн салхийг ч Тэрээр тууж авчирсан.
Тэдэн дээр махыг тоос шороо мэт,
Шувуудыг далайн элс мэт Тэр буулгасан.
Хуарангийнх нь дунд,
Суудаг газрынх нь эргэн тойронд унагаасан.
(Дуулал 78:26-28)

Бурхан энэ хүсэлтэд нь хариулаад зогсохгүй, гайхамшгаар хариулсан! Бурхан аугаа хүчээрээ хуаранд нь хэдэн зуу, мянган

шувуу тууж авчиржээ. Израильчууд тэднийг агнах ч хэрэг гараагүй. Тэдэнд нохой, зэвсэг, тор зэрэг шувуу барих хэрэгсэл ч хэрэг болоогүй. Бөднө шувууд өөрсдөө л хуаранд орж ирээд, хүмүүс тэднийг зүгээр л газраас юмуу агаараас гараараа барьж авчээ. Өнөөдөр ийм юм болсон бол, хэвлэл мэдээгээр нэг дэгдэж, сонингийн нүүрээр дүүрэн гарах байсан биз. Бурхан гайхамшиг үйлдсэн. Гэхдээ дараа нь юу болсныг магтаалч хэлжээ:

Тэр тэдэнд шунан хүссэнийг нь өгсөн тул
Ийнхүү тэд идэж, сайн цадацгаасан.
Харин шунал хүсэл нь эс хангагдсан.
Хоол нь тэдний аманд байх зуур л
Бурханы уур хилэн тэдний дээр ирж,
Тэднээс хамгийн тарганыг нь алсан бөгөөд
Израилийн шилдэг эрчүүдийг цохиж унагасан. (Дуулал 78:29-31)

Хүмүүсийн *хүссэнийг* худал бурхад юмуу чөтгөр биш, харин Бурхан Өөрийн биеэр гайхамшиг үйлдэн байж өгсөн атлаа тэднийг идэж дуусаагүй байхад нь шийтгэсэн!

Хүн эцэстээ Өөрийнх нь хүслийн эсрэг зүйлийг, өөрсөддөө хор хохиролтой зүйлийг сонгоно гэдгийг Бурхан мэдэж байсан ч, хүн төрөлхтөнийг бүтээхээсээ ч өмнө бидэнд сонгох эрх чөлөөг олгохоор шийдсэнийг нь бид санах ёстой.

Жишээлбэл тэнэмэл хүүгийн хувьд? Хүү ааваасаа өөрийнхөө хувийг хүсэхэд, аав нь хүүгээ өв хөрөнгөө зүй зохистой хэрэглэх төлөвшилд хүрээгүй гэдгийг нь мэдэж байв. Тийм боловч хүү нь хэтэрхий хүсээд байсан учраас, аав нь бууж өгөөд, өвийг нь өгчээ. Тэгээд эцэст нь хүү нь гахайн хороонд тун харуусалтай төгссөн.

Бичээсээс ийм жишээ олныг хэлж болох ч, ямар ч байсан та үнэнийг ойлгосон байх аа. *Бид Бурханы хүсээгүй зүйлд шунан дурлаж гуйснаараа, тун таагүй, аюултай нөхцөл байдалд ордог.*

Ухаант илжиг

Үүнийг мэдсэн болохоор, эргээд Балаамын түүхдээ оръё.

Тэр Моабын хаантай уулзахаар явжээ. Хааны бараа болгоч

нар Балаамтай хамт явсан боловч, Бурхан Балаамын сонголтод уурласан. Гэнэт Балаамын өмнө тэнгэрэлч хөндөлсөн зогсов. Тэнгэрэлч гэдэг нь жижигхэн нум сум барьсан, далавчтай, бандгар жаалууд бус, харин аугаа их хүчтэй, аварга том оршигчид гэдгийг санаарай. Тэр тэнгэрэлч нь 2.5-3 метр гаруй өндөртэй байсан байх гэж би тооцоолдог.

Тийнхүү Балаамын зам дээр илд барьсан Тэнгэрэлч хөндөлсөн зогссон бөгөөд Бурхан гайхамшгаараа Балаамын *илжгийнх* нь нүдийг нээжээ. Илжиг нь хариугүй цавчих гэж буй, аварга том Тэнгэрэлчийг үзээд, Түүнээс зайлахын тулд замаасаа огло харайн гарч, талбай руу зугтах гэсэнд, Балаам уурлан илжгээ цохиод, буцаад зам дээр гаргав.

Тэгтэл Тэнгэрэлч хоёр талаараа ханатай нарийн зам дээр гарч зогсонд, Тэнгэрэлчийг үзсэн илжиг мөн л Түүнээс дөлсөндөө хана, бие хоёрынхоо дунд Балаамын хөлийг хавчжээ. Тэгмэгц Балаам илжигтээ бүр ч уурлаж, дахин цохив.

Тэгтэл Тэнгэрэлч цааш явж, хаашаа ч эргэх аргагүй, нарийн зам дээр отон зогсов. Энэ удаа илжиг гартаа илд барьсан Тэнгэрэлчийг үзээд, Балаамын дор хэвтээд өгөв. Балаам галзууртлаа уурлаж, илжгээ дахиад цохиод авчээ.

Тэр үед Бурхан илжгийн амыг нээсэнд, илжиг Балаамд: “Чамд би юу хийчихсэн болоод чи намайг ингэж гурван удаа цохино вэ?” (Тооллого 22:28) гэж хэлэв.

Балаам, илжиг хоёр хурц үгс хаялцаж, эцэстээ Бурхан Балаамын нүдийг нээн, Тэнгэрэлчийг харуулахад, Балаам тэр даруй бөхийж, нүүрээрээ хөсөр унажээ.

Энэ хүртэл би тэрхүү Тэнгэрэлчийг Бурханы өмнө үйлчилдэг үй олон тэнгэрэлчийн нэг мэт ярьлаа. Гэхдээ тэр Тэнгэрэлч нь Эзэн Өөрөө байсан гэдэгт ЭнКэйЖэйВи Библийн орчуулагч нар ч, миний бие ч итгэж байгааг та тодорхой харсан байх аа. Гэхдээ би таныг ятгахгүй ээ. Үүнд итгэх эсэх нь таны л дур.

Тэнгэрэлч Балаамыг тайвшруулаад: “—Чи илжгээ юунд ингэж гурван удаа цохив? Харагтун, надаас гажсан учир би чамд садаа болохоор гарч ирсэн. Харин илжиг намайг хараад, гурван удаа надаас зайлсан. Хэрэв тэр надаас зайлаагүйсэн бол Би чамайг алж, түүнийг амьд үлдээх байсан” (Тооллого 22:32-33) гэсэн байна.

Балаамын амийг илжиг аврав! Илжиг л Эзэнээс бултаагүй бол, Балаам үхэх байж. Одоо Балаам Моаб, Мидианы удирдагч

нарт: “Нөхөд өө, би болилоо. Мөнгөө өөртөө үлдээ гэж хаандаа хэлээрэй” гэсэн байх гэж та бодож байна уу? Гэтэл Балаам ингэж хэлээгүй. Балаам оронд нь Эзэний өмнө улайжээ:

Балаам, ЭЗЭНий тэнгэрэлчид —Таныг зам дээр миний эсрэг зогсож байсныг мэдээгүй учир би нүгэл үйлджээ. Тэгэхээр танд таалагдахгүй байвал би буцах болно гэлээ.
(Тооллого 22:34)

Балаам нүглээ хүлээн зөвшөөрсөн боловч, хэлийнхээ нөгөө үзүүрээр: “Тэгэхээр Танд таалагдахгүй байвал...” гэж хэлж амжжээ.

“Балаам гуай, та тоглоод байна уу? Яалгах гээд байна аа?” Эзэн Өөрийн биеэр бууж ирээд, уран сайхан өрнөлөөр зам дээр нь хөндөлсөөд ч, өөрийнхөө хүссэнийг авах гэж улайрсан Балаам зогссонгүй. Балаам хааны санал болгосон мөнгө, нэр хүндэд шунасандаа, тэнгэрлэг сахилгажуулалтыг үл тоожээ. Шүтээн мөргөл нь түүнийг Бурханы зүрх сэтгэлд таг сохор болгожээ.

Хүсэл маань Бурханы хүслээс давж халиад, бид Бурханы тушаалд тушигдсандаа бачимдаж эхлэх үед ийм юм болдог. Мэхлэгдсэн нүгэлт хүсэл маань улам хүчээ авна. Тийнхүү өдгөө “болох, болохгүйн” зааг бүдгэрчээ. Дуулгавартай хүн юу нь болох, юу нь болохгүйг тодорхой хардаг бол, хэтэрхий хүссэн хүн хэдийгээр Бурханы зөвшөөрлийг авахыг хүссээр байдаг ч, шүтээн мөргөлийн саварт хэдийн орсон байна.

Санхүүгийн гачигдал

Намайг гуч гарсан хойно Бурхан Лиза бид хоёрт нэгэн алдартай хэвлэлийн газартай гэрээ байгуулж болохгүйг маш тодорхой илчлэв. Тэгээд тэр газрын эрхлэгч надтай анх уулзах үед би “үгүй” гэж хариулсан боловч, энэ маань Балак хааны удирдагч нарт хариулсан Балаамын аргаас өөр байв.

Тэгтэл тэр газраас над руу бараг өдөр болгон шахуу ярьж, бараг л Христийн бие миний номгүйгээр амьдарч чадахгүй бас олонд танигдаагүй олон зохиолч тэднээр дамжуулж номоо

хэвлүүлснийхээ дараа алдар нэртэй болсон талаар үй олон түүх хүүрнэв. Би түүний зусар арга, үг, өгөөшийг үмхсээр байлаа. Тэр үед би хоёр номоо бие дааж хэвлүүлээд байсан ч, тун цөөхөн хүнд хүрсэн байв. Тиймээс би тэр компаний үндэсний хэмжээний цар хүрээ, нөлөөг ашиглахыг хүсч байлаа. Гэтэл Бурхан хэдийгээр энэ үгийг түгээхийг хүсч байсан ч, энэ нь тохирох цаг, тохирох Үг, тохирох хэвлэлийн газар биш байжээ. Дээрээс нь миний сэдэл ч буруу байв. Би зүгээр л олонд танигдаж, нэр хүнд, алдартай болохыг хүссэн бөгөөд энэ маань *амьдралын бардамнал* байлаа.

Сүүлдээ тэр алдартай хэвлэлийн газраар номоо хэвлүүлэх хүсэл маань улам чангарч, би Эзэний маш тодорхой заавар, эхнэрийнхээ зөвлөгөө, нэг л биш болж байгаа шинж тэмдгийг хэрэгсэхээ болив. Тэгмэгц Ариун Сүнсний дотоод анхааруулга бүдгэрч, оронд нь бүр ч том хуурамч хүсэл хүчээ авжээ.

Гэтэл хэвлэлийн газар тэс өөр байдалтай байлаа. Миний цагийн хуваарь таарч өгөхгүй байсан учраас, бид Лизаг нисгэж, байгууллагаа төлөөлүүлэн гарын үсэг зуруулахаар шийдсэн юм. Гэтэл Лизагийн нисэх өглөө нэг хүү маань хоёр давхраас доошоо шатаар нэг бөөлжчихөв. Бөөлжсийг нь цэвэрлэж байх зуураа Лиза надад “Жон, Бурхан үүнийг хүсэхгүй байгааг чи харахгүй байна уу?” гэв.

Тэгэхээр нь би өөдөөс нь: “Үгүй ээ, дайсан биднийг няцаах гэж ингэж байна!” хэмээн тас зөрлөө. Байдал үүгээр хязгаарлагдсан бол, миний зөв байх байв. Гэтэл дэндүү олон зүйл буруудаж, дэндүү жигтэй байсан тул, би энэ дундаас нэвт харж чадахгүй байжээ. Өөрөөр хэлбэл би нүглийнхээ хүчинд мэхлэгдсэн байв.

Лиза тэр өдөр нисч очоод, гэрээ байгуулсан юм. Гэтэл удаах гурван сар нь миний амьдралыг гай гамшиг ниргэв. Амар тайван намайг орхиж, би бүх талаараа зөрчилдөн, тэмцэлдэв. Бүтэн гурван сар элдэв янзын нянгийн халдвар авч, ханиад хүрч, өвчин туслаа. Хэвлэлийн газартай харилцаа муудаж, юун дээр ч зөвшилцөж чадаагүй бөгөөд манай үйлчлэл олон мянган долларын алдагдал хүлээв.

Би Балаамаас нэг л талаараа ялгаатай байв: Шунан дурласан зүйл маань Бурханы хүслийг харах нүдийг маань сохлосон байлаа. Би Бурханы шүүх (*сахилгажуулалт*) дор оржээ. “Үүнээс болж та нарын дунд сул дорой, өвчтэй нь олон байгаа бөгөөд нэлээд нь нойрсож байна. Бид өөрсдийгөө нягталсан бол шүүгдэхгүй байхсан. Харин бид шүүгдэхдээ ертөнцтэй хамт яллагдахгүйн

тулд Эзэнээр сахилгаждаг” (1Коринт 11:30-32) гэж хэлсэн Паулын үгийг санана уу. Би шал хэрэггүй баахан бэрхшээл туулж байж, эцэстээ өөрийнхөө бүтээсэн шүтээнийг олж харсан юм. Тэгээд зөрүүд зангаа гэмшихэд, бараг тэр даруй бүх зүйл эргэж хэвэндээ оров. Хэвлэлийн газар ч бидэнтэй гэрээгээ цуцлахыг хүсч байгаагаа илэрхийлсэн юм.

Үүнээс яг нэг жилийн дараа өөр нэгэн алдартай хэвлэлийн газар миний өөр нэгэн номыг хэвлэх санал тавив. Тэр үед Бурхан надад: “Өмнөх хэвлэлийн газар чиний санаа байсан. Энэ хэвлэлийн газар Миний санаа!” гэж хэлсэн юм. Жилийн өмнө хүртсэн бангаасаа болоод санаа сэдэл маань ч өөрчлөгдсөн байлаа. Одоо би Бурханыг л дагаж, хүмүүсийг л чөлөөлөхийг үнэн голоосоо хүсч байв. Бурхан ч энэ номыг хүсч байсан бөгөөд ингэж миний хоёр сая гаруй хувь борлогдсон “Сатаны урхи” ном мэндэлсэн юм.

Ингээд би сургамж аваад, дахиж хэзээ ч ийм алдаа гаргаагүй гэж хэлмээр л байна. Гэхдээ худлаа юм. Дөчин насандаа би дахиад л Бурханы тов тодорхой илчилсэн хүсэл, эхнэрийнхээ зөвлөгөө, зөвлөлийнхөө гишүүдийн хатуу саналыг үл тоохдоо, урьдынхаасаа ч том мэхлэгдэж, үүнээсээ болж бараг арван найман сар маш том бэрхшээл, зовиур, зовлонгоор сахилгажсан билээ. Би энэ удаа ч бас шүтээнээ таньж, улайж гэмшсэн боловч, тэр алдаагаа сэтгэлийн асар их зовиур шаналалаар төлсөн юм.

Балаам Бурханы зүрхийг тэврээд авсан бол, сайн сайхан төгсөх байсан гэдэгт би эргэлздэггүй. Гэвч Балаам шүтээн мөргөлөөсөө хэзээ ч болиогүй учраас, эцэстээ Бурханаар шийтгүүлж үхсэн юм (Иошуа 13:22-ыг үзнэ үү).

Эрхэм найз минь, та над шиг яс махаараа тарчилж байж, ойлгох шаардлагагүй. Миний туулах шаардлагагүй байсан боловч, ухааны мунхгаар туулсан зовиур, зовлонгийн талаарх энэ түүх танд ийм явдлаас сэргийлж явах сэхээрэл хайрлана гэдэгт ихэд найдаж байна.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бид хэрэв хүслүүдээ Бурханд захируулахгүй бол, хүслүүд маань биднийг Бурханаас холдуулж, магадгүй бүр Бурхан биднийг хүслүүдээс минь чөлөөлөх ч шаардлагатай болж мэднэ. Бичээст олон удаа Бурхан хүслээ тодорхой илчлээд байхад, хүмүүс түүнийх нь эсрэг зүйлийг хүсээд байвал, хүссэн юм нь хүзүүгээр нь ороох байсан ч, Бурхан түүнийг нь хүмүүст өгсөн байхыг бид хардаг.

Бурхан өнөөдөр ч бидний амьдралд ийм зүйл хийнэ. Хүсэл маань Бурханы хүсэлтэй зөрчилдөж, хүссэн ерөөлийг маань авчрахгүй байсан ч, хэрэв бид шалаад байвал, Бурхан бидний хүссэнийг өгнө. Гэвч үүнээс болж бидэн дээр зовиуртай, таагүй сахилгажуулалт ирдэг.

Гэхдээ бид заавал ингэж зовох албагүй юм. Үүний оронд Бурхан бидний төлөө хамгийн сайныг хийнэ гэдэгт найд. Бурхан бидэнд хүссэн зүйлдээ хүрэх замыг тавьж өгдөг. Гэхдээ хамгийн гол нь тэр нь зөвт зам байна. Хэрэв бид Бурханыг дагавал, Тэр биднийг ерөөлтэй замаар дагуулах боловч, хүсээд байгаа үр дүн маань гагцхүү Түүний тогтоосон цагт л ирнэ. Тиймээс өнөөдөр Эзэнд амьдралаа даатга. Өөрийнхөө хүслээр дураараа давхиад байх биш, харин Бурханыг амьдралдаа урьж, Түүний хүсэлд захирагд. Бурхантай улам ойр алхахын тулд яах ёстойг Өөрөөс нь асуу. Хариултыг нь бичиж аваад, хэрэгжүүлээрэй.

ТӨӨРӨЛДСӨН

Гол санаагаа мартаггүйн тулд шүтээн мөргөлийн амин судсыг дахин нэг сэргээн давтъя. Шүтээн мөргөл гэдэг нь итгэгч байна уу, итгэгч биш байна уу хамаагүй - хүн төрөлхтөн Бурханы арга замаас зөрсөн хүсэл тачаалаа хангахын төлөө Бурханы тодорхой илчилсэн хүслийг хойш тавих явдал юм.

Садарлагч, бузрыг үйлдэгч, шунахайрагч тухайлбал шүтээн шүтэгч аливаа хүнд Христийн болон Бурханы хаанчлалд өв байхгүй гэдгийг та нар мэд. Хэн ч та нарыг хоосон үгсээрээ бүү мэхлэг. Учир нь эдгээрээс болж Бурханы уур хилэн дуулгаваргүй хөвгүүд дээр буудаг юм. Иймд тэдний хамсаатан бүү бай. (Ефес 5:5-7)

Бурханы уур хилэн үл итгэгч хүн дээр буудаг боловч, Бурхан бас шүтээн мөргөл рүү (шунал руу) эргэсэн итгэгч хүнийг Өөрийнхөө зүрх сэтгэл рүү эргүүлж авчрахын тулд сахилгажуулдаг юм. Харин итгэгч хүн Балаам шиг гэжиж, дуулгаваргүй авирласаар байвал, үхэл шиг л хатуу үр дүн үзнэ. Паул итгэгч хүмүүст: “Хэрэв та нар махбодын дагуу амьдарвал үхэх ёстой” (Ром 8:13) хэмээн анхааруулсан байдаг. Элч Иаков ч ялгаагүй: “Тэгээд тачаал нь үр тогтоон нүглийг төрүүлдэг. Нүгэл нь гүйцэд болохоороо үхлийг гаргадаг аж. Хайрт ах дүү нар минь, бүү мэхлэгдэгтүн” (Иаков 1:15-16) хэмээн анхааруулжээ.

Шүтээн мөргөлийг удаан үйлчилгээтэй хор шиг үзэх ёстой. Энэ бол сүнслэг криптонит. Бид үүнтэй сээтэгнэж болохгүй. Шүтээн мөргөлийн тор нь тун нарийн бөгөөд бат бөх нэхээстэй байдаг. Бид шүтээн мөргөлийн хүчийг Балаамын түүхээс хальт үзсэн боловч, одоо цаашаа нэг алхам ахицгаая. Бурхан Израилийн удирдагч нарт юу сэрэмжлүүлснийг анхааралтай үзнэ үү:

Хүний хүү, энэ хүмүүс зүрхэндээ шүтээнүүдээ залснаар хилэнцийнхээ бүдрэх чулууг нүүрнийхээ яг өмнө тавьсан атал Би ер нь тэднээр асуугдах ёстой гэж үү? (Езекиел 14:2-3)

Энд ч бас шүтээн мөргөлийг хөшөө баримал, овоо тахилга, сүм дуганаар хязгаарлаагүй байна. Үүнийг Бурхан “хүмүүс зүрхэндээ шүтээнүүдээ залсан” гэдэг үгээрээ багтай ойлгуулжээ. Шүтээн гэдэг нь дан ганц модон доорх, хотын төв, сүм дуган дахь хөшөө баримал биш юм. Шүтээн нь хүний зүрхэнд байдаг. Шүтээн гэдэг нь Бурханы хүсэлтэй зөрчилдсөн, далд хүслүүд юм. Бурхан цааш нь:

“Шүтээнүүдээ зүрхэндээ оруулж, хилэнцийнхээ бүдрэх чулууг нүүрнийхээ яг өмнө тавиад эш үзүүлэгч дээр очдог, Израилийн гэрийн ямар ч хүнд ЭЗЭН Би шүтээнүүдийнх нь тоо томшгүй байдлаар хариулна” (Езекиел 14:4) хэмээн айлдруун.

Шүтээн мөргөлтэй хутгалдсан (сөрөг хүслээсээ зуурсан) хүн чиглүүлэг, зөвлөгөө, Библийн сургаалаар дамжуулан хүссэн хариултаа хүлээн авч болох ч, тэр нь Бурханы хүслийн дагуу байхгүй. *Нью Американ Стандарт Библи* дээр Езекиелийн дээрх ишлэлийг “Эзэн - Би түүнд тухайн зүйлийнх нь талаар өөрийнх нь үй олон шүтээний үзлээр хариулна” гэдэг.

Тэгвэл хариултаа хайж байгаа хүнийг шүтээн шүтэж байгааг нь нүүрэн дээр нь хэлэхээс зайлсхийж, түүнд бүх юм сайн сайхан мэтээр ярьж байгаа үйлчлэлийн удирдагч нарт Бурхан юу гэж анхааруулсныг үзнэ үү (Эш үзүүлэгч, тахилч нар нь Хуучин гэрээний үйлчлэлийн - удирдагч нар байв. Одооноос эхлэн би өнөөгийн үйлчлэгч - удирдагч нарыг орчин цагийнх нь зохих нэрээр дуудаад явна):

Харин эш үзүүлэгч үг хэлэхээр өдөөгдсөн аваас тэр эш үзүүлэгчийг өдсөн нь ЭЗЭН Би бөгөөд Би түүний эсрэг мутраа сунгаж, Өөрийн ард түмэн Израилийн дундаас түүнийг устгана. (Езекиел 14:9)

Залбирч байхад, орчин цагийн үйлчлэл - нэн ялангуяа Баруун - дийлэнх сургаалаа суртал ухуулгад ашигладаг болсныг бодохоор л гүн гашуудал төрж, уйлмаар болдог юм. Тэгээд би бидний ярьж байгаа, бичиж байгаа үлбэгэр сайн мэдээний ард юу байгааг Бурханаас уйлан хайлан асуутал, Ариун Сүнс намайг Езекиелийн 13, 14-ээр бүлэг рүү хөтөлсөн юм. Хүний дадал болсон нүгэлтэй нүүр тулдаггүй, шингэлсэн сургаалын ард *шүтээн мөргөл* байдгийг энэ хоёр бүлэг илчилжээ. Үйлчлэгч хүн дагалдагч нараа цөөлөхөөс, нэр хүндээ алдахаас айсандаа дутуу хагас сайн мэдээ танилцуулж байвал, энэ нь зүсээ хувиргасан шуналаас өөр юу ч биш юм. Энэ шалтгааны улмаас, хулхи үйлчлэл цэцэглэх тэр үед эш үзүүлэгч Иеремиа:

“Учир нь тэд багаасаа том хүртэл Бүгд ашиг олох гэж шунадаг бөгөөд Эш үзүүлэгчээсээ тахилч хүртэл хүн бүр хуурамч байна” (Иеремиа 6:13) хэмээн орь дуу тавьсан байдаг.

Өнөөгийн дийлэнх чуулган дахь сүнслэг доройтол - криптонитын гүн ажиллагааг ажиглаад байхад, олон итгэгчийн хангалуун бус зүрхнээс “амьдралын гачигдал” гэх (эдгээр нь ихэвчлэн бодит хэрэгцээ биш, ердөө л хүсэл, шунал байдаг) хүсэл ойлгоддог ажээ.

Төөрөлдсөн удирдагч шуналаасаа болж, замаасаа хазайгаад, нүгэл хийгээд дадчихсан эрэлчдийн амьдралд нүдээ аньж, намжмал аядуу Бичээсийг тунхаглахын зэрэгцээ бурханлаг бус зан үйлдэлтэй тулсан аливаа Бичээсээс сурамгай бултана. Шүтээнд мөргөх энэ үйлдэл нь үйлчлэгч хүний хувьд ч, итгэгч хүний хувьд ч зөвхөн энэ хэрэгцээ, тачаалыг нь хангадаг үг, зөвлөгөөг л сонсох сувгийг нээж, шунал хүсэл, шүтээнийг нь улам л бэхжүүлж өгдөг.

Иеремиа, Езекиел нартай адил Шинэ гэрээнд ч Паул ирээдүйн талаар эш үзүүлсэн байдаг:

Цаг нь ирэхэд хүмүүс эрүүл сургаалыг тэвчихгүй болж, харин хүслийнхээ дагуу, чихийг нь гижигдсэн багш нарыг өөрсдөдөө цуглуулах бөгөөд. (2Тимот 4:3)

Тэр цагт тавтай морил! Эрэлчид хүссэн зүйлээ л сонсохын тулд өөр шигээ шуналтай “үйлчлэгч” нарыг олоход л болно.

Тэгвэл нөгөөтэйгүүр Бурханаас эмээдэг, бурханлаг удирдагч нь Бурханы Үгийн бүх зөвлөгөөгөөс хэвийхгүй. Бичээсийг энд тэндээс нь цөмөх биш, бүтнээр нь залгих ёстой юм. Бурханлаг удирдагч засч залруулж, нүүр тулахаас ч айхгүй, урамшуулж босгохоос ч айхгүй.

Паулын ярьсан үйлчлэгч нар нь нэр төр, үзэмж, дэвшил, далд сэдэлдээ л анхаардаг. Тэднийг ашигтай үр дүн, шан харамжийн амлалтаар дороо ятгах бөгөөд тийнхүү тэд хүмүүс дуртай дургүй байхаас үл шалтгаалан Бурханы үгийг итгэмжтэйгээр номлохын оронд, сонсогчийн “захиалгат” үгийг л ярьж, номлодог.

Үнэнийг хэлсэн цорын ганц үйлчлэгч

Иудагийн хаан Иехошафат нь Израилийн хаан Ахабтай ураг барилдан, нэг тал болжээ. Бурханаас эмээдэг Иехошафатын хувьд шүтээнд мөргөдөг Ахабтай эвсэх нь мэргэн нүүдэл байсангүй. Хэсэг хугацааны дараа Иехошафат Израилийн хаантай уулзахаар Самарид айлчлав.

Ахаб Иехошафатыг Сирийн эсрэг эвсэн тулалдахад уриалжээ. Иехошафат Ахаб хаанд: “Яриа юун! Чи бид хоёр чинь ахан дүүс. Миний цэрэг бол чиний цэрэг. Бид та нартай хамт тулалдана” гэж хариулснаа, араас нь: “Тэхдээ эхлээд Эзэн юу айлдахыг мэдь” хэмээв (2Шастир 18-ыг үзнэ үү).

Тиймээс Ахаб хаан Израилийн хамгийн нэртэй хүндтэй үйлчлэгч, удирдагч нарыг дуудав. Тэд Баал, Ашера, Хемош зэрэг худал бурхдад үйлчилдэг хүмүүс биш, харин Бурхан Эзэний зарц нар байв (тэд Иавэгийн нэрээр ярьдаг байв). Ахаб тэднээс дайтах уу, азнах уу гэж асуулаа.

Үйлчлэгч нар нэгэн дуугаар: “Явагтун! Учир нь Бурхан тэр хотыг хааны гарт өгнө гэж хариулцгаав” (2Шастир 18:5). Тэдгээр удирдагч нар сонсогч нартаа - нэн ялангуяа томчуудад

гагцхүү эерэг, урмын үг хэлэхэд л сургагдсан байжээ. Хэдийгээр тэд *Иавэгийн* зарц нар байсан ч, шуналд баригдсан шүтээнд мөргөгчид байв.

Тэд мундаг номлодог, Израилийн хамгийн нэр хүндтэй үйлчлэгч нар байсан ч, Иехошафат энэ үгд ханасангүй. Тэрбээр Эзэнээс эмээдэг хүн байсан тулдаа ялгах хараатай байжээ. Тэгээд Иехошафат: “Бидэнд асуучихаар, ЭЗЭНий өөр эш үзүүлэгч энд алга уу?” гэж асуув (6-аар ишлэл). Тэр хүмүүс Иавэгийн эш үзүүлэгч нар гэдгийг Иехошафат мэдэж байсан ч, нэг л биш байхыг бас мэдэрчээ.

Гэсэн Ахаб: “ЭЗЭНээс асууж болох өөр нэгэн хүн бий. Гэвч тэр миний талаар сайныг хэзээ ч эш үзүүлдэггүй, харин мууг л хэлдэг учир би түүнийг үзэн яддаг юм. Тэр бол Имлахын хүү Микаиа гэгч юм” (7-аар ишлэл) хэмээн дүрсхийв. Шүтээнд мөргөдөг хүний хувьд эсвэл худал зусард дурладаг итгэгч хүмүүс жинхэнэ Сайн мэдээний үйлчлэгчийг сөрөг, гутруу гэж үздэг.

Микаиа бусдаас өөр хүн байжээ. Учир нь тэр Ахабаас юу ч горьдоогүй, олны тааллыг ч хүсээгүй. Тэрбээр хүнээс илүү Эзэнээс эмээж, Бурханы хүслээр л ололт амжилтад хүрэхийг хүсдэг байв. Тэрбээр өөрийнх нь эх ундарга бол Иавэ болохыг мэдэж байсан тул криптонитын нөлөөн дор орсон хүнд бус, Бурхандаа л таалагдахыг хүсжээ. Үүнийхээ ачаар Микаиа бусад үйлчлэгч нарын дотор ажиллаж байсан мэхлэлээс чөлөөтэй, цэвэр байв.

Ахаб Микаиаг авчруулав. Бурханы жинхэнэ хүнийг хүлээж байх зуур нөгөө эш үзүүлэгч нар хоёр хааны өмнө үргэлжлүүлэн эш үзүүлсээр л байлаа. Тэдэн дундаас Бениамин овгоос гаралтай Зедекиа гэдэг Еврей хүн өөртөө төмөр эврүүд хийгээд: “ЭЗЭН (*Иавэ*) ийн айлдаж байна. Эдгээрээр та арамчуудыг устаж дуустал нэвт сүлбэх болно” (10-аар ишлэл) гэжээ.

Тэгтэл бүх үйлчлэгч нар дуу дуугаа авалцан: “Рамот-гилеад уруу явж, ялагтун. Учир нь ЭЗЭН тэр хотыг хааны гарт өгнө гэж эш үзүүлжээ (11-ээр ишлэл). Мэдээж олноороо дэвэргээд ирэхээр итгэл төрж, сэтгэл амарна аа даа, тийм үү? Тийнхүү бултаараа зөвшөөрч, батласан үг нь үнэхээр хийморь бадрааж, сэтгэл сэргээм байв! Тэд яг Ахабын хүссэнийг батлаж, хүслийнх нь ялалтад - шүтээн мөргөлд нь хандан ярив!

Ийнхүү үйлчлэгч нар хоёр хааныг нэгэн дуугаар ховсдож байх хооронд хааны элч Микаиаг олоод: “Харагтун, эш үзүүлэгчдийн үгс нэгэн дуугаар хааны талд байна. Үгээ тэдний нэгнийх нь үг шиг болгож, сайныг яригтун” (2Шастир 18:12) гэж хэлжээ.

Заримдаа намайг алдартай цуглаанууд урихаараа: “Жон, хүмүүсийг урамшуулаарай. Өөдрөг үг номлоорой. Хүмүүсийг байгуулж, тайвшруулаарай. Манайх их өөдрөг, дайчин дуугаар цуглаанаа өндөрлөх учраас, чи ч бас үгээ ийм өнгөөр дуусгаарай. Хүмүүст сайхан мэдрэмж төрүүлэх хэрэгтэй” гэж хэлдэг. Яг л Хааныхаа дайлгасан Үгийг гуйвуулах эрх элч хүнд байдаг мэт! Хэрэв бид хулхидбал, Бурханы ам хэл болсон элч байхаа больж, зүгээр л өөрийнхөө хүссэн юмыг авчрахын тулд Шинэ гэрээний энд тэндээс түүвэрлэсэн өөдрөг үгээ цацдаг хүмүүс л болно.

Микаиа ийм үгд автахгүй учраас, шууд л хэлжээ: “ЭЗЭН амьд! Бурхан надад юу хэлнэ, түүнийг л би ярих болно” (13-аар ишлэл).

Аав минь, Аав минь, ийм зүрх зоригтой удирдагч нарыг бидэнд илгээгээч!

Микаиаг Ахабын өмнө ирж зогсох үед түүнээс мөнөөх л асуултыг асуусанд, тэрбээр: “Явж, ялагтун. Тэд таны гарт өгөгдөх болно” (14-ээр ишлэл) хэмээн тэднийг явуулав.

Ахаб Микаиагийн даажигналд уурсжээ. Тэгтэл Микаиа яг юу болох тухай Бурханы Үгийг дуулгав: “Бүх Израиль хоньчингүй хоньд мэт уулсын оройгоор тархан явахыг би харлаа. ЭЗЭН айлдахдаа “Тэдэнд эзэн байхгүй. Тэд бүгд өөр өөрсдийн гэртээ амар тайван харьцгааг” гэжээ (16-аар ишлэл).

Ахаб Иехошафат руу хараад: “Тэр миний тухай сайн юм эш үзүүлдэггүй, харин ёрын мууг л эш үзүүлдэг гэж би чамд хэлээгүй юу? (17-аар ишлэл) гэв.

Тэгтэл Микаиа тэнд чухам юу болоод байгааг, чухам юу болох гэж байгааг үргэлжлүүлэн хэлжээ:

Тиймээс ЭЗЭНий үгийг сонсогтун! ЭЗЭН сэнтийдээ залран Түүний баруун, зүүн талаар тэнгэрийн бүх дайчид хүрээлэн зогсож байхыг би харсан юм. ЭЗЭН “Хэн Израилийн хаан Ахабыг явуулж, Рамот-гилеадад унагахаар уруу татах вэ?” гэж асуулаа. Нэг нь ийм гэхэд нөгөө нь тийм гэж байлаа.

Тэгтэл нэг сүнс урагш гарч ирэн ЭЗЭНий өмнө зогсоод, “Би

түүнийг уруу татъя” гэсэнд ЭЗЭН түүнээс “Яаж?” гэж асуув. Тэрээр “Би явж, түүний бүх эш үзүүлэгчийн аманд хуурдаг сүнс болно” гэв. ЭЗЭН түүнд “Чи түүнийг уруу татагтун. Үүнийгээ чи бас чадах болно. Явж, үүнийгээ хийгтүн” гэлээ. Тиймээс одоо, үзэгтүн, ЭЗЭН энэ эш үзүүлэгчдийн чинь аманд хуурдаг сүнсийг хийсэн билээ. ЭЗЭН таны эсрэг гай гамшгийг тунхаглажээ гэв. (18-22)

Бурхан Ахабын зүрхэнд шүтээн мөргөлийнх нь (шуналынх нь) дагуу хариулжээ. Езекиелийн хэлсэн үнэн яг энд дүрслээтэй байна. Бурхан өнгөрсөн бүлэгт Балаамын зүрхэн дэхь шүтээн мөргөлд, энэ бүлэгт Ахабын зүрхэн дэхь шүтээн мөргөлд шууд айлдсан шигээ бас үгийг дамжуулж байгаа хүнд ч яг ингэж ханддаг.

Ахаб хамгаалалт, чөлөөлөлтийг авчрах Бурханы жинхэнэ үгээс татгалзаж, хүссэн үгээ л сонссон. Ахаб байлдахаар явсан. Ахаб өөрийгөө Сириүдэд таниулахгүй хэмээн зүсээ хувиргасан ч, тэнэсэн сумд оногдож, үдэш болохоос ч өмнө үхжээ. Та хүнээ нуугдаж болох ч, Бурханаас нуугдахгүй!

Тэгвэл өнөөдөр байдал ямар байна? Бид Бурханы амласан хамгаалалт, хангамж, чөлөөлөлтийг хүсч байна уу? Эсвэл зусар бялдуу үг сонсохыг хүсч байна уу? Хутгалдсан мэхлэлээс маань асуудал суунагласаар байтал, “амар тайван” гэдэг үгийг сонсохыг хүсч байна уу?

Энэ бүхнийг Бичээсээр гэрэлтүүлж харах уу? Юу нь дээр вэ? Бурханы Үгийн бүрэн зөвлөгөөнд захирагдах урт удаан настай хамгаалалт уу эсвэл түргэн ерөөлийг хүртмэгц, буланд отож байгаа зайлшгүй сахилгажуулалт, шийтгэл үү?

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Христэд итгэдэг нэртэй олон хүн гоё сайхан мэдрэмж авчирдаг үгийг л хүсдэг. Мөн олон үйлчлэгч шуналаасаа болоод, нөгөөтэйгүүр хүнээс айсандаа болоод дагалдагч нартаа дандаа л урамшуулан дэмжсэн үг хэлэхийг хүсдэг. Ийм нөхцөлд бурам шиг үг сайхан амтагдаж болох ч, ямар ч шимгүй бөгөөд сонсогчийг ч, удирдагчийг ч хүсээгүй газарт нь хүргэнэ.

Бид үнэнийг сонсох хэрэгтэй. Эхлээд өвдөнө. Үнэн өвтгөдөг ч, заль мэх дотор амьдарсныхаа гороор эдлэх зовлонгийн дэргэд юу ч биш.

Та үнэний мөрөөр амьдарч чадна.

Бурханаас өөрийнхөө амьдарлыг үнэнээр нь асуу. Санаандгүйгээр мэхлэгдсэн тал байгаа эсэхийг илчилж өгөхийг гуй. Бурханы айлдсан үнэнийг тэмдэглэж аваад, ирэх өдөр хоногуудад тунгаан бод. Дараа нь Бурханаас үнэнийг ярих (хүмүүст таалагдахгүй, дүрмийн дагуу биш байсан ч хамаагүй) зүрх зориг гуй. Мэдээж хэрүүл өдөөд, хэдэр ёдор гээд явах хэрэггүй. Гэхдээ та Микаиа шиг: “ЭЗЭН амьд! Бурхан надад юу хэлнэ, түүнийг л би ярих болно” гэж хэлж чадна.

ХУЛХИ ЕСҮС

“Хулхи Есүс гэж юугаа яриад байгаа юм бол?” гэж бодож байна уу? Энэ бүлэгт итгэгч хүмүүсийг шүтээн мөргөлд уруу татдаг хамгийн гол бүтцийн тухай өгүүлнэ. Энэ талыг илрүүлснээрээ орчин цагийн Христэд итгэх итгэлд яагаад ийм олон хүн чуулганы болоод хувь хүмүүсийн хүчийг сордог, сүнслэг криптонитад тийм амархан урхидуулдаг нууцыг тайлах болно.

Та нарыг Өөр дээрээ авчирсан

Египетээс гарч ирсэн Израилийн чөлөөлөлт нь дэлхийгээс чөлөөлөгдсөн бидний авралыг билэгдэж байгааг өмнө хэлсэн билээ. Мосе Израилийг шатаж буй бутан дунд анх Бурхантай уулзсан газартаа буюу Синайд авчрав. Мосе хүмүүсийг ч бас яг тэгж Бурхантай уулзаасай гэж хүсчээ. Мосе юу гэж хүмүүсийг Амлагчтай нь уулзуулаагүй байж, шууд Амлагдсан газар руу дагуулах билээ? Тэгээд тэднийг Синайд ирэх үед ийм явдал болжээ:

Мосе, Бурханд өгсөж очсонд ЭЗЭН түүнийг уулнаас дуудан —Чи Иаковын гэрт, Израилийн хөвгүүдэд ингэж хэл. “Би египетчүүдэд хэрхэн хандаж, та нарыг бүргэдийн жигүүр дээр тээн Өөртөө яаж авчирсныг та нар өөрсдөө харсан. (Гэтлэл 19:3-4)

Түүний “та нарыг Өөр дээрээ авчирсан” гэдэг үгийг харна уу. Энэ мэдэгдэл нь биднийг энэ дэлхийгээс аварсан тэнгэрлэг сэдлийг хураангуйлж байгаа юм. Бурхан та нарыг Өөр дээрээ авчирсан. Бурхан та нарыг хүсдэг, та нартай нөхөрлөхийг хүсдэг, Аав - хүүгийн харилцаатай байхыг хүсдэг.

Бурхан хэдэн зуун жил боолчлолд байсан хүмүүстэйгээ уулзах гэж хичнээн догдолсон бол? Гэргий маань дөрвөн хүү төрүүлсэн юм. Би ч тухай бүр хүүгээ төрөхийг тэсэн ядан хүлээдэг байлаа. Бүтэн есөн сар хүлээх хэрэгтэй болно. Хүүгээ гар дээрээ тэвэрч, том болохыг нь харж, шулганахыг нь сонсож, зан аашийг нь ажиглаж, аав - хүүгийн харилцаа тогтоохыг хүсдэг байв. Товчхондоо тэднийгээ маш их санана.

Бурхан яг л ийм сэтгэлтэй байв! Гэхдээ Тэр есөн сараас удаан хүлээсэн билээ.

Хүмүүс ч Бурхантайгаа сайхан уулзахын тулд бэлтгэлээ базаах хэрэгтэй байв. Тэгээд Бурхан: “Ард түмэн дээр очиж, тэднийг өнөөдөр, маргааш ариун байлга. Хувцсыг нь угаалган, тэднийг гурав дахь өдөрт бэлтгэ. Учир нь гурав дахь өдөрт ЭЗЭН бүх ард түмний нүдний өмнө Синаи уулан дээр бууж ирнэ (Гэтлэл 19:10-11) хэмээв.

Эзэн хүмүүст: “Би та нарыг их саналаа. Гэхдээ бид жинхэнээсээ уулзахын тулд та нар Египетийн хирээс хувцсаа угаах хэрэгтэй. Би та нарын Аав мөн боловч бас ариун Бурхан бөгөөд та нартай өнгөц харилцаа тогтоохгүй” гэж хэлжээ.

Амиа хичээсэн хүнтэй гүн гүнзгий, жинхэнэ харилцаа тогтоох боломжгүй. Бурхан бидэнд бүрэн бүтнээрээ зориулагдсан. Тэр биднийг дэлхийн хийдгийг хийж, дэлхийтэй тогтоосон харилцаагаараа дамжуулан хувийнхаа хүсэл, тачаалыг хангахыг зөвшөөрч чадахгүй.

Синайд хоёр өдөр өнгөрч, гурав дахь хоног дээрээ Эзэн Өөрийгөө танилцуулахаар бууж иржээ. Тэгтэл хүмүүс үнхэлцгээ хагартал айн, хэдэн тийш арилав. Тэд Мосед: “Та бидэнтэй яриач. Бид сонсьё. Харин Бурхан бидэнтэй бүү яриг. Эс тэгвэл бид үхнэ” (Гэтлэл 20:19) гэжээ.

Мосе уурлав. Яаж тэд өөрсдийг нь боолчлолоос аварч, чөлөөлсөн Нэгэнээс зугтаж чадаж байна аа? Яаж тэд Бүтээгчийнхээ дуу хоолойг сонсохоос татгалзаж чадаж байна аа? Тэгвэл Бурханд Өөрт нь ямар байсныг төсөөлж байна уу? Тэр энэ цагийг тэсэн

ядан хүлээсэн. Мосе Түүнийг таньж мэдсэн шиг, тэд ч бас таньж мэдээсэй гэж Тэр хүссэн. Гэтэл тэд Түүний оршихуйг хөөжээ.

Хүү маань надад: “Аав аа, та надтай шууд харилцах шаардлагагүй. Та надтай хэн нэг хүнээр дамжуулж л харилцаж байгаарай” гэж хэлбэл, надад ямар байх уу? Үнэхээр аймаар!

Тахилчийн үйлчлэл мэндлэв

Хүмүүс Өөртэй нь шууд харилцахыг хүсэхгүй учраас, Бурхан тахилчийн үйлчлэлийг эхлүүлэхээр шийджээ. Тахилч бол хүмүүсийн өмнөөс Бурхантай ярьдаг хүн. Иүдейчүүдэд Бурханы Үгийг хүмүүст дамжуулдаг Мосе гэдэг эш үзүүлэгч байв. Гэхдээ Бурхан хүмүүстэйгээ тасралтгүй харилцаа тогтоохын тулд тахилчийн үйлчлэлийг эхлүүлэх ёстой байлаа.

Тэгээд Бурхан Мосед: “Бууж очоод, Ааронтой хамт гарч ир” (Гэтлэл 19:24) хэмээн айлджээ. Ингэж Аарон анхны тахилч болсон ч, Бурхан анхнаасаа ийм зүйл төлөвлөөгүй байв. Бурхан анхнаасаа хүмүүсээ бүгдийг нь тахилч болгохыг хүсч байжээ. Тэднийг анх Синайд ирэх үед Бурхан: “Та нар Надад тахилчдын хаант улс, ариун үндэстэн болох болно” (Гэтлэл 19:6) гэсэн юм. Бурхан Израилийн хүн бүрийг Өөртэй нь харилцах боломжтой байлгахыг хүсчээ.

Бурхан Мосед Аароныг дагуулаад буцаад ууланд гарч ирэхийг зааварлав. Гэхдээ Аарон ууланд гарсан тухай тэмдэглэгээ байдаггүй. Тодорхойгүй шалтгаанаар Аарон хүмүүстэй хуарандаа үлдэж, харин Мосе дөч хоног уулын орой дээр байж таарчээ. Аарон яагаад яваагүй юм бол? Тэр Бурханы дэргэд байснаас хүмүүсийн дунд байх нь илүү тайван гэж үзсэн үү? Тэр Бурхантай хоёулханаа байхаас айсан уу? Үүнийг бид мэдэхгүй ч, харин дараа нь Аарон ухаан санаанд багтамгүй, аймшигтай зүйл хийснийг мэднэ.

Хулхи Иавэ

Мосег уулнаас бууж ирэлгүй саатсаныг ард түмэн хараад Аарон дээр цуглав. (Гэтлэл 32:1)

Юу болоод байна аа? Нэгдүгээрт - хүмүүст биелүүлмээр хүсэл, хүсэлт байсан бөгөөд үүнийг нь хийх Бурханы хүн хэрэгтэй байв. Хоёрдугаарт - Аарон удирдах ур чадвараараа хүмүүсийг татдаг байжээ. Энэ тун чухал зүйл шүү. Учир нь хүмүүс Бурханыг дагадаг, дагадаггүй нь хамаагүй - хүчтэй удирдагчид татагддаг. Тиймээс олон дагагчтай удирдагч хүн заавал Бурхантай хамт алхаж яваа гэсэн үг биш юм. Хүмүүс Ааронд юу гэж хэлснийг харна уу:

Бос. Бидний өмнө явах бурхдыг бидэнд бүтээж өг. Учир нь биднийг Египет нутгаас гаргасан хүн болох энэ Мосед юу тохиолдсоныг бид мэдэхгүй байна. (Гэтлэл 32:1)

Хамгийн түрүүнд хүмүүс: “тэр *Бурханд* юу тохиолдсоныг бид мэдэхгүй байна” гэж хэлээгүйг анхаарах хэрэгтэй. Энэ чухал зүйлийг бид тун удахгүй авч хэлэлцэнэ.

Хоёрдугаарт - “бидэнд бурхад бүтээж өг” гэж хэлснийг анхаараарай. Бурхад гэдгийг Еврейгээр *элохим* гэж хэлсэн байгаа. Энэ нь Хуучин гэрээнд 2,600 жаахан гарантай давтагддаг үг бөгөөд 2,550 дээр нь энэ нэрээр Аугаа хүчирхэг Бурханыг дуудсан байдаг. Жишээлбэл Эхлэл номын эхний бүлэгт л гэхэд энэ үг нь гучин хоёр удаа гардаг. Библийн хамгийн эхний ишлэл дээр “Эхэнд *элохим тэнгэрүүдийг* хийгээд газрыг бүтээжээ” гэдэг.

Өөр нэг жишээ нь Дэд хуулийн 13:4 болно: “Та нар ЭЗЭН (*Иавэ*) Бурханыхаа (*элохим*) хойноос дагаж, Түүнээс айн эмээж, Түүний тушаалыг мөрдөж, Түүний дуу хоолойг сонсон дагаж, Түүнд зарагдаж, Түүнээс зуур.” Энэ Бичээст Эзэнийг “Иавэ” гэсэн атлаа бас бидний *элохим* гэжээ. Тэр бол Бурхан, туйлын эрх мэдэл, туйлын эх сурвалж мөн.

Гэх атлаа Хуучин гэрээнд 250 жаахан гарантай удаа *элохим* нэрээр Дагон (1Самуел 5:7), Баал (1Хаад 18:21) зэрэг худал бурхдыг нэрлэсэн байдаг. Тиймээс хэний тухай яригдаж байгааг нь мэдэхийн тулд ямагт бүтэн агуулгаар нь уншиж байх ёстой.

Аарон хүмүүсийн хүсэлтэд хариулахдаа, алтан ээмэгнүүдээ авчирч өгөхийг хүсчээ. Тэгээд алтыг хайлуулаад, нөгөө алдарт алтан тугалаа урлан бүтээв. Бүтээж дуусмагц хүмүүс: “Израильчууд аа, та нарыг Египет нутгаас гаргасан бурхан чинь!” (Гэтлэл 32:4) гэжээ. Энд *бурхан* гэхдээ бас л *элохим* гэдэг Еврей үгийг хэрэглэсэн байна. Гэхдээ тэдний “Египетээс гаргасан

бурхан!” гэдэг үгээс нь чухам хэний тухай яригдаж байгаа нь ойлгогдож байна. Хэн тэднийг гаргаж авчирсныг тэд мэдэж байсан. Тэд тэнэг улс биш. Гэхдээ бидний таамаг яг дараагийн ишлэлд батлагддаг:

Аарон үүнийг үзээд, тугалын өмнө тахилын ширээ босгож
—Маргааш ЭЗЭНд зориулсан баяр наадам *болно* гэж зарлан
тунхаглав. (Гэтлэл 32:5)

Энэ ишлэлд “Эзэнийг” *Иавэ* гэжээ. Энэ тухай СиДаблюЭсБи дээр:

“Энэ нэр нь Израилийн Бурханы зүй ёсны нэр бөгөөд Тэрбээр чухам энэ нэрээрээ Өөрийгөө Мосед илчилсэн байдаг (Гэтлэл 6:2, 3). Тэнгэрийн энэ нэрийн ариун дагшин чанарыг хүндэтгэсэндээ, дуудахыг цээрлэдэг уламжлалтай байжээ. Тийнхүү Сэргэн мандалтын үе хүртэл Хуучин гэрээний Еврей бичвэр дээр энэ нэрийг эгшиг бичилгүй, ЯХВХ гэсэн дөрвөн гийгүүлэгч үсгээр тэмдэглэдэг байв” гэж тайлбарлажээ.

Дээрх ганц тохиолдлыг эс тооцбол Библи энэ нэрээр худал бурхдын тухай яриагүй бас нэрлээгүй болно. Энд ямар ч алдаа байхгүй. Гэтэл Аарон тэргүүтэй хүмүүс тэр тугал руу хараад, *Иавэ* гэж нэрлэсэн нь итгэхийн аргагүй үйлдэл байв. Тэд тугалаа Баал, Дагон, Ашера, Ра, Нефтис зэрэг Египетийн бурхдын нэрээр нэрлээгүй. Тэд “Биднийг Египетээс гаргасан Ра!” гэж хэлээгүй.

Тэд: “*Мосед* юу тохиолдсоныг бид мэдэхгүй байна” гэж хэлснийг санаж байна уу? Тэд: “Бурханд юу тохиолдсныг бид мэдэхгүй байна” гэж хэлээгүй. Тэд амьдралд нь *Иавэ* оршиж, оролцсоныг үгүйсгээгүй. Иехова (буюу *Иавэ*) тэднийг аварч, чөлөөлж, эдгээж, хангасныг тэд хүлээн зөвшөөрсөн. Тэд зүгээр л Бурханы жинхэнэ дүр төрхийг өөрийнх нь хүслийг хангадаг *Иавэ* гэж нэрлэсэн, гар дорх баримлаараа сольжээ.

Үүнийг орчин цаг дээр буулган жишээлж үзье: Лиза бид хоёр зогсоо зайгүй аялдаг бөгөөд манай Мессенжер Интернэйшнэл байгууллага ч онцсайн хамт олонтой. Тиймээс одоо миний бичих жишээг манайхан уншаад элэг нь хөших байх. Яагаад гэвэл манай багийнхан хэзээ ч тийм юм хийхгүй. Байгууллагын тэргүүнийхээ

хувьд Лиза бид хоёр хүмүүстээ үйл ажиллагааны болоод байгууллагын соёлын хэдхэдэн чухал зарчмыг байн байн сануулдаг юм. Учир нь бидний хувьд тэдгээр нь тун чухал. Тухайлбал: Бид багаасаа ажлын найман цагт есөн цагийн үр бүтээмж гаргахыг хүсдэг. Бид зугаатай уур амьсгалыг хүсдэг, аливаа зүйлээ онцсайн хэмжээнд гүйцэтгэхийг хүсдэг, бидэнтэй холбоо барьсан ямар ч хүн, түнш, удирдагчийг хайрлаж хүндэтгэхийг шаарддаг, өдөр тутмынхаа ноогдол ажлыг гүйцэтгэсэн байхыг шаарддаг гэх мэт. Үйл ажиллагааны болоод соёлын эдгээр жишгийг тогтмол мөрдүүлж байхыг манай Үйл ажиллагаа хариуцсан захирал мэднэ (Түүнийг Тим гэж нэрлэе).

Лиза бид хоёрыг бас Үйл ажиллагаа хариуцсан захирлыг аян замд гараад, эзгүй хойгуур байгууллагыг хариуцаж ажилладаг, дараагийн хүн маань Санхүү хариуцсан захирал юм (Түүнийг Жордан гэж нэрлэе). Тэгээд Тимийг дөнгөж явмагц, Жордан багийнхандаа: “Манайхаан, Жон, Лиза хоёр биднийг зугаатай уур амьсгал бүрдүүлээрэй гэдэг. Нэг аятайхан ДиЖэй урьж авчраад, утаа, гэрлийн төхөөрөмжтэй бүжгийн талбай засаад, хэдэн өдөр сайхан зугаацъя” гэжээ.

Үдэшлэг дундуур багийнхан маань яг л бид хоёрын хүссэнийг биелүүлж байгаагаа “хэлнэ”. Тэд: “Жон, Лиза хоёр өөрсдөө л бидэнд зугаатай уур амьсгал бүрдүүлж байгаарай гэж хэлсэн шүү дээ” гэж ирээд л, бидний хэлснийг ахин дахин давтана. Тэгтэл нэг ажилтан маань: “Хөөе, Жон залгаж байна. Би түүнд үдэшлэгийнхээ талаар хэлэхээр, тэр баярлана даа” гэж хашхирав. Ёстой худлаа! Яагаад гэвэл би залгаад, тэднийг ийм юм хийж байгааг мэдбэл, уур хүрч, уушги сагсайна.

Хэрэв Лиза, бид хоёроос өмнө манай Үйл ажиллагаа хариуцсан захирал ажил дээрээ ирбэл, тэр ч бас маш их уурлана. Тэрбээр хөгжмийг нь хаагаад, утаа, гэрлийн төхөөрөмжийг нь буцаалгаад, багийнхандаа: “Жон, Лиза хоёр ийм юм хүсээгүй. Та нар тэднийг буруугаар таниулж байна!” гэж хэлээд, эмх замбараагүй байдал үүсгэсэн толгойлогчийг ажлаас нь хална.

Тэгвэл тэр гарын дорх Иавэг бүтээсэн Израильчууд яаж авирласныг үзэцгээ:

Тиймээс дараа өдөр нь тэд эртлэн босож, шатаалт тахилууд өргөж, эвийн тахилуудыг авчрав. Ард түмэн идэж уухаар сууж, тоглож наргихаар босоцгоов. (Гэтлэл 32:6)

Энэ бол *Иавэд* зориулсан баярын өдөр. Хүмүүс Түүнд тахил өргөөд, дараа нь цадигаа алджээ. Тэд *Иавэгийн*хээ хүссэн, таалсан зүйлийг нь л хийж байна гэдэгтээ үнэн голоосоо итгэсэн. *Иавэ* нь тэдний ховдоглол, цэнгээн, наадам цэнгэлд (үүнд бэлгийн ёс бус явдал ч орсон) дуртай байна гэж итгэсэн. Гэтэл тэдний Бурханы (*Иавэгийн*) хүлээн зөвшөөрсөн гэж бодож байсан авир үйлдэл нь Бурханд огт таалагдаагүй.

Одоо тэд шүтээн мөргөлийн хамгийн зальжин хэлбэрт шилжжээ. Тэд жинхэнэ Иавэгаас тэнгэр газар шиг ялгаатай, хулхи Иавэг бүтээв. Одоо тэд Бурханыхаа зөвшөөрлийг авч байгаад, хүссэнээрээ амьдрах болжээ. Энэ нь үндсэндээ Бурханыг хүндэтгэхээс (дагахаас) татгалздаг, худал бурхадтай улс үндэстнээс ямар ч ялгаагүй юм. Паул: “Тэгээд ч тэд бодол санаандаа хоосорч, ухваргүй зүрх нь харанхуй болжээ (Тэд Бурханы талаар янз бүрийн мунхаг санаа сэдэж эхлэсэн) (Ром 1:21) хэмээн дахин хэлсэн байдаг. Ганц ялгаа нь харь үндэстнүүд бурхдаа Дагон, Баал, Хапи, Аммит, Сопду гэх зэргээр нэрлэдэг бол, Израиль шүтээнээ Иавэ гэж нэрлэжээ.

Тэгтэл Бурхан үйл ажиллагаа хариуцсан захирал Моседоо: “Бушуулаарай! Буугаарай! Египетээс дагуулж авчирсан хүмүүс чинь өөрсдийгөө завхруулав. Миний тэдэнд тушаасан замаас тэд хурдан эргэжээ. Тэд өөрсөддөө цутгамал тугал бүтээж, түүнд мөргөж тахил өргөөд, ‘Израильчууд аа, та нарыг Египет нутгаас гаргасан та нарын бурхан энэ юм’ гэгцгээж байна” (Гэтлэл 32:7-8) хэмээв.

Мосе бууж ирээд, нилээд хэдэн хүнийг хатуу донгодох ёстой болжээ. Эхлээд хүмүүсээ удирдаж үлдсэн Аароныг, дараа нь удирдагч нарыг, эцэст нь хүмүүсийг.

Ард түмэн задгай замбараагүй болсныг Мосе харав. Учир нь Аарон тэднийг эсэргүүцэгчдийнх нь дунд шившиг болгохоор задгай замбараагүйд хүргэжээ. Мосе хуарангийн хаалган дээр зогсож —ЭЗЭНий талд байгч хэн бэ? Нааш ирэгтүн! гэж хэлсэнд Левийн хөвгүүд бүгд түүн дээр цугларав.
(Гэтлэл 32:25-26)

Тэд ч, бид ч Эзэний нэрийг дуудаж, Эзэнд зориулж дуулснаараа Түүний талынх болчихгүй. Бид Эзэний үгийн дагуу амьдарснаараа л Түүнтэй нэг тал болдог.

Энэ нь биднийг хэд хэдэн чухал асуулт дээр авчирдаг:

Өнөөдөр бид замаа алдсан хүслийг маань хангаж өгдөг “Есүсийг” бүтээжээ.

Есүс бидний төлөө цусаа урсгаж, аварч, биднийг дэлхийгээс чөлөөлснийг бид хүлээн зөвшөөрч байна уу?

Бид Есүст зориулж бас Есүсийн тухай мөн Тэрбээр биднийг тэнгэрт оруулж өгсөн тухай дуулж байгаа ч, үнэндээ “бидний тэр Есүс” Аавын баруун гарт залардаг, жинхэнэ Есүс мөн үү?

Бид хулхи Есүсийг бүтээгээ юу?

Чуулганы олон хүн Египетээс гарч ирсэн Израильчууд шиг мэхлэгдсээр явна уу?

Дээрээс нь нэмж асуухад: “Мосетэй адил Бурханы уулаас бууж ирээд, мэхлэгдсэн хүмүүстэй халуун зүрх сэтгэл, хайраар халз тулах Үйл ажиллагаа хариуцсан захирлууд гэж хэн бэ?”

Тийм хүмүүс гарч ирэхгүй бол, бид улам л мэхлэгдсээр байна. Тийнхүү криптонит ч биднийг үхүүлтлээ сул дорой талыг маань үргэлжлүүлэн ашигласаар байна.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Барууны ертөнцөд Есүст итгэдэг гэж хэлэх их амархан. Гэхдээ Барууны ертөнцөд Христэд итгэдэг хүмүүс, дэлхийн хооронд бараг ялгаа байдаггүй учраас, ихэнх хүмүүс Христэд итгэх итгэлээс залхчихсан байдаг. Христэд итгэдэг хүмүүс Есүсийн хэзээ ч зөвшөөрөхгүй нүгэлт амьдралаар амьдрах атлаа Есүсийн нэрийг барьж, Бурханыг хүндэтгэдэг гэдэг. Мосе Израилийг шүүхэд дуудахдаа: “Эзэний талд байгаа нь над дээр ир!” хэмээн тунхагласан. Тэгвэл жинхэнээсээ Христэд итгэдэг хүмүүс босч, ах эгч дүүсээ үнэн рүү дуудах цаг болжээ.

Есүсийг дагах нь бүх зүйлээ өгнө гэсэн үг. Амьдрал маань биднийх биш болно. Хүслээ Бурханд захируулна. Эс бөгөөс Тэр бидний Эзэн байж чадахгүй. Бүх хэрэгцээнийхээ төлөө Түүнд итгэх ёстой болно. Энэ бол Христэд итгэх итгэлийн дуудлага. Тийм ээ, ирээд аврагд. Гэхдээ та хуучин хүнээ үхүүлж, шинэ болох ёстой.

Жинхэнэ Христэд итгэх итгэлийн тухай эргэцүүлэн бод. Энэ нь таны сурсантай юугаараа адилхан бас юугаараа өөр байгааг

бич. Дараа нь энэ талаар гэр бүлийнхээ юмуу чуулганыхаа хэн нэг хүнтэй ярилц. Тэдэнд энэ үнэнийг хэлж өг.

ЭХЛЭХ ЦЭГ

Мосег Бурханы уулаас бууж ирэхэд, Израиль өөрсдийг нь Египетээс гаргасан Иавэг хүлээн зөвшөөрсөөр байсан ч, шүтээн мөргөлд толгойгоороо живээд байв. Шүтээн мөргөл нь Бурханы тов тодорхой илчилж өгсөн зүйлийг дагахгүй байх явдлаас үндэслэдгийг бид үзсэн. Бид Есүс Христийг Эзэн бөгөөд Аврагчаар тунхаглах атлаа Түүний эрх мэдэлд илт дуулгаваргүй байвал, энэ нь шүтээн мөргөлийн хамгийн аюултай хэлбэр болно.

Бүгдээрээ манай Мессенжер Интернэйшнэлийн талаар үзсэн нөгөө инээдтэй жишээгээ дахиж үзье. Манай Үйл ажиллагаа хариуцсан захирал Тим ажил дээрээ ирээд, доргио үдэшлэгийг үзбэл, Санхүү хариуцсан захирал Жорданд уурлана. Гэхдээ Жордан Тимд зүгээр л: “Гэхдээ бид Жон, Лиза хоёрын хүссэн зүйлийг л хийж байна! Бид зугаатай орчныг бүрдүүлж байна!” гэж хэлнэ.

Тэгвэл Тим юу гэж хэлэх үү? “Тийм ээ, Жон, Лиза хоёр зугаатай уур амьсгалыг хүсдэг. Гэхдээ тэгвэл бидэнд өгсөн бусад зааврын хувьд яах уу? Ажлынхаа найман цагт есөн цагийн ажлын үр бүтээмж гаргах, бидэнтэй холбогдсон ямар ч хүнд хариу өгөх, өдөр тутмынхаа ажлыг гүйцэтгэх гэх мэт? Та нар тэдний заавар дундаас ганцыг нь л өлгөж аваад, бусдыг нь үл хайхарчээ.”

Тэгвэл өнөөгийн чуулган иймэрхүү явдал гаргадаггүй гэж үү? Миний бодлоор, бид Шинэ гэрээнээс өөртөө таалагдсан тодорхой заавраа олж авдаг. Бид итгэлээр дамжуулан нигүүлслээр аврагдсан

бөгөөд энэ нигүүлсэл нь Бурханы нигүүсэл учраас, өөрийнхөө гавьяа зүтгэлээр олж авч чадахгүй гэдгээ тунхагладаг. Бид бие биеэ хайрлаж, сайхан амьдарч, бие биедээ үйлчилж, магтаал, хүндэтгэлийн шинэ дуу дуулж, зохицож, сайн удирдаж, эрүүл саруул нийгмийг бүтээхэд анхаардаг. Тэгээд энэ бүхнийгээ үнэн голоосоо мэдэгддэг. Эдгээр нь бүгд сайн үйл хэрэг бөгөөд Шинэ гэрээ ч үүнийг дэмждэг.

Гэхдээ бид ялгаагүй л амин чухал чанар болох зөөлөн даруу байдал, ариун байдал, бэлгийн цэвэр амьдрал, порнограф зэрэг бусад нүглээс зайлж явах зэрэг чанарыг үл хэрэгсдэг.

Бид ижил хүйстэнтэйгээ явалдах, садар самуун, архидалт, бохир хошигнол, хоосон тэнэг яриа, үл уучлал, гашуудал, хов живээс зугтаж явах зэрэг Шинэ гэрээнд байдаг, маш олон чухал тушаал, зааврыг хайртай хүмүүстээ анхааруулдаг уу?

Бид Есүсийн Үгээс гагцхүү өнөөгийн нийгэмд тогтсон жишиг, завхралтай мөргөлддөггүй хэсэг дээр л анхаарч байна уу?

Бид нийгмийнхээ бурханлаг бус арга замтай тулдаггүй Есүсийг бүтээж байж болох уу?

Бид Түүний үзэн яддаг зүйлсийн талаар ярихаас зайлсхийж, зөвхөн нийгэм биширдэг Үгийг нь л тунхаглаж байж болох уу?

Бид амь руу хөтлөдөг зам, үүдийг өргөтгөж байж болох уу?

Хүн хэдэн шидэт үг л хэлчихбэл, автоматаар аврагдана гэж итгэж болох уу?

Бид Бичээсийн бүрэн зөвлөгөөгөөр илчлэгдсэн Есүсээс тэс өөр, хулхи Есүсийг бүтээсэн юм биш байгаа? Сүнслэг криптонитын эрхшээлд орсон, Коринтын чуулганыг дахиад харбал, Паул эцэстээ тэдэнд ингэж бичсэн байх юм:

Могой, залиараа Еваг мэхэлсэн шигээ Христ дор [цэвэр] эгэл байдлаас чинь та нарын санаа бодлыг төөрүүлчих вий гэхээс би харин айж байна. Учир нь хэрэв хэн нэг нь очоод, бидний тунхагласнаас өөр Есүсийг тунхаглахад эсвэл хүлээн авсан хэн нэгнээсээ та нар өөр сүнсийг хүлээн авахад эсвэл хүлээн авсан хэн нэгнийхээ өөр сайнмэдээг та нар хангалттай тэвчдэг. (2Коринт 11:3-4)

Коринтын итгэгчдийг Есүсийг няцаадаг худал бурхад, шашин бус, харин хулхи Есүст итгэсэн итгэл нь төөрүүлжээ. Тэр хулхи Иавэ - алтан тугал нь Израилийн хүүхдүүдийг чөлөөлсөн, аварсан, хангасан Бурхан мөн хэмээн өргөмжлүүлэхийнхээ сацуу ... нөгөө талаасаа Бурханы Үгээрээ тодорхой илчилсэн мөн чанартай сөргөлдсөн авир үйлдлийг зөвшөөрөх нь байтугай хөхиүлэн дэмжсэн гэдгийг бүү мартаарай. Тэгвэл бид ч бас яг ийм зүйлийг хөхиүлэн дэмжиж, зөвшөөрдөг хулхи Есүсийг бүтээчихсэн юм биш байгаа? Бид Шинэ гэрээний хэцүү, хатуу үгийг зориуд үл хайхраад байгаа юм биш байгаа?

Паул бидэнд тоохгүй өнгөрөхийн аргагүй мэдэгдэл хэлжээ:

Тиймээс би бүх хүний цусны буруугүй гэдгээ та нарт энэ өдөр гэрчлэх байна. Учир нь би Бурханы *бүхий л* төлөвлөгөөг та нарт *мэдүүлэхээс* зайлсхийсэн нь үгүй билээ.
(Үйлс 20:26-27)

Паул Сайн мэдээний сайхан үгсийг л яриад байлгүй, харин Бурханы бидэнд мэдүүлэхийг хүсдэг *бүхнийг* ярьжээ. Паул манай байгууллагын ажилчдад Лиза бид хоёрын зугаатай байлгах хүслийн талаар л хэлсэн манай Санхүү хариуцсан захирал шиг байсангүй. Паулын энэ үгийг ЭнКэйЖэйВи Библи дээр “Би та нарт Бурханы зөвлөгөөг бүрэн эхээр нь тунхаглахаас зугтсангүй” гэдэг бол, *Амплифайд Классик* Библи дээр “Би та нарт Бурханы зорилго, төлөвлөгөө, зөвлөгөөг бүрэн эхээр нь тунхаглахаас хэзээ ч дүлэгнэж, ухарч, хөсөрдүүлээгүй” гэдэг.

Хэрэв бид Шинэ гэрээний чанга сургаалыг хэлэхээс дөлөөд байвал, Паул шиг “Тиймээс би бүх хүний цусны буруугүй гэдгээ та нарт энэ өдөр гэрчлэх байна” гэж хэлж чадахгүй. Үнэндээ хэрэв бид Шинэ гэрээний гол хэсгийг дараад байвал, үүний эсрэг нь үнэн болж мэдэх. Бид үнэнийг бүрэн эхээр нь хэлэх эрх мэдэлтэй байсан боловч, зайлсхийжээ. Бид хүмүүсийг дараагийн цуглаан, цуглалт, жижиг бүлгийн уулзалтад маань ирэх хүсэлгүй болох вий гэдэгт илүү зовнижээ.

Ийнхүү бид олон жил Христэд итгэх итгэлийн соёл дотроо Бичээсийн чухал, чухал сэдвээс зайлсхийсээр яваад, эцэстээ үл хайхралын ургацаа хурааж байна. Олон ч хүн замаасаа гарсан нь

тун тоогүй. Энэ талаар үй олон жишээ хэлж болно. Тухайлбал маш нэр нөлөөтэй үйлчлэгч, алдартай зохиолч, конференцийн илтгэгч нэг хүн байв. Тэрбээр 2016 онд гэрлэлтээ дүүргэсэн тухайгаа мэдэгдсэн юм (ямар ч утгатай юм бүү мэд). Тэгээд тэр эмэгтэй нөхрөөсөө салаад, яг одоо үүнийг бичиж байхад, сүй тавьсан эмэгтэйтэйгээ хамтран амьдарч байна.

Тэрбээр дагалдагч нартаа гэр бүлийнхээ амьдралаас байнга хуваалцана. Нэг удаа хамтран амьдрагч эмэгтэйдээ үнсүүлж байгаа зургаа нийтлээд, доор нь хэрхэн амьдралынх нь аян зам түүнийг эд эс бүрээрээ “ариун” энэ харилцаа руу хөтлөсөн тухай бичсэн байв. Гэхдээ Бичээс энэ явдлыг хэзээ ч ингэж тайлбарлахгүй. Миний зүрх тэр хүний төлөө урагддаг. Тэр бол Бурхан түүнтэй хамт гэдэгт үнэн голоосоо итгэсэн, хүмүүст туслах, үйлчлэх, хайрлах халуун хүсэлтэй боловч, тас мэхлэгдсэн “Сайн мэдээний үйлчлэгч” ажээ.

Гэхдээ үүнээс аймшигтай зүйл нь түүний хэдэн зуун мянган дагагч нарын дэмжиж, таалсан үгс байв. Тэр эмэгтэй нийтлэж байгаа зүйлээ Бурханы нэрийг барьж нийтлэдэг бөгөөд үүнийг нь ч дагалдагч нар нь талархан хүлээн авдаг. Түүний туулсан энэ аян зам алдар нэрийг нь бууруулах нь байтугай, харин ч бүр өсгөжээ. Энэ бол үнэхээрийн элэг эмтэрмээр, зовиуртай, эмгэнэлтэй бас аймшигтай явдал юм.

Өөр нэгэн эмгэнэлтэй явдал бий. Саяхан Америкийн бараг хамгийн алдартай евангелийн удирдагч бүх дагалдагчдаа болон даяар чуулганд гомо хосуудыг Есүсийн жинхэнэ дагалдагчаар бүрэн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж зарласан юм. Тэрбээр гомо хосуудтай олон цагийг хамт өнгөрүүлэхдээ, тэдний харилцаа эр, эм хоёрынхоос ямар ч ялгаагүй болохыг олж мэдсэндээ, ийм шийдвэр гаргахад хүрсэн тухайгаа хэлэв. Тэгвэл бид Шинэ гэрээн дэхь Бичээсийг зориуд устгаад, Библийн бүрэн агуулгыг үл тоож байж л ийм дүгнэлтэд хүрэх боломжтой. Аарон, алтан тугал хоёрын тохиолдол шиг дээрх удирдагчийн мэдэгдлээс болж үй олон хүн үнэнээс алдуурч одно.

Энэ бол маш эмгэнэлтэй мэхлэл. Манай Барууны үйлчлэлийн гүн ухаанаас хөгжин бий болсон, хулхи Есүсээс болж, төөрсөн хүмүүс жинхэнэ Аврагчтай учрах дэндүү хэцүү болжээ. Тиймээс бид: “Энэ жинхэнэ Есүс мөн үү? Энэ Бурханы хайр мөн үү? Жинхэнэ хайрыг зүгээр л эелдэг байдал, тэвчээр, өгөөмөр

өглөгөөр тодорхойлж болох уу?” гэж асуух ёстой. Эдгээр чанар нь үнэн бөгөөд манай нийгэмд ч алдартай байдаг. Гэхдээ Библи хайрыг чухам юу гэж тодорхойлсон байдгийг бид яаж үл тоох вэ: “Бурханыг хайрлах нь Түүний тушаалуудыг сахих явдал юм” (1Иохан 5:3).

Бид хайрын талаарх өөрсдийнхөө тодорхойлолтыг гаргаж ирэхийн тулд Шинэ гэрээний хэсэгхээн зөвлөгөөн дээр л төвлөрөөд байна уу?

Гэмших шаардлага

Гэмшил байхгүйгээс болж, замаасаа хазайсан энэ Сайн мэдээ бий болоо юу? Тэр эмэгтэй үйлчлэгч - зохиолч - пастор тэргүүтэй олон хүн Есүсийг дагахын тулд нүглээс зугтахыг заалгасан болов уу? Эсвэл зүгээр л нөгөө бидний хувьд жишиг болсон: “Есүс ээ, амьдралд минь орж ирээд, намайг Христэд итгэгч болгооч” гэдэг залбирлыг л хэлэхийг заалгаа юу?

Паул ингэж хэлжээ:

Та нарт тустай гэсэн болгоныг огоороогүй ба нийтэд чинь болон айлаас айлд сургаж, Бурханы өмнөх гэмшил, бидний Эзэн Есүс Христэд итгэх тухай иудейчүүд болон грекүүдэд гэрчилсэн. (Үйлс 20:20-21)

Ганц л үг! Эхний алхам нь нүглээ гэмших *шаардлагатай!* Бурханы хүүхэд болоход гэмшил нь сонголт бус, *шаардлага* болдог. Гэхдээ бид хүмүүст авралын талаар тайлбарлаж, тэднийг авралд урихдаа ер нь бол энэ талаар дуугүй өнгөрдөг.

Хэдэн жилийн өмнө миний мацаг барьсан эхний өдөр Ариун Сүнс надад: “Маркийн нэгдүгээр бүлгийг унш” гэж хэлсэн юм. Би тэр бүлгийг бүхлээр нь шимтэн уншсан боловч, урьд нь уншиж байснаасаа шинэ юм ойлгосонгүй. Тэгтэл Ариун Сүнс: “Дахиад унш” гэлээ. Би уншлаа ... гэхдээ бас л ойлгосонгүй. Ариун Сүнс нөгөө л үгээ гурав, дөрөв, тав дахь удаагаа хэллээ. Би ч дахиад хэдэн удаа уншлаа... гэхдээ шинэ юм байсангүй. Ингэж бараг долоон удаа давтагдсаны эцэст би дунгийн хурдаар уншив. Гэтэл энэ удаа эхлэл үг нь хуудсаасаа ховхроод гараад ирэх шиг л болов:

Бурханы Хүү Есүс Христийн сайнмэдээний эхлэл. (Марк 1:1)

Харин дараагийн үгд гол түлхүүр нь оршиж байлаа: “Харагтун, Би түүрүүнд чинь зарлага элчээ илгээнэ. Тэрээр замыг чинь бэлтгэнэ” (Марк 1:2). Тэр элч нь Иохан Баптист байв. Түүний үйлчлэл нь нэгэн төрлийн “баптисмын үйлчлэл” байлаа. Баптисм гэдэг нь хэсэгчлэн бус, харин бүрэн эхээрээ булхах явдал юм. Иоханы үг нь эхэндээ буюу Сайн мэдээг эхлэж байхад гэмшлээр дүүрэн байв. Жинхэнэ гэмшилгүйгээр, хэн ч Есүстэй жинхэнэ харилцаа тогтоож чадахгүй.

Тэгтэл Ариун Сүнс надад: “Сайн мэдээний бүх ном Иоханы үйлчлэлээр эхлэдэг. Иоханы талаар Хуучин гэрээнд байхгүй. Учир нь түүний үг Шинэ гэрээний Сайн мэдээний амин хэсэг юм” хэмээн айлдлаа.

Дараа нь Сүнс намайг Есүсийн дараах үг дээр авчрав:

“Хууль болоод бүх эш үзүүлэгч Иоханыг ирэх хүртэл эш үзүүлж байлаа.” (Матай 11:13)

Тэр үед л би суудлаасаа огло харайгаад: “Тэр шүү дээ! Есүс: “Хууль болоод бүх эш үзүүлэгч Намайг (Есүс Христийг) ирэх хүртэл эш үзүүлж байлаа” гэж хэлээгүй шүү дээ!” хэмээн дуу алдсан юм. Тэгж хэлээгүй. Учир нь бүрэн гэмшлийн талаарх Иоханы үг нь Шинэ гэрээний Сайн мэдээний эхлэл цэг болдог. Та хийж дадсан, илт нүглээ бүрэн гүйцэт гэмшихээс нааш, Есүстэй харилцаа тогтоож чадахгүй.

Гэмшил бол орох хаалга!

Нөгөө Жастины гэргий Анжелагийн гэрлэлтийн талаарх гаж үзлийг санаж байна уу? Тэр хуучин амрагуудаасаа салаагүй. Тэр Жастинд үнэхээр хайртай - үнэндээ хамгийн их хайртай бөгөөд дийлэнх цагаа Жастинд л зориулдаг байв. Гэхдээ тэрбээр Жастинтай гэрлэлтийн гэрээнд орохын тулд, хуучин амрагуудаасаа оюун бодол, сэтгэл санаа, бие - бүх талаараа тасрах *шаардлагатай* гэдгийг огт мэдээгүй байжээ. Энэ шийдвэр нь Анжелагийн хувьд Жастинтай гэрээний харилцаанд орох чадварынх нь *эхлэл цэг* буюу *гараа* болох байв.

Өөрийг нь Тонитай болзох гэж байгаад Жастиныг уурласанд Анжела цочирдсон. *Юундаа уурлаад байгаа юм бол? Хардаад*

байгаа юм болов уу? Тийм ээ, Жастин маш их хардсан бөгөөд хардах ч ёстой. Бурхан ч биднийг харддаг бөгөөд Бурханы зөв юм. Учир нь бид Түүнтэй гэрээний харилцаанд орсон атлаа яаж өөр амрагтай байж чадаж байна аа?

Бичээс дээр Иохан хамгийн түрүүнд: “Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал айсуй” гэж хэлсэн нь тохиолдол уу?

Иохан ганцаараа л ингэж хэлсэн үү? Тэр шал далий зүйл ярьж, Шинэ гэрээний бусад бичээч нарын хэзээ ч хэлээгүй юмыг хэлсэн үү? Үгүй! Есүс хамгийн түрүүнд:

“Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал айсуй” (Матай 4:17) хэмээн мэдэгдсэн билээ.

Бурхантай урт удаан харилцаа тогтооход гэмшил нь заавал шаардлагатай, амин чухал зүйл гэдгийг бидний Эзэн бөгөөд Хаан мэдэж байжээ. Хамгийн гайхалтай нь Тэр энэ шалгуураар хүн үнэхээр Бурханых мөн эсэхийг тогтооно гэжээ.

Дараа нь Есүс олон олон гайхамшиг үйлдсэн хотуудаа зэмлэсэн. Учир нь тэд гэм нүглээ гэмшиж, Бурхан руу эргээгүй юм (Матай 11:20-ыг үзнэ үү).

Хүн аврагдахын тулд зүгээр л “Бурхан руу эргэх” ёстой юм бол, Есүс үүнийг л цохож хэлэх байв. Гэхдээ яг л Анжела Жастинд бүрэн зориулагдахын тулд хуучин амрагуудаа хаях ёстой байсан шиг, бид өөрсдийгөө Есүст бүрэн өгөхийн тулд гэм нүглээ гэмших ёстой.

Энэ нь Есүсийн үйлчлэлийн үндсэн даалгавар байсан учраас, бид энэ үгийг ахин дахин хардаг. Тэрбээр: “Би зөвгийг бус, харин нүгэлтнүүдийг *гэмшилд* дуудахаар (өөрийгөө нүгэлтэйг мэддэг бөгөөд *гэмших* хэрэгтэй хүмүүсийн төлөө) ирсэн” (Лук 5:32) хэмээн мэдэгджээ. “Хэрэгтэй” гэдэг үгийг бодолцоно уу. Гэмших нь сонголт биш юм. Есүс хэсэг хүмүүст: “Үгүй, Би та нарт хэлье. Үл гэмших аваас бүгд л үүний адил мөхнө” (Лук 13:3) хэмээн айлдсан.

Тэгэхээр: *Гэмшилгүйгээр Бурхан руу эргэнэ гэж байхгүйг* мэдээрэй.

Есүсийн дагалдагч нар Сайн мэдээ хуваалцахыг юу гэж үздэг байсныг харъя. Тэд анхныхаа бие даасан илгээлтээрээ “... явж, *гэмших* ёстойг тунхаглав (Тийнхүү дагалдагч нар гадагшаа яваад, таарсан хүн бүхэндээ *гэм нүглээ гэмшиж*, Бурхан руу эргэхийг хэлжээ)” (Марк 6:12).

Таарсан хүн бүхэндээ гэдэг үгийг хараарай. Гэмшилгүйгээр аврал гэж байхгүй учраас үүнийг хүн бүрт хэлж өгөх ёстой! Гэм нүглээ гэмшихийн чухалчлалыг тамд шатаж байгаа баян хүн ч мэдэж байв:

Үгүй, Абрахам эцэг минь, үхэгсдээс хэн нэг нь тэдэн уруу явбал тэд *гэмших* болно. (Лук 16:30)

Тэгвэл амиллын дараа? Түүний үг өөрчлөгдсөн үү? Есүс амилуулагдсаныхаа дараа дагалдагч нартаа хэрхэн үзэгдсэн тухай Лук бичжээ. Тэрбээр дагалдагч нарынхаа хагуу зүрхийг зэмлэж, нүдийг нь нээгээд, дараа нь эш үзүүлэгч нар Түүний талаар хэрхэн зөгнөснийг эшлэжээ:

Иерусалимаас эхлээд бүх үндэстэнд Түүний нэрээр нүгэл уучлагдах гэмшил тунхаглагдах ёстой” гэж бичигдсэн юм. (Лук 24:47)

Эш үзүүлэгч нар “эхлээд гэмшил байвал, Аврагчаас уучлал олох боломжтойг” зөгнөжээ. Петр ч яг ингэж хэлсэн. Тэрбээр Пентекост өдөр юу болоод байгааг үнэн голоосоо сонирхсон эрэлчдэд хэрхэн аврагдах талаар хэлэхдээ:

Гэмшигтүн, хүн бүр Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Ингэснээр та нарын нүгэл уучлагдаж бас та нар Ариун Сүнсний бэлгийг авах болно (Үйлс 2:38) гэжээ.

Бас л гэмшилгүйгээр Бурхан руу эргэнэ гэж байхгүйг хэлжээ. Тэгвэл Паул юу гэж хэлсэн бол? Тэрбээр харь үндэстэнд өөр үг хэлсэн үү? Хэрхэв ч үгүй:

Агрийп хаантан, тиймээс би тэнгэрлэг үзэгдэлд дуулгаваргүй байж болсонгүй. Харин эхлээд Дамаск болон Иерусалимд, дараа нь Иудейн бүх нутгаар тэрчлэн *харийнханд* хүртэл “Та нар *гэмшиж* (бүгд нүглээ *гэмшиж*) Бурхан өөд эргэн, гэмшилд дүйцэх *үйлс* бүтээгтүн (бүтээх *ёстой*)” гэж тунхаглаж байлаа. (Үйлс 26:19-20)

“Бүгд... гэмших ёстой” гэсэн үгийг харна уу. “Гэмших хэрэгтэй”, “гэмшбэл дажгүй” гэж хэлээгүй байгаа биз? Паул: “бүх хүн нүглээ гэмших ёстой” гэжээ.

Иүдей байна уу, харь хүн байна уу - аврагдах гэсэн хүн бүрт Бурхан энэ шаардлагыг тавьдгийг Паул хэлжээ:

Иймээс ч Өөрийг нь эс харсан балар үеийг Бурхан харалгүй өнгөрөөсөн. Харин эдүгээ хаа сайгүй хүн бүхэн гэмших ёстойг хүмүүст Тэрээр тушааж байна. (Үйлс 17:30)

Хэрэв та Есүс Христийн суурь сургаалыг үзэх юм бол, жагсаалтын хамгийн эхэнд юу орж байгаад нэг их гайхахгүй л болов уу:

Тиймээс Христийн тухай балчир ойлголтыг орхиж, төлөвшилд тэмүүлцгээе. Түүнчлэн үхлийн үйлсээсээ гэмших, Бурханд итгэх. (Еврей 6:1)

Би энэ тушаал гардаг Шинэ гэрээний бүх хэсгийг тоочсонгүй. Гэхдээ нүглээ гэмших нь ямар чухал болохыг батлан харуулахад, дээрх хэдэн жишээ хангалттай буюу. Бурханд дуулгаваргүй хандсан, дадал болсон, илт дуулгаваргүй үйлдлээ гэмшихээс нааш Эзэн Есүст итгэнэ гэж байхгүй.

Тиймээс санаатайгаар порнографтай зууралдах атлаа Христэд итгэнэ гэж байхгүй.

Бид найз охин, залуутайгаа бэлгийн харилцаанд орохоо болихгүйгээр итгэгч болно гэж байхгүй.

Ижил хүйсийн явдлаа таслан зогсоохгүйгээр, Христэд итгэгч болно гэж байхгүй.

Татварын тал дээр залилаж мэхлэхээ болихгүйгээр, итгэгч болно гэж байхгүй.

Уучлахгүйгээр Христэд итгэгч болно гэж байхгүй гэх мэт энэ жагсаалт цаашаа хөвөрнө.

Хэрэв бид Шинэ гэрээний хэдхэн тушаалаас л зуураад байгаа бол, “хулхи Есүсийг” бүтээжээ гэсэн үг. Бид зүрхэндээ мэхлэгдсэн бөгөөд итгэл маань зүгээр л төсөөлөл болжээ. Иаков бидэнд: “Гэхдээ өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид байг” (Иаков 1:22) хэмээн сэрэмжлүүлсэн буюу.

Тэгвэл бид үүнийг хэлэхгүй бол, эрэлчид яаж мэдэх билээ? Удирдагчид бид хүмүүсийг зүгээр л бор зүрхээрээ олж мэдэг гээд хувь заяанд нь даатгачихаж болох уу? Хэрэв бид эрэлчдэд зүгээр л: “Та Бурханаас хол яваа юм биш биз? Тэр таныг ирэхийг харуулдан сууна. Зүгээр л намайг дагаад залбирахад л болно” гээд байвал, тэднийг хайрлаж байгаа хэрэг мөн үү?

Бид ингэж хандах юм бол, гэр бүл, ойр орчных нь хүмүүс Анжелад гэрлэлтийн талаар хэлж өгөөгүйтэй л адил зүйлийг хийж байна. Тэд Анжелаг Жастинтай гэрлэхийн тулд бусад амрагаасаа салах хэрэгтэй гэдгийг хэлж өгөөгүй. Тэд Анжелаг яваандаа өөрөө олж мэдэг гэсэн үү? Ийнхүү Анжела эргэлзэж, мухарджээ. Учир нь түүнийг хайрлаж, гэрлэлтдээ бүрэн үнэнчээр зориулагдсан Жастин уурлаад, ширүүн байв.

Бид хэнд танилцуулахаасаа үл хамааран, нэг л янзын Сайн мэдээг ярих ёстой: нэгдүгээрт - өөрийнхөө мэдэх болон мэдэхгүй бүх нүглээ гэмш. Тэгээд дараа нь Бурхан руу эргэх ёстой. Жинхэнэ *гэмшил* байхгүй бол, жинхэнэ итгэл байхгүй.

Тэгвэл орчин цагт Сайн мэдээг дараах маягаар танилцуулах болжээ: эрэлчдийг итгүүлж, залбируулаад, яваандаа хэдэн долоо хоног, сар, тэр бүү хэл жилийн дараа өөрийнхөө мэдэх нүглээсээ эргэг гээд орхино. Гэхдээ ингэж хойшлуулахаар, эрэлчид маань хэдийнээ аврагдсан гэдэгтээ итгээд, ямар ч гэмших сэтгэлгүй болбол яах уу?

Анжела Жастинтай гэрлэхээсээ өмнө үнэнийг олж мэдээгүйдээ харууссан. Үүнтэй адил бид ч бас аврагдахын тулд юу шаардлагатай болохыг хүмүүст хэлж өгөөгүйгээсээ болоод, баахан самуурсан хүмүүстэй чуулгануудыг л бий болгодог.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Шинэ гэрээ маш тодорхой хэлдэг: Нүглийн гэмшил байхгүй бол, аврал байхгүй. Та дэлхийтэй явалдсан чигээрээ Есүстэй гэрлэж чадахгүй. Та шинэ амьдрал эхлүүлэхийн тулд хуучин амьдралаа хүүхлэх ёстой.

Хэрэв та хүнтэй харилцах ажил хийдэг бол, хамгийн чухал зүйлээ маш гаргацтай, тодорхой болгох ёстойг мэдэж байгаа. Эс бөгөөс сонсогч чинь таныг буруугаар ойлгож, харилцааны чинь

зорилго гээгдэнэ. Бурхан ч үүнийг мэднэ. Тиймээс л биднийг гэмш хэмээн маш тодорхой айлджээ.

Та энэ хэсгийг уншиж байхдаа, хэдийнээ хэдэнтээ гэмшсэн байх. Гэхдээ гэмшил ямар чухал болохыг энэ бүлэг яаж бататгаж байна? Одоо та үүнийг баттай мэддэг боллоо гээд, амьдралд чинь ямар өөрчлөлт гарах бол? Одоо таны дэлхийтэй, хайртай хүмүүстэйгээ эвсэл төөрсөн хүмүүстэй харилцах харилцаанд чинь ямар өөрчлөлт гарах бол? Гэмших уриалгад яг ямар хариу алхам хийх ёстойг Бурханаас лавлаж асуу. Бурханы айлдсан бүгдийг заавал бичиж авахын сацуу тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар өөрийн гэсэн төлөвлөгөө боловсруулж бичээрэй.

20

ГЭМШИЛ

Бичээс “Нүглээ гэмшиж, Бурхан руу эргэ” хэмээн ахин дахин хэлдэг болохыг бид өмнөх бүлгээрээ үзлээ. Мөнхийн аминд гэмшил нь сонголт биш, *шаардлага* учраас, энэ талаар илүү дэлгэрэнгүй авч үзье. Бид энэ үнэнийг дэлгэхдээ, гэмшил нь Христэд итгэдэг хүний хувьд Бурхантай дотно харилцаатай байхад амин чухал байдгийг (цааш цаашдынхаа бүлгээр) мэдэх болно.

Нэгдүгээрт - Шинэ гэрээний гэмшил нь Хуучин гэрээний гэмшлээс өөр болохыг ойлгох нь амин чухал буюу. Хуучин гэрээнд Бурханы хүмүүс гэмшихдээ ноорхой хувцас өмсөж, толгой дээрээ үнс асгадаг байв. Тэгээд гэмшиж буйгаа харуулах гэж орь дуу тавьж, газар сунаж унан, асгартал уйлдаг байжээ. Энэ нь гашуудаж, бурханлаг дуулгавартай байдал руу эргэж буй гадаад үзүүлэн байв. Тэгвэл Шинэ гэрээнд гадаад үзүүлэн дээр бус, харин зүрхэн дээр төвлөрсөн байдаг.

Шинэ гэрээний гэмшил

Шинэ гэрээнд “гэмшил” (*метаноиа*) гэдэг нэр үг хорин дөрвөн удаа, “гэмших” (*метаноео*) гэдэг үйл үг гучин дөрвөн удаа гардаг.

Үүнийг ер нь бол “сэтгэлгээний өөрчлөлт” гэж тодорхойлдог. Гэхдээ зүгээр л сэтгэлгээний өөрчлөлт гээд ойлгочихбол жинхэнэ утгынх нь бүрэн хүчийг гээнэ.

Бэйкерийн Библийн нэвтэрхий толь гэмшлийг “Энэ нь яг л үгчилсэн утгаараа сэтгэлгээний өөрчлөлт юм. Түүнээс биш, хувь хүний төлөвлөгөө, санаа сэдэл, итгэл биш, харин нүгэлт үйлийнхээ чиглэлээс Бурхан руу эргэх, хүний *бүрэн хувь чанарын* өөрчлөлт мөн (тодруулгыг нэмэв)” гэж тэмдэглэжээ.

Би *бүрэн хувь чанар* гэдэг үгд дуртай. Хүн сэтгэлгээгээ өөрчиллөө ч, бүрэн ятгагдаагүй байж болно. Эрдэмтэд энэ үгийг хэрэглэснээрээ, энэ бүхэн нь зүгээр нэг оюуны юмуу ухааны өөрчлөлтөөс том зүйл болохыг харуулдаг. *Лексамын теологийн Үгийн ном* гэмшлийг “хувь хүн ухаан, хүслээ дахин нүглээс салган, Бурхан руу чиглүүлэх үйл явц” хэмээн, бүр ч гүн тодорхойлжээ.

Гэмшил нь мэдээж оюун ухааныг хамардаг ч, үүнээс гүнзгийрч, хүний хүслийг болон сэтгэл мэдрэмжийг хамардаг аж. Гэмшил бидний ятгалгын төв болсон зүрхний цөм рүү нэвтэрч ордог. Есүс:

Зүрхнээс ёрын бодол, аллага, завхайрал, садарлал, хулгай, худал гэрчлэл, гүтгэлэг гардаг. Эдгээр нь хүнийг бузарладаг. Харин гараа угаалгүй идэх нь хүнийг эс бузарлана (Матай 15:19-20) хэмээн айлджээ.

Цочир зан авир, дадсан зан авир нь бүгд бидний цөм болсон хэсгээс л ургаж гардаг. Жинхэнэ гэмшил нь оюун ухааны л өөрчлөлт төдий юм бол, Есүс эдгээр зан авир нь оюун ухаанаас л ургадаг гэж хэлэх байсан. Гэтэл: “Тэрбээр зүрхэндээ боддогтойгоо адил юм” (Сургаалт үгс 23:7, ЭнКэйЖэйВи) гэж хэлсэн шүү дээ. Бид амьдралыг зүрхэндээ хэрхэн ойлгож байгаагаараа л үйлдэл хийдэг бөгөөд энэ үйлдэл маань биднийг тодорхойлдог.

Та: “*Би үйлдлээрээ дүгнүүлмээргүй байна*” гэж бодож байгаа байх. Энэ таатай үнэн биш гэдгийг би мэднэ ээ. Гэхдээ бид: “Та нар тэднийг үр жимсээр нь танина” (Матай 7:16) гэсэн Есүсийн үгийг хайхралгүй өнгөрч чадахгүй шүү дээ. Үнэндээ бид санаа сэдлээрээ биш, үйлдлээрээ л тодорхойлуулдаг юм.

Бид үүнийг мэдэхэд л Сайн мэдээ ямар хүчтэй болохыг харж чадна. Учир нь Сайн мэдээ л биднийг эхлээд дотроос маань, дараа нь гаднаас маань өөрчилдөг хүч чадалтай. Сайн мэдээгээр

дамжуулан үнэн голоосоо өөрчлөгдөх гэдэг нь цоо шинэ аргаар сэтгэдэг болох юмуу эсвэл сэтгэл хөдлөсөн хариу үйлдэл бус, харин жинхэнээсээ шинэчлэгдсэн зан үйлдлийг дагуулсан, үзэл бодол, итгэлийн гүн өөрчлөлт юм.

Бид үнэнд сэрж, гүн ухаан, үйлдэл маань Бүтээгчийнхтэй маань сөргөлдөж байгааг голоосоо ойлгосон үед л жинхэнэ гэмшил ирдэг. Энэ зүрхний ухаарал нь үзэл бодлыг маань өөрчлөхөөр барахгүй, хүсэл, үйлдлийг маань ч өөрчилдөг. Хүсч, хайрлаж байгаа зүйл маань Бурханыхтай сөргөлдөж байвал, бид үнэн голоосоо өөрчлөгдөхөөр шийдэн, тэдгээрийг хаяж - тэр бүү хэл үзэн яддаг. Гэмшил нь жинхэнэ даруу байдал бөгөөд даруу байдал нь биднийг бурханлаг амьдралаар амьдрах чадалтай болгодог Бурханы яндашгүй нигүүлсэлд үүд нээж өгдөг.

Үл итгэгч

Гэмшил нь итгэгч хүнд ч, итгэгч бус хүнд ч хамаатай боловч, арга зам нь яльгүй өөр байдаг. Эхлээд үл итгэгч хүн дээр авч үзье.

Өмнөх бүлгээрээ бид Иохан Баптистаас ч, Есүсээс ч, дагалдагч нараас ч: “Нүглээ гэмшиж, Бурхан руу эргэ” гэдэг үгийг байн, байн сонссон. Энэ хоёр тушаал нь нягт холбоотой бөгөөд бие биеэсээ саланги биш юм. Өөрөөр хэлбэл та нэгийг нь аваад, нөгөөг нь авахгүй байх боломжгүй. Учир нь эдгээр нь нэг зоосны хоёр тал юм. Библийн гэмшил нь Бурхан руу бүх талаараа эргэх явдал мөн. Христ дээр жинхэнээсээ ирсэн хүн:

“Би өөртөө юу нь сайн болохыг өөрөө шийдэж ирсэн боловч, өөрийгөө тэр чигээрээ буруу байсныг одоо мэдлээ. Одооноос эхлэн цаашид Бурхан юу гэж хэлнэ, би түүнд нь бүх зүрх, оюун ухаан, үйлдлээрээ итгэн, хүлээн авна” гэж хэлдэг.

Энэ хүн Бурханы хүслийг хийнэ гэж зүрхээрээ (үүнд оюун ухаан, сэтгэл мэдрэмж, хүсэл багтана) шийддэг. Харин үүнийх нь шагналд тэр хүнийг Бурханы дуу хоолой дагалдах болно. Есүс мөн: “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсвэл тэрээр энэ сургаал Бурханаас уу эсвэл Би Өөрөөсөө ярьж

байна уу гэдгийг мэднэ” (Иохан 7:17) гэж хэлсэн. Үл итгэгч хүн гэмшихдээ, өөртөө засах байдлаасаа эргэн, Бурханы бүрэн засаглалд захирагддаг бөгөөд үүнийх нь ачаар зүрх нь Бурханы дуу хоолойд нээгддэг байна.

Үл итгэгч хүн жинхэнээсээ гэмшихдээ, шүтээн мөргөлөөс салж, Бурханы эрх мэдэлд бүрэн төгс захирагдаж, дагана. Үндсэндээ тэд: “Би цаашид өөрийгөө Бурханы Үгээс дээр тавьдаг бодол, итгэл, учир шалтгаан, баримтыг хүлээж авахгүй” хэмээн мэдэгдэж байгаа юм. Паул:

Бидний байлдааны зэвсэг нь махбодынх бус, харин ялагдашгүйг ч ялж чадах Бурханы хүчит зэвсгүүд юм. Бид цэцэрхлийг *нурааж*, Бурханы мэдлэгийн эсрэг босогч алив бардамналыг *устгаж*, бодол бүрийг Христийн дуулгаварт олзолдог (2Коринт 10:4-5) хэмээн чангаар мэдэгдсэн.

Бурханы зэвсэг нь Түүний Үг, цэц ухаан, зөвлөгөө юм. Газрын зэвсэг нь Бурханы Үгтэй зөрчилддөг гүн ухаан, соёл, заншил, хууль, амьдралын хэв маяг юм. Та “Дэлхийд зэвсэг байдаг аа?” гэж асууж болно. Тийм ээ, дэлхийн системээр дамжуулан Христэд итгэдэг хүмүүсийг ч, итгэгч бус хүмүүсийг ч буулгаж авах гэсэн зогсолтгүй ажилладаг тамын довтолгоонууд бий.

Дээрх Бичээст “устгах”, “нураах” гэсэн үг гарч байгааг анхаараарай. Хуучин гэрээнд хүмүүс шүтээн мөргөлөөс эргэх үед эдгээр үгсийг маш их хэрэглэсэн байдаг. Израиль шүтээн мөргөлийг нурааж, бяцлаж, арчин хаяж, устгасан. (Тэд чухам юу хийснийг санаарай. Улайм цайм нүглийг дадал болтол үйлдэх явдал нь шүтээн мөргөлийн үндэс юм. Тиймээс тэд үнэндээ хөшөө баримлыг биш, харин үүнийгээ л устгаж байв).

Паулын ярьж буй зарчмын хувьд ч ялгаагүй юм. Бид Христээс холдсон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн шүтээн мөргөлч бодолтой Бурханы Үгээр л тулдаг. Ингэснээр сонсогч нар хүний учир шалтгаан, хэлцэл, Бурханы эрх мэдэлд дуулгаваргүй хандах байдлаа гэмшдэг (нурааж, устгадаг). Дадсан нүглээ гэмших гэж үндсэндээ үүнийг л хэлж байгаа юм. Ингэснээрээ хүн Бурхан руу эргэж, өөрөө чөлөөлөгддөг.

Философийн ялгаа

Энэ нь биднийг орчин цагийн - нэн ялангуяа Барууны үйлчлэлийн боловсруулж гаргасан философи дээр авчирч байна. Төөрөгсдөд хүрэхийн тулд аль болох Сайн мэдээний зөрчилгүй, зөөлөн талыг баримтлаж ярих ёстой гэдэг сэтгэлгээ Барууны удирдагч нарын дийлэнх хувьд зонхилох болжээ. Өөрөөр хэлбэл гэмших шаардлагатай нүглийг ил гаргахаас хойш сууж, аль болох эерэг байх. Ийм хандлагаасаа болоод бид санаатай юмуу санаандгүйгээр яг л худалдан авагч хүнд зарах гэж байгаа барааныхаа ашиг тусыг л тоочоод, харин сул талыг нь дурьддаггүй худалдагч шиг болдог. Бид яг ийм сэтгэлгээг төөрөгсдөд хүрэх арга барилын жишиг болгон тогтоосон нь тун харамсалтай.

Үйлчлэлийн энэ алдаатай философи нь илэрхий хоёр хор уршигтай. Нэгдүгээрт - хүмүүсийг зэмлэх бүх боломжийг хаадаг. Хуульчлал нь зөв байх, зан үйлдлийг хянах, эрх мэдлээ хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө хуулийн үг үсэг дээр анхааран төвлөрдөг бөгөөд ямар ч хайр найргүй байдаг. Хуульчлалын замд өртөж, хатуу харгис чанарт нь хяргуулсан хүмүүс Бурханыг хайж очих газаргүй, шархласан сэтгэлтэй л үлддэг. Учир нь Есүсийг төлөөлж байгаа хувь хүн, байгууллага тэднийг жанжилж, жанчаад байдгаас тэр. Тэгээд хамгийн аюултай нь хуульчлал нь хүмүүсийг Бурхантай тогтоох жинхэнэ харилцаанаас нүүр буруулахад хүргэх гол шалтгаан болдог.

Есүс: "...та нар хүмүүсээс тэнгэрийн хаанчлалыг хаадаг. Та нар өөрсдөө ч ордоггүй, орох гэснийг нь ч оруулдаггүй" (Матай 23:13) хэмээн айлдахдаа, хуульчлалын үр дагаварыг зааж хэлжээ.

Тиймээс хуульчлалыг устгах гэсэн хүсэл маань зөв юм. Гэхдээ бид зүүгээ нөгөө туйл руу эргүүлчихэж болохгүй. Бид хүмүүсийг дахин шархлуулахаас зайлсхийсэндээ, жинхэнэ Шинэ гэрээний үйлчлэлээс бултах ёстой юу? Бид хуульчлалын аливаа дохионоос зайлсхийхийн тулд нүгэлтэй нүүрэлдэж, гэмшилд дуудахаас бултах ёстой юу? Бид нярайг бохир устай түмпэнтэй нь хамт гаргаад хаячихдаг билүү?

Бид энэ талаар дуугарах ёстой. Яагаад гэвэл өнөөдөр Сайн мэдээнд Бичээсийн бус зүйлс хэв хэмжээ болон тогтжээ. Библи

гэмших *шаардлагатай* гээд байхад, бид яаж гэмшилгүй авралыг санал болгох юм бэ? Түүнчлэн бидний ийм хязгаарлагдмал Сайн мэдээг хүлээн авч байгаа хүмүүс үнэхээр аврагдаж байгаа гэж үү?

Гэмшлийг тойрч байгаа хоёр дахь хор уршиг нь бид хүмүүсийг хамаагүй амархан дагуулж, үүнийхээ ачаар хавьгүй том үйлчлэл, чуулган, жижиг бүлэг байгуулж чадна гэж бодмоор. Гэхдээ Аароны алдааг хүний олон нь дагасныг мартаагүй биз? Хир олон юмуу цөөн хүн дагаж байгаагаар нь Бурханы тал мөн үгүйг шийдэхгүй. Үнэхээр Бурханы тал мөн эсэхийг тоо биш, харин үнэн л шийднэ.

Бид Есүсийг дагахын үнэ цэнийг мартаа юу? Бид “нүглийг хаяж (өөрийгөө няцааж), (Түүнийг дагах бүрэн төгс хүслээр) загалмайгаа аваарай” хэмээн ахин дахин айлдсан Есүсийн зааврыг мартаа юу?

Хэрэв бид хүмүүсийн дадал болсон нүгэлтэй тулахгүй бол, Есүст итгэхээр шийдсэн тэр хүн Бурханы Үгээр бус, харин нийгмийн жишгээр амьдарсаар байна. Гэрлээгүй атлаа хамтран амьдрагчтай байх, ижил хүйсийнхээ хүнтэй явалдах нь байтугай, бүр өөрсдийнх нь хэлдгээр “гэрлэх”, архидан согтуурах, хар тамхи хэрэглэх, нүүр улаймаар, завхарсан, зохисгүй хөтөлбөр, видео, кино үзэх гэх мэт үйлдэл нь нийгэм дээр бол хэвийн явдал юм. Гэтэл энэ бүх үйлдэл нь Шинэ гэрээний тушаалтай шууд зөрчилддөг.

Тэнгэрийн жишиг

Шинэ гэрээнд тушаал байдаг гэж үү? Тийм ээ бий. Үнэндээ Шинэ гэрээнд янз бүрийн бодол, үйлдлээс авахуулаад таван зуу гаруй тушаал бий. Бурханы нигүүлслийг хэнээс ч илүү хүлээн авсан элч Паул: “Хозлол нь юу ч биш, хозлуулахгүй нь ч юу ч биш. Харин Бурханы тушаалуудыг сахих нь чухал юм” (1Коринт 7:19) гэж бичсэн байдаг.

Жишээлбэл, Бурхан гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаа нь хориотойгоор барахгүй, шийтгэлтэй хэмээн тодорхой хэлсэн. Энэ бол хоосон үг биш шүү:

Садарлагч, бузрыг үйлдэгч, шунахайрагч тухайлбал шүтээн шүтэгч аливаа хүнд Христийн болон Бурханы хаанчлалд өв байхгүй гэдгийг та нар мэд. Хэн ч та нарыг хоосон үгсээрээ бүү мэхлэг. Учир нь эдгээрээс болж Бурханы уур хилэн дуулгаваргүй хөвгүүд дээр буудаг юм. (Ефес 5:5-6)

Мөн:

Гэрлэлтийг бүгд хүндлэгтүн. Ор дэр нь ч бүү бузартаг. Учир нь янхан эрчүүдийг болон завхайрагчдыг Бурхан шүүнэ (Еврей 13:4) гэдэг.

Энэ нь гэрлэлтээс гадуурх бэлгийн бүх харилцааг хамарсан үг төдийгүй мөн порнограф зэрэг бүх төрлийн бэлгийн цэвэр бус явдлыг багтаана. Тиймээс хэрэв бид энэ талаар амаа үдчихбэл, эрэлчид маань яаж мэдэх билээ? Энэ бүхнийг нууснаараа бид аврах гэж байгаа хүмүүсээ үнэхээр хайрлаж байгаа хэрэг үү?

Завхайрах, ижил хүйсийнхээ хүнтэй явалдах, хулгайлах, архидах (үүнд бас мансуурах явдал орно) гэх мэт өнөөгийн нийгмийн хувьд хэвийн үзэгдэл болсон бусармаг явдлыг үйлдэгч нар нь хаанчлалыг өвлөхгүй гэдгийг Бурхан тодорхой хэлсэн:

Зөвт бусчууд ер нь Бурханы хаанчлалыг өвлөхгүйг та нар мэддэггүй хэрэг үү? Бүү мэхлэгдэгтүн. Садарлагчид ч, шүтээн шүтэгчид ч, завхайрагчид ч, янхан эр ч, ижил хүйстэнтэйгээ нөхцөгчид ч, хулгайч нар ч, шуналтнууд ч, архичид ч, хараалчид ч, дээрэмчид ч Бурханы хаанчлалыг өвлөхгүй. (1Коринт 6:9-10)

Хуульчлагч нар ямар ч хайр, энэрэлгүй сэтгэлээр бөөн балаг тарьжээ. Тэд Шинэ гэрээний үгтэй итгэл үнэмшил, хууль дүрмээ хавсаргаж байгаад, өөрсдийнхөө таалдаг зан үйлдлийг хүмүүст тулгадаг байсан бол, эдүгээр бид эсрэгээрээ - Есүсийн Өөрийн биеэр айлдсан бас элч нарын амаар хэлүүлсэн тушаалыг огт тунхаглахаа больчихоо юу даа?

Би саяхан 1Коринтын энэ хэсгийг нэгэн алдартай, том чуулганд заасан юм. Тэгээд хамгийн эхний цуглаан дээр нь номлоод

байтал, пастор нь надад үлдсэн хэдэн цуглаан дээр нь ижил хүйсийн талаар нэг ч үг ярихгүй байхыг анхааруулав. Гэтэл яг энэ үеэр хорь гаруй жил лесби явсан нэгэн цагдаа эмэгтэй манай байгууллагын танилцуулах ширээн дээр уйлсаар хүрч ирээд: “Би сая Жоны ярьсан “Сайныг уу, Бурханыг уу?” гэдэг номыг авмаар байна. Жоны үг намайг үнэхээр хөндлөө” гэж хэлжээ.

Хэрэв бид энэ янзаараа үргэлжлүүлээд байвал, хүмүүс яаж тэнгэрийн жишгийг мэдэх билээ? Иохан Баптистын үгийг бодоод үз. Тэрбээр сургаалаараа тухайн үеийнхээ нийгмийн нүгэлтэй тулсан. Тэрбээр баян хүмүүст баялгаа тараахыг, хулгайч нарт хулгайлахаа болихыг, айж сүрддэг нь айхаа болихыг, ажилчид нь цалин хөлсдөө хангалуун байхыг заасан (Лук 3:10-14-ийг үзнэ үү). Үнэнээр ангаж цангасан хүмүүс Иоханыг сонсох гэж цөлийн бэрхшээлийг туулсаар ирдэг байв. Тэд Иоханы үгийг үг дуугүй хүлээн авч, нүглээ улайжээ. Тэд амьдралынхаа ноцтой үр дагаварын талаар юу ч мэдээгүй явсан цагдаа эмэгтэй шиг л байжээ.

Иохан Баптист олон түмний өмнө Иудагийн хаан Херодыг дүүгийнхээ эхнэртэй унтаж, Бурханы Үгийг зөрчлөө хэмээн зэмлэсэн бөгөөд үнэнийг хэлснийхээ төлөө хожим толгойгоо авахуулсан юм. Иохан нэр нөлөө бүхий удирдагчид таалагдах гэж хичээгээгүй ч, олны хүндэтгэлийг хүлээсэн. Хэрэв Иохан Херодын нүгэлтэй олны өмнө нүүрэлдэхээс зайлсхийсэн бол, магадгүй урт наслах байсан байх. Гэхдээ Иоханы үйлдлийн хэтийн үр дүнг бодоод үз: Хожим Есүс Иоханыг маш олон хүний өмнө хүндэтгэсэн (Матай 11:7-15) бөгөөд Шүүх өдөр Иохан ямар мундаг шагнал хүлээн авахыг төсөөлөшгүй. Иохан төөрөгсдийн төлөө тэнгэрийн жишгийг итгэмжтэй тогтоожээ.

Паул ч энэ үлгэр загварын дагуу яг ижил зүйл номлож, бичжээ. Тэрбээр төөрөгсдөд: “Та нар гэмшиж, Бурхан өөд эргэн, гэмшилд дүйцэх үйлс бүтээгтүн” (Үйлс 26:20) хэмээн алдахын аргагүй тодорхой хэлжээ. Мөн Паул Тимотод: “Үгийг тунхагла. Цагаа олсон ч, олоогүй ч бэлэн бай. Уужим сэтгэлээр, сургаалаар сэнхрүүл зэмлэ, урамшуул” (2Тимот 4:2) хэмээн тушаасан бол, өөр нэгэн үйлчлэгчид: “Чи эдгээрийг бүхий л эрх мэдлээр ярь, ятга, зэмлэ” (Тит 2:15) гэсэн юм.

Паулын үгд эргэлзээд байх юм ширхэг ч алга. Нэг удаа Паул Фелик хэмээх алдартай удирдагч, түүний гэргий Друзил хоёрт номложээ. Суут элч маань тэр хоёрт урам хайрлаж, амар тайвны

үгээр илбэсэн гэж бодож байна уу? Үгүй. Харин ч оронд нь ийм юм болжээ:

Хэдэн өдрийн дараа Фелик өөрийн эхнэр иудей эмэгтэй Друзилтэйгээ хамт хүрч ирээд, Паулыг дуудуулан, Христ Есүст итгэх итгэлийн тухай ярихыг нь сонсов. Зөвт байдал, биеэ захирах болон хожмын шүүлтийн тухай Паул ярьсанд Фелик аягүйцэж —Одоохондоо явж бай. Завтай үедээ би чамайг дуудна гэжээ. (Үйлс 24:24-25)

Энэ тухай ЭйЭмПиСи дээр бүр ч тодорхой хэлдэг: “Гэхдээ тэрбээр зөвт байдал, амьдралын ариун байдлын талаар (дур хүслээ хянан захирах) болон айсуу шүүхийн талаар үргэлжлүүлэн маргахад, Фелик цочирдон, айдаст автаад: “Яв!” хэмээв.”

Түүхийг бүрэн эхээр нь уншбал, Фелик Бурханы талаар бас нөгөө ертөнцийн талаар мэдэхийг хүссэндээ Паулыг дуудуулсан байдаг. Фелик Бүтээгчтэйгээ холбоо тогтоохыг хүссэн нь илт байна. Феликийг өнөөгийн аврагдаагүй боловч, чуулганыг сонирхож ирсэн эрэлчинтэй адилтгаж болох. Паул номлолоороо Феликийн хаях дургүй нүгэлтэй халз тулсан нь тодорхой байна. Тиймээс л Фелик айгаад, Паулыг явуулжээ.

Өөрөөр хэлбэл, өнөөдөр нэр нөлөө бүхий үл итгэгч хүн: “Аймаар юм номлодог энэ цуглаанд би дахиж ирэхгүй!” гэж ирээд л, цуглаан хаяж гарахтай адил юм болжээ. Фелик яагаад айх болов? Бурханы Үг Феликийн хаях дургүй нүгэлтэй нь халз тулаа юм болов уу?

Паул манай өнөөгийн Барууны философиор ярьдаг байсан бол: “Фелик, Бурхан чамд хайртай. Тэр чамайг аврахаар Есүсийг явуулсан. Чи Есүсийг зүрхэндээ оруулмаар байна уу? Тийм бол, ингэж залбир: “Есүс ээ, миний зүрхэнд орж ирээд, намайг Бурханы хүүхэд болгооч!” гэж хэлээд л дуусгах байсан байх.

Гэтэл Паулын үг Феликийг сүрдүүлж орхисон. Паул Феликийг дадал болсон бүх нүглээ гэмшсэн цагтаа л Христэд итгэгч болно гэдгийг нь мэдэж байв. Паул Феликийг амар тайвны үгээр баахан урамшуулж байгаад, гэмшлийн залбирал хэлүүлээд гараад ирсэн бол, Фелик том мэхлэгдэх байв. Тэр өөрийгөө дахин төрсөн гэдэгт үнэн голоосоо итгэх боловч, үнэндээ аврагдаагүй шүтээнд сүсэглэгч хэвээрээ л үлдэх байжээ. Паул ч ийм юм хийснээрээ

криптонитыг чуулганд нэвтрүүлэх байв. Гэтэл Есүс Христийн итгэмжит зарц Паул хэзээ ч ийм зүйлд оролцохгүй.

Энэ бүхэн нь үнхэлцэг хагалмаар байгааг би мэдэж байна аа. Гэхдээ өнөөгийн Сайн мэдээний элч болсон бид ч яг л ийм байх ёстой.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Өнөөгийн дийлэнх чуулган хүмүүст бидний нүглийн төлөө өргөгдсөн Есүсийн тахилыг хүлээн зөвшөөрч, Түүнийг зүрхэндээ урих энгийн уншлага болсон “гэмшлийн залбирлыг” мэдүүлэх төдий замаар л байгуулагдаж байна. Танай чуулганы удирдлага хүмүүсийг гэмшиж, Бурхан руу эргэхийг уриалж эхлэвэл, чуулганд чинь юу болохыг төсөөлж байна уу? Хэдэн хүн үлдэх бол?

Энэ нь нэн ялангуяа чуулганы удирдагч нарын хувьд төсөөлөхүйеэ аймшигтай ойлголт юм. Гэхдээ үлдсэн хүмүүсийн хувьд юу болохыг төсөөлж байна уу? Анхны аугаа сэргэлт юунаас эхлэснийг мэдэх үү? Сэргэлтийн удирдагч нар чуулганаас чуулганд очин, гэмшлийг номлох үед үүнийг сонссон хүмүүс бандан сандлаасаа зууран унаж, Бурханаас аврал эрэн хашхирч уйлснаар эхлэсэн гэдэг. Тэдгээр мянга мянган гэмшсэн хүмүүс дэлхийг өөрчилсөн юм. Хотууд бүхлээрээ нүглээ гэмшиж, Бурхан руу эргэжээ.

Гэмшлийг номлох үед чуулган чинь эзгүйрнэ биз. Гэхдээ эзгүйрэхээсээ илүүтэй дүүрнэ байх. Гэмшлийн хүчин чадлыг харуулж өгөхийг Бурханаас гуй. Дараа нь тэр хүчин чадлыг амьдралд чинь бас чуулганд чинь асгахыг гуй.

ГУРВАН ТӨРЛИЙН ХААН

Хуучин гэрээний зургаан номыг уншсан явдал маань намайг энэ номыг бичихэд хүргэсэн билээ.

Миний бие сүүлийн дөчин жилийн хугацаанд Самуел, Хаад, Шастирууд номыг тогтмол уншиж судласаар ирсэн юм. Гэхдээ саяхан би эдгээр номыг урьд хэзээ ч залбирч байгаагүйгээрээ залбиран, уншиж байгаагүйгээрээ уншин, системтэй судлав. Гэтэл Бурхан урьд өмнө миний хэзээ ч харж байгаагүй зүйлийг илчлэн, намайг ангайлгасан юм.

Одоо миний ярих зүйл нилээд эрдмийн - тэр бүү хэл дэндүү залхмаар санагдаж магадгүй. Гэхдээ Хуучин гэрээний хаадын тоймыг товч хуваалцалгүй, олж мэдсэн бусад зүйлээ л дүгнээд заачихбал, энэ бүх сургамжийн нөлөө хавьгүй буурна. Тэдгээр хаадын амьдралыг товчлон судласнаар - номуудыг нь бүрэн бүтнээр нь уншаад ч, үй олон сүлэлдэж сүлбэлдсэн үйл явдал дундаас анзаарагдахгүй өнгөрдөг - маш хүчирхэг үнэн тодрон ил гардаг.

Би өмнө эдгээр номыг уншихдаа, бүх хаадыг: “Эзэний мэлмийн өмнө зөв зүйлийг хийдэг” нэг хэсэг, “шүтээн шүтдэг” нөгөө хэсэг гэж хоёр ангилна гэж л боддог байлаа. Гэтэл тэр үеэс би яг үнэндээ *гурван* бүлэг хаад байдгийг ойлгосон юм.

Амьдралынхаа адаг дээр бас л замаасаа хазайсан Иехүг эс тооцбол, Израилийн нэг ч хаан Эзэний мэлмийд зөв зүйтэйг

үйлдээгүй нь үнэн. Тиймээс Иудагийн хаад руу оръё. Саул, Давид, Соломоноос гадна нийт хорин хоёр хаан Иудаг захирчээ. Эдгээрээс Рехобоам, Абиам, Иорам, Ахазиа, Аталиа (хатан), Ахаз, Манассе, Амон, Иехоахаз, Иехоаким, Иехоакин, Зедекиа нар шүтээн шүтэгчид байв. Эдгээр удирдагч нарын гар дор Иуда үгээр хэлшгүй гай гамшигт нэрвэгдэн, дайсныхаа хөлд өртөхдөө ихэвчлэн ялагдаж, улс орноороо сүүлдэг байлаа.

Тэгтэл бас сайныг үйлддэг хаад байв (Давид, Соломон нар зөв зүйлийг үйлдсэн (гэхдээ Соломон сүүлээрээ бас л бүдэрсэн). Хаанчлал хуваагдсаны дараа: Аса, Иехошафат, Иоаш, Амазия, Уззия, Иотам, Хезекиа, Иосиа нар хаанчилжээ. Гэхдээ энэ найман хааныг дотор нь бас хоёр хувааж болно. Нэгдүгээр бүлэг хаад нь - өөрөө Эзэний мэлмийн өмнө зөв амьдарсан боловч, ард түмнийхээ дунд байгаа шүтээний өндөрлөгүүдийг нураагаагүй.

Хоёрдугаар бүлэг хаад нь Эзэний мэлмийд зөв амьдраад зогсохгүй, ард түмнийхээ дунд байгаа шүтээний өндөрлөгүүдийг нурааж, устгасан хүмүүс. Эдгээр хаадын захиргаа дор улс орон нь өндөрлөгүүдийг нураагаагүй хаадын дор байснаасаа хавьгүй том амжилтыг үзжээ. Тэгвэл тэдгээр хаадыг нэг бүрчлэн авч үзье:

1. Давид. Давидын хаанчлалын үеэр улс үндэстэнд шүтээн мөргөл гэж байсангүй. Тэрбээр ард түмнээ Эзэнд бүх зүрх, ухаан, сэтгэл, биеэрээ үйлчлэхийг гал халуунаар дэмжин уриалдаг байв. Давид дайнд ялагдаж үзээгүй, хаанчлал нь ч итгэмээргүй баян тансаг байв. Давид маш амжилттайгаар хүүдээ хаанчлалаа залгамжлуулжээ.
2. Соломон. Соломон хаан ширээнд суусан дийлэнх хугацаандаа аав Давидынхаа мөрөөр явжээ. Соломоны дуулгавартай зангийн үр дүнд өөрийнх нь амьдрал ч, ард түмнийх нь амьдрал ч тэр чигээрээ гайхамшиг байжээ. Соломоны хаанчлалын үеэр "... Данаас Беершеба хүртэлх Иуда ба Израиль амар жимэр амьдарч, хүн бүр өөрийн усан үзэм, инжрийн модон дор суудаг байв" (1Хаад 4:25) гэдэг. Бодоод үз: Улс орон нь нэг ч хүнд төр засгийн туслалцаа хэрэггүй болтлоо хөгжин цэцэглэжээ. Соломоны удирдлага дэндүү аугаа байсанд "Соломоны мэргэн ухааныг сонсохоор үндэстэн бүрээс, мэргэн ухааных нь талаар дуулж мэдсэн газар дэлхийн бүх хаадаас хүмүүс

ирдэг байжээ” (1Хаад 4:34). Үнэндээ “Тиймээс Бурханаас түүний зүрхэнд өгсөн мэргэн ухааныг сонсох гэж Соломонд бараалхахыг дэлхий даяар хүсэмжилдэг байлаа” (1Хаад 10:24). Мөн “Тэгээд Соломон өөрийн эцэг Давидын оронд хаан болж, ЭЗЭНий сэнтийд залран, хөгжин дэвшсэн бөгөөд бүх Израиль түүнийг дуулгавартай дагав” (1Шастир 29:23) гэдэг. Тэр улс хөгжихийн дээдээр хөгжиж, хөгжлийн манлайд хүрчээ: “Соломон хаан Иерусалим дахь алт, мөнгийг чулуу шиг элбэг мөн хуш модыг нам газрын инжрийн мод шиг элбэг болгосон билээ” (2Шастир 1:15).

Гэвч цаг хугацаа өнгөрөхөд, Соломон Бурханы Үгээс дайжиж, хар мянган харь хүүхэнтэй гэрлэжээ. Тэд Соломоны зүрхийг өөр, өөрийнхөө бурхад руу (дадал болсон, илт нүгэл рүү) урвуулсан бөгөөд эцэст нь Эзэн Соломоны ахицад садаа хийж, хаанчлалд нь гай барцад учруулсан дайснуудыг гаргаж иржээ (1Хаад 11:14, 23-ыг үзнэ үү). Түүний илт дуулгаваргүй байдлаас болж хаанчлал нь хуваагдаж, арван овог нь ор тас алга болж, хүүд нь хоёрхон овог л үлджээ.

Үүнээс хойш би гагцхүү Иудагийн удирдагч нарын тухай л өгүүлэх болно:

3. Рехобоам. Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.
4. Абиам. Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.
5. Аса. Тэрбээр өөрөө Бурханыг халуун зүрхээр дагаж, Эзэний мэлмийд зөвийг үйлдээд зогсохгүй, ард түмнийхээ дунд байгаа шүтээн мөргөлийг төмөр нударгаар устгав. Тэрбээр шүтээн мөргөлийн эр, эм янхануудыг зайлуулж, эмэг эх Маакагаа Ашера зэргийн хөргийг бүтээснийх нь төлөө хатан эхийн суудлаас нь авч хаясан (1Хаад 15:11-13). Түүнчлэн Аса харийн тахилгын ширээ, мөргөлийн өндөрлөгүүдийг зайлуулан, онгон багануудыг нурааж, Ашерагийн модон шонг цавчиж, Иудагийн бүх хотоос мөргөлийн өндөрлөгүүдийг болон утлага тахилгын ширээнүүдийг зайлуулжээ (2Шастир 14:2-4-ийг үзнэ үү).

Аса ард түмэндээ гэм нүглээ таягдан хаяхыг хэлсний ачаар: “Түүний удирдлага дор хаанчлал амар амгалан байв” (2Шастир 14:5). Энх тайван тогтсон тэр жилүүдэд

Аса хаан Иуда даяар бэхлэлт хотуудыг босгож чаджээ. Хожим сая цэрэгтэй арми Аса руу, Иуда руу довтлохдоо “Эзэний өмнө болон Түүний цэргийн өмнө устжээ (2Шастир 14:13). Дайсан ялагдаад зогсохгүй, энэ дайны ачаар Иуда маш их олз омогтой буцсан байна.

Эндээс бид Бурханыг өөрийн биеэр дуулгавартай дагаж, дадал болсон илт нүглээс холдоод зогсохгүй, хүмүүсийг үүндээ уриалан дууддаг удирдагч хүний ерөөлийг харж байна.

6. Иехошафат. Тэр ч бас хувьдаа ч, хувьсгалдаа ч Эзэний мэлмийд зөвийг үйлддэг хүн байв. Тэрбээр хүмүүсийг шүтээн мөргөлөөсөө (дадал болсон илт нүгэл) гэмшихийг уриалан дуудаж, шүтээн мөргөлийн үлдэгдэл болсон эр, эм янханг үлдэн хөөв (1Хаад 22:46). Түүнчлэн Иудагаас мөргөлийн өндөрлөгүүдийг болон Ашерагийн модон шонг зайлуулсан (2Шастир 17:6). Хаанчлалынхаа гурав дахь жилд тэрбээр Иудагийн бүх хот руу албатуудаа илгээсэнд, тэд Эзэний хуулийн хуулбарыг авч яваад, Иудагийн бүх хотоор аялан, ард түмэнд зааж өгчээ.

Иехошафатын энэ удирдлагаас ямар үр дүн гарав? “Иудагийн эргэн тойрон дахь бүх газрын хаанчлал дээр ЭЗЭНээс эмээхүй байсан бөгөөд тэд Иехошафатын эсрэг дайтсангүй. Филистчүүдээс Иехошафатад бэлэг сэлт болон алба гувчуурт мөнгө авчрав. Мөн арабууд түүнд долоон мянга долоон зуун хуц, долоон мянга долоон зуун ухнатай сүрэг авч иржээ. Иехошафат улам өргөмжлөгдөж, Иудад бэхлэлт цайз болон нөөц хангамжийн хотуудыг барьж байгуулав” (2Шастир 17:10-12). Тэгээд “Иехошафат асар их эд баялаг, нэр хүндтэй байлаа” (2Шастир 18:1). Дайсан Иехошафат руу болоод Иуда руу дайрахаар ирэх үед Бурхан дайсныг өөр хоорондоо алалдахад хүргэж, Иуда энэ удаа ч бас асар их олз омогтой буцжээ.

Дараа нь мөн: “Иймээс ЭЗЭН хаанчлалыг түүний гарт багатгаж, бүх Иуда Иехошафатад алба гувчуур авчирсанд тэрээр үлэмж баялагтай, нэр хүндтэй болов. Түүний зүрх ЭЗЭНий замуудад зоригжиж, тэрээр Иудагаас мөргөлийн өндөрлөгүүд болон Ашерагийн модон шонг зайлуулсан юм” (2Шастир 17:5-6) гэдэг.

Иехошафат нэг л том алдаа гаргасан нь шүтээнд мөргөдөг Ахабын гэр бүлтэй ураг төрлийн барилдлагатай болсон явдал байв. Тэрбээр үүнээсээ болж өөрөө амиа алдахаа дөхөж, хүүгээ завхруулахаа алджээ. Энэ талаар Иехү гэх эш үзүүлэгч Иехошафаттай тулсан байдаг: “Та гэм буруутнуудад туслан ЭЗЭНийг үзэн ядагчдыг хайрлана гэж үү? Үүнээс чинь болоод ЭЗЭНээс ирэх уур хилэн өөр дээр чинь буув” (2Шастир 19:1-2). Иехошафат хэдий энэ талаараа алдсан ч, ерөнхийд нь авч үзбэл, түүний дуулгавартай амьдралын ачаар буюу тэрбээр ард түмнийхээ дадал болсон нүгэлтэй нүүрэлдсэний ачаар Иехошафат өөрөө ч, Иуда ч ихэд хөгжин цэцэглэж, ерөөгджээ.

7. Иехорам. Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.
8. Ахазиа. Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.
9. Аталиа (хатан). Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.
10. Иоаш. Түүний тухайд “Тахилч Иехоиадагийн бүх өдрийн турш Иоаш ЭЗЭНий мэлмийд зөв зүйтэйг үйлдэв” (2Шастир 24:2) гэдэг. Гэхдээ түүний удирдлагын тухайд тэс өөр асуудал яригдана. Тэр шүтээний өндөрлөгүүдийг нураагаагүй. Өөрөөр хэлбэл Иоаш ард түмнээ нүглээсээ эргэхийг уриалан дуудаагүй юм. Эцэстээ “...Тэд эцэг өвгөдийнхөө Бурхан болох ЭЗЭНий өргөөг орхин Ашерагийн модон шон болон шүтээнүүдэд үйлчилжээ” (2Хаад 24:17-18) гэдэг.

Нөлөөлөх ёстой хүмүүс нь эргээд хаандаа нөлөөлж, “... Тэдний энэ гэм буруугийн улмаас Иуда болон Иерусалим дээр ял бууж ирэв” (18-аар ишлэл). Эш үзүүлэгч түүн дээр ирээд: “Та нар яагаад ЭЗЭНий тушаалуудыг зөрчиж байна вэ? Ингэснээр та нар хөгжиж дэвжихгүй” (20-аар ишлэл) хэмээн айлджээ. Тэгээд эцэстээ “Дараа жилийн эхэнд арамчуудын цэрэг Иоашийн эсрэг дайран ирэв. Тэд Иуда, Иерусалимд хүрч ирээд, хүмүүсийн дундаас ард түмний удирдагчдыг бүгдийг алж, бүх олз омогоо Дамаскийн хаанд илгээжээ. Үнэндээ арамчуудын цэрэг цөөхөн тооны дайчидтай байв. Гэтэл иудачууд эцэг өвгөдийнхөө Бурхан болох ЭЗЭНийг умартсан учраас тэдний үлэмж

их цэргийг ЭЗЭН арамчуудын гарт оруулж өгчээ. Ингээд тэд Иоашийн дээр шийтгэлийг гүйцэлдүүлжээ” (23-24-ээр ишлэл). Арамчууд түүнийг шархдуулаад, эцэст нь хөнөөжээ. Иоашийн хаанчлал нь ард түмнийхээ нүгэлтэй тулдаггүй удирдагчаас болж ирдэг гарз хохирлын аймшигт жишээ юм.

11. Амазия. “Тэрээр ЭЗЭНий мэлмийд зөв зүйтэйг үйлдсэн ч, бүх зүрх сэтгэлээсээ үйлдсэнгүй” (2Шастир 25:2). “... мөргөлийн өндөрлөгүүдийг зайлуулаагүй юм. Ард түмэн мөргөлийн өндөрлөгүүд дээр тахил өргөж, утлага уугиулсаар л байв” (2Хаад 14:4). Энэ бүхэн нь хаанчлалд ч тун таагүй үр дагавар авчрав. Амазия Едомыг ялсандаа эрдэж, Израилийн хаан Иоашийг тулаанд дууджээ. Иоаш Амазиад аятайхан байхыг анхааруулсан боловч, Амазия сонсолгүй дайраад, Израилийн армид салам цохиулж, олзлогджээ. Дараа нь Израиль Иерусалим дахь Иудагийн ханаас зуун наяд метр гаруйтай үргэлжилсэн хэсгийг нураагаад, Эзэний сүмээс алт, мөнгө, сав суулга тэргүүтнийг хуу тонохоор барахгүй, хааны эрдэнэсийн санг цөлмөж, нэг хэсэг хүмүүсийг олзлоод арилав. Харин Амазия алуулжээ (2Шастир 25:11-28). Эзэний мэлмийд зөвийг үйлдэж эхлэсэн ч, ард түмнийхээ нүгэлтэй тулаагүй удирдагчийн эмгэнэлтэй төгсгөлийг бид дахин харж байна.
12. Уззия. Энэ хаан Эзэний мэлмийд таатай зүйлийг үйлдэж, Эзэнийг дагах хугацаандаа үнэхээр Эзэнээр ерөөгдөж, туйлын хүчирхэг, амжилттай нэгэн болжээ. Тэрбээр шүтээн мөргөлийн газрыг хэрхсэн талаар ямар нэг юм бичээгүй боловч, өөрийнхөө бардам зангаас болж, арьс өнгөний өвчнөөр үхсэнийг бид мэднэ.
13. Иотам. Энэ хааны талаар ч гойд юм бичигдээгүй байдаг. Тэрбээр Эзэний мэлмийд таатай зүйлсийг үйлдсэн боловч, ард түмэн нь үргэлжлүүлэн завхарсаар байжээ. Хамгийн харамсалтай нь “Зөвхөн мөргөлийн өндөрлөгүүд зайлуулагдаагүй бөгөөд ард түмэн мөргөлийн өндөрлөгүүд дээр тахил тахиж, утлага уугиулсаар байв” (2Хаад 15:35). Тэгээд үр дүнд нь “Тэр өдрүүдэд Иудагийн эсрэг Арамын хаан Резин болон Ремалиагийн хүү Пека нарыг ЭЗЭН илгээж эхлэжээ” (2Хаад 15:37).

14. Ахаз. Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.
15. Хезекиа. Хезекиагийн аав Ахаз ёрын муу хаан байв. Ахаз сүмийн хаалгыг барьж, жинхэнэ хүндэтгэл мөргөлийг таслан зогсоожээ. Хезекиа хамгийн түрүүнд Эзэний сүмийн хаалгыг нээж, бүх сав суулгыг цэвэрлэж, барилгыг засчээ. Түүний тухай “Тэр өвөг эцэг Давидынхаа хийсний адил, ЭЗЭНий мэлмийд зөв зүйтэйг үйлдэв. Тэрээр мөргөлийн өндөрлөгүүдийг зайлуулан, онго баганануудыг хугалан хэсэглэж, Ашерагийн шонгуудыг цавчиж хаяжээ. Бас тэр өдрүүдийг хүртэл Израилийн хөвгүүд Мосегийн бүтээсэн зэс могойд утлага уугиулж, түүнийг Нехуштан гэдэг байсан тул тэрхүү зэс могойг тэрээр сэглэж хаяв” (2Хаад 18:3-4) гэсэн байдаг. Дараа нь хаан Эзэний Алгасал баярын ёслолыг сэргээжээ. Энэ нь нүсэр үйл явдал байсан бөгөөд хүмүүс буцацгаахдаа “...Иудагийн хотууд уруу явж, бүх Иуда, Бениамин даяар болон Ефраим, Манассед буй онго баганануудыг хугалан хэсэглэж, Ашерагийн модон шонгуудыг хуга цавчин, мөргөлийн өндөрлөгүүд болон тахилын ширээнүүдийг устаж дуустал нураав” (2Шастир 31:1) гэдэг.
- Хезекиа “... ЭЗЭНээс зуурч, Түүнийг дагахаа болилгүй, харин Мосед ЭЗЭНий тушаасан тушаалуудыг сахижээ. ЭЗЭН түүнтэй хамт байсан тул тэр хаа явсан газартаа мэргэн ухааныг олж байв. Тэрээр Ассирийн хаанд үйлчилсэнгүй түүний эсрэг тэрслэв” (2Хаад 18:6-7) хэмээн бичиж тэмдэглэжээ. Түүн рүү Ассиричууд халдах үед Эзэний тэнгэрэлч Ассирийн хуаранд бууж ирээд, 185,000 цэргийг хөнөөжээ. Хезекиа ард түмнийхээ гэм нүглийг шийдвэрлэсэн учраас, өөрөө ч, улс үндэстэн нь ч цэцэглэн хөгжив.
16. Манассе. Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.
17. Амон. Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.
18. Иосиа. Тэрбээр хувьдаа ч, хувьсгалдаа ч туйлын эрс дуулгавартай хаан байв. Түүний тухайд “Хаан болон Иудагийн бүх эрчүүд, Иерусалимын бүх оршин суугч мөн тахилч нар, эш үзүүлэгчид болон их, бага бүх ард түмэн түүнтэй хамт ЭЗЭНий өргөө уруу явсан бөгөөд ЭЗЭНий өргөөнөөс олдсон гэрээний номын бүх үгийг тэр тэдний

сонорт уншив” (2Хаад 23:2) хэмээн тэмдэглэсэн байдаг. Тэрбээр дараа нь гэрээг шинэчилж, Баал, Ашераг болоод тэнгэрийн бүх хүчийг хүндэтгэж мөргөхөд ашигласан бүх сав суулгыг Эзэний сүмээс гаргаж хаяад, тэдгээрийг шатааж, үнсийг нь шүтээнд мөргөдөг байсан хүмүүсийн булшин дээр асгах заавар өгчээ.

Энэ удирдагч дадал болсон илт дуулгаваргүй байдлаас салахын тулд чухам юу хийсэн талаар олон зүйл хэлсэн байдаг. Би Библи дээрээ Иосиа “зайлуулав, шатаав, авч хаяв, эвдэв, устгав, бяцлав, тайрав, буулгав, таягдав, арчин хаяв” гэсэн хэсгийг болон Иудагийн нүгэлтэй тулсан бүх хэсгийг дугуйлж зурсан байдаг. Эдгээр үг нь 2Хаадын 23-аар бүлэгт л гэхэд 25 удаа гардаг. “Мосегийн бүх хуулийн дагуу өөрийн бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадлаараа ЭЗЭН өөд эргэсэн түүн шиг хаан түүний өмнө ч байгаагүй, түүнээс хойш ч гарсангүй” (2Хаад 23:25). Энэ хугацаанд Иосиа өөрөө ч, ард түмэн нь ч өөдлөн дэгжжээ.

19. Иехоахаз. Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.

20. Иехоаким. Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.

21. Зедекиа. Эзэний мэлмийд зөвийг үйлдээгүй.

Тэгэхээр, эдгээр хаадын түүхийг базаж дүгнэе: Өөрөө ч бурханлагаар амьдарч, ард түмнийхээ ч нүгэлтэй (шүтээн мөргөлтэй) тулсан удирдагч нар алс хэтдээ сайн сайхан үр дүн үзжээ. Харин өөрөө бурханлаг амьдарсан ч, ард түмнийхээ нүгэлтэй тулаагүй удирдагчийн хувьд ийм таатай хувь зохиол бүрдээгүй.

Өнөөгийн цуглаан үүнийг сурах ёстой. Бид эрэлчдийг жинхэнэ гэмшилд дуудалгүй, зүгээр гэмшлийн залбирлыг хоосноор залбируулснаараа, гайгаа л дуудаж байгаа хэрэг юм. Хэрэв “шинээр итгэсэн хүмүүс” маань гэм нүглээсээ эргэх ямар ч бодолгүй бол яах уу? Тэгвэл бид тойрон хүрээлэлдээ шүтээнд мөргөгчдийг л залж байгаа хэрэг юм.

Удирдагч бид хувьдаа жигтэйхэн бурханлаг амьдарч болох ч, хүмүүсийнхээ дундах нүглийн өндөрлөг газруудтай тулахгүй бол, үр дагавраа заавал хүртэх бөгөөд тэр үр дагавар нь дээрх хаадынхаас нэг их ялгарах юмгүй байна. Бид хэсэг зуур амжилтад хүрч болох ч, тэр хэвээрээ төгсөхгүй. Ард түмнийхээ нүгэлтэй

тулаагүй хэд хэдэн хаан эхэн үедээ сайн сайхан байсан ч, яваандаа удирдлагынхаа алдаанд гүйцэгджээ.

Хэрэв бид Сайн мэдээг ийм энхийн замаар хуваалцахыг сонгобол, өөрсдийгөө Бурханы талынх гэж боддог шүтээнд мөргөгч баахан хүнтэй л хоцорно. Өөрөөр хэлбэл өөрийнхөө нийгмийг сүнслэг криптонитад нээнэ гэсэн үг.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Заримдаа хүн зураг дээрх нарийн ширийн, чимхлүүр хэсгийг харсаар байгаад, зургаа томоор нь харахаа мартаж тал бий. Ямар сайндаа л “модтой нь хөөцөлдсөөр, ойгоо алдах” гэж ярихав дээ. Тэгвэл бид Бурханы Үгд суралцахдаа - нэн ялангуяа урт, урт түүхэн үйл явдлыг хөврүүлж судлах явцдаа ийм алдаа гаргачих гээд байдаг. Тиймээс яг энэ бүлэгт үзсэн шигээ түүхээ сэргээн санах нь урьд өмнө анзаараагүй үлгэр загварыг бидэнд илчилж өгдөг. Өөрөөр хэлбэл зургийг томоор нь харуулдаг.

Израиль, Иудагийн түүхийг томоор нь харбал, удирдагч нар нь өөрсдөө зөв амьдраад зогсохгүй, цаашлаад Бурханы хариуцуулан даалгасан бүхний дээр эрх мэдлээ тогтоосон шиг тогтоож, үүрэг хариуцлагаа үүрсэн шиг үүрэх үед Бурхан тэднийг ерөөсөн байдаг.

Та мэдээж хаан юмуу хатан биш. Тэр байтугай менежер юм уу зөвлөх ч биш байж болно. Гэхдээ Бурханаас танд даалгасан, их бага хэмжээний эрх мэдэл бүхий талбар хүрээ байж л байгаа. Хувийнхаа амьдралыг зөв авч явах төдийгүй, тухайн хүрээндээ хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрхэхээс чинь Бурхан таны төлөө юу үйлдэх нь ихээхэн хамаарна. Өөрийнхөө талбар хүрээг Бурханаас асууж лавлаад, түүн дээрээ хариуцлагатай байх цэц ухааныг гуй. Бурханы хэлсэн үгийг тэмдэглэж аваад, үйл хэрэг болгох төлөвлөгөө гаргаарай.

КРИПТОНИТЫГ ҮСГТЭХ

「ХЭСЭГ 4」

БАГИЙГ НЬ ХУУЛАХ

Тэгэхээр эхлээд хувьд болоод хувьсгалд чинь нөлөөлж байгаа Криптонитын сэм үр дагаварын багийг хуу татан илчилж байгаад, дараа нь үхлийн энэ бодисыг устган сөнөөх ажлаа эхлэх үү?

Намайг сургуульд байхад хар тамхиас сэргийлсэн хоёр өдрийн сургалт хийж, хар тамхины аймшигт үр дагаварыг таниулж билээ. Би Христэд итгэхээсээ өмнө нилээд хөдөлгөөнтэй жаал байсан боловч, элдэв төрлийн мансууруулагч бодистой хэзээ ч хутгалдаж яваагүй юм. Үүний үр дагавараас айх айдас намайг цэвэр байлгасан билээ.

Эрүүл бус айдас гэж байх бөгөөд үүнээс Есүс биднийг чөлөөлсөн. Гэтэл дунд сургуульд сурсан хар тамхи шиг амийг минь авдаг зүйлээс биднийг сэргийлдэг бурханлаг айдас гэж бас бий. Бичээс “Ингэхээр Түүний амралтад орох амлалт байгаа учраас та нараас хэн нэгэн нь өөрийгөө түүнд хүрсэнгүй гэж санах вий гэдгээс эмээцгээе” (Еврей 4:1), “Энэрэл хайр ба үнэнээр хилэнц цагаадна. ЭЗЭНээс эмээвээс ёр муугаас зайлна” (Сургаалт үгс 16:6) гэдэг.

Энэ бүлгээрээ би бас л Христэд итгэдэг удирдагч нарын тухай ярина. Гэхдээ энэ үг бидэнд бүгдэд маань хамаатай. Учир нь итгэгч хүнийг “...сүүл болгохгүй, толгой болгоно” (Дэд хууль

28:13) гэдэг. Бид бүгдээрээ Бурханы хаанчлалын удирдлагын маш чухал байр суурь болох элч нар байхаар дуудагдсан.

Бид Бичээсийн гэгээрлээр үйлчлэлийнхээ стратегийг эргэцүүлж үзсэн үү? Бид яагаад нүглийн өндөрлөг газруудтай тулахаас цааргалж байна? Бурханыг мэдэх хүсэлтэй хүмүүс биднээс үнэнийг л хүсэн хүлээдэг. Гэтэл бид жинхэнэ харилцаанд саад болдог зүйлсийн талаар ярихаас цааргалсаар байх. Бид тэднийг хамгаалж байна уу? Үнэнээс зайлсхийснээрээ үнэндээ бид эрэлчдийг алсдаа хорлож байгаа бус уу? Мөнхийн амийг сонсохоор ирсэн хүмүүсийг яагаад мэхлэх ёстой гэж?

Тэд хэн ч анхааруулж хэлээгүй учраас, гэрлэснийхээ дараа хүнд байдалд орсон Анжела шиг л болно. Яахаараа хүн Есүстэй тогтоох харилцаанд гэм нүглийг оруулж болно гэж бодов? Ийм байх боломжгүй. Тиймээс бид тэдэнд үнэндээ байхгүй харилцааг санал болгож байна уу? Энэ чинь хуурамч аврал бус уу?

Үүнийг тал талаас нь авч үзье. Эхлээд бүгдээрээ эрэлчдийн талаар болон криптонитын талаар ярилцахаас хойш суудаг удирдагчдыг авч үзээд, эцэст нь эдгээр нь чуулганд ямар үр дүн авчирдаг талаар үзье. Хэтийн үр дүн нь хэн, хэнийх нь хувьд аюултай юм.

Эрэлчид

Шүүх өдөр Бурханы хаанчлалд орох гэж очсон цөөн биш, хэсэг биш, харин олон хүн Есүсээс: “Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” (Матай 7:23) гэдэг үг дуулна.

Эдгээр хүмүүс хэн бэ? Тэд сүнс дуудагч нар уу? Эсвэл өөр шашны хүмүүс үү? Гаж урсгал, сургаалтнууд уу? Гэхдээ хэрэв Есүсийн үгийг нарийн харах юм бол, тэдгээр нь бидний дунд байдаг, Христэд итгэх итгэлийг тунхагладаг, чуулганд явдаг хүмүүс болохыг харна. Есүс эхлээд: “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Эцэгийн минь хүслийг үйлдэгч л орно” (Матай 7:21) гэжээ. Есүс Өөрийг нь Эзэн гэж дуудах хүмүүс хэн болохыг хэлж байна. Есүс Жосеф Смит, Мухамед, Будда, Харе Кришна, Кунз, Ра, Сих зэрэг худал эш үзүүлэгч, бурхдыг нэрлээгүй. Орохыг хориглосон

тэдгээр хүмүүс нь Есүс Христийг “Эзэн” хэмээн үнэн зүрхээрээ дууддаг хүмүүс ажээ.

“Эзэн” гэдэг үгийг энэ ишлэлд яагаад давтан хэлэв? Бичээст алив үг юмуу хэллэг давтагдсан байвал, энэ нь тохиолдол биш гэдгийг бид өмнө сурсан. Өөрөөр хэлбэл бичээч үгээ цохон хэлж байна. Гэхдээ энэ тохиолдолд зүгээр нэг цохолт хийсэн бус, харин хүчтэй сэтгэл мэдрэмжийг хавсаргасан цохолтыг илэрхийлжээ.

Жишээлбэл, Давид хаанд хүүг нь Иоабын цэргүүд цаазласан тухай дуулгах үед, Давид маш хүчтэй сэтгэл мэдрэмж илэрхийлэн, хоёр алгаараа нүүрээ дараад: “... *чанга дуугаар* —Миний хүү Абсалом. Абсалом оо. Миний хүү, миний хүү! гэж орилон *хаихирсан*” (2Самуел 19:4) гэдэг. Хэрэг дээрээ Давид “хүү минь” гэдэг үгийг давтаагүй, харин бичээч түүний дэндүү ихээр гаслан гашуудсан зовлонг гаргаж илэрхийлэхийн тулд энэ үгийг давтсан байж болох.

Яг үүнтэй адилхан Эзэнтэн маань ч Өөрийг нь гэх тэдгээр хүмүүсийн сэтгэл хөдлөлийг харуулахыг зорьжээ. Тэд Есүс Христ бол Бурханы Хүү гэдэг сургаалыг хүлээн зөвшөөрөхөөр барахгүй, бүр гал халуунаар, хамаг зүрхээрээ итгэх ажээ. Тэд Христэд итгэдэгтээ баярлахаар барахгүй, итгэлийнхээ тухай хөөрцөглөн ярих ажээ.

Тэд Христийн төлөө шатахаар барахгүй, Түүний төлөө үйлчлэх ажээ:

“Тэр өдөр Надад олноороо: “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгийг үйлдэж байсан бус уу?” гэх болно.” (Матай 7:22)

Мессеж Библи тэднийг хөндлөнгийн үзэгчид байгаагүй гэж хэлсэн нь миний бодлоор хамгийн шилдэг хөрвүүлэг болж таарах байх. Тэд чуулганыхаа ажилд шууд гар бие оролцож, үйл ажлыг нь дэмжинэ. “Бид Таны нэрээр эш үзүүлсэн” гэж хэлснээс нь үзбэл, тэд Сайн мэдээг ил тод тунхагладаг ажээ. Өөрөөр хэлбэл тэд хүмүүсийн амьдралыг өөрчлөхөд хувь нэмрээ оруулдаг байж.

Зарим утгачилсан хөрвүүлэг дээр “мянга мянган” гэж хэлдэг боловч, дийлэнх орчуулга дээр “олон” гэдэг. Полус хэмээх энэ

Грек үг нь “дийлэнх тоо, хэмжээ, дүн” гэсэн утгатай бөгөөд үүнийг гол төлөв “дийлэнх, ихэнх” гэсэн утгаар хэрэглэдэг.

Ямар ч байсан Есүс цөөн хэдэн хүний талаар яриагүй, харин маш том бүлгийн талаар - магадгүй бүр тэнд байгаа хүмүүсийн дийлэнх олны талаар ярьсан байх боломжтой.

Тэгэхээр үндсэндээ: Есүс Сайн мэдээний сургаалд итгэдэг, Өөрийг нь “Эзэн” гэж дууддаг, үгийг нь бүх зүрхээрээ дэлгэрүүлдэг, Түүний төлөө идэвхи зүтгэлтэй үйлчилдэг хүний талаар ярьжээ. Бид байсан бол тийм хүнийг шууд л жинхэнэ Христэд итгэгч гэнэ. Тэгвэл чухам юу тэднийг биднээс тусгаарладаг вэ? Тэд яг жинхэнэ итгэгч хүмүүсээс юугаараа ялгардаг вэ? Есүс бидэнд: “Тэгэхээр нь Би тэдэнд: “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ” (Матай 7:23) гэжээ.

Гол оньс нь “ёс бусыг үйлдэгч” гэдэг мэдэгдэл ажээ. Нэгдүгээрт - ёс бус гэж юу вэ? Үүнийг Грекээр *аномиа* гэнэ. *Тайерсийн Грек толь бичигт* үүнийг “хуулийг хайхрахгүй юмуу зөрчих байдлаас үүдсэн хууль ёсгүй нөхцөл байдал” гэж тодорхойлдог. Энгийнээр хэлбэл, хууль ёсгүй хүн Бурханы Үгийн эрх мэдлийг сахин баримтладаггүй. Тэрбээр огт гэмших юмгүй гэм нүгэл үйлдэж сурчээ. Өөрөөр хэлбэл тэр бол орчин цагийн шүтээнд мөргөгч ажээ.

Тиймээс хууль ёсгүй байдал нь нэгэн төрлийн криптонит юм.

Эдгээр эрчүүд, эмэгтэйчүүд нь *хааяа нэг* бүдэрчихдэг хүмүүс биш, харин Бурханы Үгээс зайлсхийж, үл тоож, үл хайхарч, үл дагаад дадчихсан, бурханлаг бусаар амьдраад хэвшчихсэн хүмүүс ажээ. Тэдний зарим нь “Бичээсийн тодорхой хэсэг нь бичигдсэнээсээ өөр утгатай” гэж итгэдэг бол, зарим нь “Бичээсийн тодорхой хэсэг нь орчин цагт хэрэгжихээ больсон” гэж итгэх бөгөөд тэд бүгдээрээ шахуу Бичээсийн бус “нигүүлслээр хучигдсан” гэж итгэдэг.

Харин миний хувьд, удирдлага нь тэднийг хэзээ ч жинхэнэ гэмшилд уриалж, нүгэлтэй нь тулж байгаагүй учраас, тэр хүмүүс нүглээ хийсээр байдаг гэдэгт харуусалтайгаар итгэдэг. Есүс Христтэй тогтоох харилцаанд амраг - шүтээнүүдээ авчрах боломжгүй байдгийг хэн ч тэдэнд хэлж өгөөгүй ажээ. Тэд үнэхээр нигүүлслээр аврагдсан л юм бол, нүгэл үйлдэх бодлыг цээрлээд зогсохгүй, давтан нүглээс бушуухан холдоно. Тэд хамаг хүсэл, байдаг хүчээрээ махан биеэ цовдлож, бурханлаг зан чанар, үр

жимстэй амьдралыг мөшгинө. Энэ бол жинхэнэ итгэгч хүний тэмдэг!

Есүс тэдэнд: “Би та нарыг танихгүй” гэж хэлсэн нь тун сонирхолтой. “Танихыг” Грекээр *гноско* гэж хэлсэн бөгөөд энэ нь “дотоно мэдэх” гэсэн утгатай юм. Тэгэхээр тэр хүмүүс Есүстэй хэзээ ч жинхэнэ харилцаатай байгаагүй ажээ. Хэдийгээр тэд Есүсийг “Эзэнтэн”, “Эзэн” гэж дуудсан боловч, үнэндээ Түүнийг дагадаггүй байсан учраас, энэ нь зүгээр л хэргэм зэрэг төдий л байжээ. Бурхантай жинхэнэ харилцаатай хүн Бурханы Үгийг сахидаг:

Бид Түүний тушаалуудыг сахивал, үүгээрээ бид Түүнийг таньснаа мэднэ. “Түүнийг би мэднэ” гэж хэлээд, Түүний тушаалуудыг сахидаггүй нь худалч бөгөөд түүнд үнэн алга. (1Иохан 2:3-4)

Энэ мэдэгдэл нь Есүсийн: “Тэгэхээр та нар тэднийг үр жимсээр нь танина” (Матай 7:20) гэдэг үгтэй төгс таарч байна. Есүс дээрх үгээрээ Христэд үйлчлэх, үгийг ярих, чуулганд явах тухай яриагүй ажээ. Учир нь тэнгэрийн үүдээр орохыг хориглох хүмүүс нь эдгээр чанарыг эзэмшсэн хүмүүс байх юм. Өнөөдөр дийлэнх хүмүүс Есүсийг “Эзэн” хэмээн дууддаг, сургаалд нь итгэдэг, сэтгэл санаагаа зориулдаг, Христийн үйлчлэлд идэвхитэй хүмүүсийг Бурханы хүүхэд гэж үзэх байх. Гэтэл эдгээр нь жинхэнэ итгэгчийг тодорхойлох шийдвэрлэх хүчин зүйлс биш болохыг бид тодорхой харлаа.

Тэгэхээр ийм юм л даа: Мэдээж жинхэнэ итгэгч хүнд эдгээр чанар зайлшгүй байна. Үнэндээ эдгээр чанаргүй хүн жинхэнэ итгэгч байх ч боломжгүй. Гэхдээ эдгээр чанарыг эзэмшлээ гээд автоматаар Бурханы хүүхэд болчихгүй юм. Хамгийн гол нь: Та дадал болсон нүглээ гэмшиж, Түүнийг гал халуунаар дагаж байна уу? Үүнийг “Тэд Есүсийн “*Яв, дахиж нүгэл бүү үйлд*” (Иохан 5:14-ийг үзнэ үү) *гэсэн үгийг сонголт гэж үзэж байна уу, үүрэг гэж үзэж байна уу?*” гэдэг асуултаар л шалгана.

Түгээгч нар

Одоо Сайн мэдээний түгээгч болсон удирдагч нар ямар үр дагавар авчирдгийг авч үзье. Шинэ гэрээ тэдэнд Бурханы Үгийг хариуцуулсаар байтал, үнэнтэй нүүрэлдэх хэсгийг нь хөсөрдүүлсэн хүмүүс дээр Бичээс үнэхээр аймшигтай шүүх буулгасан байдаг. Бурхан Үгийнхээ элч нарт юу гэж анхааруулсныг сайтар уншина уу:

Би буруутад “Чи заавал үхнэ” гэж айлдах үед хэрэв чи түүнд *сэрэмжлүүлэхгүй* эсвэл амьд байхын төлөө буруу замаасаа эргэхийг нь түүнд *сэрэмжлүүлж* хэлэхгүй аваас тэрхүү буруут нь хилэнц дотроо үхэх болно. Харин түүний цусыг *Би чиний гараас нэхнэ*. Гэвч чи буруутад *сэрэмжлүүлсэн* ч тэрээр гэм буруугаасаа, буруу замаасаа эргэхгүй аваас тэрээр хилэнц дотроо үхэх болно. Харин *чи амиа аварсан* билээ. Дахиад, хэрэв зөвт нэгэн зөвт байдлаасаа эргэж гажуудал үйлдэх бөгөөд Би түүний өмнө бүдрэх чулуу тавих аваас тэр үхэх болно. Чи түүнд *сэрэмжлүүлээгүй* учир тэрээр нүглийнхээ дотор үхэж, түүний үйлдсэн зөв үйлс ч дурсагдахгүй. Гэвч *түүний цусыг Би гараас чинь нэхнэ*. Харин чи зөвт нэгэнд, нүгэл үйлдэх ёсгүйг *сэрэмжлүүлээд*, тэр нь нүгэл эс үйлдэх аваас тэр хүн *сэрэмжлүүлгийг* авсан учир үнэхээр амьд үлдэнэ. *Чи ч амиа аварсан* гэв. (Езекиел 3:18-21)

Энд “сэрэмжлүүлэх” гэдэг үгийг ахин дахин давтсан байгааг анхаарна уу. Пастор, удирдагч, итгэгч нар бүгд төөрөгсдөд хүрч, нүгэлд байгаа хүмүүстэй хайраар тулах даалгавар хүлээсэн учраас, би та нараас шулуухан л асууя. Та дагуулж байгаа хүмүүстээ дадаж хэвшсэн нүглээсээ салахыг *анхааруулж* хэлээгүйгээсээ болоод, тэднийг Бурханы өмнө зөв амьдарч байна хэмээн хуурмагаар итгэхэд хүргэснийхээ төлөө хариуцлага хүлээхийг хүсч байна уу? Тэд аврагдсан хэмээн дүрдээ итгэв ч, тэдэнд хэн ч анхааруулж хэлээгүйгээс болоод нүглээ үргэлжлүүлэн үйлдсээр байгаад, Шүүх өдөр Эзэнээс “Надаас зайл” гэдэг үг сонсоно.

Иймээс л Сайн мэдээг зүй ёсоор номлоно гэдэг нь “хүн бүрийг Христэд төгс болгохын тулд бүх мэргэн ухаан дотор хүн бүрд

сануулж, хүн бүрд заан Түүнийг тунхаглах” (Колоссай 1:28) явдал ажээ. Бид заахаас гадна *анхааруулах* ёстой.

Бурхан дээрх ишлэлд: “Би тэдний цусыг чиний гараас нэхнэ” гэж хэлсэн байгааг сайтар эргэцүүлэн бод. Бид хариуцлагагүй байдлаа өнө мөнхөд санаж явна гэдгийг та мэдэх үү? Шинэ тэнгэр, газарт:

“Шинэ сараас шинэ сар хүртэл, Амралтын өдрөөс Амралтын өдөр хүртэл бүх махбод Миний өмнө мөргөхөөр ирнэ” гэж ЭЗЭН айлдаж байна. “Дараа нь тэд гарч ирж, Намайг эсэргүүцэгч хүмүүсийн хүүрийг үзнэ. Учир нь өт хорхой нь үхэхгүй, гал нь унтрахгүй. Тэд бүх махбодод жигшил болно” (Исаиа 66:23-24) хэмээн Исаиа хэлжээ.

“Хариуцлага алдсан удирдагч” нь өөрсдийнх нь буруугаас болж тэр хүмүүс галт нуурт хаягдсаныг зүгээр л мартчихна гэж бодож байна уу?

Хэрэв бид хүмүүсээр хоосон “гэмшлийн залбирал” хэлүүлчихээд, яаж ч амьдарсан хамаагүй тэнгэрт баталгаатай орно гэсэн философиороо тэдэнд хуурамч найдвар атгуулбал, юу болох бол? Бид сонсогч нараа хуурамч баталгаагаар хуурч, тэдний жинхэнээсээ гэмших сэтгэлийг үргээнэ. Тийнхүү эцэстээ бид өөрийн биеэр төөрүүлсэн хүмүүсээ бие арзайн, айдаст автсаар харж зогсоно гэдгийг хэлэх илүүц байх.

“Тиймээс би бүх хүний цусны буруугүй гэдгээ та нарт энэ өдөр гэрчлэх байна. Учир нь би Бурханы бүхий л төлөвлөгөөг та нарт мэдүүлэхээс зайлсхийсэн нь үгүй билээ” (Үйлс 20:26-27) гэсэн Паулын чин зүрхний үгийг санаарай. Бурхан Езекиелээр дамжуулан Өөрийнхөө Үгийн түгээгч нарт юу айлдсаныг Паул сайн мэдэж байв. Хэрэв бид Бурханы арга замыг тунхаглахаас хойш суубал, энэ нь бидний алдаа болж, бид хариуцлагатан болно. Магадгүй иймээс л элч Иаков:

Ах дүүс минь, багш нар бид үлэмж хүнд шүүлтэд орно гэдгийг мэдэн, та нараас олноороо багш бүү бол (Иаков 3:1) гэсэн байх.

Эдгээр нь бидний хувьд үл тоох юмуу хөнгөн хийсвэр хандаж болохгүй Бичээс юм. Бурхан биднээс “дадал болсон нүглээ гэмшээрэй” гэсэн тушаалд нь хөнгөн хуумгай хандалгүй, хүмүүст заавал заахыг бараг л учирлан гуйжээ. Бурхан үүнийг удирдагч хүний ч төлөө, эрэлчин хүний ч төлөө айлджээ. Бурхан бидэнд хайртай. Гэхдээ Тэрбээр ариун Бурхан учраас, Өөрийнхөө оршихуйд нүглийн мөн чанарыг хэрхэв ч зөвшөөрөхгүй. Тиймээс Бурхан гарц гаргаж өгчээ. Тэрбээр биднийг чөлөөлөх үнийг төлөөд зогсохгүй бас нүглээс ангид, эрх чөлөөтэй амьдрах хүчийн үнийг төлсөн юм. Тиймээс хэрэв бид ийм аугаа авралыг заах ч үгүй, хүлээн авах ч үгүй бол, шүүхээс мултарна гэж ярилтгүй.

Шинэ гэрээний маш тодорхой дуудлагаас гадуур амьдрах тийм үнэ цэнэтэй гэж үү? Шинэ гэрээний төгсгөлийн номын дүгнэлт үг дээр: “Хэн нэгэн нь энэхүү *эш үзүүлэгийн номын үгсээс хасах аваас* Бурхан энэхүү номд бичигдсэн амийн модноос болон ариун хотоос хувийг нь хасах болно” (Илчлэл 22:19) гэдэг. Энэ анхааруулгыг яаж эс хайхрах вэ? Биднээс үнэнийг хайж яваа хүмүүст бид яаж аврагдахын тулд хамгийн түрүүнд жинхэнээсээ гэмших ёстойг хэлж өгөхгүй байх вэ?

Бид өөрийгөө Бурханаас илүү мэднэ гэж бодож байна уу? Бид эрэлчдийг чуулгандаа л ахиж авчрах нь илүү чухал, харин гэмшлийн хувьд - яваандаа өөрөө нүглээ хаяна биз гэж боддог уу? Гэхдээ гэмшлийн залбирлыг хэлэхэд л аврагдаж, шууд “гэр бүлийн” гишүүн болно гэж заалгасан хүмүүс чинь юу гэж хожим гэмших билээ? Тэд чинь хэдийнээ “аврагдаад”, “нигүүлслээр хучигдчихсан” шүү дээ.

Чарльз Жи. Финни бол суут сайн мэдээ дэлгэрүүлэгч хүн. Түүний хүчирхэг үйлчлэлийн нөлөөнд нэг бус удаа бүхэл бүтэн хотууд автаж, нэгэнтээ бүр Нью-Йоркийн Рочестер хот тэр чигээрээ өдөр тутмын бизнесээ зогсоосон гэдэг. Заримдаа тэрбээр Бурханыг хайж байгаа хүмүүст хэдэн шөнө дараалан зөвхөн гэмшил, авралын талаар л номлодог байв. Авралын төлөө залбирч ч эхлээгүй байхад, Финнигийн сургаалыг хэдэн өдөр сандлынхаа ирмэг дээр урагш сунасан сонссон эрэлчид юу юугүй аврагдахад бэлэн өндөлзөн суудаг байжээ. Ингэж хэдэн өдөр номлосныхоо дараа тэрбээр: “Та Христэд итгэмээр байгаа бол, энэ цуглааны дараа манай сонирхогчийн буланд очоорой” гэх маягийн энгийн үг хэлдэг байжээ.

Түүний цуглаанаар мянга мянган хүн аврагдаж, тэдний бараг ерэн хувь нь итгэлдээ үнэнч үлдсэнийг түүх харуулдаг. Өнөөдөр иймэрхүү баримт мэдээ ховор шүү. Финни Шинэ гэрээний сургаалыг баримтлаж, үүнээс илүү арга барил байхгүйг мэдэж байсан учраас ийм аугаа амжилт гаргав!

Нийгэм

Тэгэхээр номынхоо эхэнд хэлсэн нөгөө чухал зүйлс маань одоо ил болж байна. Нүглээ үргэлжлүүлсэн хийсээр байгаа хүнд аврал санал болгох нь чуулгандаа нүглийн хөрөнгө хийж байгаа хэрэг юм. Криптонит Супермэнийг хорлодог шиг, санаатай нүгэл хувь хүн, нийгэм даяар үтэр түргэн тархаж, хороо цацдаг.

Бид нүгэлтэй тулахаас зайлсхийснээрээ, чуулган, нийгмээ доройтуулах бөгөөд үүнээс болж хот, аймаг, улс үндэстэн маань Бурханы алдрыг үзэхгүй. Анхны чуулган Бурханы алдрын хүчээрээ жижиг том хот, бүс нутгийг тэр аяар нь өөрчилдөг байсан. Тэгвэл хорин нэгдүгээр зууны бид яагаад нийгмээ өөрчлөхгүй байна? Бид чинь анхны чуулганыг бодвол, үсрэнгүй хөгжсөн технологитой улс шүү дээ.

Яагаад Америк, Барууны ертөнцөд үр хөндөлт, завхайрал, бэлгийн ёс бус явдал, ижил хүйсийн явдал, хүйсийн самуурал хөгжин цэцэглэж байна? Энэ бүхэн нь нийгмийн хөгжил огт биш юм. Дөрөв, тавдугаар зуунд чуулган хөрөх үед яг ийм хууль ёсгүй байдал хөлжин цэцэглэсэн байдаг. Ромын нийгэмд Христэд итгэх итгэл алдартай болох үед чуулган нийгэмтэйгээ уусч, үр нөлөө нь буурсаар, адагтаа өдгөө бидний мэдэх Харанхуй үе рүү гулсан оржээ.

Би л хувьдаа ийм зүйл дахиж болоосой гэж хүсэхгүй. Надтай санал нийлэх хар мянган удирдагч байгаа гэдгийг ч би мэдэж байна. Бид бүхэл үнэнийг хайр, халуун сэтгэлээр тунхаглахаас буцахгүй.

Алдартай байна уу, алдаргүй байна уу, хүлээн авч байна уу, хүлээн авахгүй байна уу хамаагүй, үнэний уухайтай л нэгдэхээр хатуу шийдээрэй. Амьдрал, нийгэм, хот, улс үндэстнийг өөрчилдөг Бурханы Үгийг тунхагла. Эс бөгөөс хөршөө хайрлахгүй байна гэсэн үг.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Нүглийн үр нөлөөг хаацайлах үүрэг Христийн биед байхгүй. Энэ нь удирдагч нарыг хорлоод зогсохгүй, хүлээн авсан ганц хүнээр дамжин халдвараа дэгдээнэ. Бид нүглийн талаар дуугүй өнгөрснөөрөө хүмүүсийг сүйрэлд хүргэж, харин өөрсдөө тэдний үхлийн төлөөх хариуцлагатан болно.

Сүүлийн өгүүлбэрийг дахин унш. Гэхдээ өөр дээрээ тохоон унш - би нүглийн талаар дуугүй өнгөрбөл, хүмүүсийг сүйрэлд хүргэж, харин өөрөө тэдний үхлийн төлөөх хариуцлагатан болно. Энэ үгийг яс махдаа шингэтэл давтаж хэл. Энэ үнэний жинг зүрхэндээ ч, тархиндаа ч шингээ.

Бурхан энэ тал дээр тантай хариуцлага тооцно. Бид нүглийг өнгөлөн далдалж болохгүй. Энэ үг таны амьдрал дээр хэрхэн тусах бол? Гэрлэлтийн эсвэл аав ээжийн үүргийг чинь хэрхэн өөрчлөх бол? Чуулганыхаа хүмүүстэй тогтоох харилцаа, яриаг чинь хэрхэн өөрчлөх бол? Энэ үнэнээр амьдарна гэж яахыг яс махдаа шингэтэл ойлготлоо эдгээр асуултыг Бурханаас асуу. Тэгээд энэ бүхнийг ажил хэрэг болгох төлөвлөгөө гаргаад, итгэл даасан хүнтэйгээ хуваалцаарай.

ХҮЛЦЭНГҮЙ БАЙДАЛ

Бүгдээрээ амилсан Их Хааныхаа айлтгалыг үзье.

Библийн төгсгөлийн номд Есүс Азийн долоон чуулганд долоон янзын үг айлджээ. Хэрэв Есүс зөвхөн тэдгээр түүхэн чуулганд хандаж өгүүлсэн бол, Түүний үгс Бичээст бичигдэхгүй байх байлаа. Гэтэл Бичээст бичигдсэн гэдэг баримт нь өөрөө энэ үг тухайн түүхэн эздэд ч, өнөөгийн бидэнд ч хамаатай гэсэн үг юм.

Бурханы Үг амьд учраас, бид Есүсийн мэдэгдлийг өнөөгийн бидэнд хандсан айлтгал гэж үзэх ёстой. Тиймээс Эзэний сайшаалаар урам орно уу эсвэл хайрын зэмлэлээр нь сахилгажина уу хамаагүй - үг дуугүй хүлээн зөвшөөрөөд, хэрэгжүүл.

Иезебел гэж хэн бэ?

Энэ удаа бид Туатейр чуулган дээр төвлөрөн ярилцах болно. Есүс Өөрийгөө “Галын дөл адил нүдтэй, өнгөлсөн хүрэл мэт хөлтэй Бурханы Хүү ийнхүү айлдаж байна” (Илчлэл 2:18) гэсээр үгээ нээжээ. Харин бид үүнийг нь Түүний нүд нь хүний зүрхний явдлыг нэвт шувт сүлбэх лазерын туяа мэт, Түүний аугаа хүчийг илтгэсэн хөл нь сайн чанарын хүрэл мэт хэмээн ойлгож болно.

Эзэн үгээ: “Би чиний үйлс, хайр, итгэл, үйлчлэл, тэвчээр болон эцсийн үйл чинь эхнийхээсээ илүү гэдгийг мэднэ” (Илчлэл 2:19) хэмээн сайшаалаар эхлэсэн нь тун таатай. Тэгэхээр, Эзэн үгүй болсон чуулганд бус, харин өдгөө амьд бөгөөд өсч байгаа чуулганд хандаж өгүүлсэн нь тов тодорхой байна.

Эзэн эхлээд бидний хайрыг хүлээн зөвшөөрч, магтан сайшаажээ. Аливаа чуулган юмуу үйлчлэл мөхөхийн өмнө эхлээд тэдний Бурханыг болоод хүмүүсийг хайрлах хайр хөрч, аньдаг. Энэ гаслантай нөхцлөөс өгсүүлээд, эцэстээ зөвт байдлын бусад бүх үр жимс нь үхнэ.

Тиймээс Эзэн хамгийн эхэнд Ефесийн чуулганыг засахдаа, тэднийг чухам хайраа алджээ хэмээн зэмлэсэн байдаг. Гэтэл Туатейрийн хувьд өөр байв. Есүс тэдний хайрыг магтсан. Итгэгчид нь бие биеэ халамжилдаг бөгөөд энэ нь ч Бурханы мэлмийд чухал юм. Иймээс л Есүс итгэл, үйлчлэл, тэвчээр зэрэг өөр бусад зүйлийн талаар ярихаасаа өмнө эхлээд бидний хайрыг сайшаадаг гэж би итгэдэг.

Бусад онцсайн талыг нь тоочбол, тэр чуулган хайр, итгэл, үйлчлэл, тэвчээрээр өсч байв. Үнэхээр мундаг! Тэр итгэгчдийн биеийг “хэвэндээ байх” гэдэг үгээр тодорхойлохгүй. Учир нь тэд амин чухал тал бүрээрээ өсч байв. Мессеж Библи: “Миний төлөө үйлдэж байгаа бүхнийг чинь Би харж байна. Мундаг байна! Хайр, итгэл, үйлчлэл, тууштай чанар. Тийм ээ, эдгээр нь үнэхээр мундаг! Та нар өдөр ирэх тутам үүн дээрээ сайжирсаар байна” хэмээн маш сайхан хэлдэг. Чуулганы ямар ч удирдагч, гишүүн Эзэний амаас ийм үг дуулахыг хүснэ.

Гэтэл гэнэт Эзэний магтаал засвар болон хувирав:

Гэвч Надад чиний эсрэг зүйл байна. Миний зарц нарыг садарлуулан, шүтээнүүдэд өргөсөн юм идэхийг сурган, төөрөлдүүлэхийг өөрийгөө эш үзүүлэгч хэмээн нэрлэдэг Иезебел гэгч эмэгтэйд чи зөвшөөрсөн. (Илчлэл 2:20)

Энэ үгээс сурах юм их бий. Эхлээд *Иезебел* гэдэг нэрийг авч үзье. Энэ нь түүхэн хүний жинхэнэ нэр үү? Ихэнх тайлбарлагч нар үгүй гэдэг. *Шинэ Америк тайлбар: Илчлэл* дээр “Тухайн үеийн Грек - Ромын утга зохиолд Иезебел гэх нэр гардаггүй... нэгдүгээр зуунаас хойшхи эрин зуунуудад Христэд итгэдэг хүн үр хүүхдээ

Иуда гэж нэрлэдэггүйтэй адил эсвэл Еврей хүн үр хүүхдээ Есүс гэж нэрлэдэггүйтэйгээ адил охин хүүхдээ Иезебел гэж нэрлэдэггүй байжээ” гэсэн байдаг. *Нью Ливинг Транслэйшн* Библийн орчуулагч нар энэ бодолтой санаа нэгтэй байсан болтой. Учир нь тэд Есүсийн үгийг “нөгөө Иезебел” гэж хөрвүүлсэн байдаг.

Хүнийг “нөгөө” гэж дуудах нь яг л байнга алиалж, хошигнож явдаг хүнийг “нөгөө алиалагч” гэж ярьдагтай л адил юм. Хамаг учир нь нэрэндээ бус, харин тэдгээр хүмүүсийн тогтсон зан үйлдлийг тодорхойлж буй явдал гэж хэлж болно.

Бид “Иезебел” гэдэг шошготой, нөлөө бүхий, түүхэн эмэгтэйтэй тулж байна гэж хэлж болох ч, энэ нь түүний жинхэнэ нэр биш ажээ. Тэрбээр маш хүчирхэг нөлөөтэй байсан бөгөөд эцэстээ хэсэг бүлэг удирдагч нар түүний сургаалыг өвлөн залгамжилжээ. Өнөө цагийнхаар бол энэ нь иймэрхүү сургаал ухуулдаг эрэгтэй, эмэгтэй нэг хүн юмуу эсвэл хэсэг бүлэг удирдагч нар байж болно. Гэхдээ хамгийн гол аюул нь энэ үйлчлэлийн философи нь чуулганыг бүхлээр нь дайрсанд оршиж байв.

Эзэн яагаад Иезебел гэх болов? Магадгүй, үүний үр жимс нь Хаадын номд гардаг, эртний Израилийн хаан Ахабын хатан Иезебелийнхтэй тун төстэй байсан болтой. Энэ түүхэн хатны талаар ихийг өгүүлж болох ч, Израильд үзүүлсэн нөлөөг нь ерөнхийд нь тоймлон үзье. Иезебел хатан улайрсан шүтээн шүтээгч байсан бөгөөд үүнийх нь урхагаар нийгэмд Эзэний Үг намжиж, ард түмэн мангар тэнэгтээ тултлаа урагш унхиагүй болжээ.

Елиа ард түмэнтэй нүүрэлдэж, Бурханыг дуулгавартай дагах, нүглээ үргэлжлүүлэн хийхийн алийг нь сонгохыг асуух үед Иезебелийн нөлөө маш хүчтэй харагддаг. Елиа энэ бүхнийг Иезебел хатны ивээл дор цалин хөлстэй ажилладаг Баал, Ашерагийн “үйлчлэгч” нарын улаан нүүрэн дээр хийжээ. Тэд бол тухайн үеийнхээ хэвлэл мэдээлэл, тусгай сонирхлын бүлгүүд, хууль санаачлагч нар, хуульчид байв. Ард түмэн цуглаж, Елиа тэдгээр “элитүүдийн” нүүрэн дээр:

Та бүхэн хэдий болтол хоёр замын хооронд тээнэгэлзэх юм бэ? Хэрэв ЭЗЭН л Бурхан мөн юм бол Түүнийг дага. Харин Баал (дадал болсон нүгэл) мөн бол түүнийг дага гэв.
(1Хаад 18:21)

Бурханыг дагах нь зүгээр нэг битүүхэн итгэхээс хавьгүй том зүйл шүү. Бид Түүний Үгийг ярих элч байхаар дуудагдсан. Үүнийг хэрхэн хийх вэ? Паул маш тодорхой хэлжээ:

“Үгийг тунхагла. Цагаа олсон ч, олоогүй ч бэлэн бай. Уужим сэтгэлээр, сургаалаар сэнхрүүл зэмлэ, урамшуул” (2Тимот 4:2). (Тухтай байна уу, тухгүй байна уу, уриалгахан хандаж байна уу, хандахгүй байна уу хамаагүй - Үгийн номлогч та хүмүүст аль талаараа буруу явж байгааг нь харуулах ёстой).

Гэтэл хамаг Израильчуудад бурууг нь харуултлаа хайрлаж чадсан ганц хүн л гарч ирсэн нь Елиа байжээ.

Иезебелийн нөлөө удирдагч нарыг ч, нийгмийг ч айлгасанд, тэд сүрдсэндээ дуугаа хураан гөлийж, Иавэгийн төлөө дуугарахаа больжээ. Нүгэл хүчирхэгжин, Бурханы Үг тоогдохоо болив. Шинэ гэрээний чуулганд ч адилхан үр нөлөө өрнөж эхэлжээ. Гэхдээ Есүс үүнийг зөвшөөрөхгүй. Тиймээс Есүс яг л Елиа шиг дуугарах Иохан гэдэг элчийг олжээ.

Жинхэнэ асуудал

Тэгэхээр бид Есүс “Туатейрийн чуулганы бэлгийн ёс бус явдалтай хутгалдсан эсвэл шүтээнд өргөсөн идээ будааг идсэн гишүүдийн талаар ярьж байна уу?” гэж асуух ёстой. Магадгүй юм. Гэхдээ би л хувьдаа ийм тайлбараас зайлсхийнэ. Учир нь Паул хоёр чуулганд бичихдээ шүтээнд өргөсөн идээ будааг идэх явдлыг яллаагүй байдаг (Ром 14, 1Коринт 10-ыг үзнэ үү). Ариун Сүнсний нөлөөн дор Паулын зөвшөөрсөн явдлыг яагаад Есүс ёрын муу гэж үзэх ёстой гэж? Нэгэн алдартай тайлбар ном дээр “Хүмүүс бэлгийн ёс бус явдалд оролцсон гэж үзэх тухайд, бэлгийн ёс бус явдлыг чуулган хэзээ ч хүлцэн зөвшөөрөхгүй байсан учраас, яг энэ тухай ярьсан гэж үзэх үндэслэлгүй хэмээн цөөнгүй орчуулагч хэлсэн байдаг. Үүний оронд энэ хэсэг нь сүнслэг бөгөөд/эсвэл доктрины итгэмжгүй явдалд хамаатай байж болох” (*Шинэ Америк Тайлбар: Илчлэл*) гэж тайлбарласан байдаг.

За юу ч байлаа гэсэн, ямартаа ч Есүс энэ бүхнийг тоогоогүй. Есүс хамгийн гол нь үйлдэл дээр - за нарийндаа бол ямар ч

үйлдэлгүй байдал дээр хараагаа тавьсан бөгөөд бид ч үүн дээр л анхаарах ёстой. Энэ байдлыг *хүлцэнгүй байдал* гэнэ. Есүс “чи зөвшөөрсөн” гэжээ. Үүнийг Грекээр *еао* гэдэг. Иоханы Илчлэлийн гарын авлага дээр: “Энэ үгийн утгыг “чи зөвшөөрдөг”, “чи боломж олгодог” гэх мэт эерэг утгаар ч илэрхийлж болно эсвэл “чи хориглодоггүй”, “чи таслан зогсоодоггүй”, “чи сэргийлдэггүй” гэх мэт сөрөг утгаар ч илэрхийлж болно” гэдэг.

Сайтар тунгаан бодох юм бол, үнэхээр цочирдмоор үг шүү. Есүс Өөрийнх нь хүмүүсийг шүтээн мөргөл (дадал болсон нүгэл) рүү өдөөн урхиддаг сургаалыг залгамжлуулдаг гэмт этгээдийг буюу энэ тохиолдолд гэмт этгээдүүдийг цохон хэлжээ. Есүс: “Би тэр эмэгтэйд гэмших хугацаа өгсөн. Харин тэр садар үйлсээсээ гэмшихийг хүсэхгүй байна” (Илчлэл 2:21) хэмээн тодорхой айлдсан. Тэгэхээр удаа дараа анхааруулсан боловч, тэр хүмүүс юу ч ойлгоогүй нь тодорхой байна.

Есүс ийм зүйлээ хийсээр байдаг хэнийг ч засна. Өөрөөр хэлбэл асуудалтайгаа тулахын оронд Шинэ гэрээний урамтай, өөдтэй, чимэгтэй хэсгийг л түүж заадаг хүнийг. Үндсэндээ тэд Иезебелийн үеийн хүмүүс шиг амаа үддэг. Үүнийг ийм жишээгээр тайлбарлаж болох юм: Бид бүгдээрээ шатаж байгаа байшинд гацчихсан атлаа юу юугүй дээвэр, хана туургад дарагдаж үхэх гэж байж, өөрөө ч зугтаж гарахыг оролдохгүй, өрөөлийг ч зугтаалгаж туслахгүй, зүгээр л бие биеэ хичнээн ерөөлтэй сайхан улс болохыг магтан сайшааж, хайраа зарласаар сууж байна.

Өөр нэгэн ацан шалаа

Элч Иуда ч дээрхтэй төстэй ацан шалаанд оржээ. Тэрбээр итгэл нэгт нөхдөө авралын гайхамшгийн талаарх урмын сайхан үгээр мялаахыг хүссэн боловч, үнэндээ чадаагүй. Орон гэр нь улаан галаар дүрэлзэж байхад, тэрбээр чуулган руу гэтэх криптониттай тулахаас өөр аргагүй болжээ.

Хайртууд аа, би та нарт бидний хуваалцдаг авралын тухай бичихээр бүх зүтгэлээ гаргаж байхдаа, ариун хүмүүст тушаагдсан итгэлийн төлөө тэмцэхийг ятган бичих

шаардлагатай хэмээн бодлоо. Учир нь шийтгэлд хэдийнээ заагдсан, сүсэг бишрэлгүй хэсэг хүн сэм шургалан орж ирсэн бөгөөд тэд Бурханы маань нигүүлслийг садарлал болгон гажуудуулж, бидний цорын ганц Эзэгнэгч бөгөөд Эзэн Есүс Христийг үгүйсгэдэг. (Иуда 3-4)

Бурханы энэ зарц хайртай хүмүүстээ Христ доторх амьдралын ашиг тус, ерөөл, амлалтын талаар бичихийг хүсчээ. Тэрбээр бусдын л адил өргөж, урамшуулахыг хүссэн.

Битүүний зовлонг ойлгож байна. Би ч бас олонтаа “урамшуулсан” үгийг л бичээд л, заагаад л байх хүсэлтэйгээ мөргөлддөг. Би ч бас өөдрөг байхыг хүсч байна - ер нь хэн хүсэхгүй байх билээ? Гэтэл Ариун Сүнс намайг Бурханы нандин хүүхдүүдийг устгахыг эрэлхийлэгч зүйлсийн талаар хэл хэмээн шахдаг.

Тиймээс Иуда жинхэнэ хайраасаа болж анхааруулгын үгийг бичих шахаанд оржээ. Юу болоод байна аа? Энэ чинь Туатейраас жаахан өөр байх чинь. Пастор, удирдагч, итгэгчийн дүрд хувилсан тэр бурханлаг бус гэмт этгээдүүд нь жинхэнэ “хүчирхэгжүүлэгч нигүүлслийг” заахын оронд “бүхнийг зөвшөөрөгч нигүүлсэл” гээчээ заахаар барахгүй, өөрийнхөө амьдралаар үлгэрлэн харуулдаг. Өөрөөр хэлбэл тэдний заадаг “бүхнийг зөвшөөрөгч нигүүлсэл” нь биднийг криптонитаас хамгаалах юмуу зугтаалгахгүй, харин хязгааргүй бурханлаг бус амьдралаар амьдрахыг зөвшөөрдөг. Ийнхүү бид нигүүлслийг хүчирхэгжүүлэгч хүч гэж үзэхээсээ илүүтэй зүгээр л хучдаг хөнжлийн дайтай болгодог учраас, яваандаа нийгэм бидэнд хэрхэн амьдрахыг маань зааж эхлэнэ. Үндсэндээ сул дорой итгэгч нар нийгмийн соёлыг шүтдэг нүгэлт мөн чанарынхаа хүсэл тааллыг дагаж, өөрийгөө криптонитад мэдрэг болгодог. Гэтэл Бурханы нигүүлсэл ийм байдлыг хүсдэггүй.

Хүмүүс чуулган руу гэтэх хөрөнгийг зүгээр л хараад сууж байгаатай Иуда эвлэрээгүй. Тэрбээр жинхэнэ аав хүн учраас, хүүхдүүдээ Бурханы амиас урхидан холдуулдаг, гуйвсан амьдралын хэв маягаас хамгаалжээ. Есүс Иудаг Туатейрийн удирдагч нарыг зассан шигээ засалгүй, харин сайшаасан байдаг.

Тэгвэл өөр нэгэн халамжтай аав болох Паул мөн л ялгаагүй хуваагдал, тэмцэл, ёс бус явдал, шүүхдэх, шунахайрал зэрэг бурханлаг бус үйлдэл чуулганд байхыг хүлцэн, дуугүй суусангүй.

Паул тэдэнд дэндүү хайртайдаа, биеэр маш хурдтай тархдаг хөрөнгийг бушуухан шиг таслан зайлуулахаар босчээ. Иаков, Петр хоёрын хувьд ч ялгаагүй.

Хэрэв та эртний чуулганы эцгүүдийн үгийг харбал, тэд ч бас энэ дагуу үйлдэн, хүмүүсийн дадал болсон нүгэлтэй Бурханы бичигдсэн, тунхаглагдсан үгээр зэвсэглэн тулдаг байжээ. Тэд ахуй соёлоос хөврөн бий болсон, эрүүл бус санаа, зөвтгөлийн эсрэг чанга дуугарч, шахан зайлуулдаг байв. Соёлын шүтээнийг нураагч тэр удирдагч нарыг Иезебелийн хүчирхийлэл айлган сүрдүүлээгүй.

Чимээгүй байх нь зөвшөөрсний дохио

Чимээгүй байх нь удирдлагын хувьд нэгэн төрлийн аман бус харилцаа юм. Энэ нь зөвшөөрлийг илтгэх бөгөөд “Наадахаа хий, хий” гэсэн утга илэрхийлдэг. Эртний Латин зүйр үгд “Дуугүй өнгөрөх нь зөвшөөрсний дохио. Өнгөрсөн хойно нь халаглаж байхаар боломжтой үед нь дуугарч бай” гэдэг. Амь амьдралыг нь хариуцсан, хайртай хүмүүсийнх нь амьдрал руу криптонит мярааж байхад, эртний чуулганы эцгүүдийн нэг нь ч дуугүй байгаагүй. Тэд хөрөнгө мэт тархах чадвартай, сүйтгэгч, хорон, үхлийн зүйлийг харсан учраас дуугарчээ.

Элч Иохан “...бүх ертөнц нь ёрын нэгэн дор байдгийг мэднэ” (1Иохан 5:19) хэмээн мэдэгдсэн. Нийгэмд байх ёрын муугийн тасралтгүй урсгал дундаас хамгийн аюултай нь *далд ёрын муу* юм. Тийм ээ, сайнаар зүсээ хувиргасан ёрын муу. Энэ мэхлэгч урсгалыг “энэ дэлхийн урсгал” (Ефес 2:2) гэдэг.

Ингэж бодъё: Та голоор сөрж явахын тулд урсгал сөрж сэлүүрдэх ёстой. Бид Бурханы хаанчлалын эсрэг урсдаг *сайны* баг зүүж, зүсээ хувиргасан урсгалтай дэлхий дээр амьдардаг. Хэрэв бид дуугарахгүй бол, энэ нь сэлүүрээ өргөөд, урсгал дагаж хөвөхтэй ижил юм. Бид Христэд итгэдэг царайлсаар, итгэлийн хэлээр ярьсаар, урсгал өөд харсан чигээрээ явсаар байж болох ч, нийгмийнхээ ёс зүйг даган хөвж, үр нөлөөгөө гэээн.

Бид сэлүүрээ өргөснөөрөө, хэцүү бэрх асуудлаас зугтаж болох ч, зугтсан асуудал маань байсан хэвээрээ л үлдэнэ. Эдмунд

Берк: “Сайн хүмүүс юу ч хийгүй байхад л ёрын муу ялна” гэж хэлсэн. Удирдагч хүн дуугүй байхад, итгэгч хүний зүрх, ухаанд нутагласан соёлын шүтээн хүчээ авдаг.

Мэхлэл өсөх тусам, хүлцэж өнгөрөөсөн зүйлс маань эцэстээ биднийг мэдээгүй болгоно. Тийнхүү бид ер бусын хүчийг маань сордог зүйлсийг аялдан дагалдаж, яваандаа түүнтэй нэг тал болно. Бид сөрөг хүчин бус, харин аялдан дагалдагч нар болно. Бид “Христэд итгэдэг” нэртэй боловч, үнэндээ *хүч чадлын элч нар бус*, харин *эргэлзээний төлөөлөгч нар* болно. Тэгээд хүрээлэн байгаа дэлхий маань бидэнд: “Бид танай чуулгануудыг үзлээ, хөгжмийг чинь сонслоо, хайр, нигүүслийн сургаалыг чинь сонслоо. Гэхдээ танай Аугаа хүчирхэг Бурханыг чинь нэг л харахгүй байна” гэж хэлнэ.

Христэд итгэдэг гэх боловч, дэлхийн урсгалтай нэгддэг хүмүүс нь загалмайн дайсан болохыг Паул хатуу мэдэгдсэн. Тийм ээ, дайсан!

Миний та нарт үргэлж ярьж байсан олон хүн Христийн загалмайн дайснууд мэт явдаг гэж би одоо уйлан байж хэлж байна. Тэдний төгсгөл сүйрэл, тэдний бурхан нь ходоод бөгөөд тэд гутамшигт зүйлсээр сайрхдаг. Тэд дэлхийн юмыг л сэтгэдэг. Харин бидний иргэний харьяалал тэнгэрт байгаа бөгөөд тэндээс бид Аврагч Эзэн Есүс Христийг хүлээж байна. (Филиппой 3:18-20)

Дээрх ишлэлийг анхааралтай унш. Нэгдүгээрт - “олон хүн” гэж байна. Хоёрдугаарт - тэд Есүсийг хүлээн зөвшөөрдөг учраас, амаараа дайсан болохоо зарладаггүй ажээ. “Тэд Бурханыг мэднэ гэдэг ч үйлсээрээ Түүнийг үгүйсгэдэг” (Тит 1:16). Тэд бурханлаг дүр төрхөөр зүсээ хувиргавч, зан үйлдлээрээ дайсан болохоо харуулж, махан биеийн дур хүсэл - тачаал, статус, алдар нэр, бэлгийн гаж явдал, хов жив зэргээр жолоодуулдаг.

Паул хүлцээгүй, харин дуугарч, тулсан. Түүний захидлыг уншбал, тэрбээр бурханлаг бус, дэлхийн зан үйлдлийг хичнээн их засч зэмлэж, анхааруулж байхыг харна. Гэхдээ Паулын үзгийн үзүүрээр Бурханы Үг л бичигдсэн болохыг бүү мартаарай.

Бурханы Үгээр шууд тулах нь тэдгээр цайз хэрмийг буулгаж хаях цорын ганц арга зам ажээ. Бичээсээр шууд тулахгүй бол, үүгээрээ итгэгчдийн төдийгүй төөрөгсдийн зүрх, тархин дахь

тэдгээр философийн цайз хэрмийг улам л зузаатган бэхжүүлнэ. Бидний амаа үдсэн байдал криптонитыг саадгүй нэвтрүүлнэ.

Өөр, өөр үр дүн

Есүс эцэст нь чуулганд юу гэж хэлсэн бэ? Зүрх муутай хүн уншилтгүй үгс шүү. Худал сургаалд нэвтэрсэн хүмүүс гэмшихгүй аваас, “маш их гаслан зовлонд” унах ажээ. Энэ нь тэмдэг байх бөгөөд оюун санаа хийгээд зүрхийг Нягтлагч нь Би байгаа юм гэдгийг бүх чуулган мэдэх болно. Би та нарын хүн бүрд үйлсийнх нь дагуу хариу өгнө (Илчлэл 2:22-23-ыг үзнэ үү).

Гэхдээ үүнээс хавьгүй аугаа өөр нэгэн мэдээ байна аа: Есүс айлдахдаа “криптонитын эрхшээлд оролгүй, Түүний Сүнс, Үгээс чанга атгасан хүнд Есүсийн Бурхан Ааваасаа хүлээн авсантай адил үндэстнүүдийг захирах эрх өгөгдөнө” гэжээ. Үр дүн нь нилээд өөр байна: нэг нь муу явдлыг ёрлож, нөгөө нь яндашгүй шагналыг зөгнөж байна. Тэгвэл бид амилсан Хааны амаас шууд гарсан энэ заавар үгийг анхаарахгүй өнгөрч зүрхлэнэ гэж үү?

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Иезебел Бурханы эш үзүүлэгч нарын амыг барихаар барахгүй амийг нь барсан. Тэдэн дундаас нэг л хүн Эзэний төлөө дуугарахаар зүрхэлсэн бөгөөд Бурхан түүний төлөө юу ч хийхэд бэлэн байсныг үз. Бурхан түүнийг хамгаалсан, хангасан, өнөөг хүртэл бишрүүлсэн ер бусын тэмдэг, гайхамшгаар дэмжсэн.

Бурхан босоод үнэнийг хэлэх хүнийг хайж байна. Энэ нь шүүмжилдэг хүн гэсэн үг биш юм. Учир нь бид нүглийн ангууч биш. Гэвч нөгөөтэйгүүр бид хүмүүс биднийг “эсэргүүцэгч, тэвчээргүй” зэргээр элдвээр дуудах вий хэмээн зовнисондоо, айж сүрдэж хэрхэв ч болохгүй.

Хамгийн түрүүнд энэ анхааруулгыг өөрийнхөө амьдралд хүлээж ав. Өмнө хийдэг байсан нүглээсээ ямар ч аргаар хамаагүй чөлөөлөгд. Чөлөөлөгдсөн бол, бусдыг чөлөөлөгдөхөд нь туслахын төлөө ажиллаж, тэдэнд нүглийн аюулыг хичээнгүйлэн анхааруул. Паул: “Та нарын дуулгавар биелэгдэх үед бид бүх дуулгаваргүйг

шийтгэхэд бэлэн байна” (2Коринт 10:6) гэж бичсэн.

Та нүүр тулж чаддаггүй бол, бусадтай нүүр тулахаас өөр аргагүйд хүргэдэг, бусдыг хайрлах хайрыг Бурханаас гуй. Үүнийг өөрийн болгох удаах зорилгоо болго. Тэгвэл дараа нь бусдад ч Бурханы нигүүлслээр ялан гарахад нь туслах чадвартай болно.

ХАЙР БА ҮНЭН

Одоо бид криптонитыг устгахын хамгийн гол зорилго дээр тулж ирлээ. “Криптонитыг устгах гэсэн далд санаа сэдэл маань юу вэ?” Хэрэв бидэнд энэ хүчирхэг хөдөлгүүр нэг бол байхгүй байх юмуу эсвэл дутагдбал, бид нөгөө туйл руу хадуурч, Сайн мэдээ, үйлчлэлийн философийг бүр ч гажуу байдлаар танилцуулдаг болох аюултай. Миний ярьж буй далд сэдэл нь *Бурханы хайр* юм. Паул маш хүчирхэг мэдэгдэл хийжээ:

Бид цаашид хүүхэд байхаа больж, давалгаанд энд тэнд шидэгдэн, аливаа номлолын салхи, хүмүүсийн ов мэх болон зальхай хуйвалдааны башир аргад туугдалгүй, *үнэнийг барьж*, ингэхдээ харин *хайранд*, тэргүүн болох Түүн өөд, Христ өөд бүх талаар өсцгөөе. (Ефес 4:14-15)

Есүсийн Туатейрт хэлсэнтэй адил бас Иуда, Петр, Иохан, Паулын дүрслэсэнтэй адил худал сургаал нь үнэнтэй андуурмаар адилхан харагддаг. Дайсан бидний бодсоноос ч илүү ухаантай шүү. Дайсан Бурханаар хамгаалагдсан, төгс орчинд байгаа Еваг дөнгөж чадсан бол, ийм завхарсан орчинд амьдарч байгаа биднийг

хурууныхаа үзүүрээр л дөнгөх бус уу? Тэгвэл худал сургаалын мэхлэлээс биднийг чухам юу хамгаалах вэ?

Хариулт нь: үнэн хамгаална! Гэхдээ дан үнэн биднийг хамгаалахгүй, харин *хайраар хэлсэн үнэн л* хамгаална. Хайр байхгүй үнэн нь биднийг “хуулийн үсэг” гэдэг замаар уруудуулсаар, адагт нь “*хуульчлалаар*” хөнөөдөг. Энэ нь мэхлэлийг хөхүүлэн дэвэргэсээр, чуулганы эрүүл ухааны амь болсон Бичээсийн анхааруулгыг түрсээр, үгүй хийдэг.

Үзэн ядагч, харгис, муухай хууль биднийг жанчдаг. Тиймээс бид хайр дээр төвлөрч байж л, хуулийн харгислалаас хамгаалагдана. Гэхдээ үнэн байхгүй хайр нь хайр огт биш бөгөөд хулхи хайр юм. Үнэн байхгүй хайр нь ялгаагүй л бурханлаг хайрын дүртэй - эелдэг, энэрэнгүй, зөөлөн, тэвчээртэй байдаг. Гэхдээ энэ бүх чанарыг агуулсан атлаа үнэн байхгүй бол, тэр хайр биднийг мэхлэн төөрүүлнэ шүү.

Бүгдээрээ илэн далангүй ярьцгаая. Бичээсийн зарим үнэн бидэнд хайр байхгүй, хатуу харгис юм шиг санагддаг учраас, бид тэр тухай ярихаас дөлдөг. Гэтэл тэр үг хүмүүсийг бахь байдгаараа байгаад байх биш, харин амьдралынхаа хэв маягийг өөрчлөхийг уриалан ятгадаг. Бид хүмүүсийг гэмшилд дуудах явдлаа зөөлөн сэтгэлгүй, эелдэг зангүй, энэрэл хайргүй явдал гэж боддог. Жишээлбэл, би өндөр хавцлаас хариугүй унаж үхэх гэж яваа сохор хүнтэй таарчээ. Би тэр хүний зорих замд хөндлөнгөөс оролцох нь түрэмгий, сөрөг явдал болно гэж үзээд, осолдож үхэхийг нь зөвшөөрч болно. Хэрэв би тэр хүнийг зогсоохгүй, зөв зүг рүү чиглүүлэхгүй бол, тэр хүн үхнэ. Би тэр хүнийг зөв замд нь оруулалгүй, баахан худлаа өөдрөг үгээр хөөргөөд орхибол, түүний эцсийн хэдэн алхмыг хачин зугаатай болгож болох ч, тэрбээр төд удалгүй хадны ёроолд үхэдхийн хэвтэх болно. Энэ тэгээд жинхэнэ хайр уу?

Манай нийгэмд ч тэр, чуулганы багагүй хувьд ч тэр - ийм жинхэнэ хайрыг үзэн ядсан, тэвчээргүй явдалд тооцдог. Энэ үзэл бодлын цайз хэрэм нь итгэгч хүмүүс амьдралыг өнө мөнхийн үзлээр бус, харин дал наян жилийн үзлээр харсны хар гайгаар бүрэлдэн тогтжээ. Жишээлбэл, хэрэв би “олдож байгаа дээр нь жарга” гэж үздэг бол, найрын ширээн дээр өрсөн амттаныг юу ч бодолгүй, бүгдийг нь нэг дор хусч орхино. Өөрөөр хэлбэл дураараа дургина. Тэгвэл хэрэв би аз жаргалыг арай урт хугацаагаар хардаг

бол, тэр найрын ширээн дээрх идээ будаанд арай өөрөөр хандаж, ганц л амттан идэх юмуу эсвэл огт идэхгүй өнгөрнө. Яагаад гэвэл би маргааш гэхэд гэдэс маань өвдөж, дээрээс нь таргалж, алсдаа эрүүл мэндийн элдэв асуудалтай болохыг хүсэхгүй.

Бид жинхэнэ хайрыг ойлгохын тулд амьдралыг мөнхийн агуулгаар харах ёстой. “Ганц олдсон амьдралдаа жарга” гэдэг үзэлтэй хайр нь хүмүүсийг бахь байдгаар нь хүлээн зөвшөөрч, амьдралаа өөрчлөхөд уриалан дууддаггүй. Өөрөөр хэлбэл өнө мөнхийн нүхэнд унаж үхэхээсээ өмнө амьдралынхаа эцсийн хэдэн алхмыг зугаатай өнгөрөөг гээд орхисонтой л адил юм. Харин өнө мөнхийн үзэлтэй жинхэнэ хайр нь “Би чамд дэндүү хайртайдаа, чамайг үгээр хэлэхийн аргагүй аймшигтай, “үеийн үед өдөр шөнөгүй тарчлах” (Илчлэл 20:10) тамаас аврахын тулд, нэг хэсэг дургүйг чинь хүргэхээс өөр арга алга” гэдэг. Бид “Тэд мөнх шийтгэлд, харин зөвт нь мөнх аминд орох юм” (Матай 25:46) гэж айлдсан Есүсийн үгийг бас “Тэд мөнх сүйрлийн төлөөсийг төлж, Эзэний оршихуй ба Түүний хүчний алдраас сална” (2Тесалоник 1:9) гэсэн Паулын үгийг хайхралгүй өнгөрч чадна гэж үү?

Үүрд мөнх гэдэг нь мөнхийн мөнх гэсэн үг бөгөөд үүнийг өөрөөр дүрслэх арга байхгүй. Үгээр дүрслэхийн аргагүй тэр тамлал, зовиур, шийтгэл нь хэзээ ч дуусашгүй юм. Гэхдээ энэ бүхнээс илүүтэй Эзэний оршихуйгаас бүр мөсөн цөлөгдөнө гэдэг л хамгийн аймшигтай юм. Энэ цөллөг нь нөгөө ертөнцөд л болох явдал бус, мөн энэ амьдралд ч тохиолдох боломжтой явдал юм. Энэ талаар би тун удахгүй ярина.

Бурхан тамыг хүмүүсийн төлөө бус, харин “Диавол болоод түүний тэнгэрэлч” (Матай 25:41) нарт зориулсан юм. Сатан хүн төрөлхтөнийг мэхлэж, биднийг өөрийнхөө гараар өөрийгөө хоригдол болгоход хүргэжээ. Гэтэл Есүс биднийг дэндүү хайрласандаа, энэ бүх ялаас суллахаар ирсэн юм. Есүс тийм аугаа авралын ажлыг гүйцэтгэчихээд байхад, бид ийм аймшигтай хувь тавилангаас зугтаалгах Есүсийн арга замыг үл ойшоож зүрхлэнэ гэж үү?

Нөгөө найрын ширээнийхээ дүрслэл рүү эргэж орё. Идээ амттанаас ганц нэг хүртэх юмуу эсвэл огт хүртэхгүй суух нь олны дургүйцлийг төрүүлж болох. Хүмүүс: “Алив, ид л дээ Жон. Наадах шиг чинь сайхан амттан үгүй. Амсаад л аз жаргалтай болно. Амьдралын сайн сайхныг эдлэ л дээ” гэж хэлж болох.

Гэхдээ энэ мэт үг уран залжин үг нь үнэнээс хол бөгөөд намайг хөл алдуулах аюултай. Энэ бүхэн нь “амьдралын сайн сайхан” гэхээсээ илүү “ганц өдрийн л жаргал” юм. Үнэндээ би араа бодож амьдарснаараа л, амьдралын жинхэнэ сайн сайхныг эдлэнэ. Тэгвэл Бурханы хаанчлалын тал дээр ч ялгаагүй юм.

Паул юуны төлөө чулуугаар нүүлгүүлж, таван удаагийн тохиолдлоор гучин есөн удаа ташуурдуулж, гурвантаа саваагаар жанчуулж, өдөр шөнөгүй дайсандаа нүд үзүүрлэгдэн зовох гэх мэт үй түмэн зовлонг сайн дураараа амссан гэж бодож байна? Нэр алдар олж, конференцийн алдартай номлогч болж, хүмүүсийг татаж, нэртэй зохиолч болох гэсэндээ тэр үү? Үгүй. Паул Бурханы хайрын улмаас л энэ бүхнийг хийхэд хүрчээ. Тэрбээр бүхнийг өнө мөнхийн үзлээр харж, айдасгүйгээр хайрлажээ. Паул үнэнийг хөсөрдүүлээд, алдар руу тэмүүлж зүрхлээгүй. Учир нь тэрбээр Христ рүү дагуулахаар илгээгдсэн хүмүүсээ хайрладаг байв.

Жинхэнэ хайр гэж юу вэ?

“Бурхан бол хайр” (1Иохан 4:8). Түүнд зүгээр л хайр байдаг бус, харин Тэр Өөрөө хайрын амин мөн чанар *болой*. Тэгэхээр бид энэ хайрыг хэрхэн тодорхойлох вэ?

Саяхан намайг залбирч байтал, Эзэн зүрхэнд минь: “Хүү минь, Миний хүмүүс хайрын цөм рүү нэвтрэхгүй, өнгөн хэсэг дээр нь л төвлөрөх юм” гэж айлдсан юм.

Тэгтэл хайр тэвчээртэй, эелдэг, бардам биш, бүдүүлэг биш, өөрийнхөөрөө шаарддаггүй зэрэг 1Коринт дээр болон Библи даяар байдаг хайрын тухай дүрслэлүүд санаанд буув. Дараа нь Ариун Сүнс надад хүн жаахан хүүхдэд эрэгтэй, эмэгтэй хүний ялгааг зааж өгөхдөө, яадгийг харуулав. “Хэрэв бид: “Эмэгтэй хүн хоёр хөлтэй, хоёр нүдтэй, хамартай, амтай, хоёр шуутай, хоёр гартай, хоёр хөлтэй” гэж зааж өгбөл, энэ оновчтой дүрслэл болж чадах уу?”

Энэ нь маш ерөнхий дүрслэл учраас, хүүхэд эрэгтэй хүн дээр гүйж очоод: “Энэ эмэгтэй хүн” гэж хэлж болно. Та хүүхдэд эрэгтэй, эмэгтэй хүний гол ялгааг хэлж өгөөгүй учраас, ийм явдал тохиолдох боломжтой. Та: “Эрэгтэй, эмэгтэй хүний гол ялгаа нь...” гэж ирээд л хэлж өгөөгүй ажээ.

Тэгвэл дэлхийн хайр ч ялгаагүй бүдүүлэг биш, тэвчээрэй, эелдэг бөгөөд олон талаараа Бурханы хайртай төстэй байдаг. Гэхдээ Бурханы хайрыг дэлхийн хайраас ялгадаг туйлын ганц ялгаа нь: “Бурханыг хайрлах нь Түүний тушаалуудыг сахих явдал юм” (1Иохан 5:3) гэсэн үгд бий.

Хайрын элч гэдгээрээ алдартай Иохан энэ үгээ мөн хоёр дахь захидалдаа ч хэлжээ:

“Түүний тушаалын дагуу явах нь хайр юм” (2Иохан 6).

Энэ хайр нь 1Коринт дээр хэлсэн элч Паулын “хайрын” тодорхойлолтоос арай өөр байна. Иохан хайрын дүрслэлийг хэлээгүй, харин Бурханы хайрыг бусад бүх төрлийн хайраас ялгаж өгдөг, үндсэн тодорхойлолтыг нь хэлжээ. Жинхэнэ хайр нь Есүсийн тушаалыг сахих явдал ажээ. Үүнийг сүүлчийн зоог дээр Эзэн ч тодорхой айлдсан:

“Миний тушаалуудыг хүлээн авч сахигч нь Намайг хайрлагч мөн.” (Иохан 14:21)

Тиймээс хэрэв би атаархуу биш, бүдүүлэг биш, сайрхуу биш, хурц биш, эелдэг, тэвчээртэй, зөөлөн зантай атлаа зогсоо зайгүй гэргийгээ араар нь тавьж, татвараа төлдөггүй бол, Бурханы хайр дотор алхахгүй байна гэсэн үг юм.

Хэрэв би атаархуу биш, бүдүүлэг биш, сайрхуу биш, хурц биш, эелдэг, тэвчээртэй, зөөлөн зантай атлаа өнөөдөр олон улсын төр засгууд хүлээн зөвшөөрч, дэмжихэд хүрсэн ижил хүйсийн явдал мэтийн бэлгийн гаж явдлыг үйлддэг бол, Бурханы хайр дотор алхахгүй байна гэсэн үг юм.

Би хэрэг дээрээ мэхлэгдэж, Бурханаас хол байгаагаа мэддэг, бүдүүлэг, атаархуу, сайрхуу, хурц зантай хүнээс ч илүү аюултай байдалд оржээ. Би хоосон “гэмшлийн залбирал” хэлсэн атлаа, хийж дадсан нүглээ хэзээ ч жинхэнээсээ гэмшээгүй бөгөөд Бурханыг өөрийнхөө талд байгаа хэмээн эндүү боджээ.

Одоо би маш чухал нэгэн зүйлийг хэлье: “Би аврагдахын тулд Бурханы тушаалыг сахидаг бус, харин аврагдсан учраас, Түүний хайр миний дотор оршдог учраас, би тэдгээрийн дотор алхдаг. Дуулгавартай байна гэдэг нь би зүрх, амьдралаа Бурханд өгсний гэрч юм.

Дахин хэлье. Үнэндээ Бурханы Үгтэй шууд зөрчилдөж байгаа бүх төрлийн хайр нь мөнх настай хайр бус, зуурдын хайр юм. Энэ

хайр нь хүмүүст сайхан мэдрэмж төрүүлж, тэр бүү хэл бусдын төлөө золиос гаргаж, бусдыг хүлээн зөвшөөрч, угтан авч болох ч, энэ бүхэн нь мөнх биш юм. Энэ хайр мөнхийн амьдрал руу хөтлөхгүй, нэг л өдөр хадан хавцлаас галтай гав руу унагана.

Тэгвэл яагаад маш зөв мэт энэ хайр зуурдынх байдаг вэ? Адам, Ева хоёр сайн, мууг мэдүүлэгч мэдлэгийн модны үр жимсийг өөрсдийг нь ухаантай болгох, сайн зүйл гэж үзжээ.

Тэгээд тэр эмэгтэйг харгал уг мод нь хүнсэнд *сайн*, нүд булаам, *ухаан тэлмээр*, хорхой хүрмээр сайхан харагдсан тул... (Эхлэл 3:6)

Евагийн энэ эхлэл бодол яваандаа “*Яагаад хайрын Бурхан биднээс “сайн” зүйлийг нуудаг билээ? Шал утгагүй юм*” гэсэн бодолд хүргэжээ. Тэгээд Ева Бурханы зөвлөгөөнөөс гадуурх “сайн сайхан”, “цэц ухааныг” өөрийн болгохыг сонгожээ. Бид яагаад гэдгийг мэдэхийг хүсдэг. Гэхдээ шулуухан хэлэхэд: Бурхан биднийг цаад учрыг нь ойлгохгүй байлаа ч гэсэн, үгэнд нь ороосой гэж хүсдэг. Бурхан биднийг сайн сайхны дүртэй зарим юмсаас хол яваарай гэж хэлэх үед, бид Түүнийг бидэнд хайртайдаа л ингэж хэлж байна гэдэгт итгэдэг үү? Бид Түүний зан чанарт итгэдэг үү эсвэл Еденд байсан хос шиг өөртөө юу нь сайн болохыг Бурханд заадаг шүүгч зан гаргадаг уу?

Бурхан цаад учрыг нь тайлбарлалгүйгээр, үгээ шууд зарлигдсан жишээ олон байдаг ч, энэ удаа би ганц жишээ л дурдъя. Бурхан яагаад Хуучин гэрээний нэгэн эш үзүүлэгчид: “Чи талх ч идэж, ус ч ууж болохгүй, тэр ч бүү хэл ирсэн замаараа ч буцаж явж болохгүй” (1Хаад 13:9) хэмээн тушаасны цаад учрыг тайлаад өгөх хүнтэй би өнөө хэр учраагүй л явна. Гэтэл тэр эш үзүүлэгч Бурханы нэг их гэм хоргүй гэмээр тушаалыг зөрчөөд, үүнийхээ гороор үхсэн юм.

Шулуухан хэлэхэд, жинхэнэ хайр нь заримдаа бидний мэдэх хайраас тэс өөр харагддаг. Паул яагаад Коринтын чуулганд: “Би та нарын сүнсний төлөө ихэд баяртайгаар зарж үрэх бөгөөд өөрийгөө ч гэсэн үрэх болно. Хэрэв би та нарыг илүү хайрлавал өөрөө бага хайрлагдах уу?” (2Коринт 12:15) гэж хэлсэн гэж бодож байна? Тэр хүмүүс Паулыг өөрсдөд нь хайргүй гэж бодсон нь шал утгагүй! Тэд Паулыг өөрсдийг нь захиргаадахыг хүсдэг, өөртөө

эрдсэн, хуульчлагч удирдагч мэтээр үзсэн нь Паулын хариултаас тодорхой харагдаж байна. Магадгүй тэд Паулыг бүр туйлшрагч ч гэж үзэхдээ тулсан байх. Гэхдээ энэ шал худлаа байв. Паул тэднийг дэлхийн хайраар бус, харин мөнхийн хайраар хайрлажээ. Паулын үнэнээр нүүрэлдэж, анхааруулж, гэмшилд дуудсан явдал нь тэр хүмүүст хайр биш юм шиг харагджээ. Гэхдээ Паулын үг Бурханы жинхэнэ хайрыг агуулдаг.

Хайр дотор үнэнийг ярих

Энэ бүхнийг хэлсэн болохоор одоо жинхэнэ хайрыг эргэн харцгаая. Жинхэнэ хайрыг ингэж дүрслэжээ:

Хайр тэвчээртэй.
 Хайр эелдэг.
 Хайр атаархуу биш.
 Хайр сайрхуу биш.
 Хайр бардам биш.
 Хайр бүдүүлэг биш.
 Хайр өөрийнхөөрөө шаарддаггүй.
 Хайр хурц биш.
 Хайр бурууг санадаггүй.
 Хайр шударга бусад баясдаггүй.
 Хайр хэзээ ч бууж өгдөггүй.
Түүний тушаалыг сахих нь хайр мөн.

Бид үнэнийг ярих атлаа эелдэг бус, тэвчээргүй, атаархуу, сайрхуу, бардам, бүдүүлэг, өөрийнхөөрөө шаарддаг, цочмог, бүх бурууг санадаг, уучилдаггүй, шударга бусад баярладаг, хүмүүсийн тал дээр амархан бууж өгдөг бол, Бурханы тушаалыг сахихгүй байна гэсэн үг. Тиймээс бид Есүс Христ доторх гэмшил, итгэлийг номлож болох ч, жинхэнэ хайр дотор ажиллахгүй байгаа хэрэг. Бид хүмүүсийг Бурхан руу дагуулахын оронд, хуульчлал руу хазайж, тэднийг гэмтгэнэ.

Нэг удаа нэгэн залуу надтай уулзаад: “Би тан шиг, Христийн биеийг засах дуудлагатай!” гэж хэлсэн юм.

Түүнийг тэгж хэлэхэд, сэдэл нь тэс өөр газар тэнэж явааг би мэдрэв. Тэгтэл Ариун Сүнс намайг түүнд: “Жинхэнэ эш үзүүллэйн үйлчлэл яаж ажилладгийг мэдмээр байна уу?” гэж хэл гэлээ.

Залуугийн нүд нь гялалзаж ирээд л, тэр даруй: “Мэдмээр байна” гэж хариулав.

- “Чи ямарваа нэгэн засвар, анхааруулга хэлэхдээ, зүрх чинь сонсогч хүмүүсээ хайрлах хайраар бадарч байх ёстой!”

Залуу хэсэг нам болсноо: “Пөөх, Бурханд ч миний дотор хийх ажил их байна даа” гэж хэлэв.

Тэгэхээр нь би түүнд: “Чамаар бахархаж байна. Даруу хүн л ингэж хэлж чадна. Чи бодсоноосоо ч илүү ойрхон байна. Зүрх чинь зөөлөн юм” гэж хэлсэн юм.

Хайр өөрийгөө бус, бусдыг л боддог. Иймдээ ч хэнийг ч хадан хавцлаас унаж үхэхийг зөвшөөрөхгүй. Энэ хайр IКоринт дээр тоочсон бүх зөөлөн чанарыг агуулдаг боловч, үүнийхээ сацуу Аврагч, Бурханы маань тушаалыг хэзээ ч хөсөрдүүлдэггүй.

Хайр амин чухал зүйл бөгөөд амьдралын үндэс юм. Зүрхээ Бурханаар, хайраар дүүргэхийн төлөө залбираарай. Тийнхүү та өөртөө бус, бусдад анхаардаг болно. Энэ хайрыг Ариун Сүнс л зүрхэнд маань дүүргэдэг. Бурханы амийг өгдөг энэ хайрыг гүнтэй нь, урттай нь, өргөнтэй нь гуйгаарай.

Зүрхийг чинь тэнгэрлэг, мөнхийн хайраараа дүүргэж өгөхийг Бурханаас ахин дахин гуйгаарай.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бид чуулган руу гэтэх нүглийн өөдөөс дуугарах ёстой - гэхдээ хайраар дуугарах ёстой. Эс бөгөөс зорьсон үр дүн маань гарахгүй. Бурхан бидэнд нүгэл бүү үйлдээрэй хэмээн Библи даяар анхааруулсаар байтал, бид үйлдэж л орхисон. Тийм боловч, Бурхан биднийг хайрласандаа илүү том алхам үйлдэн, тэр бүх нүглийн төлөөсийг төлүүлэхээр Хүүгээ илгээсэн билээ.

Бид хүмүүст нүглийг анхааруулахдаа, яг л ийм хайраар хандах ёстой. Харин ийм хайрыг өгдөг цорын ганц эх ундарга нь Бурхан болой. Бурхан бол хайр. Хайраар өсмөөр байвал, Бурхантай тогтоох харилцаагаа хөгжүүл.

Бурханыг эрэн хайж, Түүнтэй тогтмол уулзаж, Түүний хайраар дүүрэх нь үгээр илэрхийлэшгүй чухал юм. Хайраар дүүрэн хүн алив асуудалтай ямар ч айдасгүй нүүр тулдаг. Тийнхүү бид эргэн тойрныхоо хүмүүсийн төлөө сайн сайхныг үйлдэхээс гадна шаардлагатай үед нь анхааруулж сурна. Бурханы хайр биднийг чөлөөлж, тэр эрх чөлөөг бусдад түгээх чадвартай болгодог. Өнөөдөр Бурхан таныг хайраараа дүүргэхийн төлөө чин сэтгэлээсээ залбирах цаг гаргаарай. Битгий амархан бууж өгөөрэй.

КРИПТОНИТЫГ УСТГАХ НЬ

Итгэгч хүмүүс үндсэн гурван янзаар нүгэлд ханддаг.

Нэгдүгээрт - хатуу зүрхнийхээ улмаас нүглийг үл хайхардаг хүмүүс байна. Тэд Бурханы зүрхийг эмтлэдэг. Бурхан тэдний талаар: “Үйлдсэн энэ жигшүүрээсээ болж тэд ичсэн үү? Огт ичээгүйгээр барахгүй ичиж улайхыг ч хүртэл эс мэдэх ажээ” (Иеремиа 8:12) гэдэг. Тэд дуусан дуустлаа ухамсраа үл хайхарна.

Хоёрдугаарт - хүн төрөлхтөн угаасаа нүгэлт мөн чанартай учраас, Есүсийн хүчирхэг цус биднийг ялаас чөлөөлсөн ч, нүглийн хүлээсээс чөлөөлөөгүй гэдэг худалд итгэх бөх зүрхтэй хүмүүс байна. Тэд ч бас ялгаагүй аюултай нөхцөлд байгаа юм. Тэд өөсдийгөө Христийн дотор ариун болсон учраас, ариунаар амьдраад байх шаардлагагүй гэдэг худалд бат итгэнэ. Яг ийм худал сургаалыг Туатейрийн чуулганд заадаг байжээ. Паул:

Тэгвэл бид юу гэх вэ? Нигүүлсэл ихэсгэх гээд бид нүгэлдээ байсаар байх уу? Огт үгүй! Нүгэлд үхсэн бид цаашид түүн дотроо яахин амьдрах билээ? (Ром 6:1-2) гэж бичихдээ, яг ийм сэтгэлгээний тухай хэлжээ.

Энэ хоёр үзэгдэл нь итгэгч хүнийг ч, итгэгчдийн нийгмийг ч доройтуулдаг, дадал болсон илт нүгэл болох криптонит гэдгийг бид тодорхой сурсан. Эдгээрийг үйлдэгч нь “нүгэлд орсон” хүмүүс юм. Тэд Шүүх өдөр Есүсээс: “Надаас зайл” (Матай 7:20-23) гэдэг үгийг сонсоно.

Гуравдугаарт - нүглээсээ чөлөөлөгдөхийн төлөө тэмцэж байгаа хүмүүс байна. Тэд болихыг хүсэв ч, чанга атганд оржээ. Тэд Бурханы үгээр чөлөөлөгдөх арга ухаанаа хараахан олоогүй л явна. Тэд нүгэл үйлдэв ч, Бурханы хайрыг санаад, зүрх эмтрэн уйлна. Тэд жинхэнээсээ гэмшдэг ч, хэсэг хугацааны дараа дахиад л нүгэлдээ унана. Тэд нүглээс гадна нүглийнхээ ял, ичгүүрт улам чанга боомилуулах ажээ. Тэд нүглийнхээ ичгүүрт барьцаалагджээ.

Хэрэв та энэ гурав дахь бүлэгт хамрагдаж байгаа бол, намайг сонс. Есүс: “Болгоомжтой бай! Хэрэв ах дүү чинь нүгэл үйлдвэл, түүнийг зэмлэ. Хэрэв тэр гэмшвэл, түүнийг уучил. Хэрэв тэр чиний эсрэг өдөрт долоон удаа нүгэл үйлдчихээд, чам дээр долоон удаа эргэн ирж, “Би гэмшиж байна” гэвэл түүнийг уучил” (Лук 17:3-4) хэмээн айлдсан. Тэнгэрийн Аав маань биднийг ахин дахин уучилдаг учраас л, Эзэнтэн маань биднийг Аавыгаа дууриан, өдөр бүр нүгэл үйлдэв ч, ахин дахин үнэн голоосоо гэмшдэг хүнийг уучлахыг айлджээ (Ефес 4:32-ыг үзнэ үү). Хэрэв та хэдэнтээ нүгэл үйлдэв ч, тэгэх тоолондоо сэтгэл эмтрэн, үнэн голоосоо гэмшиж, Бурхан руу чин сэтгэлээсээ очбол, уучлагдаж, Есүсийн цус таныг хэзээ ч нүгэл үйлдээгүй мэт цэвэрлэнэ. Тиймээс өөрийгөө бүү шийтгэ. Өөрийгөө шийтгэх нь Есүсийн цусыг үнэгүйдүүлж, хүний үйлсээр зөвтгөлд хүрэх гэсэн оролдлого болж хувирна. Ингэх аваас, та хэзээ ч аврагдаж, уучлагдаж чадахгүй. Уучлал нь Бурханы нигүүлслийн бэлэг юм.

Би энэ бүлгээрээ чухам энэ гуравдугаар үзэгдлийн талаар ярьж, Бурханы Үгээр чөлөөлөгдсөн түүхээсээ хуваалцмаар байна.

Боол явсан минь

Намайг арван хоёртой байхад, найзууд маань намайг порно сэтгүүлтэй танилцуулсан юм. Яваандаа бид янз бүрийн сэтгүүл солилцсоор, тун удалгүй би порнод оров. Анхандаа хөнгөн порно үздэг байснаа, сүүлдээ хатуу материалд шилжсэн юм. Үүнээс

болж толгой доторх сексийн төсөөлөл маань жолоогоо алдав. Би ахлах сургуульд байхдаа, ангидаа сууж байгаад л охидтой бодолдоо унтдаг байв. Сексийн тачаал намайг амьдаар минь залгиж байлаа.

Би арван ес хүрээд, хуурай ахан дүүсийнхээ байранд байхдаа, амьдралаа Есүст өгсөн юм. Тэгэхэд архидан согтуурах, хэрүүл хараал тавих, охидтой зохисгүй харилцах, бүдүүлэг зан авир гэх зэрэг маш олон бурханлаг бус үйлдэл, нүгэл тэр даруй хүчээ алдан сарнисан боловч, порно л ганцаараа бөх хэвээрээ үлдэв. Порно намайг хүлчихсэн байсан болохоор, би зүгээр л салаад явчихаж чадсангүй. Тэгээд нүгэл үйлдэх тоолондоо бушуухан гэмшиж, Бурханаас үнэн голоосоо уучлал эрдэг байв.

Аврагдаагүй байхдаа би хүсэл төрөө л бол, шууд порно нүгэлд умбадаг байсан бол, аврагдсаныхаа дараа хатуухан тулаанд орсон юм. Порно нь бурханлаг зан авиртай сөргөлдсөн зүйл гэдгийг би ойлгож, байдгаараа эсэргүүцдэг байсан ч, тэр хүчний өмнө хүчин мөхөсддөг байлаа.

Би 1982 онд буюу хорин хоёр насандаа Лизатай гэрлэхдээ, мөрөөдлийнхөө охинтой гэрлэсэн учраас, тачаал маань сарнина гэж найдаж байсан ч, сарних нь бүү хэл, улам дордов. Миний ойр хавьцаа порно байвал, би яг л соронзонд татагдах төмөр мэт шууд татагддаг байлаа. Энэ байдал Лиза бид хоёрын харилцааны бүх эд эсэд нөлөөлөв - ор дэрний явдалд ч, ойр дотно харилцаанд ч.

1983 онд би Бурханд үйлчилж эхлэсэн ч, порнотой зөрчилдсөөр л байлаа. Гэхдээ нөгөө талаас энэ маш буруу зүйл гэдэг итгэл үнэмшил маань ч бэхжиж байв. Би чуулганыхаа пасторын гэр бүлийг бас чуулганд ирсэн зочин номлогчдыг халамжлах үүрэгтэй байлаа. Манай чуулган Америкийн хамгийн алдартай чуулганы нэг байсан учраас, маш олон нэр хүндтэй пастор, номлогч нар айлчилна. Тэдний дунд чөлөөлөлтийн үйлчлэлээрээ алдартай нэг хүн байв. Тэрбээр Азид овоо хэдэн жил амьдрахдаа, хүмүүс Бурханы гайхамшгаар харын хүч, чөтгөрүүдээс хэрхэн чөлөөлөгдөж байгааг биеэр үзсэн бөгөөд тэдгээр нь ч үнэхээрийн гайхамшигтай түүх байв. Бурхан түүнийг үнэхээр гайхам арга замаар ажиллуулжээ. Тэр хүнийг Лестер Сумрал гэнэ.

1984 оны намар Лестер Сумрал манай чуулганд дөрвөн өдрийн семинар хийхээр ирж, би түүнд үйлчлэв. Би түүнийг урьд урьдын айлчлалаас нь нилээд сайн мэддэг болсон байлаа. Тэгээд нэг

удаа түүнийг машинаар зөөж явахдаа, хоёулхнаа байсан сайхан боломжийг ашиглан, хамаг зовлонгоо үнэн голоосоо тоочив! Лестер яг л итгэлийн жинхэнэ эцэг хүн шиг шулуухан ярьдаг хүн байлаа. Тэрбээр миний үг бүрийг чих тавин сонсож байлаа. Би ярьж дуусаад, хамгийн сүүлд нь түүнээс: “Миний төлөө залбирч өгөөч!” хэмээн чин сэтгэлээсээ гуйв.

Лестер миний төлөө час хийсэн залбирал хэлсэн боловч, харамсалтай нь юу ч өөрчлөгдсөнгүй. Ирэх долоо хоног, саруудад нь би бахь байдгаараа л байлдсаар байв.

Есөн сарын дараа би нэг найзынхаа байранд тусгайлан мацаг барьж, залбирав. Гэтэл мацгийн дөрөв дэхь өдөр буюу 1985 оны 5-аар сарын 6-ны өдөр гүн залбирч байхдаа, би тачаалын сүнсээс бүр мөсөн чөлөөлөгдсөн юм. Би тэр өдрийг хэзээ ч мартахгүй. Би чөлөөгдөж, урьд өмнө хэзээ ч үзээгүй эрх мэдлийг хүлээн авав. Тийнхүү тэр өдрөөс хойш өнөөдрийг хүртэл би эрх чөлөөтэй байгаадаа, Бурхандаа талархдаг.

Яагаад дараа нь?

Хэдэн жил эрх чөлөөтэй явсны дараа намайг нэгэн яншаа асуулт хоргоож эхлэсэн бөгөөд би энэ талаар Эзэнээс асуув: “Аав аа, би Бурханы аугаа хүн Лестерийн өмнө өөрийгөө даруу болгосон. Түүний үйлчлэлээр олон хүн чөлөөлөгдсөн байдаг. Гэтэл би яагаад түүний залбирлаар чөлөөлөгдөлгүй, есөн сарын дараа чөлөөлөгдсөн юм бэ?”

Тэгтэл Эзэн надад тэр үеийн амьдралыг минь харуулж эхлэв. 1984 оны намар Лестерийг номлохоор ирэх үед би өглөө бүр дор хаяж цаг гучин минут залбирдаг байв. Үнэндээ олон жил ингэж залбирсан юм. Би өглөө 5 цагт сэрээд, 5.30 гэхэд гадагшаа гараад, 7 цаг хүртэл залбирна. Тэр үеийн миний хамгийн хүчтэй залбирал бол: “Бурхан минь, намайг олон хүнийг Есүс рүү дагуулахад, олон хүнийг эдгээхэд, олон хүнийг чөлөөлөхөд ашиглаач! Аав аа, намайг Есүсийн төлөө улс үндэстэнд хүрэхэд ашиглаач!” гэдэг залбирал байв. Би үүнийг өдөр бүр ахин дахин залбирч, үйлчлэлд гарч, хэний ч хааж дийлэхгүй хаалгыг нээхийн төлөө гуйдаг байв. Энэ бол миний чин сэтгэлийн залбирал байв!

Тэр намрын нэгэн өглөө би нөгөө олон сар, жилээр хэлсэн залбирлаа залбираад яг сайхан халж байтал, Ариун Сүнс надтай яриад: “Хүү минь, чи үй олон хүнийг Есүс дээр авчирч, чөлөөлж, өвчтэйг эдгээсэн ч, өөрөө мөнхийн тамд орж болно” гэж хэлэв.

Би гайхлаа. *Ийм юм байж болно гэж үү? Энэ үнэхээр Ариун Сүнсний дуу хоолой мөн үү?* Би сонссон зүйлдээ жаахан сэжигтэй хандаад байж байтал, Бурхан дахин чимээгүй байдлаа эвдэн, ингэж хэлэв: “Хүү минь, Иуда Намайг дагахын төлөө бүхнийг орхисон, Иуда Сайн мэдээг номлосон, Миний нэрээр өвчтэйг эдгээсэн, Миний нэрээр хүмүүсийг чөлөөлсөн. Гэхдээ тэр одоо тамд байгаа.”

Би Католик чуулганд өссөн бөгөөд дахин төрөөд тавхан жил болж байсан учраас, одоо ярих гэж байгаа зүйлийнхээ талаар огт мэддэггүй байв. Би дээрх үгийг сонсоод хамаг байдгаараа салганан чичирч, үг ч дуугарахаасаа айв. Би мэл гайхаж, цэл хөхрөөд байсан ч, ямар ч байсан Бурхан ярьж байгааг мэдэж байлаа. Би Түүний оршихуйд эмээн зогсов.

Тэгж тэгж зүрх ороод, Бурханаас эмээн байж: “Тэгвэл би юуг хамгийн түрүүнд хайх ёстой вэ? Юу нь хамгийн чухал вэ?” гэж асуулаа.

Тэгтэл: “Намайг дотно таньж мэд” гэхийг маш тод сонсов.

Энэ уулзалтаас хойш би Библийг хувьчлан судлаж байхдаа, Бурханыг таньж мэдэх нь Давид, Мосе, Паул тэргүүтэй амьдралаа сайн дуусгасан хүмүүсийн амин хүслэн байсныг олж мэдсэн юм. Паул:

Тэр ч байтугай, би Христ Есүс Эзэнээ танин мэдэхүйн хосгүй давуу талын төлөө бүх юмсыг хохирол болгон үздэг. Би Түүний төлөө бүх юмсын хохирлыг амсаж, тэдгээрийг хог гэж үздэг нь Христийг олохын тулд (Филиппой 3:8) хэмээн мэдэгдсэн буюу.

Тэрбээр Есүсийг л мэдэхийн төлөө амьдарсан бөгөөд энэ мэдлэгээс л түүний аугаа үйлчлэл төржээ. Гэтэл би Есүсийг мэдэхээсээ илүү үйлчлэлтэй л хөөцөлдөж байв. Тийнхүү тэр өдрөөс хойш бүх юм өөрчлөгдсөн юм.

Одоо би өглөө бүр: “Эзэн минь, би Таныг хэнээс ч илүү таньж мэдмээр байна. Би танд хэнээс ч илүү таалагдаж амьдармаар

байна. Надад зүрхээ илчилж, Танд юу хамгийн чухал болохыг хэлээч. Надад арга замаа зааж өгөөч. Амьдрал минь Таныг баясгах болтугай” гэж залбирдаг болсон.

Би өглөө бүр залбирдаг хэвээрээ боловч, миний чин зүрхний залбирал ийм л үгтэй болсон юм. Тухайн үед би юу болсныг мэдээгүй боловч, Бурхан хожим надад харуулж билээ.

Тийнхүү “Лестер Сумрал миний төлөө залбирах үед би яагаад чөлөөлөгдөөгүй юм бэ?” гэдэг залбирлын хариулт орж ирэв. Тэгтэл дараа нь Бурхан надтай яриад: “Чи тачаалын нүглээсээ болж Миний дуудсан үйлчлэлээс тасрах вий гэдгээс айсандаа л Сайн мэдээ дэлгэрүүлэгчид нээгдсэн. Чи нүглээсээ болж үйлчлэлд тэнцэхгүй байх вий гэж айсан. Чи өөрийнхөө төлөө л шаналсан бөгөөд харин энэ чинь дэлхийн шаналал байв” гэсэн юм.

Тэгээд үргэлжлүүлэн: “Гэтэл есөн сарын дараа чи үйлдэж байгаа нүглээрээ Намайг өвтгөж байгаагаа ойлгоод, сэтгэл чинь өвдөж, Намайг дотно таньж мэдэхийн төлөө орь дуу тавьсан. Чиний нүгэл Намайг алуулахад хүргэснийг чи ухаарч, Намайг загалмайд хадуулахад хүргэсэн тэр юмсыг үзэн ядсан. Тэгээд чи Миний төлөө шаналсан бөгөөд харин энэ чинь бурханлаг шаналал байв” гэсэн юм.

Паул Коринтын чуулганд:

“Харин одоо би та нарыг гашуудуулсандаа бус, гашуудал чинь гэмшилд хүргэж, та нар Бурханы дагуу гашуудсанд чинь баярлаж байна. Ингэснээр та нар биднээс болж ямар нэг байдлаар зовоогүй билээ. Бурханы дагуух гашуудал нь авралд хүргэдэг гэмшлийг бий болгодог. Харин *ертөнцийн гашуудал* үхлийг бий болгодог” (2Коринт 7:9-10) гэжээ.

Энэ ишлэлд байгаа “аврал” буюу “сотериа” хэмээх Грек үг нь дахин төрөх авралыг илэрхийлэхээс гадна мөн “аюул, сүйрлээс хамгаалагдах, аюулгүй байдал, чөлөөлөлт, хамгаалалт” гэсэн утгыг илэрхийлэх ажээ (WSNTDICT). Энэ тодорхойлолтод байгаа “чөлөөлөлт” гэдэг үгийг аваад, дээрх ишлэлд орлуулж үзье: “Бурханы дагуух гашуудал нь *чөлөөлөлтөд* хүргэх гэмшлийг бүтээдэг.” Би бурханлагаар гашуудсан учраас, чөлөөлөгджээ.

Хоёр гашуудал

Дэлхийн гашуудал, бурханлаг гашуудал гэсэн хоёр төрлийн гашуудал байна. Эдгээрийг хэрхэн тодорхойлох вэ? Саул, Давид гэдэг хоёр хааны жишээ үүнийг тодорхой дүрслэн харуулдаг. Саул Амалекуудын асуудал дээр Бурханд дуулгаваргүй авирласныг бид өмнө үзсэн. Саултай эш үзүүлэгч Самуел нүүрэлдэхэд, Саул хүмүүсийг буруутгаж эхлэсэн бөгөөд эш үзүүлэгч түүнийг ахин дахин зэмлэсний эцэст тэрбээр: “Би нүгэл үйлджээ” хэмээн буруугаа хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэвч Саул улайсныхаа араас шууд л: “... одоо миний ард олны ахмадууд ба Израилийн өмнө намайг хүндэлж, надтай хамт буцаж, Бурхан ЭЗЭНд мөргүүлж өгнө үү?” (1Самуел 15:30) гэж хэлсэн байдаг. Саулын гэмшил нь өөр дээрээ л төвлөрч байжээ. Самуел Саулыг ард олон, удирдагч нарынх нь нүүрэн дээр ичээсэн байв.

Нөгөөтэйгүүр Давид хаан бүр ч аймшигтай нүгэл үйлджээ. Давид хүний гэргийтэй завхайраад, нүглээ нуухын тулд нөхрийг нь хороох ажлыг зохион байгуулсан байдаг. Гэтэл эш үзүүлэгч Натан мөн л ялгаагүй удирдагч нарынх нь өмнө Давидтай нүүрэлдэж, нүглийг нь илчилжээ. Тэр үед Давид хөсөр унаад: “Би ЭЗЭНий эсрэг нүгэл үйлдлээ” (2Самуел 12:13) гэж хэлжээ.

Саул: “Би нүгэл үйлджээ” гэж хэлсэн. Давид: “Би ЭЗЭНий эсрэг нүгэл үйлдлээ” гэж хэлсэн. Үүнд ялгаа бий. Давид Өөрийнхөө хайртай Нэгэний зүрхийг өвтгөсөндөө шаналжээ. Тэрбээр Саул шиг өөрийнхөө төлөө гашуудаагүй. Давид Эзэний өмнө шөнөжин хэвтэж, долоон өдөр мацаг барьснаас нь үүнийг харж болно. Тэрбээр Бурханы эсрэг үйлдсэн хэрэгтээ үнэн голоосоо харуусахдаа:

Таны, зөвхөн Таны эсрэг би нүгэл үйлдэж, Таны мэлмийд ёрын мууг хийлээ (Дуулал 51:4) хэмээн хашхирсан байдаг.

Дэлхийн гашуудал нь: Миний нүглээс болж ямар үр дүн гарах бол? Би шүүгдэх болов уу? Би тэнцэхгүй болов уу? Би зовох болов уу? Хүмүүс намайг юу гэх бол? гэх мэтчилэн өөр дээрээ л төвлөрдөг. Тэгвэл бурханлаг гашуудал нь Есүс дээр төвлөрдөг: Би хайртай Эзэнээ гомдоочихлоо. Тиймээс Тэр юу ч гэж шийдсэн

бай - Түүний шүүх шударга бөгөөд би Түүний нигүүлслийн өмнө сөгдөнө гэдэг.

Зугтах

Ийнхүү би чөлөөлөгдсөн болохоор, одоо оюун санаагаа шинэчлэх хэрэгтэй болов. 1985 оны 5-аар сараас өмнө миний ойр орчимд порно байх л юм бол, би шууд л дайрдаг байв. Тэгвэл одоо эсэргүүцэх нь байтугай бүр зугтах хүчтэй болов. Гэхдээ ганган хувцастай, гунхсан хүүхэн хажуугаар өнгөрбөл, бодлынхоо жолоог алдчихгүйн тулд би харц буруулдаг байлаа. Гэтэл энэ нь бидэнд өгсөн Есүсийн бүрэн эрх чөлөө биш байв. Өөрөөр хэлбэл чөлөөлөлт маань гүйцээгүй байжээ.

Чөлөөлөгдөх, чөлөөтэй байхын хооронд ялгаа бий. Би таван сарын зургаанд чөлөөлөгдсөн боловч, Есүс “Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө (чөлөөтэй байлгана)” (Иохан 8:32) хэмээн айлдсан байдаг. Бидний зорилго нь чөлөөтэй байх бөгөөд үүний тулд үнэнийг мэдэх хэрэгтэй.

Цаг хугацаа өнгөрөх тусам, би Бурханы Үг дотор амьдарч, яваандаа би эмэгтэй хүнийг Эзэний нүдээр харж эхлэв. Тэгээд эмэгтэйчүүд бол нэн түрүүнд хэн нэг хүний охин үр гэдгийг зүрхээрээ ухаарах үед анхны жинтэй өөрчлөлт бий болсон юм. Энэ нь мэдээжийн ойлголт боловч, миний хувьд зүрхний ухаарал шиг л тусав. Эмэгтэй хүн бүр аль нэг аав ээжийн жаахан охин болохыг Ариун Сүнс надад харуулсан юм. Тэд миний чөлөөлөгдөхөөсөө өмнө хардаг байсан шиг зүгээр нэг нүцгэн бие биш ажээ.

Хэсэг хугацааны дараа зүрхэнд минь бүр ч том илчлэл орж ирэв. Эмэгтэй хүмүүс Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн бөгөөд Бурхан тэднийг алдар, хүндэтгэлийн титмээр гоёсныг би ойлгов (Эхлэл 1:26-27, Дуулал 8:5-ыг үзнэ үү). Энэ ч бас гайхалтай шинэ мэдээлэл шиг санагдахгүй байж болох ч, миний хувьд амьдралыг маань амин голоос минь үндсээр нь өөрчилсөн илчлэл байсан юм.

Одоо би порно харахаараа эвгүйцдэг! Тийм ээ, нэгэн цагт дурладаг байсан зүйл минь одоо намайг эвгүйцүүлдэг болов. Одоо миний хажуугаар хөөрхөн бүсгүй өнгөрбөл, би чөлөөлөгдсөнийхээ дараа үйлддэг байсан шигээ харц буруулдаггүй. Би түүний нүд рүү бохир бодолгүй, цэвэр санаа сэтгэлээр хараад, халуун дулаанаар:

“Сайн уу?” гэж мэндэлж чаддаг болсон.

Би Есүс Христийн хүчийг харсан хүн. Христэд итгэдэг ихэнх хүмүүс нигүүлслийг аврал, нүглийн уучлал, хязгааргүй бэлэг гэж үзэхээс цаашгүй байдгийг би мэднэ. Тийм ээ, Бурханы нигүүлсэл нь үнэхээр аврал, уучлал, бэлэг мөнөөс мөн. Гэхдээ үүнээс гадна Бурханы нигүүлсэл биднийг өөрчлөгдөх бас үнэний дуудлагыг үйлдэх хүчтэй болгодог.

Есүсийн үнэ төлбөргүй бэлэг биднийг *нүглийн мөнхийн шийтгэлээс чөлөөлсөн* атлаа *нүглийн хүлээсээс чөлөөлөх хүчгүй* гэдэгт та итгэх үү? Би л лав итгэхгүй.

Учир нь би үүнийг багтай мэднэ. Би Түүний амьдрал өөрчлөгч нигүүлслийг өөрийн биеэр үзэж, чөлөөлөгдсөн. Тэр намайг чөлөөлсөнд би гүнээ талархаж явдаг бөгөөд бас Таны төлөө ч үйлдэж чадах зүйлсийнх нь төлөө талархана! Энэ бүхэн нь зугаалга бус, харин тулаан шиг байсан. Би шүдээ зууж, шатан залбирсан. Та ч бас тэгэх л байх. Гэхдээ Бурханы нигүүлсэл хайр биднийг хөсөрдүүлдэггүй учраас, та амжилтад хүрэхдээ л хүрнэ гэдэг нь хамгийн сайхан мэдээ юм. Тиймээс нигүүлслээс салалгүй, эрх чөлөөтэй бай.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бурхан таны Аврагч. Түүнээс өөр аврагч байхгүй. Таныг “таван алхмын хөтөлбөр”, хүний хүчин зүтгэл, дүрэм журмын жагсаалт нүглээс чөлөөлөхгүй. Гэхдээ энэ нь биднийг гараа хумхиад сууж байхад, Бурхан ирээд чөлөөлөөд өгнө гэсэн үг биш юм. Бурхан таныг чөлөөлнө. Гэхдээ Түүнийг дагахын тулд үйлдэл шаардагдана. Та тэнгэрийн Аавыгаа зөв сэдлээр дагаж - таньж мэдэж, Түүнийг ашиглах санаагүй байвал, чөлөөлөгдөнө.

Тиймээс “Таны хувьд чөлөөлөгдөх нь хэр чухал вэ?” Та Бурханыг эрэн хайх цаг гаргах уу? Шаардлагатай тохиолдолд ухралт хийх үү? Бурханы оршихуйг олон олтлоо, амлалтыг нь аван автлаа хашхирсаар байх уу? Бурханаар харилцааныхаа зорилгыг гаргуулах уу? Хүссэн амьдралд чинь саад хийж байгаа учраас бус, харин Бурхантай тогтоох харилцаанд чинь саад хийж байгаа учраас, нүглээс татгалзаж чадах уу? Өөрийгөө даруусган, найдвартай, бурханлаг удирдагч нараар өөрийнхөө төлөө залбируулж, тэдний үгийг сонсох уу?

Боолчлолынхоо төлөөсийг тооц. Гэхдээ бас эрх чөлөөнийхөө ч төлөөсийг тооц. Тэгээд Бурханы араас бүх зүрхээрээ яв. Тэр тантай ойр дотно танилцахаар хүлээж байна!

НҮГЭЛ БИШ НҮГЭЛ

Энэ гарчгийг үзээд, гайхаж байна уу?

Бид шүтээн мөргөлийн нэг талыг хараахан судлаагүй байгаа бөгөөд үүнийг нүгэл биш нүгэл гэж хэлж болно. Криптонитыг нэг мөр устгахын тулд бид үүнийг тоохгүй өнгөрч болохгүй. Учир нь үүнийг тодорхойлох хамгийн хэцүү байдаг. Тэгэхээр эхлээд нэгэн сургаалт үлгэр үзье.

Нэгэн өдөр нэг хүн Есүст Бурханы хаанчлалын найранд оролцох ямар сайхан байх бол гэж хэлжээ. Есүс түүний үгээр дамжуулан гүн гүнзгий үнэнийг дүрслэжээ. “Нэгэн хүн их зоог бэлдэж, олон хүн урьжээ. Тэгээд зоог барих цаг болоход уригдсан хүмүүст боолоо илгээн «Зоог бэлэн болов. Морилон ирцгээнэ үү» гэж хэлүүлжээ. Гэтэл уригдсан хүмүүс бүгдээрээ л шалтаг хэлж эхлэв. Эхнийх нь «Би газар худалдаж авсан тул явж, түүнийг үзэх хэрэгтэй байна. Намайг уучлаарай» гэжээ” (Лук 14:16-18). Энэ сургаалт үлгэрийг “шалтаг тоочих үлгэр” гэж нэрлэж болох.

Та ийм байдалд орж байсан уу? Хэн нэгнээс тусламж гуйх, үдэшлэг, оройн зоогт урих, ажил үүргээ гүйцэтгэхийг шаардах, ойр зуурын юмд туслуулах зэрэг ямар нэг юм гуйх үед хариуд нь хөгийн шалтаг хэлдэг. Шалтаг юуг илэрхийлнэ вэ? Тэр хүнд таны

хүсэлтээс илүү чухал ажил байна гэсэн үг. Үндсэндээ: “Миний ажил чиний ажлаас чухал” гэсэн үг.

Есүсийн ярьснаас үзбэл, гэрийн эзэн хүмүүсийг зүгээр нэг зайдастай талх, хавчуургатай талх, төмс, шорлогтой нөхөрлөлд уриагүй ажээ. Гэрийн эзэн нүсэр найр наадам хийж, зочдоо ерөөхийг хүсчээ. Урилгаа хэвлэж, тамгалж, урьмаар байгаа зочиддоо илгээсэн боловч, хүн бүр ямар нэг шалтаг хэлсэн байна. “Эхнийх нь: “Би газар худалдаж авсан тул явж, түүнийг үзэх хэрэгтэй байна. Намайг уучлаарай” гэжээ” (Лук 14:18).

Тэгэхээр нэг чухал асуулт байна: Талбай худалдаж авах нь нүгэл үү? Мэдээж үгүй. Хэрэв тийм бол, өдий хүртэл хэд хэдэн газар худалдаж авсан би гэдэг хүн том асуудалд орох нь байна. Гэхдээ газар худалдаж авах нь Эзэний Үгээс илүү чухал болбол, энэ нь нүгэл болно. Өөрөөр хэлбэл “нүгэл биш нүгэл” болох буюу шүтээн мөргөл - криптонит болно.

Дараагийн хүнийг харъя: “Нөгөө нэг нь: «Би арван үхэр худалдаж авсан юм. Тэднийг үзэхээр явлаа. Уучлахыг гуйя» (Лук 14:19) гэжээ.

Тэгэхээр үхэр худалдаж авах нь нүгэл үү? Эсвэл бизнестээ зориулж тоног төхөөрөмж худалдаж авах нь нүгэл үү? Мэдээж үгүй. Би ч бас амьдралдаа бизнесийн янз бүрийн тоног төхөөрөмж худалдаж авч л байлаа. Тийм боловч юм худалдаж авах нь Эзэний Үгээс илүү чухал болбол, тэр нь нүгэл болно. Өөрөөр хэлбэл “нүгэл биш нүгэл” болох буюу нарийндаа бол шүтээн мөргөл - криптонит болно.

Урилга хүлээж авсан сүүлийн хүнийг харъя:

... нөгөө нэг нь: «Би эхнэр авсан. Ийм учраас би очиж чадахгүй» гэжээ. (Лук 14:20)

Эцэст нь: “Эхнэр авах нь нүгэл үү?” гэж асууя. Тийм бол, над мэтийн олон эр асуудалд орох нь байна. Эхнэр авах нь мэдээж нүгэл биш. Гэхдээ эхнэр нь Бурханы Үгээс чухал болоод ирбэл, энэ нь “нүгэл биш нүгэл” буюу шүтээн мөргөл - криптонит болно.

Миний бодлоор энэ бүх түүхийн сургамж - санаа нь маш тодорхой байна: Бид хэн нэг хүн, юм, үйл ажлыг Эзэний Үгээс дээгүүр тавьбал, тэр нь нүгэл болох ажээ.

Миний криптонит илчлэгдэв

Би Пердю Их Сургуулийн хоёрдугаар дамжаанд сурч байхдаа, Есүст дурласан юм. 1981 онд би ахан дүүсийн нөхөрлөлд байхдаа, Есүсийг Эзэнээ болгож, тэр цагаас хойш Түүний төлөө дүрэлзэв!

Хэдэн сарын дараа Пердюгийн хөл бөмбөгийн улирал эхлэв. Энэ үед би гуравдугаар дамжаанд ороод байлаа. Нэг, хоёрдугаар дамжаандаа би нэг ч тоглолт алгасалгүй үзсэн ч, одоо миний хувьд Есүсээс чухал зүйл байхгүй болсон учраас, би тоглолтын завсарлагыг хүртэл ашиглан Библиэ судлаж байв. Хуурай ахан дүүс маань тоглолт үзэхээр явчихсан учраас, байр маань эзгүй байлаа. Энэ нь ч надад Бурхантай нөхөрлөж, залбирах хосгүй боломж олгосон юм. Тэр үед надад хэн ч тоглолт үзэхийг хориглоогүй эсвэл би өөрөө тоглолт үзэх нь буруу гэж бодоогүй. Би зүгээр л Бурхантай хамт байж, Түүнийг таньж мэдэхийг юу юунаас илүү хүсч, хамаг ухаан санаа маань үүн дээр л төвлөрч байсан учраас, би тоглолт үзэлгүй, Есүстэй нөхөрлөсөн юм. Гэхдээ дөрөвдүгээр дамжаандаа би олон тоглолт үзсэн.

Пердюг төгсөөд би Даллас рүү нүүж, хэдэн сарын дараа чуулганы ажилтан болов. Үйлчлэлийн цар хүрээ, нөлөөллөөсөө болоод чуулган маань дөрвөн зуун ажилтантай байлаа.

Тэр үед Үндэсний Хөлбөмбөгийн Лигийг өнгөлж байсан багийн нэг нь Далласын Ковбойууд байв. Би Мичиганд өссөн учраас, тэдний тоодоггүй байлаа. Гэтэл Даваа гариг бүр цуглааны ажилчид Ковбойчуудын талаар ярихыг сонсдог болов. Тэд урьд өдрийн тоглолт - статистик, онцгой довтолгоо тэгээд мэдээж хасагдах шатны тоглолтод тэнцэх багуудын зургийг хэлэлцэнэ.

Тэгээд би ч зурагтаар Ковбойчуудыг үздэг болж, яваандаа улам шимтэн хорхойсов. Үүний ачаар би чуулганыхаа ажилчидтай ярих юмтай болсон учраас, энэ маань надад давхар ашигтай байсан юм.

Энэ бүхэн эхлээд нэг их гэм хоргүй, гэнэн цайлган сонирхол шиг л байв. Гэхдээ цаг хугацаа өнгөрөх тусам, миний сонирхол улам лавширч, би тоглолт алгасахаа болилоо. Бүр улайрах шинждээ орж, уухайлан дэмжиж, заримдаа тоглогч нар руу хашхичих зэргээр зурагттайгаа ярьдаг болов. Яваандаа би тэдний бүх

тоглолтыг хором алдалгүй, бүтэн үздэг болов. Тоглолтгүй үеэр ч би ажилчидтайгаа Ковбойчуудын ирээдүй, ирэх жилийн гялалзсан амжилтын талаар хөөрөлдөнө. Эцэстээ би Ковбойчуудын талаар ажилчидтайгаа ярилцаагүй, ганцаараа байх үедээ ч зогсоо зайгүй боддог болов. Би тэдний улаан фэн болжээ.

Тоглолтын шинэ улирал эхлэхэд над шиг баяссан хүн байсангүй. Бүтэн сайн болгон цуглааны дараа би гэртээ чавхдаж хариад, хувцсаа ч солилгүй зурагтаа асаана. Заримдаа бүр бие засмаар байсан ч, зангиа хослолоо ч тайлалгүй, хавчигнаж байгаад үзнэ. Тоглолт алгасах талаар ярихын ч хэрэггүй.

Тэгээд завсарлагаанаар л өрөөндөө орж, хувцсаа солино. Лизад тусламж хэрэгтэй болбол, “Хонгор минь, наана чинь Ковбойчууд тоглож байна!” гээд ёстой зангүй. Манайх тоглолтын завсарлагаанаар эсвэл тоглолт дууссаны дараа л хоолоо иддэг байв.

Би Ковбойчуудын статистикийг цээжилдэг боллоо. Тэгээд дүн шинжилгээ хийгээд, явал сайжирч болохыг эргэцүүлнэ. Ажил дээрх Ковбойчуудын талаарх яриаг би удирддаг болов. “Тэр бас тэр тамирчин сайхан тоглосон!” хэмээн сайрхана. Яриа маань ганц Даваа гаригт биш, долоо хоногийн турш өрнөдөг болов. Чуулганыхан маань тоглолтын урилга өгбөл, би шууд л хүлээж авна.

Гүйлгээд, жилийн дараах үйл явдал дээр очъё. Энэ явдал болохоос өмнө би Бурханд хандан тун энгийн нэгэн залбирал хэлсэн бөгөөд тэр залбирал маань миний амьдралыг орвонгоор нь өөрчлөх юм чинээ санаагүй билээ. Би: “Эзэн минь, Та миний зүрхийг ариусгаач. Би Тан руу тусгаарлагдсан байхыг, ариун байхыг хүсч байна. Тиймээс Танд таалагдахгүй зүйл амьдралд маань байвал, илчилж зайлуулаач” гэж залбирсан юм. Ингэхдээ энэ залбирлынхаа гүнийг ч, цаанаас нь юу илчлэгдэхийг ч мэдээгүй билээ.

Хөл бөмбөгийн улирал төгсөж, хасагдах шатны тоглолтууд ойртсоор, шийдвэрлэх тоглолтын өдөр ирэв. Ковбойчууд Филадельфийн бүргэдүүдтэй тоглов. Ялагч нь шалгарч, ялагдагч нь хасагдах байв. Би буйдан дээр суулгүй, зурагтынхаа өмнө босоогоороо дэлгэцдээ наалдсан байлаа. Тоглолт маш өрсөлдөөнтэй өрнөж байсан учраас, суухтай манатай л байв. Дөрөвдүгээр хагас дуусахад найман минут дутуу байтал, Ковбойчууд маань дөрвөн оноогоор хожигдож, хамгийн мундаг

хамгаалагч нь багаа ёстой л алж байв. Би урагш хойш холхиж, муу тоглохоор нь хашхичиж, сайн тоглохоор нь дэвхцэж, ганцаараа галзуу хүн шиг л авирлаж байлаа.

Тэгтэл юу юугүй гэнэт л Ариун Сүнс намайг залбирахыг шивэгнэв. Миний дотор гэнэт л “Залбир, залбир, залбир” гэсэн жинтэй ятгалга бууж, зүрх маань хүнд жинд дарагдав. Бурханы Ариун Сүнс хүнийг Бурханы өмнө очиж, залбирахыг хүссэн үед ийм ятгалга төрдгийг би мэднэ.

Лиза байгаагүй учраас, би чангаар: “Эзэн минь, тоглолт дуусахад наймхан минут үлдээд байна. Дуусгаад залбирья!” гэлээ. Гэтэл ятгалга намайг тавьсангүй.

Хэдэн минут өнгөрлөө. Би ч амар заяа үзэхийг хүсч: “Эзэн минь, тоглолт дуусмагц би таван цаг залбирья! Зургаахан минут өгчих!” хэмээн санаа алдлаа.

Баг маань талбайн доод хэсэг рүү бөмбөгөө нүүлгэж байлаа. Тийм боловч залбирах ятгалга намайг орхих нь бүү хэл, улам л ширүүсэв. Би урам хугарлаа. Тоглоомоосоо холдохыг үнэхээр хүссэнгүй. Тэгээд чангаар: “Эзэн минь, Та хүсээд байгаа юм бол, би тоглолтын дараа өдөржин, хүсбэл бүр шөнөжин залбирья!” гэж чангаар хэллээ.

Тоглолт дуусав. Ковбойчууд ялж, цэнгэлдэх тэр аяараа доргиж байв. Би ч бас тэдэнтэй хамт зурагтынхаа өмнө доргиж байлаа. Гэхдээ би Бурханд амлчихсан байв. Тэгээд тэр даруй зурагтаа унтраагаад, дээшээ ажлынхаа өрөөнд ороод, хаалгаа хаагаад, хивсэн дээрээ суугаад, залбирлаа. Гэтэл мөнөөх залбирах ятгалга замхарч, ямар ч жин, ямар ч мэдрэмжгүй, хов хоосон оргив.

Би ч идэвхижих гэж хичээлээ. Залбирах гэж хичээсэн ч, үг маань хоосон хонгио шиг л байв. Тэгээд би юу болсныг даруй ухаарав. Би Бурханы хүсэлтийг Ковбойчуудын тоглолтоор сольчихжээ. Би Түүний хүсэлтээс өөрийнхөө *дэмий шалтгийг* дээгүүр тавьжээ.

Тэгээд би нүүрээрээ хивс шааж унаад: “Бурхан минь, хэрэв хүн надаас “Чамд хэн чухал вэ? Бурхан уу, ковбойчууд уу?” гэж асуусан бол, би хором ч эргэлзэлгүй: “Бурхан!” гэж хариулах байсан. Гэхдээ би сая хэн нь илүү чухал болохыг харуулчихлаа. Би танд хэрэгтэй байсан. Гэтэл би Таныг биш, хөлбөмбөгөө сонгосон. Намайг өршөөгөөч!” хэмээн уйлсан юм.

Гэтэл Бурхан тэр даруй миний зүрхэнд: “Хүү минь, Надад чиний таван цагийн залбирал хэрэггүй. Би чамайг Миний үгэнд ороосой л гэж хүсч байна” гэж хэлэв.

Амьдралын аль ч талбар

Энэ төрлийн шүтээн мөргөл амьдралын аль ч хэсэгт тохиолдож болно. Барагцаалбал тэр үеэр юм даа. Нэг өглөө би өглөөнийхөө цайг уухаар хамгийн дуртай овъёосоо аягалав. Би өглөөнийхөө цайнд овъёос идэх дуртай! Гэтэл тэр өглөө Бурхан надад: “Өнөөдөр чи өглөөнийхөө цайн дээр мацаг барь!” гэх нь сонсдов.

Би овъёос руугаа харлаа - арааны шүлс асгармаар сайхан харагдана. Тэгээд: “Эзэн минь, би дараагийн долоо хоногт гурван өдөр мацаг барья” гэлээ. Энэ маань бас л Бурханы хүссэн зүйлийг хийхгүй байх, *хоосон шалтаг* байв. Гэтэл би хоолыг шүтээн болгоод байсныг Эзэн надад харуулжээ. Би хоол хүнсийг Бурханы оршихуй, Үгээс хүчтэй хүсч байсандаа, Бурхантай уулзаж учрах үнэт завшаанаа алджээ.

Яг үүнтэй адилхан хожим гольф миний амьдралын эзэн болох үед Ариун Сүнс надад гольфийнхаа бүх тоноглолыг өөр нэгэн пасторт (түүний гольф хэрээс хэтрээгүй байв) өгөхийг хэлсэн юм.

Түүнээс хойш цохиур барилгүй жил хагас өнгөрөв. Гэтэл нэг өдөр Эзэн нэгэн мэргэжлийн тамирчинд хэдэн мянган долларын үнэтэй гольфийн эд хэрэгслээ надад өгөхийг хэлжээ. Би ч үүнийг нь сонсоод цочирдов. Хэдэн сарын дараа өөр нэг пастор надад: “Бурхан ингэж хэлсэн юм аа!” гэсээр үнэтэй цайтай гольфийн тоноглолоо бэлэглэв. Би бүр ч алмайрав!

Хожим би ганцаараа байхдаа Эзэнээс: “Би энэ олон хэрэгслээр чинь яах ёстой болж байна аа?” гэж асуулаа.

Гэтэл Эзэн надад: “Тогло!” гэв.

-“Гэхдээ Та чинь намайг жил хагасын өмнө хамаг юмаа хүнд өг гээд өгүүлээ биз дээ?”

Гэтэл Бурхан надад: “Чи одоо гольфт ухаанаа өгөхөө больсон. Тиймээс эрүүл мэндийнхээ төлөө ч, зугаа цэнгэлийнхээ төлөө ч тоглож болно” гэсэн юм.

Би түүнээс хойш өнөөг хүртэл гольф тоглосоор байна. Бурхан

энэ тоглоомыг миний хувьд амарч, сэргэх сайхан завшаан болгож өгснөөс гадна төөрөгсдийг аврах, хөвгүүдтэйгээ, удирдагч нартайгаа, үйлчлэлийнхээ түншүүдтэй нөхөрлөх талбар болгосон юм. Үнэндээ манай Мессенжер цомын тэмцээнээр дамжуулан гольф тоглодог найз нөхөд, түншүүд маань Мессенжер Интернэйшнэл байгууллагын илгээлтийн үйлчлэлд таван сая гаруй доллар хандивласан билээ. Хэрэв би гольфийг амьдралаасаа тасдаад хаячихсан бол, хэзээ ч ийм юм болохгүй байв.

Миний амьдралд ийм л “нүгэл биш нүглүүд” байжээ. Бид бизнес, үйлчлэл, спорт, харилцаа, дуртай юмс, тэр бүү хэл амьдралын онц чухал тал дээр ч ийм алдаа гаргаж болох. Эдгээр юмс, үйл ажиллагаа, харилцаа, байр суурийн жагсаалт дуусашгүй.

Бурхан биднийг амьдралын сайн сайхныг эдлээсэй гэж хүсдэг. Үнэндээ Паул энэ талаар:

биднийг баясгах бүхнээр арвин хангагч Бурханд найд...
(1Тимот 6:17) хэмээн маш гайхамшигтай үг хэлжээ.

Бурхан биднийг Өөрийнх нь хүртээсэн гайхамшигтай ерөөлийг эдлээсэй гэж хүсдэг. Бурхан биднийг бүрэн дүүрэн амьдраасай гэж хүсдэг. Гэхдээ үүнийхээ хажуугаар биднээс ганц л зүйл шаарддаг - Түүнийг амьдралынхаа тэргүүнд тавихыг! Өөрөөр хэлбэл бид Бурханыг, Бурханы хүслийг бүх цаг, газар, үйл ажлаасаа дээгүүр тавих ёстой.

Үүнд хоосон шалтаг байтугай, сайн шалтаг ч тоочих эрх байхгүй!

Найраас бүү хоцор

Есүсийн сургаалт үлгэрийн дүгнэлтийг үзье. Бид найранд уригдсан боловч, шалтаг тоочоод, ирээгүй гурван хүний талаар сурсан. Гэтэл дараа нь ийм явдал болжээ:

Боол нь буцаж ирээд үүнийг эзэндээ хэлэв. Тэгтэл өрхийн тэргүүлэгч хилэгнэн, боолдоо «Даруй гарч, хотын чөлөө, гудамжаар явж ядуу, тахир дутуу, сохор болон хазгар доголон

хүмүүсийг нааш авчир!» гэв. Боол нь «Эзэнтэн, тушаасныг тань ёсоор болгосон хэдий ч сул суудал байсаар л байна» гэхэд эзэн нь боолдоо «Зам, хашаа хавиар яв. Гэрийг минь дүүрэн байлгахын тулд хүмүүсийг албадан авчир. Би та нарт хэлье, уригдсан байсан нөгөө хүмүүсээс нэг нь ч миний зоогноос амсахгүй» гэжээ гэв. (Лук 14:21-24)

Энэ бүхэн нь мэдээж энэ дэлхийн төгсгөл дээр Бурхан Аавын Хүүдээ зориулж хийх найр - Хурганы хуримын зоогийн талаарх түүх юм. Тэр зоогт бид бүгдээрээ уригдсан. Гэхдээ энэ түүх бидэнд яг өнөөдөр, энэ амьдралдаа хэрэгжүүлэх ёстой нэг зарчмыг зааж өгдөг. Бурхан бидний өдөр тутмын үйл ажлыг эвдэх юмуу эсвэл дуртай зүйлээ хийж байхад минь тасалдуулах үе бий. Энэ нь Бурхан бидэнд ямар нэгэн том зүйл бэлтгэснийг илтгэнэ. Үүнийг тэнгэрлэг учрал гэх бөгөөд энэ нь хүлээн авалт, Түүний үгийн найр, цэц ухаан, оршихуй, хангамж, зөвлөмж, хүчээр юмуу гагцхүү Түүний л өгч чадах, үй олон гайхамшигтай ерөөлийн аль нэгээр өндөрлөнө.

Бурхан Далласын Ковбойчуудын тоглолтын үеэр надад ямар нэгэн гайхамшигтай зүйл өгөхөөр бэлдсэн байжээ. Чухам юу байсныг нь би хожим л олж мэднэ. Бурхан анх надад өгөх гэж байсан тэр ерөөлөө хөдөөгийн зам дээр явж байсан эсвэл бутлаг хашааны цаана зогсож байсан хэн нэг хүнд өгсөн байх гэж би боддог юм.

Мэдээж би гаргасан алдаандаа насаараа харамсаж, өөрийгөө яллаж явдаггүй л дээ. Яагаад гэвэл би гэмшиж, уучлал гуйсан бөгөөд Бурханы өршөөл яндашгүй. Гэхдээ би гаргасан алдаанаасаа сургамжаа авсан. Би криптониттай зууралдсанаасаа болоод, дахиж Бурханы бэлэгийг алдмааргүй байна.

Бурхан бидэнд Өөрийнхөө Үг, цэц ухааныг хайрлахаар гэнэтийн урилга өгөх үед бид дэмий хоосон бүх шалтгаа хойш хаяад очбол, улам хүчирхэгжээд үлдэнэ. Криптонит биднийг зөвхөн доройтуулдаг гэдгийг санаарай.

Харамсалтай нь зарим хүмүүс шалтаг тоочсоор л байна. Тэд Бурханыг хэзээ ч тэргүүнд тавьж чадахгүй бөгөөд том найраас ч хождож мэдэх. Харин би тэгэхгүйн төлөө ихэд хичээж явна. Учир нь Бурханы уужим зайтай, саруул өргөөнд бид бүгдээрээ уригдсан билээ.

Миний олон жилийн өмнө бичиж байсан, дараах энгийн залбирлыг дагаж хэлнэ үү: *“Аав аа, Эзэн Есүс Христийн нэрээр зүрхийг минь ариусгаач. Би ариун байж, Таны төлөө тусгаарлагдмаар байна. Амьдралд маань Танд таалагдахгүй, Танаас чухал зүйл байвал, илчилж зайлуулаач. Би Таны найрын зоогоос хоцормооргүй байна!”*

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Энэ бүлгийн төгсгөлд байгаа залбирлыг та хэдийнээ хэлсэн байх. Хэлсэн бол, Бурхан дараагийн хэдэн өдөр, долоо хоног, сарын турш таныг Өөр рүүгээ ойртуулах ажлаа хийх бөгөөд ингэх явцдаа Бурхан - та хоёрын хооронд хөндөлсөж байсан юмсыг илчилнэ. Бурханы Үгтэй шууд харилцаатай байхаас барьж хорьж байгаа юмсыг ил гаргахыг Түүнээс гуйж, даруй арга хэмжээ ав. Бурханы илчилж өгсөн зүйлсийг бичиж тэмдэглэж аваад, энэ талаар залбирах цаг гарга. Бас энэ талаарх Бурханы санаа бодлыг асуугаад, хэлсэн бүгдийг нь тэмдэглэж аваарай.

Бүлгийн төгсгөлд байгаа залбирлыг хэлж зүрхлэхгүй байгаа бол, яг одоо Бурханаас тэр залбирлыг хэлэх хүсэл, зүрх зоригийг гуй. Залбирах үеэр чинь Бурхан зүрхэнд чинь ямар нэг зүйл сануулсан бол, түүнийг нь бичиж тэмдэглэж аваарай.

НАЙРЫН ҮҮД

Есүс Илчлэл ном дээр өөр нэгэн чуулганд маш онцгой нэг үг хэлсэн байдаг. Тэр нь бидний өмнөх бүлэгт үзсэнтэй тун төстэй үг юм:

Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь дууг минь сонсоод үүдээ нээвэл, Би дотогш түүн уруу орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.
(Илчлэл 3:20)

Есүстэй найрлах! Энэ бол Эзэнтэй нөхөрлөх нөхөрлөлийн найр юм. Тэнд бид Түүний Үг, цэц ухаан, зөвлөгөө, хүч болоод Түүний оршихуйн бусад гайхамшигтай ерөөлийг хүлээн авна. Тиймээс таныг Есүсээс энэ бүхнийг хүлээн авахсан гэсэн догдлосон сэтгэлээр өлсөж цангаж, хүсэн хүлээнэ гэдэгт найдаж байна. Есүсийн хангаж өгдөг хоол нь криптонитаас тэс өөр бөгөөд эсрэгээрээ биднийг хүчтэй болгодог юм. Яг л Супермэн маань нараас шинэ хүч хүлээн авдаг шиг. Есүс бол амьд Үг, тэнгэрийн жинхэнэ талх бөгөөд Түүний оршихуй нь бидэнд ямар ч криптонитыг эсэргүүцэн түрэх хүчийг өгдөг.

Тэгвэл “Есүс ямар хаалга тогшино вэ?” Ихэнх үйлчлэгч нар хүмүүсийг авралд дуудахдаа энэ ишлэлийг ашигладаг бөгөөд энэ нь ч зөв зүйтэй юм. Гэхдээ Есүс энэ үгээ Өөрийг нь хэзээ

ч мэдээгүй хүмүүст бус, харин Өөрийнхөө чуулган, дагалдагч нартаа хэлж байгааг санаарай. Тэгээд ч Есүсийн энэ үгийн гол санаа нь хаалган дээр бус, харин “чи сонсоод” гэдэг үг дээр буудаг.

Намайг гэртээ хөгжмөө байдгаар нь орилуулчихсан байж байтал, хэн нэг чухал зочин хаалга тогшиж, нэрийг минь дуудбал, би сонсохгүй. Зочин маань ч баахан нүдэж, нүдэж байгаад яваад өгнө.

Тиймээс: “Бид юунаас болж сонсохгүй байна?” гэж асуух ёстой. Энэ амин чухал асуулын хариултыг бид заавал олох ёстой юм. Учир нь хэрэв бид сонсохгүй бол, найраасаа хоцорно.

Ариун байдал

Орчин үеийн чуулганд “ариун байдал” гэж ярьбал, хүмүүс гэдрэг ухраад, бушуухан шиг сэдвээ өөрчлөх болжээ. “Ариун амьдрах” нь өнөөдрийн “хөгжиж соёлжсон” хүмүүст сонирхолгүй, утгагүй зүйл ажээ. Хүмүүс ариун байдлыг үйлсээр аврагдах явдал юмуу хуульчлал гэж үзэх болсон.

Гэтэл энэ нь Есүсийн эргэж ирэх чуулганы Шинэ гэрээнд хэлсэн цорын ганц дүрслэл болой. Есүсийг “хүчтэй удирдлагатай”, “ач холбогдолтой”, “уялдаа холбоо сайтай” эсвэл “хүчтэй хамтралтай” чуулганы төлөө эргэж ирнэ гэж хэлээгүй. Хэдийгээр дээрх шинж чанарууд нь чуулганы өсөлт, амжилтад амин чухал боловч, аль нь ч Христийн сүйт бүсгүйг тодорхойлох чанар болж чадахгүй.

Харамсалтай нь хуульчлагч номлолын хар гайгаар өнөөдөр олон хүн ариун байдлын талаар ярихаас дургүйцэх болжээ. Өнөөдөр аль болох ариун амьдралын талаар амаа үдэж байж л томоохон чуулган байгуулдаг болсон. Гэтэл Шинэ гэрээ тэр чигээрээ ариун байдлын талаар ярьдаг учраас, энэ талаар заавал дуугарах ёстой гэдгийг гярхай удирдагч нар мэддэг. Тиймээс тэр сэргэлэн гарууд ариун байдлыг дараах маягийн доктринтай хутгаад, тун сонсголонтой сургаал зохиочихжээ. Тэд ингэж ярина: “Ариун байдал нь хувь хүний хариуцлага биш учраас, хүмүүс заавал ариун амьдрах гэж шаналах шаардлагагүй. Учир нь Есүс - бидний ариун байдал. Бид Христ дотор баталгаатай ариун болсон.” Энэ доктрин нь тодорхой хэмжээнд л зөв болохоос биш, яг бүрэн үнэн биш юм. Учир нь Шинэ гэрээ ариун байдлын хоёр

талын тухай ярьдаг. Хэт орчин үежүүлсэн сургаал, номлолыг бүгдийг нь нэг саван дотор хутгажээ.

Ариун байдлын эхний талын тухайд:

Түүний өмнө биднийг хайр дор *ариун* бөгөөд *гэм зэмгүй* байхын төлөө Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ дотор сонгосон юм (Ефес 1:4) гэдэг.

Биднийг ширхэг ч мөнхийн үнэ цэнэтэй зүйл үйлдээгүй байхад, Бурхан тогтоол гаргажээ. Бурхан биднийг сонгохдоо, ариун хэмээн тунхагласан бөгөөд бид Бурханы мэлмийд гэмгүй болсон юм. Энэ бол “байр суурийн ариун байдал.” Бид Есүст итгэхдээ, Бурханы мэлмийд хэдийнээ төгс ариунд тооцогдсон тул, түүнээсээ илүү ариун болно гэсэн ойлголт байхгүй. Өдгөөгөөс хорин таван сая жилийн дараа ч та Есүст итгэсэн өдрийнх шигээ л ариун хэвээрээ байна.

Үүнийг нэгэн жишээгээр дүрслэх гээд оролдоё. Би 1981 оны зургаан сард Лиза Тосканотай учраад, шууд дурлаж, гэрлэхээр шийдсэн юм. 1982 оны 10-аар сарын 2-нд Лиза миний гэргий болов. Тэр цагаас хойш гучин таван жил өнгөрсөн ч, Лиза яг л анх надтай суусан шигээ миний гэргий хэвээрээ л байна. Хуримынхаа далан жилийн ой дээр ч тэр миний гэргий хэвээрээ л байна. Лиза “Жон Бивэрийн гэргий” гэдэг *байр суурийн эзэн* юм. Лиза миний гэргий байх гэж гавьяа байгуулж, хөдөлмөрлөж эсвэл энэ байр суурийг худалдаж авах шаардлагагүй. Би Лизаг сонгосон учраас, тэр миний гэргий болсон юм.

Дээрх удирдагч нар яг энэ ариун байдлын талаар заадаг бөгөөд энэ бүхэн нь үнэн юм. Гэхдээ ариун байдал гэдэг нь үүнээс хавьгүй гүн гүнзгий утгатай. Ариун байдлын хоёр дахь талыг би мөн л өөрийнхөө гэрлэлтийн жишээгээр дүрслэх гэж оролдоё.

Лиза надтай гэрлэхээсээ өмнө сэтгэлд нийцсэн залуустайгаа сээтэгнэж, дугаараа солилцож, болздог байсан бол, надтай гэрлэснийхээ дараа өөр залуустай хөөцөлдөж сээтэгнэхээ болиод, Жоны гэргий гэдэг *байр суурьдаа зохицсон зан үйлдэлтэй байх хариуцлагатай* болсон юм.

Элч Петрийн үгийг харна уу:

(Та нар Бурханы дуулгавартай хүүхдүүд шиг амьдрах ёстой).

Дуулгавартай хүүхдүүдийнхээ хувьд, мэдэхгүй байхад чинь та нарт байсан урьдын хүсэл тачаалдаа бүү нийцүүл. Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа (*хийсэн бүхэндээ*) бас ариун байгтун (*байх ёстой*). (1Петр 1:14-15)

Би зарим үгсийг тодруулсан байгаа биз? Эхлээд ёстой гэдэг үг дээр анхаарна уу. Петрийн ярьсан ариун зан үйлдэл нь сонголт биш ажээ. Хоёрдугаарт - Петр Христ доторх байр суурийн талаар яриагүй, харин бидний хийдэг үйлсийн талаар ярьжээ. *Амплифайд Библи* үүнийг маш сайхан хэлсэн байдаг: “Та нар өөрсдөө бүх үйлдэл, амьдралын хэв маягаараа ариун бай.” Тэгэхээр энэ нь *байр суурийн бус, харин зан үйлдлийн ариун байдал* ажээ. Яг л Лиза надтай гэрлэснийхээ дараа зан үйлдлээ өөрчилсөн шиг. Бидний зан үйлдэл байр суурийг маань тусгах ёстой.

Яг үүн дээр л мөргөлдөөн гардаг юм. Би Христэд дөнгөж итгээд байхдаа, ариун амьдрах гэж хичээгээд, ахин дахин бүтэлгүйдэг байлаа. Тэгээд зөөлнөөр хэлэхэд - урам хугарав. Тэгж байтал би Бурханы нигүүлсэлтэй танилцаж, Бурханы нигүүлсэл бол биднийг өөрийнхөө хүчээр хийж чадахгүй зүйлээ хийх чадалтай болгодог, хязгааргүй хүч чадлын цэнэг болохыг олж мэдсэн юм. Би порно мэтийн олон нүгэлт зан үйлдлээсээ чөлөөлөгдөж чадахгүй явахдаа, нигүүлсэлтэй танилцаж, нигүүлсэлд итгэж, нигүүлсэлтэй гар нийлж ажилласнаараа эрх чөлөөнд амьдрах чадвартай болсон юм.

Нэгэн харамсалтай түүх хуваалцъя. Хэдэн жилийн өмнө манай байгууллага нэгэн судалгаа хийсэн юм. Бид Америкийн олон янзын чуулганд очиж, янз бүрийн доктрин, урсгал чиглэлийн дахин төрсөн Христэд итгэдэг хүмүүсээс Бурханы нигүүлслийг гурваас дээш янзаар тодорхойлохыг хүстэл, бараг бүгдээрээ “аврал, нүглийн уучлал, үнэгүй өгөгдсөн дуусашгүй бэлэг, Бурханы хайр” гэх зэргээр тодорхойлсон байлаа. Энэ мэдээж сайхан мэдээ. Гэхдээ хамгийн эмгэнэлтэй нь тэдгээр итгэгч хүмүүсийн хоёр хүрэхтэй үгүйтэй хувь нь л нигүүлсэл бол Бурханы хүч гэдгийг мэдэж байв. Гэтэл Бурхан Өөрөө “Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөс байдал дотор (*Миний*) хүч бүрэн төгс болно (2Коринт 12:9) хэмээн айлдсан байх. Бурхан нигүүлсэлээ Өөрийнхөө хүч гэжээ.

Петр: “Бурханыг болон бидний Эзэн Есүсийг мэдсэнээр та нарт нигүүлсэл ба амар амгалан улам арвижиг. Алдар ба давуу чанараараа биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжин бурхан хүч нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон” (2Петр 1:2-3) гэдэг. Петр Бурханы нигүүлслийг бидэнд бурханлаг - ариун амьдрах хүчийг өгдөг Бурханы тэнгэрлэг хүч хэмээжээ.

Үнэндээ бид итгэхээс нааш Бурханаас юу ч хүлээж авахгүй. Харин мэдэхгүй бол, юундаа итгэх билээ? Нигүүсэл бидэнд хүчийг өгдгийг Америк итгэгч нарын хоёр хувь нь л мэддэг юм бол, ерэн найм орчим хувь нь өөрийнхөө хүчээр ариун амьдрах гэж хичээдэг болж таарч байна. Гэтэл энэ ямар ч боломжгүй юм. Үүнээс гутрал, ялагдал, сэтгэл санааны өвчин, ял, буруутгал л төрнө.

Тэгэхээр Христийн багш, сургагч нар яагаад ариун байдлыг тэр чигээр нь “*байр суурийн* ариун байдал” гэдэг ангилал руу чихээд байдаг нь үүнтэй холбоотой ажээ. Христэд итгэдэг дэндүү олон хүн өөрийнхөө хүчээр ариун амьдрах гэж хичээгээд урам алдаж, гутардаг. Гэтэл Бурханы нигүүлсэл биднийг аварч, уучлаад зогсохгүй, бидэнд ариун амьдрах хүчийг өгдөг! Еврей номын бичээч:

Бүх хүнтэй эвтэй байхыг болон ариуслыг мөшгөгтүн.
 Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй болой. Хэн чинь ч
 Бурханы нигүүлслээс хоцрохгүйн тулд болон аливаа гашуун
 үндэс урган хор учруулж, түүгээр олноороо бузарлагдахгүйн
 тулд сэрэмжил (Еврей 12:14-15) гэдэг.

Дээрх хоёрхон ишлэлд дэндүү олон зүйл хэлжээ. Нэгдүгээрт - мөшги гэдгийг Грекээр *диоко* гэх бөгөөд энэ нь “Юмны араас дагах, тэмүүлэн зүтгэх, олж авахын тулд чин сэтгэлээсээ хичээнгүй мөрдөх” (WSNTDICT) гэсэн утгатай ажээ. Өөр нэгэн толь бичиг дээр “Ямарваа нэгэн зүйлийг чухам тодорхой зорилго, хараагаар улайран хийх” (LOUW-NIDA) гэдэг.

Дээрх тодорхойлолтыг уншсан болохоор, одоо бид нэн түрүүнд “Еврей ном дээр *байр суурийн* ариун байдлын талаар хэлсэн үү, *зан үйлдлийн* ариун байдлын талаар хэлсэн үү?” гэж асуух ёстой. Хариулт нь ч энгийн: Еврей ном дээр *зан үйлдлийн* ариун байдлын

талаар л ярьсан байхаас гарцаагүй. Жишээлбэл Лизад: “Лиза Бивэр, чи маш их хичээн зүтгэж байж л Жон Бивэрийн гэргий байна” гэж хэлбэл яах уу?

Тэр инээд алдаад: “Би угаасаа л гэргий нь шүү дээ!” гэж хэлнэ.

Байр суурийн тал дээр - бид хэдийнээ ариун болсон учраас, ариун байдлаа давуулан биелүүлэх шаардлагагүй. Тиймээс Еврей номын бичээч зан үйлдлийн ариун байдлын талаар ярьжээ.

Бид *зан үйлдлийн* ариун байдлын араас хичээнгүйлэн мөшгих ёстой юм. Эс бөгөөс “Бурханы нигүүлсэлд хүрч чадахгүй.” Гэтэл хаацайлдаг нигүүлсэлд хүрэхгүй байна гэж байхгүй. Ингэх боломжгүй. Харин жинхэнэ нигүүлсэл нь зан үйлдлээрээ ариун байхын төлөө мөшгүүлдэг Бурханы тэнгэрлэг хүч гэдгийг ойлгобол, үүнд хүрч чадалгүй, унах боломжтой байдгийг ойлгоно.

Еврей номын бичээч бүлгээ “Бурханд таалагдахаар үйлчлэх нигүүлсэлтэй байцгаая” (ЭнКэйЖэйВи) хэмээн төгсгөжээ. Нигүүлслийн ачаар л бид Бурханд таалагдахаар үйлчилж, ариунаар амьдарч чадна.

Харин одоо маш чухал хэсэг дээрээ ирлээ. “Бүх хүнтэй эвтэй байхыг болон ариуслыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй болой” (Еврей 12:14). Бичээч юуны талаар ярина вэ? Бид бүгдээрээ л Есүсийг харахгүй гэж үү? Бидэнд “Харагтун, Тэр үүлсийн хамт ирэх бөгөөд нүд бүр Түүнийг харна” (Илчлэл 1:7) хэмээн тодорхой хэлсэн бус уу? Тэгтэл энэ Бичээс дээр яагаад “ариун байхгүй бол, бид Эзэнийг харахгүй” гэнэ вэ? Энэ бүхэн ямар утгатай вэ?

Есүсийг харах

Ариун байдлыг мөшгих аваас “Эзэнийг харна” гэсэн амлалт нь ямар утгатай болохыг тайлбарлая. Би тавин найман жил Америкийн иргэн байхдаа, арван хоёр ерөнхийлөгчийн нүүрийг үзсэн. Би тэдний бүгдийнх нь удирдлага, хууль цааз дор амьдарч, тэдний шийдвэр ч миний амьдралыг хөнддөг. Би тэднийг “манай ерөнхийлөгч” гэдэг. Гэхдээ би тэдний нэгийг нь ч хувьчлан *хараагүй* билээ. Гэтэл ерөнхийлөгчтэй хамт ажилладаг эсвэл нөхөрлөдөг учраас, түүнийг өдөр бүр *хардаг* Америк иргэд байна аа. Тэд ерөнхийлөгчөө тогтмол харж, *оршихуйд* нь байнга ордог, завшаантай хүмүүс ажээ.

Гэтэл би өдий хүртэл амьдрахдаа, ерөнхийлөгч маань юуны төлөө зогсдог, ямар шийдвэр гаргадаг гэх мэт маш ерөнхий зүйлсийг л мэднэ. Хувийнх нь амьдралын тухайд ч олон нийтэд нээлттэй мэдээллээс өөр юм мэдэхгүй. Ерөнхийлөгчтэйгээ хэзээ ч хувьчлан харилцаж үзээгүй. Олон нийтээс хаалттай, хувийн амьдралынх нь нарийн ширийн юмсын талаар бүр ч мэдэхгүй. Тэгээд би нэг ч ерөнхийлөгчтэй нөхөрлөж яваагүй.

Яг үүнтэй адилхан зарим итгэгч нар Есүсийн захиргаа дор амьдардаг. Тэд Есүсийн гаргасан шийдвэрт захирагдаж, Түүнийг “Эзэн” хэмээн дууддаг боловч, Есүсийг хардаггүй, оршихуйд нь ордоггүй хүмүүс юм. Та гайхаж байж магадгүй. Гэхдээ Есүс чухам энэ тухай л хэлснийг би танд харуулаад өгье:

Миний тушаалуудыг хүлээн авч сахигч нь Намайг (үнэхээр) хайрлагч мөн. Намайг (үнэхээр) хайрлагч нь Эцэгт минь хайрлагдана. Би ч түүнийг хайрлаж, Өөрийгөө түүнд *илчилнэ* гэж хэллээ (Би түүнд Өөрийгөө *тодорхой харуулж*, түүнд Өөрийгөө бодитой гэдгийг мэдүүлнэ). (Иохан 14:21)

“Түүнд Өөрийгөө *тодорхой харуулна*” гэдэг үгийг харна уу. Есүсийн *тушаалыг* тээж, сахих нь зан үйлдлийн ариун байдлын араас мөшгих явдал юм. Үүнийг үйлдэгч нь *Эзэнийг харна*. Эзэн тэр хүнд Өөрийгөө илчилнэ. Эзэн тэднийг Өөрийнхөө үзэгдэхүйц *оршихуйд оруулна*. Энэ харилцаа нь зүгээр нэг захирч - захирагдахаас хавьгүй дээд төвшний харилцаа бөгөөд Хаантай Өөртэй нь нөхөрлөх эрхмийн дээд харилцаа юм. Есүс мөн:

Та нар тушаасныг минь *үйлдвээс* Миний нөхөд мөн (Иохан 15:14) хэмээн айлдруун.

Есүс “үйлдбээс” буюу өөрөөр хэлбэл “хэрэв” хэмээн айлдсан байгааг анхаарна уу. Бид “Есүс - найзынхаа” тухай дуу дуулж, ном бичиж, сургаал номлодог. Гэхдээ “хэрэв” гэдэг үг нь Түүний нөхөрлөл *болзолтой* болохыг илтгэж байна. Есүстэй тогтоох нөхөрлөл нь жинхэнэ ариун байдал дээр л үндэслэх бөгөөд үүнийг биелүүлдэг хүмүүс нь *зарцаас найз руу* дэвшдэг. Есүс Өөрт нь үнэнч үлдсэн хүмүүст: “Би та нарыг боолууд гэж дахиж дуудахгүй” (Иохан 15:15) гэж хэлсэн. “Дахиж” гэж хэлснээс нь

үзбэл, нэгэн цагт Есүс тэднийг нөхөр биш, зарц гэж дууддаг байсныг илтгэнэ.

Үнэндээ Бурханы зарц байх нь муу биш бөгөөд мэдээж Бурхантай огт харилцаагүй байснаас дээр юм. Гэхдээ зарц хүн “юуны” цаадах “яагаадыг” мэддэггүй бол, харин найз нь мэддэг.

Та: “Гэхдээ бид бүгдээрээ л Бурханы хөвгүүд, охид шүү дээ” гэж бодож байгаа байх. Тийм ээ мөн. Гэвч бид Паулын хэлсэн үгийг санах ёстой: “... хэдийгээр өв залгамжлагч нь бүгдийн эзэн мөн боловч хүүхэд байхдаа зарцаас ялгагдах юмгүй байдаг” (Галат 4:1). Энэ ишлэлд гарч байгаа “зарц” гэдэг Грек үг нь дээрх ишлэлд Есүсийн хэлсэн “зарц” гэдэг үгтэй яг адилхан үг билээ. Бурхан Өөрийнхөө жинхэнэ хөвгүүд, охидоос үйлдэж буй *зүйлийнхээ* цаадах яагаадыг нуудаггүй.

Аав ээж - үр хүүхэд хоорондоо нөхөрлөх шиг сайхан юм үгүй. Тэгвэл Бурханы гэр бүл дотор ч ялгаагүй юм. Аав маань биднээс нууж хаах юмгүй бол, харилцаа маань ч өөр төвшинд гарч, үүнийгээ дагаад бид ч өөрчлөгдөнө. Одоо бид Аавыгаа гомдоохгүйн төлөө илүү ихээр мэрийх болсон бөгөөд энэ нь зүгээр л Аавынхаа үгэнд орох ёстой гэдгээс хавьгүй том зүйл юм. Мэдээж бид Аавынхаа үгэнд орсоор л байна. Гэхдээ одоо бид ёстой учраас бус, харин хайртай учраас Бурханы үгэнд ордог.

Үүд

Ариун байдал нь хуульчлагч нарын ярьдаг шиг эцэс биш юм. Энэ нь Есүстэй тогтоох жинхэнэ дотносол руу нэвтрүүлдэг үүд билээ. Тиймээс л Есүсийн ярьсан “үүд” тийм чухал байдаг. Учир нь энэ нь итгэгч хүний зүрх ажээ. Ариун байдлыг мөшгих явдлыг үл хайхрах нь бидний сонсох, хариулах чадварыг үгүй хийдэг. Яг л маш их дуу чимээтэй айлын хаалгыг нэгэн чухал эрхэм нүдсээр нүдсээр, нэрийг нь дуудсаар, дуудсаар эцэстээ яваад өгөхтэй адил юм.

Ариун байдлын талаар заахаас зайлсхийх нь Хаантайгаа ойр дотно харилцах замаа хааж байгаатай л адил юм. Гэтэл энэ нь жинхэнэ итгэгч хүн бүрийн эрхмийн дээд хүсэл байх ёстой! *Хүчирхэгжүүлэгч нигүүлслийн оронд хаацайлагч нигүүлслийг заах* стратеги маань үндсэндээ хаалгаа цоожлоод, хөгжмөө

тултал нь чангалахтай л адил юм. Бид нигүүлслийг *хаацайлдаг ч, хүчирхэгжүүлдэг ч* - давхар ашигтай нигүүлсэл болгон хямдхан борлуулах болжээ! Гэхдээ хүчирхэгжүүлэгч нигүүлсэл л биднийг Эзэнтэнтэйгээ дотно сайхан нөхөрлөх байр суурьд хүргэнэ.

Лиза бид хоёр Индианад гэр бүлээ бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай, хууль ёсны эхнэр нөхөр хоёр. Тэгвэл дараах үзэгдлийг төсөөлнө үү: Би Лизагийн нүүрэн дээр гэрлэлтийн баталгаагаа эргүүлээд л: “Хонгор минь, бид албан ёсоор гэрлэсэн, хууль ёсны эхнэр нөхөр хоёр мөн боловч, одоо би өөр хүүхнүүдтэй амраглалаа” гэж хэлж байна гээд бод доо. Тэгвэл бид хууль ёсны эхнэр нөхөр хоёр хэвээрээ байх боловч, Лиза урьдынх шигээ сэтгэл зүрхний амин хүслээ надад нээхгүй. Үнэндээ бидний хоорондох дотно байдал үгүй болж, бид найз нөхөд ч байхаа болино. Учир нь би өөрөө далдганаж байж, тэр завшаанаа алдсан шүү дээ. Хэрэв би тэр чигээрээ дарвалзаад байвал, гэрлэлтээ ч нэг мөр алдана.

Тэгвэл чуулганд заагаад байгаа зүйл чинь яг л ийм байдлыг хөхүүлэн дэмжээд байгаа бус уу? Бид зарим нэг ишлэлийг Шинэ гэрээний бүрэн хэсгээс нь ховхлож аваад, яаж ч амьдарсан, зүгээр гэж ярьж явна уу? Бид Есүст: “*Би гэмиллийн залбирал хэлсэн, нигүүлслээр аврагдсан тул Таных болсон биш үү?*” гэж хэлэнгээ, дэлхийтэй орон дотроо хөлбөрч байна уу? Ийм байдалтай биднийг Есүс зүрхнийхээ цөмд нэвтрүүлнэ гэдэгт бид яаж итгэж зүрхлэнэ вэ?

Тиймээс хоёулхнаа дэрээ дэрлээд, өөд өөдөөсөө хараад хэвтэж байхдаа, Лиза маань өөр хэнд ч хэлэхгүй үгээ надад л шивэгнэдэг тэр гайхамшигт, дотно, нандин харилцааныхаа төлөө би Лизагаа хэзээ ч гомдоохгүй. Энэ л миний хөдөлгүүр юм. Гэргий минь болсон тэр хосгүй бүсгүйтэй тогтоосон харилцаагаа би хэзээ ч алдахыг хүсэхгүй.

Тэгвэл Есүсийн тухайд ч ялгаагүй юм. Би Есүстэй тогтоосон дотно харилцаагаа алдаж, нөхөрлөлөө гээхийг хүсдэггүй учраас л, Есүсээс урвадаггүй юм. Есүстэй тогтоох дотно харилцаанаас аугаа хэргэм зэрэг, баялаг, таашаал, үйл ажиллагаа, алдар нэр, байр суурь, гэм нүгэл - ер нь юу ч байхгүй.

Би Түүний “Намайг дууд, Би чамд хариулж, чиний мэдэхгүй аугаа хүчит зүйлийг Би чамд ярина” (Иеремиа 33:3) гэдэг амлалтгүйгээр

амьдарч чадахгүй. Эсвэл Түүний “Гүн хийгээд нууц юмсыг Тэр л илчилдэг. Харанхуйд юу буйг Тэр мэддэг Гэрэл Түүнтэй хамт оршдог” (Даниел 2:22) гэсэн бодит байдалгүйгээр амьдарч чадахгүй. Эсвэл Түүний “Энэ бүхнийг Би та нарт зүйрлэлээр ярьсан. Гэвч дахин зүйрлэлээр ярихаа болих цаг ирж байна. Харин Эцэгийн тухай та нарт шууд хэлнэ” (Иохан 16:25) гэсэн үггүйгээр амьдарч чадахгүй. Тэгээд мэдээж Ариун Сүнсний амлалт бидэнд айсуй зүйлсийг харуулдаг (Иохан 16:13-ыг үзнэ үү).

Ариун байдал нь сөрөг биш, харин ч эсрэгээрээ Шинэ гэрээн дэхь хамгийн эерэг зүйлийн нэг болой. Хэрэв бид үүний хүчин чадлыг үнэн голоосоо ойлгобол, оргил дээрээс хашхирмаар болно!

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Ариун байдал нь муу үг биш, харин нэвтрэх үг юм. Ариун байдал нь таны зүрхийг Бурханы дуу хоолойд нээнэ. Ариун байдалгүйгээр та Бурханы яриаг сонсохгүй. Ариун байдал бол Бурхан Аав нь Есүсийн тахилыг бодсондоо, танд зүгээр өгчихдөг зүйл биш юм. Энэ нь таны бодол, үг, үйлдлээр бодитой болох ёстой зүйл юм.

Бурхан биднийг ариун амьдрах гэж зовоосой гэж хүсдэггүй. Тиймээс л нигүүлслийг өгсөн! Аврал нь өөрөө гайхамшиг мөнөөс мөн боловч, нигүүлсэл биднийг аврахаас гадна дотроо ч, гаднаа ч ариун амьдарч, Бурханд бүрэн таалагдах хүчтэй болгодог!

Бурханыг яг одоо хай. Бүү хүлээ. Яг одоо Бурханаас нигүүлслийг нь үнэн голоосоо гуй. Амьдралынхаа аль хэсэг дээр Бурханы нигүүлслээр хамгийн их дутагдаж яваагаа хэлээд, Бурханы дуу хоолойг сонсоход садаа бологч бүхнийг ялах нигүүлслээрээ дүүргэхийг гуйгаарай.

БОС

Яагаад супер баатруудын тухай кино тийм алдартай байдаг вэ? Бодоод үз: Холливүүдийн эдгээр бүтээл нь байлдаантай кино, Барууны кино, тагнуултай триллер, хайр сэтгэлийн киноноос ч олон үзэгч татдаг. Энэ нь зөвхөн эрчүүдийн ч кино биш юм. Тэдгээр блокбастер хитэд хайртай дуртайгаа зарладаг эмэгтэйчүүдтэй би байнга таардаг. Яагаад ийм байдаг вэ? Яагаад гэвэл бид одоо байгаагаасаа хавьгүй илүү байхаар бүтээгдсэн бөгөөд супер баатрууд нь бидний дотоод санаашралын үлгэр загвар болж өгдөг юм.

Супермэнийг аваад үз. Бэрх нөхцөл үүсч, аймшигт дайсан гарч ирж, хамаг найдвар тасрахад, *Өдрийн гаригийн* Кларк Кент л ажлаасаа гүйж гараад, утасны бүхээгтээ ороод, эгшин зуурын дотор хүн төрөлхтөнийг аврахаар гүйж гарч ирээд, үхэшгүй гэмээр дайсныг дарж авахыг нь бид сэтгэл оволзон, бахдан харж суудаг. Шударга бус явдал дарагдаж, золиосны хүмүүс чөлөөлөгдөж, нийгэм эмх цэгцдээ орох нь бахдам сайхан.

Тэгэхээр ийм байна: Хорон санаатныг дарах супер баатруудын баатарлаг үйлс нь бидний дотоод санаашралыг хангадаг учраас л бид хөөрдөг. Анх Бурхан хүнийг бүтээхдээ, “Ийнхүү Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээсэн” (Эхлэл 1:27) гэдэг. Түүнчлэн “ЭЗЭН бол дайчин, Түүний нэр ЭЗЭН билээ” (Гэтлэл 15:3) гэдэг. Та энэ талаар бодож байсан уу? Түүний энэ чанарын талаар бид бараг ярьдаггүй. Яг л энэ үнэнийг яах ёстойгоо, хаашаа

хийхээ мэдэхгүй балмагдах шиг. Гэтэл Исаиа мөн:

ЭЗЭН дайчин мэт урагшилж, дайнч эр мэт зүтгэн босоод,
Хашхиран уухайлж, дайснаа дарна (Исаиа 42:13) гэжээ.

Шударга бус явдалтай тэмцдэг дайчид нь баатрууд юм. Есүсийн тухайд Тэр бол жинхэнэ супер баатар болой. Тэр бол Байлдан дагуулагч бөгөөд Ялагч.

Исаиаг энэ үгийг үзэглэхээс ч өмнө Иошуа тэр Дайчин Бурханыг харжээ. Хаан маань хурга бус, харин илд бариад, Өөрийгөө “...ЭЗЭНий дайчдын командлагч” (Иошуа 5:14-ийг үзнэ үү) гэжээ.

Исаиаг дээрх үгийг үзэглэснээс бүр хожим элч Иохан Эзэнийг үзээд, Түүнийг: “Түүний мэлмий нь галын дөл шиг... Түүний амнаас хурц сэлэм гарсан” (Илчлэл 19:12-15) хэмээн бүр ч аймшигтай бөгөөд гайхамшигтай дүрслэн хэлсэн байдаг.

Бурхан бол Дайчин! Дайчин хүн цаанаасаа л эмзэг, дорой, хойлог зантай байдаггүйг бид мэднэ. Дайчин хүн зорилготой, шийдчихсэн, хатуу бөгөөд чадуу байдаг.

Тэгэхээр одоо өөрсдийнхөө талаар бодъё. Илчлэл ном дээр гардаг бүх долоон чуулганд Есүс: “Ялсан (ялагч) хүн бүрт...” гэсэн утгатай үг айлдсаныг та эргэцүүлэн бодож байв уу? Тэгвэл ялах юм байхгүй бол, ялагч яаж гарах вэ? Тулаан байхгүй бол, юундаа ялах вэ?

Өнөөдөр олон хүн энэ дуудлагыг ойшоодоггүй. Тэд зүгээр л “бидний Христ доторх байр суурь л биднийг ялагч болгодог” гэдэг. Өөрөөр хэлбэл Христ Ялагч учраас, бид автоматаар Христийн дотор ялагч болно гэнэ. Хэдийгээр энэ нь Христийн доторх бидний байр суурийн хувьд үнэн боловч, яг бүрэн үнэн биш юм. Хэрэв бид аврагдахдаа л автоматаар ялчихсан юм бол, Есүс яагаад долоон чуулганы бүх хүнд “ялсан нэгэнд” гэж хэлэх гэж?

Ертөнцөд бодит Лекс Лютор байх бөгөөд түүнийг Сатан гэдэг. Сатаны цэргүүд нь тэнэг биш бөгөөд тэдний тэргүүний зорилго бол таныг зогсоож, баривчилж, хяналтдаа байлгах юм. Дашрамд хэлэхэд Сатан 7/24 (хорин дөрөв долоо) ажилладаг юм шүү. Гэхдээ Сатан зэвсгээ хураалгаж, таны дээр тогтоосон эрх мэдэл, хүчээ алдсан!

Яг л Лекс Лютор төмөр хүний өмнө хүчин мөхөс байсан шиг. Гэвч Лекс Лютор хорон санаат гоц ухааныхаа ачаар криптонитыг олж ашиглан санаандаа хүрч, Супермэнийг барьж, захирах чадвартай болжээ. Үүнтэй адил Сатан ч өөрийнхөө мөхлийг дуудсан сүнслэг криптонитыг ашиглан, бидэнтэй хүч тэнцүү болдог. Тэр үүнийг тэнгэрт, тослогдсон херуб байхдаа бүтээжээ (Езекиел 28:14-16-г үзнэ үү).

Жинхэнэ Лекс Лютор болох Сатан биднийг сүнслэг криптонитыг таньчих юм бол, байх ёстой газар нь байлгана гэдгийг мэддэг учраас, арга залиа ашиглан криптонитын зүсийг хувиргадаг ажээ. Криптонитын дотрыг малтаад үзбэл, юу гардгийг та мэдэх үү? Криптонит танд хэсэгхэн хугацааны таашаал, зугааг өгч болох ч, эцэст нь таныг ямар ч хүчгүй болгож бас сэтгэл дундуур үлдээдэг. Та байлдан дагуулагч чанараасаа тасарч, ус, наргүй ургамал шиг л хатна. Ийнхүү цаг хугацаа өнгөрөх тусам, та дотроосоо үхэжсээр байна.

Зэрвэс харсан минь

Бурханы хүү, охин минь, жинхэнэ дүрдээ эргэж ор. Та манай үеийн жинхэнэ супер баатар байхаар дуудагдсан. Танд ялах бүх хүчин зүйл нь бий. Энэ бол зөгнөлт кино биш. Би дэлхий даяар аялж, Христийн биеийг томоор харсан аз завшаантай хүн. Би итгэгч хүмүүс ч, даяар чуулган ч ямар хүчин чадалтай болохыг зэрвэс харсан хүн.

Ийм жишээ олныг дурьдаж болох ч, цөөхөн хэдэн жишээгээр хорхойг чинь даръя. Би хамгийн олон лалын сүсэгтэнтэй нэгэн улсын зуун дөч гаруй мянган итгэгчтэй чуулганд хэдэнтээ очиж заасан билээ. Тэдний тал хувь нь өмнө лалын шашинтай байсан хүмүүс байв. Чуулганы гол танхим нь гучин таван мянган хүний суудалтай боловч, тэд Бүтэн сайн өдөр хэд хэдэн цуглаан хийдэг ажээ. Би өөрөө тэнд очиж, нүдээрээ хараагүй бол, энэ бүхэнд итгэхгүй байх байлаа. Тэр бол дэндүү бэрх нөхцөлд цэцэглэж яваа, тун их үр нөлөөтэй чуулган юм. Тэр чуулганы дайчид нь жинхэнэ ялагч - баатрууд мөн.

Тэр чуулганы пасторын хоёр дахь хүү нь төрөхдөө тархиндаа гэмтэл авсан тул, эмч нар түүнийг хэзээ ч ярьж, явж чадахгүй

гэсэн онош тавиад, нэг их урт наслахгүй, наслалаа ч ургамал - хүн болно гэсэн байна.

Гэтэл Бурхан тэр пастортай яриад: “Би хаана байна?” гэж асуужээ.

- “Та тэнгэрийн сэнтийдээ л байгаа шүү дээ!”

- “Үгүй ээ, Би чиний дотор оршиж байна! Тиймээс Би чиний харж байгаа бүхнийг үгээрээ бүтээсэн шигээ, хүүгийн чинь тархинд тушааж, цоо шинэ тархийг бүтээнэ!”

Тиймээс пастор дуулгавартай байж, хүүгийнхээ тархинд хандан өдөр бүр Есүсийн нэрээр тушаах болжээ. Тэгээд хүү нь эцэстээ ярьж эхлэв. Тэгтэл Бурхан хүүгийн хөлний төлөө яг адилхан зүйл үйлдэхийг тушаажээ. Тэгээд хүү зургаан настайдаа явж эхлэсэн байна. Би тэр пасторын хүүтэй гольф тоглосон бөгөөд тэрбээр гэрлэж, гурван хүүхэдтэй, эрүүл саруул эр хүн болсон байлаа.

Тэр пастор криптонитын эрхшээлд ороогүй, жинхэнэ ялагч байв.

Би саяхан нэг улсад очиж, чуулганы хөдөлгөөний пастор, удирдагч нарт заасан юм. Тэд намайг 12,500 хүн хуран цугласан, уулга алдмаар том цэнгэлдэх хүрээлэнд авчрав. Тэд халдвар авмаар халуун сэтгэлтэй, дүрэлзэж яваа хүмүүс байлаа.

Маргааш нь би тэргүүн удирдагч нартай нь хооллохдоо, тэдний сүлжээнд гурван зуу гаруй мянган хүн байдгийг олж мэдэв. Тэгэхээр нь би тэр хөдөлгөөнийг их л эртний хөдөлгөөн байх гэж бодоод, хэдийд эхлэснийг нь лавлатал, арван зургаахан жилийн өмнө ганц хүнээс эхлэсэн гэх нь тэр.

Би ч мэл гайхав. Тэгээд дэлхийн тэргүүлэх зэргийн улсад яаж ийм зүйл хийж байгааг нь асуулаа.

Тэгтэл Англиар дуржигнадаг нэг удирдагч нь надад: “Бид хүмүүстээ өнө мөнхийн хараагаар амьдрахыг заадаг” гэлээ.

Одоо би цэл хөхрөв.

Тэгтэл мөнөөх удирдагч: “Би Америкийн маш олон чуулганд сууж үзсэн. Тэгээд Америк чуулганууд бүхнийг дал, наян жилийн уртаар л хардгийг мэдсэн. Харин манай хүмүүс өнө мөнхийн хараагаар амьдардаг” хэмээн ярьлаа.

Ийм л хандлага биднийг сүнслэг криптонитын аюулаас сэргийлдэг.

Лиза, бид хоёр Армен улсын Ереван хотод 3,500 пастор, удирдагч нарт номлосон юм. Иранаас олон удирдагч хүрэлцэн

ирсэн байв. Цуглааны завсарлагаанаар нэгэн залуу эмэгтэй “Ираны цагдаа нар түүнийг байхгүй болохоор нь гар утас руу нь залгаад, хаана, юу хийж явааг нь шалгаасан” тухай ярих.

Тэгэхээр нь би: “Чи тийм аюултай нөхцөлд байгаа юм бол, эргэж очих хэрэг байна уу?” гээд хэлээдхэв.

Тэгтэл бүсгүй над руу ширтээд: “Би буцаж очихгүй бол, Иранчуудад хэн Есүсийн тухай хэлэх билээ?” гэж хариулсан юм. Миний ичсэн гэж. Тэрбээр яахын аргагүй криптонитыг гишгэлсэн дайчин байв.

Хэдэн жилийн өмнө нэгэн чуулган хоёр сарын турш өдөр бүр цуглаан хийтэл, үдэш бүр дөрвөн мянган хүн ирж оролцов. Тоолохын аргагүй олон мянган хүн аврагдаж, жинхэнээсээ эдгэж, чөлөөлөгдөв. Гэтэл нэгэн орой тэдэнд Есүс Өөрийн биеэр үзэгджээ. Есүсийг харсан олон хүн орилолдон уйлав. Есүс нүд ирмэхийн зуур үзэгдээд өнгөрөхдөө, Өөрийнхөө оршихуйн нотолгоог үлдээгээд явжээ. Түүний нүүрний дүрс тэр танхимын 2,5x1,8-ын харьцаатай ханан дээр хэвлэгдсэн байв. Тэр дүрс нь “Турины даавуурхуу” л харагдаж байсан бөгөөд ханан дээр арван найман сарын турш байж байгаад, яваандаа бүдгэрсээр, бүр мөсөн арилжээ.

Нэг орой чуулганы үүдэн дээр эмнэлгийн машин ирж зогсоод, эмч нар нэгэн тэргэнцэртэй хүнийг танхим руу оруулжээ. Тэр хүнд хорин дөрвөн цагийн л нас үлдсэн байв. Гэтэл Бурханы аугаа хүчээр илбүүлсэн тэр хүн төгс эдгэрч, тэргэнцрээ өөрөө түрээд чуулганаас гарсан юм.

Би энэ түүхийг нүдээрээ гэрчлэн харсан билээ. Учир нь би тэр цуглаанд байхаар барахгүй, тэр чуулганы пасторынх нь туслахаар үйлчилж байв.

Энэ бүхнээс гадна би цуглааны оффис руу чиглэж яваа, хуйхлам улаан гал гайхамшгаар унтрахыг харсан. Би тайлбарлахын аргагүй гайхамшгаар хар шуурга намжих юмуу зүгээ өөрчилж одохыг харсан. Би дүлий нь сонсож, сохор нь харж, суунги нь алхахыг харсан. Манай нэг найз Төв Америкийн Мексикт олон хүнийг үхлээс амилуулсныг би мэднэ. Бурханы оршихуй цүл хийтэл бууж ирээд, гайхамшгаараа хуу шавхуурдаж, үй олон хүний амьдралыг орвонгоор нь өөрчлөхөд, тэр газарт цуглаад байсан найман мянган хүн хөл дээрээ тогтож ядан, энэ бүхнийг гэрчлэн харсан гэдэг.

Хэдийгээр би үүнийг нүдээр хараагүй боловч, бүхэл бүтэн овог, бүхэл бүтэн нийгэм, соёл үндсээрээ өөрчлөгдсөн хөдлөшгүй баримтат өөр олон түүх мэднэ. Өнөөдөр иймэрхүү үйл явдал өдрийн од шиг ховор болсон нь үнэн. Гэхдээ эртний чуулганд өрнөж байсантай адил боловч, хавьгүй том цар хүрээтэй гайхамшгийн үе айсуу гэдэгт би итгэдэг.

Есүстэй хамт байсан

Миний ярьсан жишээнд гарсан хүмүүс эртний чуулганд л болж байсан гайхамшгийг үзжээ. Сайн мэдээний номууд, Үйлс ном ийм гайхамшгаар дүүрэн байдгийг бид мэднэ. Эдгээрийг: *эрх мэдэл, хүч, эр зориг* гэсэн гурван үгээр базаж хэлж болно.

Есүсийг хүрэлцэн ирмэгц, тухайн газрын уур амьсгал сууриараа эргэдэг байжээ. Жишээлбэл, Есүсийг синагогт орж ирэхэд, “Хүмүүс сургаалыг нь гайхаж байлаа. Учир нь Есүс хуулийн багш нар шиг бус, эрх мэдэлтэй Нэгэний хувьд тэдэнд зааж байв” (Марк 1:22) гэдэг.

Тэгтэл юу, юугүй л ийм үйл явдал өрнөжээ: “Тэр үед тэдний синагогт бузар сүнстэй нэгэн хүн байв. Тэр хашхиран — Назарын Есүс ээ! Бид Танд ямар хамаатай билээ? Та биднийг устгахаар ирэв үү? Таны хэн болохыг, Бурханы Ариун Нэгэн гэдгийг би мэднэ” (Марк 1:23-24) гэсэнд, Есүс: “Дуугаа тат! Түүнээс гар” хэмээв. Ёрын муу сүнс чарласаар, сайх хүнийг газар татагнуулан унагаад, далдрав. Есүсийн эрх мэдэл, хүч, эр зоригийг үзсэн үзэгчид шаагилдан, айж биширчээ (21-38-аар ишлэлийг үзнэ үү). Ийм хүчирхэг жишээ Сайн мэдээнд олон байдгийг та мэднэ.

Гэхдээ Есүс энэ дэлхийгээс явах үедээ: “Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ” (Иохан 20:21) хэмээн айлдсан нь бүр ч гайхмаар. Үүнд гайхахгүй байвал, Түүний: “...Надад итгэдэг нь Миний хийдэг үйлсийг бас хийх бөгөөд эдгээрээс агуу ажлуудыг ч хийх болно” (Иохан 14:12) гэсэн өөр нэг үгийг нь хар. Яг адилхан ажил хийх боловч, илүү аугаа хэмжээнд хийнэ! Ингэх боломжтой гэж үү? Есүс боломжтой гэсэн бол, боломжтой! Эртний чуулган энэ боломжийг бүрэн дүүрнээр хүлээн авч, ашигласан. Тэдний тэр их эрх мэдэл, хүч, зоригоос болж хэдхэн

өдрийн дотор хот хотоороо, суурин суурингаараа Есүс рүү ирдэг байжээ. Орчин цагт ч ийм түүх олонтаа өрнөдгийг би мэднэ.

Тухайлбал эртний Иерусалимыг л аваад үзэхэд, тэр хотод чуулганы үйлсийн хөлд өртөөгүй нэг ч хүн байгаагүй. Хэдхэн өдрийн дотор гурван зүйл болжээ: чуулганы хүчирхэг үйлсийн улмаас Иерусалимын иргэд нэг бол - Есүсийг ярьлаа гэж хилэгнэсэн, нөгөө бол - хаанчлалд татагдан орсон. Чуулган огцом өсч, аугаа хүчээр ажиллаж, хэд хэдэн ер бусын гайхамшиг болжээ. Нэг удаа өдөр бүр цуглааны газар руу зөөлгөдөг байсан, төрөлхийн суунги хүн эдгэрчээ. Түүнийг огло үсрэн босч хашхирахад, хотынхон хотол олноороо цуглаж, гайхшрав!

Энэ хөдөлгөөний эрчийг нураах гэсэн эрх баригчид Петр, Иохан нарыг баривчлаад, зөвлөлийн гишүүдийн өмнө зогсоход, зөвлөлийнхөн:

“Эрдэм номгүй, юм сураагүй Петр, Иохан хоёрын зоригтой байгааг тэд хараад гайхацгаан, *Есүстэй хамт байсныг нь мэджээ.*” (Үйлс 4:13)

Тэдний эр зориг зөвлөлийн анхаарлыг татжээ. Петр, Иохан хоёр хотын нэр нөлөө бүхий хүмүүсийн өмнө энх тайвныг сахиад л, “политиктай” юм яриад л өнгөрч болох л байсан. Тэд үнэнийг хэлэлгүй, аргалаад өнгөрч болох л байсан. Гэтэл тэд алуулж мэдэх байсан ч, үнэнчээр үлджээ.

Юу гээчийн эр зориг, хүч вэ? Энэ бүхэн хаанаас гарна вэ? Хамаг учир нь “Тэд Есүстэй хамт байсан” гэдэг үгд л бий. Тэр эрчүүд Эзэнтэнийхээ оршихуйд алхаж явсан бөгөөд одоо ч алхсаар байж. Тэд Түүнийхтэй ижил үйлсийг хийж, хотуудыг өөрчилжээ. Тэд ариун байдлын хүмүүс байв. Эртний чуулган криптонитаас цэвэр байж, хүч чадлынхаа ундарга болсон Бурханы Хүүтэй ойр байсныхаа ачаар л тийм аугаа эр зориг, эрх мэдэл, хүч дотор алхсан буюу.

Гэтэл дагалдагч нар Иерусалимаас авахуулаад Самари, Иоппа, Лудда, Шарон, Антиохыг өөрчилсөн шиг, Коринтын чуулган хотоо өөрчилж чадаагүйг түүх гэрчилдэг нь мөн тоогүй. Коринтын чуулган шал өөр байжээ. Тэд хотоо өөрчлөх ямар ч хүчгүй, дорой байв. Гэтэл тэд Ариун Сүнсний бэлэгт итгэдэг байсан нь бүр ч

жигтэй. Коринтын итгэгч нарын дунд цөөн гайхамшиг өрнөж, тэдэнд хотын хэмжээнд нөлөөлөх хүч байгаагүй.

Тэгвэл бид өөрийнхөө үеийнхэнд юу хүснэ вэ? Хотууд нөлөө авч, өөрчлөгдөхийг дахин харах боломжтой юу? Би олон хот, олон том чуулганы цуглаанд уригддаг. Гэхдээ үүнийхээ хажуугаар хаанчлалын нөлөө хүрэхгүй байгаа олонхи болох сая, сая хүний төлөө гашууддаг. Бид яагаад суурин, хот, бүс нутагт нөлөөлж чадахгүй байна? Криптонитын эрхшээлд орчихоод тэр бус уу?

Бурхан Хуучин гэрээний нэгэн шүүгчийн амьдралаар бидний хувь тавиланг илчилдэг. Тэр шүүгчийг Самсон гэнэ. Дуулгаваргүй загнах нь Самсоны хувьд эхлээд гэм байсан бол, адагтаа зан болжээ. Үүнийхээ урхагаар Самсон криптонитад хамаг хүчээ алдаж, аймшигтай төлөөс төлсөн юм. Нэгэн цагт ид хаваа гайхуулж явсан, хүчирхэг Самсонаас бараа ч үлдээгүй. Гэвч зовлон үзэж, тартагтаа тулаад ирэхийн цагт Самсон үнэн голоосоо гэмшихэд, хамаг хүч нь эргэн иржээ. Самсоны үхэхээсээ өмнө байгуулсан ялалт нь түүний ид хүчирхэг явсан үеийн бүх ялалтын нийлбэрээс ч аугаа байв.

Эш үзүүлэгч Даниел эцсийн өдрүүдэд ямар ч дайсагналын өмнө ухрашгүй үеийнхэний талаар:

... Бурханаа мэдэгч ард түмэн хүчирхэг болж, үйлдэл хийнэ
(Даниел 11:32) гэдэг.

Тэр цэргүүд “Бурханаа ойр дотно” мэддэгт тэдний хамаг хүч нь оршин байна. Харин жинхэнэ ариун байдлыг мөшгиж байж л бид Бурхантайгаа ийм ойр дотно байх юм.

Эцэст нь

Тэгэхээр ийм байна. Бурхан таныг баатар, аварга, ялагч, нөлөөлөгч болгохоор дуудсан. Хүчтэй, урамтай байж, Хаандаа улам ойрт. Бурхан таныг хүснэ. Бурхан тантай ойр дотно байж, хүчирхэгжүүлэхийг хүснэ. Бурхан таны төлөө байдаг. Бурхан танд итгэдэг. Гэхдээ үүнээс чухал нь Бурхан танд мөнхөд хайртай.

Та бол энэ дэлхий дээрх жинхэнэ супер баатар. Таны дотор

байгч Ялагч нь энэ дэлхийн Лекс Лютораас хол хүчтэй. Тэр Ялагчийнхаа хүчийг аваад, олон хүний амьдралыг өөрчил. Та хожим Хаан сэнтгийн өмнө зогсохдоо л, өөрийнхөө нөлөөг бүрэн эхээр нь харна. Та өнөөдөр ч, тэр өдөр ч криптонитад бууж өгөөгүйдээ хагартлаа баярлана.

Тиймээс криптонитыг ал, устга, сөнөө. Амьдралынхаа эд эсэд бүү нэвтрүүл. Та аугаа алдар, хүчийн төлөө бүтээгдсэн. Хүчирхэг хүн минь, танд хувь тавилан байна. Түүнийгээ биелүүлэхийг чинь энэ дэлхий танаас шаардаж байна.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бурхан бол Дайчин. Харин бид Түүнтэй адилхан бүтээгдсэн. Тиймээс л супер баатруудын кино бидний сэтгэл зүрхийг олзолдог юм. Бид аугаа зүйлийн төлөө төрснөө дотроо мэдэрсээр л байдаг.

Бурхан таныг үүний л төлөө бүтээсэн. Амьдралдаа дадал болсон, илт нүглийн криптонитад зай тавьж өгөлгүй, Бурханы төлөө аугаа үйлсийг бүтээсэн түүхэн хүмүүсийг бид мэднэ. Бурханы хүч, Түүний хүмүүсийн эр зоригоор хотууд хэдхэн өдрийн дотор л өөрчлөгддөг байсан. Бурхан таныг урагш гарч, үүнийг дахин хийх хүмүүсийн нэг болгохоор дуудаж байна.

Таныг ямар тулаанд дуудаж байгааг нь Бурханаас асуу. Таныг ямар хот, бүс, нутаг дэвсгэр, улс үндэстэнд хүргэхээр дуудаж байна? Бурханы хэлснийг бичиж аваад, тэр зорилгыг биелүүлэх нигүүлслээр дүүрэхийн төлөө залбиран гуй. Тэгээд өнө мөнхийн шагнал дээр буюу энэ амьдралдаа итгэмжтэйгээр, ялгууснаар хийсэн үйлчлэлээрээ өөрийн болгох юмсын амлалт дээр хараагаа тавин, урагшаа давш. Бурхан таныг баатар болгохоор дуудсан!

ХЭЛЭЛЦЭХ АСУУЛТ

Хэрэв та номоо уншихынхаа хажуугаар “Криптонитыг устга” судлалаа бүрэн эхээр нь хийж байгаа бол (энэ тун зөв санаа шүү), би танд DVD дотор юмуу CloudLibrary.org цахим хаяг дээр байгаа тохирох видео хичээлийг үзээд, дараа нь тухайн хичээлийн төгсгөлд байгаа хэлэлцэх асуултыг бүлгээрээ ярилцахыг зөвлөж байна. Видео хичээл дээр номынхоо гол, гол сэдвийг дэлгэрүүлэн ярьсан байгаа учраас, оролцогч нар номоо уншихынхаа хажуугаар видео хичээлээ үзээд явах нь хамгийн зүйтэй болно.

За амжилт!

Хичээл 1: Бидний хүчин чадал

1-3-аар хичээлийн гол сэдэв

1. Та мэдэхгүй хүчин чадлаа хэзээ ч хэрэгжүүлье гэж хүчрэхгүй. Энэ зарчим үнэн болохыг та амьдрал дээр харсан уу? Ашиг, ач холбогдлыг нь олж мэдсэнийхээ дараа шууд өөрийн болгосон шинэ бүтээгдэхүүн, технологи юмуу итгэл үнэмшил

- танд бий юу? Байгаа бол юу вэ? Энэ бүхэн чинь энэ хичээлээс сурсан зүйлтэй чинь юугаараа адилхан байна?
2. Бид Бурханы дотор бараг л боломжгүй гэмээр их боломжтой. Энэ хичээл танд чухам яаж Христ доторх хүчин чадлаа олж мэдэх хүсэл өгөв? Тухайлбал та ямар тал дээрээ дэндүү өчүүхэн бодолтой явав?
 3. Яагаад өнөөдөр Христ доторх хүчин чадлын талаар ийм бага заадаг болсон гэж бодож байна? Энэ бүхэн нь боломжтой гэдгийг бид мэдсэн бол, чуулган яаж өөрчлөгдөх байсан бол? Энэ бүх боломжийн талаар тунгаан бодохоор, эдгээр нь таныг хэрхэн өөрчилж эхлэж байна?
 4. Христэд итгэдэг хүмүүс - бид байх ёстой хэм хэмжээндээ байж чадахгүй үед дэлхий Христэд итгэх итгэлийг маань төдийгүй, Бурханыг өөрөөр хардаг. Хэрэв бид хүчин чадлаа тултал ашиглабал, дэлхий биднийг хэрхэн харах бол? Бурханыг хэрхэн хардаг болох бол?

Хичээл 2: Ганц хүний хүч

4-7-аар хичээлийн гол сэдэв

1. Коринтынхон Христийн биед хаа хамаагүй хандсанаасаа болоод, олон хүн доройтож, өвчилж, зуурдаар нас барсан учраас, Паул тэдэнд захидал бичжээ. Үүнд олон хүн өртсөн гэж хэлсэн бөгөөд энэ бүхэн нь өнөөгийн бидэнд ч хамаатай болно. Энэ бүхэн нь Христийн бие болох чуулганы талаар заалгаж ирсэн зүйлээс чинь юугаараа өөр байна? Яагаад энэ бүхнийг ойлгох нь өнөөгийн итгэгч нарт чухал вэ?
2. Чуулган доторх илт нүглээс болж, Христийн бие доторх олон хүн хүчин чадалдаа хүрч чаддаггүй. Гэхдээ энэ нь Христэд итгэдэг хүмүүсийг өвчин тусч, нас барахад хүргэдэг цорын ганц шалтгаан биш юм. Тэгвэл яагаад заавал энэ хоёрын хоорондох ялгааг тодруулах ёстой вэ? Чуулганд өөр ямар шалтгаанаар гай барцад ирж болох вэ?
3. Баруунд хувь хүн дээр төвлөрсөн сэтгэхүй ноёлдог. Гэтэл Ахан Бурханы эсрэг нүгэл үйлдэхэд, нэг бие болохынхоо

хувьд Израиль бүхлээрээ зовлонд өртжээ. Энэ үнэн Христийн бие дотор эзлэх үүрэг хариуцлагадаа хандах үзэлд чинь хэрхэн нөлөөлөв?

4. Сүнслэг криптонит нь мэдсээр байж үйлдсэн илт нүгэл юм. Ахан нүгэл хийж байгаагаа мэдэж байсан, Коринтын чуулган Эзэний зоогийн үеэр архидах, ховдоглох, амиа бодох нь нүгэл гэдгийг мэдэж байсан. Аль аль тохиолдлоос нь болж гэмгүй хүмүүс доройтол, үхэлд хүрсэн. Тэгэхээр Бурхан яагаад Өөрийн бие доторх нүглийг тийм ноцтой авч үздэг гэж бодож байна? Таны бодлоор Бурхан яагаад биднийг хувь хүнийг чухалчлаад зогсохгүй, биеийг бүхлээр нь чухалчилдаг болоосой гэж хүсдэг вэ?

Хичээл 3: Криптонит

8-10-аар хичээлийн гол сэдэв

1. Жастин, Анжела хоёрынх шиг явдал жинхэнээсээ байж болох уу? Мэдээж үгүй. Гэхдээ зарим Христэд итгэдэг хүн Бурханд яг ингэж ханддаггүй гэж үү? Тэдний хандлага юугаараа төстэй байна? Ханьдаа тэгж хандаж байгаа хүнд та яаж хандах вэ? Бурханд тэгж хандаж байгаа хүнд та яаж хандах вэ?
2. Илт нүгэл нь сүнслэг криптонит бөгөөд харин сүнслэг криптонит нь шүтээн мөргөл юм. Тэгвэл өнөөдөр чуулганд явдаг маш олон хүн үнэндээ шүтээнд мөргөж байгаа нь юу гэсэн үг вэ? Хөшөө баримал, шүтээнд сунаж мөргөдөггүй улсуудын шүтээн мөргөл ямархуу дүр хэлбэртэй байдаг вэ?
3. Шүтээн мөргөлийн талаар чуулганд барагтай заадаггүй. Энэ хичээлээр шүтээн мөргөлийн талаар сурсан хамгийн гол зүйл чинь юу вэ? Энэ нь юугаараа таны хувьд хамгийн их гайхагдав?
4. Бурхан Бичээс даяар шүтээн мөргөлийг завхайралтай адилтгасан байдаг. Бурхан яагаад ингэдгийг өөрийнхөөрөө тайлбарлана уу? Энэ нь Бурханы бидэнд санал болгодог харилцааны талаар юуг илэрхийлнэ вэ?
5. Шүтээн мөргөл нь Бүтээгчийгээ бус, бүтээлийг хүндэтгэх явдал юм. Бурхан энэ үйлдэлд хэрхэн ханддаг вэ? Бурхан

- яагаад Өөрийг нь хүндэтгэхгүй байгаа хүмүүсээс холддог вэ? Яагаад ижил хүйсийг хөхүүлэн дэмжих хандлага нь тухайн нийгэм шүтээн мөргөлийг хүлээн авсныг илтгэдэг вэ?
6. Бид шүтээн мөргөлийг хүлээн зөвшөөрөх гэж байгаа бол, жинхэнэ хүндэтгэл мөргөлийг ойлгох ёстой. Жинхэнэ хүндэтгэл мөргөл нь уртын дуу дуулах явдал бус, харин Бурханы тушаалыг дуулгавартай дагах явдал юм. Хүндэтгэл мөргөлийг ойлгосноороо таны Христэд итгэх итгэлийн амьдрал хэрхэн өөрчлөгдөж байна? Таны хувьд Бурханыг яаж хүндэтгэж амьдрахыг үлгэрлэн харуулсан хүн байдаг уу?

Хичээл 4: Орчин цагийн шүтээн мөргөл

11-14-ээр хичээлийн гол сэдэв

1. Зарим Амалекуудыг амьд үлдээсэн Саулын дуулгаваргүй авирын түүх нь чуулганд байдаг шүтээн мөргөлийн уг үндсийг харуулдаг. Саулын шунаг зан нь хэрхэн шүтээнд мөргөх явдалтай тэнцэх вэ?
2. Самуел Саулд зөрүүд зан нь шүтээнд мөргөхтэй адил гэжээ. Энэ нь Бурхан хүслээ хэлсээр байтал, өөрийнхөө хүссэн зүйлээс зуураад байх явдал юм. Тэгээд Саулын амьдралаас харсанчлан, энэ авир нь түүнийг бүр ч том нүгэл рүү хөтлөсөн байдаг. Зөрүүд зан яаж шүтээн мөргөл болдог вэ? Яаж илүү том нүгэл рүү хөтлөдөг вэ?
3. Шунал биднийг шүтээн мөргөл рүү дагуулдаг бөгөөд үнэндээ энэ нь өөрөө ч шүтээн мөргөл мөн. Тэгвэл хангалуун байдал бурханлаг байдал руу хөтлөдөг. Өөрийнхөө зорилго, чухалчлал, дадал хэвшлийг харах юм бол, амьдралд чинь аль нь илүү хүчтэй байна - шунал уу, хангалуун байдал уу? Та яаж илүү аугаа амьдралыг мөшгих вэ?
4. Христэд итгэдэг хүн бүрийн амьдралд сэтгэл хангалуун байдал чухал боловч, бид үүнийг өөрөөрөө бардсан байдалтай андуурч болохгүй. Энэ хоёр нь ямар ялгаатай болохыг өөрийнхөө үгээр тайлбарлана уу. Хүн өөртөө бардаагүй, харин сэтгэл хангалуун байгааг яаж мэдэх вэ?

5. Тодруулах ёстой өөр нэг чухал зүйл бий: Итгэгч хүн нүгэлд унах нь шүтээн мөргөл биш, харин нүгэлд бууж өгөх нь шүтээн мөргөл болохыг санаарай. Энэ хүртэл сурсан зүйлээ ашиглан, энэ хоёрын ялгааг хэлж чадах уу?
6. Хэрэв бид санаатай нүгэл нь сүнслэг криптонит болохыг ойлгох юм бол, Бурхан бидэнд Өөрийнхөө мөн чанартай, цоо шинэ амьдралыг санал болгож байгааг ойлгох ёстой болно. Нүгэлд өртөмхий бус, харин зөвт байдалд өртөмхий байж болдгийг та ухаарсан уу? Энэ өөрчлөлт боломжтой гэдгийг - тэр бүү хэл болох ёстой гэдгийг мэдэх нь танд ямар санагдаж байна?

Хичээл 5: Хулхи Есүс

15-18-аар хичээлийн гол сэдэв

1. Бурхан таныг Өөртөө авчрах гэж л аварсан. Тэр тантай ойр дотно байхыг хүсдэг. Энэ нь таныг дэлхийн юмсаас өөрийгөө угаахыг шаардана. Учир нь Тэр тантай жинхэнэ харилцаа хүсдэг. Энэ юу гэсэн үг вэ? Ийм харилцаатай гэдгээ яаж мэдэх вэ?
2. Өөр дээрээ авчрахыг хүсэн хүлээсэн хүмүүс нь Түүгээр авруулснаа хүлээн зөвшөөрсөн атлаа Түүн рүү очихоос татгалзахад Бурханд ямар хэцүү байсныг төсөөлж байна уу? Таны гэрлэсэн хүн чинь тантай нэг өрөөнд байхаас татгалзаад байвал, танд ямар байх уу? Утсаар ч ярихгүй бол ямар байх уу? Өөр нэг хүнээр л дамжуулж тантай харилцана гэвэл ямар байх уу? Та хоёрын харилцааг ямар харилцаа гэх үү?
3. Аарон хуарандаа үлдсэн тул тэрбээр уулан дээр Бурханы оршихуйд байснаас, ард түмнийхээ дунд байсан нь дээр гэж үзсэн болтой. Зарим хүн яг ийм байдаг. Тэд Бурханы оршихуйд байхаасаа илүү чуулганд байх дуртай байдаг. Та Бурханы оршихуйг мэдрэхээрээ хэрхэн хариулдаг вэ?
4. Өөрсдийг нь Египетээс гаргасан Иавэд зориулж янз бүрийн өргөл, тахил шатааж байна гэдгээ Израилийн тахилч хэлсэн боловч, өөрсдийнхөө дур хүслийн төлөө алтан тугал дээрээ л хамаг анхаарлаа тавьсан байв. Израиль жигшүүртэй, худал шүтээнд мөргөсөн явдлаа яг зөв нэрээр нэрлэж чадсан бол,

өнөөгийн чуулган ийм зүйл хийж чадахгүй гэж үү? Энэ нь ямар дүр хэлбэртэй байх бол?

5. Израиль Бурханы зарим тушаалыг дагасан атлаа заримыг нь үл хайхарсан. Дэлхий дээр байгаа чуулганууд яг л ийм зүйл хийж, дуртай ишлэлээ сонгоод, харин Бурханд бүрэн зориулагдсан, ариун амьдралд уриалан дуудсан ишлэлүүдийг нь үл хайхардаг. Тэгвэл бид хулхи Есүсийг биш, жинхэнэ Есүсийг хүндэтгэж байгаагаа яаж мэдэх үү?

Хичээл 6: Эхлэх цэг

19-21-ээр хичээлийн гол сэдэв

Хулхи Иавэ Израильд хэрхэн үүсч хөгжив? Хулхи Есүс чуулганд хэрхэн үүсч хөгждөг вэ? Аль аль нь жинхэнэ гэмшил байхгүй, хатуурсан зүрхнээс бий болсон үр дүн юм.

1. Энэ хичээлээр гэмшлийн талаар маш их ярина - гэмшлийн зайлшгүй шаардлага, Сайн мэдээн дэхь гэмшлийн үүрэг, энэ нь ямар утгатай болох гэх мэт. Энэ нь таны урьд өмнө гэмшлийн талаар бодож байснаас юугаараа ялгаатай байна? Энэ нь Сайн мэдээнд хандах арга замыг чинь өөрчилж байна уу? Тийм бол, хэрхэн?
2. Сайн мэдээний ном болгон нүглээ гэмшихийг номлосон Иохан Баптистын түүхээр эхлэдэг. Энэ нь Есүсийн Сайн мэдээ нь ямагт гэмшлээр эхлэдэг гэсэн үг юм. Энэ мэдэгдэл танд ямар санагдаж байна? Гэмшил нь яагаад Сайн мэдээнд тийм чухал вэ?
3. Илт нүглээ гэмшихгүйгээр Есүс Христэд жинхэнээсээ итгэнэ гэж байхгүй. Нүгэлтэйгээ зууралдаад л, Христэд итгэдэг гээд л байвал, бид мэхлэгджээ. Бурхан яагаад бидний амьдралд тийм их санаа тавьдаг гэж бодож байна?
4. Жастин, Анжела хоёрын түүхийг санаж байна уу? Анжела гэрлэхээрээ хуучин амрагуудаасаа салах ёстойг мэдээгүй. Хэрэв бид Есүсийг мэдэхгүй хүмүүст гэмшихийг хэлж өгөхгүй бол, тэд яаж гэмших ёстойгоо мэдэх билээ? Бид хүмүүст нүгэл хийхээ боль гэж хэлбэл, юу болох бол? Сайн

мэдээг бүрэн эхээр нь хуваалцахын төлөөсийг урьдаас тооцсон байх нь яагаад тийм чухал вэ?

5. Бид сэдлээрээ бус, үйлдлээрээ дүгнүүлнэ. Энэ нь Сайн мэдээний хүч нь хүнийг бүхлээр нь өөрчлөх хүчтэйг харуулдаг. Энэ нь гэмшил нь эерэг, сайн зүйл болохыг хэрхэн харуулж байна? Гэмшээрэй гэсэн Бурханы шаардлага нь үнэндээ бидэнд үзүүлж буй Түүний өршөөл мөн болохыг өөрийнхөө үгээр тайлбарлана уу.

Хичээл 7: Үнэн, хүлцэл, хайр

22-24-ээр хичээлийн гол сэдэв

1. Иуда авралын гайхамшгийн талаар эсвэл их гоё сайхан зүйлийн талаар бичихийг хүссэн ч, сонсогч нартаа Бурханы нигүүлслийг нүгэл үйлдэх лиценз болгон хувиргадаг хүмүүсийн талаар анхааруулахаас өөр аргагүй болжээ. Тэгвэл та сайхан зүйл л яриад, Бурханы анхааруулгыг мэдэхгүй царайлж байсан удаа бий юу? Амьдралдаа, яриандаа анхааруулгыг сахиж байх нь яагаад чухал вэ?
2. Чуулган жинхэнэ хайрын тухай ойлголтыг будлиулснаасаа болоод, нүгэлд хүлцэнгүй хандах болжээ. Жинхэнэ хайр нь үнэнийг шаарддаг бол, үнэн нь хэзээд өнө мөнхийн үзэл байдаг. Мөнхийн үзэл нь амьдралын чинь эрэмбэ дарааг өөрчилж байна уу?
3. Бурханы хайр нь Бурханы тушаалыг сахина гэсэн үг. Үүгээр л Христэд итгэх итгэлийн хайр, дэлхийн хайраас ялгардаг. Бурханы тушаалгүйгээр Бурханы хайр, дэлхийн хайрын хоорондох ялгааг яаж гаргах билээ?
4. Бурханы үнэнийг тээгээгүй хайр нь жинхэнэ хайр биш юм. Энэ нь хулхи эд болно. Манай соёл Бурханы энэ хайрыг хаясан бөгөөд ингэж л чуулган хулхи Есүс рүү эргэдэг. Үнэнийг хайраар ярина гэдгийг та юу гэж ойлгодог вэ? Яагаад олон хүн үнэнийг хэлэхээс, үнэнийг сонсохоос тавгүйтдэг вэ?

Хичээл 8: Криптонитыг утсга

25-28-аар хичээлийн гол сэдэв

1. Зарим итгэгч нар нүгэл Бурханы зүрхийг үйрүүлдгийг мэддэггүй учраас, нүглийг тоодоггүй. Нөгөө хэсэг нь хүн төрөлхийн нүгэлт мөн чанартай бөгөөд Есүсийн цус биднийг нүглийн шийтгэлээс чөлөөлж дөнгөсөн атлаа нүглийн хүлээсээс чөлөөлөх хүчгүй гэдэг худал хуурмагт итгэдэг. Эдгээр нь криптониттай хүмүүс буюу дадал болсон, илт нүгэл үйлдэгч нар юм. Энэ хоёр итгэл үнэмшил таны амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ? Бусад итгэгч нарын амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?
2. Харин гурав дахь төрлийн хүмүүс нь нүгэл үйлдээд байгаагаа мэддэг ч, үүнтэйгээ тэмцдэг хүмүүс юм. Тэд чөлөөлөгдөхийг хүсдэг ч, хэрхэн нүглээс эрх чөлөөтэй амьдрахаа Бурханы Үгээс олж мэдээгүй байдаг. Тэд нүглийнхээ ичгүүрт барьцаалагджээ. Ийм нөхцөлд байгаа итгэгч хүнд та сая сурсан хичээлээсээ ямар үнэнийг хэлж өгөх вэ?
3. Энэ хичээлээрээ би Бурхан намайг яаж порно донтолтоос чөлөөлсөн тухай ярьсан. Энэ гэрчлэл маань юугаараа танд урам болов? Яагаад тэр вэ? Юу нь хамгийн хэцүү санагдав? Яагаад тэр вэ?
4. Нүглээс чөлөөлөгдөх чөлөөлөлт нь дэлхийн гашуудлаас бус, бурханлаг гашуудлаас ирдэг. Бурханлаг гашуудал нь бид нүглээрээ Бурханыг өвтгөдөг гэдгийг ойлгодог бол, дэлхийн гашуудал нь нүгэл бидэнд, бидний ирээдүйд хэрхэн нөлөөлж байгаад л зовнидог. Бурхан яагаад биднийг нигүүлслээрээ нэг төрлийн гашуудлаас нь чөлөөлсөн атлаа, нөгөө төрлийн гашуудлаас нь чөлөөлөхгүй үлдээх гэж? Таны амьдралд энэ хоёр гашуудал ямар янзтай байгааг хэлэх үү?
5. Супер баатруудын түүх бидний төсөөллийг олзлодог нь хүн бүрийн зүрхэнд оршдог санаашралтай холбоотой юм. Эртний итгэгч нар тухайн үеийнхээ жинхэнэ супер хүмүүс байжээ. Тэгвэл бид яаж өнөөдрийн супер хүмүүс болох вэ? Энэ нь Бурханыг үзэх дэлхийн үзлийг хэрхэн өөрчлөх вэ?

6. Бурхан бол Дайчин. Харин бид Түүнтэй адилхан бүтээгдсэн. Есүс Илчлэл дээрх бүх долоон чуулганыг ялалтад уриалсан бөгөөд энэ нь бид ч ялалтад дуудагдсан, бидэнд ялах дайсан байгаа гэсэн үг юм. Энэ үгийг бүхлээр нь эргэцүүлэн бодохоор танд хандсан Бурханы дуудлагад хандах арга зам чинь хэрхэн өөрчлөгдөж байна? Өөрийгөө үзэх, бусад итгэгч нарыг үзэх, даяар чуулганыг үзэх арга зам чинь хэрхэн өөрчлөгдөж байна?

Хавсралт

БҮГДЭД НЭЭЛТТЭЙ АВРАЛ

*Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан
Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл,
аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч,
амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ.*

Ром 10:9-10

Бурхан таныг бүрэн дүүрэн амьдраасай гэж хүсдэг. Тэрбээр таныг гэхээр л сэтгэл нь дүрэлздэг бөгөөд амьдралд чинь хандсан төлөвлөгөө зэхсэн байдаг. Гэхдээ хувь тавиландаа хүрэх замыг эхлүүлэх цорын ганц арга нь: Бурханы Хүү Есүс Христээр дамжин авралыг хүлээн авах зам юм.

Есүсийн үхэл, амиллаар дамжуулан Бурхан таныг Өөрийнхөө хайртай хүү, охин болгон хаанчлалдаа угтан авах зам гаргажээ. Есүсийн загалмай дээрх тахил нь танд мөнхийн баялаг амьдралыг нээж өгчээ. Аврал нь танд өгсөн Бурханы бэлэг бөгөөд та авралыг юугаар ч олж авч чадахгүй.

Энэ үнэт бэлэгийг хүлээн авахын тулд эхлээд Бүтээгчээсээ тусгаар, дураараа амьдарсан нүглээ хүлээн зөвшөөр. Энэ нь таны хийсэн нүглийн хамаг үндэс юм. Энэ гэмшил нь авралыг хүлээн авахад амин чухал хэсэг болно. Үйлс ном дээр таван мянган

хүн аврагдсан тэр өдөр Петр үүнийг тодорхой хэлсэн: “Иймээс гэмшицгээ. Гэм нүглээ үгүй болгохын тулд эргэцгээ” (Үйлс 3:19). Хүн бүр нүглийн боол болж төрснийг Бичээс мэдэгддэг. Энэ боолчлол нь санаатай дуулгаваргүй байдлын үлгэр загварыг эхлүүлсэн Адамын нүглээс үндэстэй. Гэмшил нь өөртөө бөгөөд худалчдын эцэг Саганд дуулгавартай байх явдлаас салж, таны төлөө амиа өгсөн, шинэ Эзэнтэн Есүс Христ рүүгээ дуулгавартай эргэх сонголт юм.

Та Есүсийг Эзэнээ болгож, амьдралынхаа жолоог атгуулах ёстой. Есүсийг “Эзэн” болгоно гэдэг нь өөрт байгаа, өөрийн гэх бүхнээ - амьдралынхаа (сүнс, сэтгэл, биеийнхээ) мэдлийг өгнө гэсэн үг юм. Тэр таны амьдрал дээр төгс мэдлээ тогтооно. Үүнийг хиймэгц, Бурхан таныг харанхуйгаас чөлөөлж, Хаанчлалынхаа гэрэл, алдарт гаргана. Та үхлээс амь руу нэвтэрч, Түүний хүүхэд болно!

Хэрэв та Есүсээр дамжих авралыг хүлээн авмаар байвал, дараах залбирлыг хэлнэ үү:

Тэнгэрийн Бурхан минь, би өөрийгөө нүгэлтэн бөгөөд Таны зөвт байдлаас хол дутна гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Би нүглээсээ болж мөнхийн шийтгэл авах зохистой хүн. Гэхдээ Та намайг энэ чигээр минь үлдээгээгүйд баярлалаа. Та миний төлөө Өөрийнхөө цорын ганц хайртай Хүү Есүс Христийг илгээсэн. Тэр онгон Мариагаас мэндлэж, миний төлөө миний шийтгэлийг үүрэн Загалмай дээр үхсэн. Гэвч Тэрбээр гурав дахь өдрөө дахин амилуулагдаж, одоо миний Эзэн бөгөөд Аврагч болон Таны баруун гарт залран суугаа гэдэгт би итгэж байна. Тиймээс энэ өдөр би Танаас тусгаар, дураараа байдлаа гэмшин, амьдралаа бүхлээр нь Есүсийн Эзэний эрх мэдэлд өгч байна.

Есүс ээ, Та одоо миний Эзэн бөгөөд Аврагч. Сүнсээрээ амьдралд маань ирээд, намайг Бурханы хүүхэд болгооч. Би урьд нь зуурч байсан харанхуйн юмсаа хүчингүй болгон таслаж, өнөөдрөөс эхлэн цаашдаа би өөрийнхөө төлөө амьдрахгүй. Таны нигүүлслээр би намайг мөнх амьдруулахын төлөө Өөрийгөө өгсөн Таны төлөө амьдарна.


*Эзэн минь, баярлалаа. Одоо миний амьдрал бүхлээрээ
Таны гарт очлоо. Тиймээс Таны хэлснээр би одоо хэзээ ч
ичихгүй. Есүсийн нэрээр. Амень.*

Бурханы гэр бүлд тавтай морилно уу! Өөрийнхөө баярт мэдээг бусад итгэгч нартайгаа хуваалцаарай. Библид итгэдэг нутгийн чуулганд хамрагдаж, шинэ итгэлийг чинь урамшуулан дэмждэг хүмүүстэй холбогдох нь чухал шүү.

Ийнхүү та хамгийн ер бусын аян замд гарлаа. Өдөр өдрөөр Бурхантай илчлэл, нигүүлсэл, нөхөрлөлөөр өсөх болтугай!

Сайныг уу, Бурханыг уу?

Бурхангүй сайн сайн байдаггүйн учир



Сайн л бол, Бурханаас байх учиртай. Тийм үү?

Өнөөдөр **“сайн”** хийгээд **“Бурхан”** гэдэг хоёр үгийг ижил утгатай үгс шиг хэрэглэх болжээ. Бид “сайн” гэж үздэг зүйлсээ Бурханы хүсэлтэй төгс эгнэх учиртай гэж итгэдэг. Өгөөмөр, даруу, шударга зан чанар нь сайн юмс. Амиа хоохойлох, тоомжиргүй зан, харгислал нь муу юмс. Ядах юмгүй л ялгачихаж болмоор харагдаж байна.

Гэхдээ ингээд л болмоо юу? Сайныг ялгахад тийм амархан юм бол, Библи яагаад сайн мууг ялгах хараатай бай гэж хэлсэн юм бол?

Сайныг уу, Бурханыг уу? ном нь бас л нэг төрлийн хувь хүний хөгжлийн гарын авлага биш юм. Энэ ном танаас зүгээр нэг зөв, сайн, сайхан хүн болохыг шаардахгүй. Энэ ном таны Бурхантай тогтоосон харилцааг хэзээ ч гарч үзээгүй оргилд аваачиж, амьдралыг чинь эд эс бүрээр нь ширхэглэн сэгсэрч, орвонгоор нь эргүүлнэ.

А Д А М А Н Т

Олон санаат ертөнцөд үнэнийг олох



Үнэн, хайрын тал дээр хад чулуу мэт хөдлөшгүй байх ёстой цаг гэж байдаг бол тэр цаг иржээ. Бурхан бол хайр. Бурхан бол үнэн. Хайр ч, үнэн ч цаг хугацаагүй бөгөөд үе үеийн чиг хандлага, санаа бодлыг давдаг. Заримдаа үнэнийг ярих нь бидний хийж чадах жинхэнэ хайрын үйлс болдог. Гэхдээ үнэнийг ярих нь үнэнээр амьдрахаас эхлэнэ.

Шилдэг борлуулалтай номын зохиолч Лиза Бивэр Бичээс, түүхийг хослуулан байж, таныг Бурханы ганхашгүй үнэн, хайр дотор амьдруулахаар барахгүй, харин “адамант” буюу хөдлөшгүй, шийдэмгий, ганхашгүй хүмүүс болгох газрыг зорих аян замд гаргана.

Бурханы дотор амьдрах үед Түүний төлөвлөгөө илчлэгддэг. Тэнд л бид хэлбэршин бүрэлддэг. Бид Булангийн чулуу болох Христ дотор амьдрахдаа, адамантын буюу хөдлөшгүй нэгний дүрд хувирдаг.



CloudLibrary.org CLOUD
LIBRARY

ӨНӨ МОНХООР ХОТ ЛОГ ДОХҮЙ

Өнөөдөр ч, үүрд мөнхөд ч үнэ цэнэтэй байх амьдрал




Нэг өдөр та Бурханы өмнө зогсоод хэрхэн амьдарснаа тайлагнана. Тэгвэл одоо өөрөөсөө асуух хамгийн чухал асуулт нь та үүнд бэлэн үү? Дийлэнх Христэд итгэгч нар загалмайд хэрхэн хандсанаараа өнө мөнхөд хаана амьдрахаа шийднэ гэдгийг мэддэг. Гэхдээ энэ амьдралд юу хийснээрээ өнө мөнхөд яг л тэгж амьдарна гэдгээ та мэдэх үү?

Бурхан таныг дуудлагаа мэдээсэй гэж хүсдэг. Тэр танаас юу ч нуухыг хүсдэггүй. Үнэндээ Бурхан таныг энэ дэлхийд яагаад төрснөө мэдэх мэдлэгийг дагалддаг утга, зорилгыг олж мэдээсэй гэж үнэн голоосоо хүсдэг. Эцсийн амьсгал тасрахтай эхлэдэг амьдрал нь зүгээр нэг эцсийн зогсоол биш юм. Хождох хүртлээ бүү хүлээ. Бурханаас өгөгдсөн хувь тавилангаа олж мэдээд, өнөөдөр ч, үүрд мөнхөд ч үнэ цэнэтэй байх амьдралыг бүтээ.

АФФАБЕЛ

Сонсдог жүжиг



Аффабел нь Жон Бивэрийн бичсэн сонсдог жүжиг юм. Үүнд энэ дэлхийн амьдралаас цаашхи бодит амьдралыг өгүүлэх бөгөөд үүгээр Бурханы хаанчлалын олон үнэнийг тусган харуулдаг. Итгэгч хүмүүс өнө мөнхийн хараатай амьдрах ёстой ч, олон хүн өнө мөнх гэж юу болохыг ч мэддэггүй.

Аугаа их хаан Жэйлин, харанхуйн хар санаат эзэн Дагон болон Өгөөмөр, Бие даагч тэргүүтэй гол дүрүүдтэй болон Аффабел хэмээх ер бусын нутагтай бас Ганц хэмээх аймшигт хөсөр газартай танилцаарай. Гол дүрүүдийн амьдралаар дамжин зүрхний чинь үнэн төрх илчлэгдэх үед та өөрийнхөө амьдралын талаар нэгийг бодох буй за.

Аффабел сонсдог жүжиг нь сонсогчийг нэгэнт ухааруулахын төлөө бүтээгдсэн “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын жүжигчилсэн хэлбэр болно.

САТАНЫ ҮРХИ

Өстөн дайсныхаа үхлийн занганаас эрх чөлөөтэй амьдар



САТАНЫ ҮРХИ ном Бурханы хүслээс итгэгчдийг тун амархан урхиддаг арга болох “гомдол”-ын тухай өгүүлнэ. Олон хүн урхидуулсанаа ч мэдэлгүй энэ урхинд унадаг..

Бүү хуурт! Таныг гомдоох зүйлээс зугтаж чадахгүй ч гомдох гомдохгүйгээ сонгох боломж танд бий. Гомдлыг зөв шийдвэл хорсож үлдэлгүй харин улам хүчирхэг болно. Зөвхөн зөв шийдсэн нь Бурхантай ямар ч саадгүй харилцана.

Энэ номоор, Жон Бивэр хардалт, үл итгэлцэлээс чөлөөтэй байж Бурханы хүсэл дор үргэлж явах замыг зааж өгөх болно. Байнга хэн нэгэнд уурлаж, цухалдаж явах хохирогчийн сэтгэлгээнээс чөлөөтэй амьдрахыг энэ номд өгүүлнэ. Бурханд амьдралаа бодлоо бүрэн даатган өгөх бүр уучлал, эвлэрэл, баяр хөөрөөр дүүрэн амьдрахын нууцыг та нээж олох болно.



CloudLibrary.org CLOUD
LIBRARY

САТАНЫ ҮРХИ

(Монгол бичгээр)



САТАНЫ ҮРХИ номыг Өвөр Монгол болон Монгол бичгээр унших хүсэлтэй бүх Монгол хүнд зориулан гаргав. Мараната үйлчлэл Жон Бивэрийн кирилл үсгээр хэвлэгдсэн Монгол номуудаас Өвөр Монголын итгэгч ах эгч дүүс нартаа зориулан ажиллаж байгаа билээ. Үүгээрээ Өвөр Монгол дахь Христийн чуулганыг Үгээр хүчирхэгжүүлэх зорилготой болно.

Энэхүү номыг доорх цахим хаягаар ороод “Монгол бичиг” гэсэн хэлийг сонговол татаж авахаар бэлэн байгаа болно. Та таньдаг мэддэг Өвөр Монгол хүнд энэхүү номыг хуулж, олшруулж, тарааж түгээхэд маань дэмжин оролцоно гэдэгт итгэлтэй байна. Монгол чуулганы энэхүү бэлэг Өвөр Монгол дахь Христийн ах эгч дүүс бүхний гарт хүрэх болтугай!

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

Гэрлэлтээ авар



ЭРТ УРЬДЫН ЦАГТ ... Гэрлэлт бол үүрд мөнхийн зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйг холбож зангиддаг гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоос тэднийг анх бүтээгдсэн зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй. Харин энэ бүхний эхлэл нь хурим юм. Хурим нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй нандин үйл явдал билээ. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөлцсөн нөхөр эхнэр хоёр тааж мэдэх аргагүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа босгоно.

Гэхдээ бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл “Гэрлэлтийн түүх” номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, ганц бие байна уу, сүй тавьсан байна уу – Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг билээ.

АРИУН СҮНС

Түүнтэй танилцахуй



Анхны дагалдагч нар Есүстэй 3 жил хамт байж, Түүний заасан бүхнийг сонсож байсан. Харин загалмайд цовдлогдохынхоо өмнө Есүс “Би явж Ариун Сүнс ирэх нь та нарт илүү дээр юм” гэжээ. Хэрэв Есүстэй өдөр бүр байсан дагалдагч нарт Ариун Сүнс тийм их хэрэгтэй байсан юм бол, бидэнд бүр их хэрэгтэй бус уу?

Энэ сургаалаараа Жон Бивэр танд Ариун Сүнсийг танилцуулж, Ариун Сүнсний мөн чанар, хүч чадлыг заана. Таны итгэлийн төлөвшил ямар ч төвшинд байсан “Ариун Сүнс: Түүнтэй танилцахуй” ном танд Бурханыг илүү дотно танин мэдүүлнэ.

АЙДСЫГ ЯЛАХУЙ

Өөрийгөө ялахгүйгээр “Үгүй” гэж хэлж сур
Хүнд таалагдахын төлөө биш, өөртөө итгэлтэй байж сур



Амьдралдаа айж үзээгүй хүн байдаггүй байх. Хэрхэн ийм зүйл болдог, хэрхэн ирээдүйд үүнээс зайлсхийхийг та мэдэх үү? Хэрэв үгүй бол, та энэ чухал асуудлыг шийдэх л хэрэгтэй.

Таныг хөдөлгөөнгүй болгож байгаа тэр зүйлтэй нүүр тулахад, та өөртөө итгэлтэй, эр зоригтой амьдрах болно. 2Тимот 1:7-д Бурхан бидэнд айдсын сүнсийг өгөөгүй гэж тунхагладаг. Христийн өгсөн эрх чөлөөн дор эр зоригтой амьдрах цаг болжээ.

Жон Бивэр энэ сургаалаараа айдсын уг үндсийн тухай ярина. Айдсын хар саврыг тасдаж, Эзэний өгсөн бэлэг авъяасыг хэрэглэж, танд өгсөн Бурханы эрх мэдлээр хэрхэн амьдрах талаар та сурна. Та санаа зовнил, депресс, найдвараа алдах, эргэлзэн самуурахаас чөлөөтэй амьдрах болно. Айдсыг ялахуй ном таныг Бурханы эрх мэдэл дор хүчирхэг амьдрахад сургаж таныг хүчирхэгжүүлэх болно.



CloudLibrary.org CLOUD
LIBRARY

СЭЛЭМТЭЙ ОХИД

Загалмайгаа жинхэнэ баатар шиг үүрье



Бурханы Үг болох илдний тухай судлах нь илдийг сугалж хэрэглэхээс амархан бөгөөд таатай байдаг. Охидууд бид тэнгэрийг газартай холбох цаг болжээ. Дэлхий даяар эмэгтэйчүүд алив гадуурхал, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлийн бай болсоор байна.

Лиза Бивэр энэ номдоо эмэгтэйчүүдийн өнгөрсөнийг биш, харин ирээдүйг өгүүлжээ.

Тиймд Бурханы дайчин охид оо, эр зоригтойгоор босоод, ялгах чадвараа ашиглан, уучилж, мэргэн байж сэлмээ эргүүлэн баатарлаг үйлсийг бүтээгээрэй.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Эргэлзээ, харьцуулалтын энэ эрин цагт өөрийгөө болон зорилгоо олж мэдэх



Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд цутгагдчихсан мэт ялгарашгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтолж байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг.

Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга. Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт. Эмэгтэйчүүд таарахгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаанд хариу барь. Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сур. Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!

МЯТРАШГҮЙ

Хэзээ ч бууж өгөхгүй байх хүч



Хүн бүр асуудалтай тулгардаг. Хүн зовлонг яаж туулдгийг та сайн мэднэ. Зогсоод, атгаа чангалаад, амьд л гарчих юмсан гэсэн горьдлогоор зовлонгийн хөлгүй далайд шидэгддэг. Амьд гарах гэсэн ганц л зорилготой. Гэхдээ тэдгээр сорил нь таны амьдралыг өөрчлөхийн тулд ирсэн байвал яах уу? Танд нүүрлэсэн дайсагнал нь таныг итгэл, төлөвшлийн дараагийн төвшин рүү дэвшүүлэх зорилготой байвал яах уу? Та зовлон дундаас амьд гарахаар барахгүй, ялагч болоод гарахаар бүтээгдсэн байвал яах уу?

Та Бурханы Үг, залбирлаар сургагдаж, зовлон, эсэргүүцлийн талаар, Бурханаас танд хандсан хувь тавилангийн биелэлийн талаар амьдрал өөрчлөгч үнэнийг сурна. Бурханы хүүхэд та дайсагналыг хүчээ болгон ашиглаж, амьдралаа сайнаар өндөрлөх чадалтай шүү!



Мессенжер Интернэйшнэл нь Бурханы өөрчлөгч хүчийг хувь хүн, гэр бүл, чуулган, үндэстэнд ухааруулж, бодитоор харахад нь туслах зорилготой байгууллага болно.

Энэ ухаарал нь хүчирхэгжсэн амьдрал, өөрчлөгдсөн нийгэм, дэлхий дээрх шударга бус зүйлст хариу барих эрч хүчтэй үйлсийг дагуулдаг.

Cloud Library нь даян дэлхийн пастор, удирдагч нарт зориулагдсан, төрөлх хэлээрээ танилцаж болох онлайн дижитал сургалтын сан юм.

CloudLibrary.org хаягаар орж, Жон, Лиза Бивэрийн 90 гаруй хэл дээрх сургалтын материалтай танилцаарай!

Цахим ном, видео, аудио, сургаал, сонсдог ном, Библи, сонсдог жүжиг гэх мэт...



CLOUD LIBRARY



Дэлгэрэнгүйг эндээс авна уу:

КРИПТОНИТЫГ УСТГА

ЦОГЦ СУРГАЛТЫН МАТЕРИАЛ

Таны уншиж байгаа ном нь Жон Бивэрийн бичсэн “Криптонитыг устга” цогц сургалтын материалын нэг хэсэг юм. Номоо уншиж, дагалдах DVD бүхий сургалтын материал, CloudLibrary.org хаягаас татаж авч хэрэглэхэд зориулагдсан сургалтын материалыг хэрэглэснээрээ, та энэхүү амьдрал өөрчлөгч, эрч хүчтэй сургаалын хэсэг бүрийг өөрийн болгож чадна. Зүй ёсоор суралцах аваас, энэ нь таны Христэд итгэх амьдралд нөлөөлж, Бурханы төлөө илүү ихийг хийж чадвартай болгоно.

“Криптонитыг устга” цогц сургалтын материалд дараах зүйлс багтсан болно:

— **“Криптонитыг устга” ном**

Цаасан хэвлэл бүхий ном
PDF цахим ном

— **“Криптонитыг устга” DVD**

Номыг дагалдах диск дээр энэхүү цогц сургалтын материалыг тэр чигээр нь дижитал хэлбэрээр хэвлэсэн болно. Энэхүү диск нь гэрийн DVD тоглуулагч дээр уншигдахгүй, зөвхөн таблет, компьютер юмуу ухаалаг утас дээр л уншигдана.

— **“Криптонитыг устга” сонсдог ном**

“Криптонитыг устга” сонсдог ном нь Монгол хэл дээр уншигдсан, сонсох зориулалттай MP3 форматтай 28 бүлэг бүхий ном юм.

— **“Криптонитыг устга” видео сургаал**

MP4 форматаар бичсэн, 8 бүлэг бүхий видео хичээл.

— **Аффабел сонсдог жүжиг**

MP3 форматаар бичсэн, сонсох зориулалттай жүжиг

— **Нэмэлт материал**

Эдгээрээс гадна DVD дээр “Аффабел” сонсдог жүжиг, “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй”, “Сайныг уу, Бурханыг уу?” цахим ном зэрэг бусад ном, материалыг багтаасан болно.

ЭНЭ БҮХ ЦОГЦ СУРГАЛТЫН МАТЕРИАЛ НЬ ТАНД БАРИХ БИДНИЙ БЭЛЭГ ШҮҮ!



Энэхүү DVD дээрх бүх материалыг чөлөөтэй хувилж, тарааж, найзууддаа имэйлээр илгээж, хуулж, Word документ дээр хуулж, сургаалыг нь чуулгандаа илгээж, бусдын хэрэглээнд зориулж интернет дээр тавьж болно. Эдгээрийг Бурханы үгийн сайн сургаал, хүчтэй итгэлийн амьдралаар дутагдаж байгаа газар бүрт хүргэж, тараагаарай.

“Криптоницыг устга” цогц сургалтын материалын нэмэлт тайлбар:

- DVD дээрх файл нь ахуйн хэрэглээнд зориулагдсан видео тоглуулагч дээр уншигдахгүй, гагцхүү компьютер, дижитал тоглуулагч дээр л уншигдана.
- MP4 видео файл нь таблет, компьютер дээр уншигдана.
- MP3 аудио файл нь аудио медиа тоглуулагч, ухаалаг утас, компьютер дээр уншигдана.
- PDF дижитал файл нь таблет, компьютер дээр уншигдана. Үүнийг хялбархан уншиж, хэвлэж, хувилж болно.
CloudLibrary.org

УСТГА КРИПТОНИТЫГ



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org



Илүү дэлгэрэнгүй
доорх цахим хуудаснаас:
CloudLibrary.org

Зөвхөн компьютерт
хийж хэрэглэнэ үү

ЖОН БИВЭР



Жон Бивэрийн энэхүү болоод бусад цогц сургалтын материал нь Мессенжер Интенэйшнэлийн үнэ төлбөргүй видео суваг дээр болон доорх цахим хуудас дээр бий.



CloudLibrary.org

Монгол болон бусад хэл дээрх материалыг YouTube.com
YouKu.com тэргүүтэй бүхий л олон нийтийн медиа
хуудсаас үзэж болно.

Саад бэрхшээлийг гишгэлэн, дайсан бүрийг сөнөөх
СУПЕРМЭН ШИГ Христийн дагалдагч болгон ирэх саад
тотгорыг байлдан дагуулах чадвартай байдаг. Гэхдээ
Супермэн бид нарт нэг зовлон байдаг нь хүчийг маань
хулгайлагч криптонит юм.

Мэдээж Супермэн ч, криптонит ч уран зөгнөл бол, харин
сүнслэг криптонит нь бодитой юм.

Яагаад өнөөгийн бид Нэгдүгээр зууны Христэд итгэгч хүмүүс
шиг тэнгэрлэг хүчтэй байж чадахгүй байгаад энэ ном хариулах
болно.

“Криптонитыг устга” номдоо Жон Бивэр криптонит гэж юу
болох, яагаад манай нийгэмд аюул занал болж байгааг мөн
раж үүний хүлээсийг тасдахыг илчилжээ.

“КРИПТОНИТЫГ УСТГА” СУРГАЛТЫН DVD-Г ХАВСАРГАВ



Мессенжер Интернэйшнэл байгууллагын үндэслэн
байгуулагч Жон Бивэр нь Бурханы найраагүй үнэнийг халуун
сэтгэлээр, зоригтой заадаг номлогч төдийгүй, шилдэг
борлуулалттай номын зохиолч хүн билээ. Газар газрын,
үндэстэн үндэстний, боломжтой боломжгүй чуулган,
удирдагч нарыг Бурханы үгээр хангах нь Жоны чин хүсэл.
Өнөөгийн байдлаар Жоны материал 100 гаруй хэл дээр
орчуулагдан, сая сая хувиар тараагдан, даян дэлхийн
пастор, удирдагч нарын гарт хүрээд байна.



Хэрэгтэй материалаа
эндээс татаж аваарай
CloudLibrary.org



Энэ ном нь танд зориулсан зохиолчийн
бэлэг бөгөөд худалдахыг хориглоно

Дэлгэрэнгүй
эндээс

